

ЖОН БИВЭР

САТАНЫ ҮРХИ

өстөн дайсныхаа
үхлийн занганаас
эрх чөлөөтэй амьдар

Дэлхий даяар 1,000,000 хувь хэвлэгдсэн

ЧИМЭЭГҮЙ ЦАГИЙН МАТЕРИАЛТАЙ

Эрхэм анд минь,

Өөрөөсөө зугтаж байсан үеэ орхиж бодит байдалтайгаа нүүр тулах хүндхэн сэдвийг энэ ном хөндөнө. Би өөрөө бичсэн учраас ингэж хэлж байгаа юм биш харин би өөрөө энэ замаар туулж үзсэн учраас баттай хэлж байгаа юм шүү. Энэ номд миний нэр байгаа нь эхлээд надад уншуулахын тулд тэнгэрээс бичигдсэн ном гэлтэй. Гомдох гэдэг асуудал Сатаны том урхи юм. Ихэнхдээ гомдолтойгоо хэрхэн нүүр тулж, хэрхэн шийдэх тухайгаа бид мэддэггүй.

Энэ ном арав гаруй жилийн өмнө худалдаанд гарч нэг сая гаруй хувь борлогдож олон арван хэлэнд хөрвүүлжээ. Энэ номоор дамжуулан Сатаны урхинаас чөлөөлөгдөж, эрх чөлөөтэй болж, харилцаа нь сэргэж, Бурханы тэдэнд хандсан гайхамшигтай төлөвлөгөө дор амьдарч буй гэсэн хэдэн зуун мянган гэрчлэлтэй захиа бидэнд ирдэг.

Харин одоо дэлхий даяар энэ номыг удирдлагын байр сууринд байгаа удирдагч нарт болон өсч буй шинэ залуу удирдагч нарт хайрынхаа урьдчилгаа болгон үнэгүй тараан өгөх нь тэдний нөлөө дор буй олон зуун сая хүнийг эрх чөлөөнд хүргэх юм гэсэн гүн бат итгэл үнэмшлийг Эзэн зүрхэнд минь суулгав.

Сүнсэнд минь Бурхан энэ сургаалыг суулгасан цагаас хойш амьдрал минь эргэшгүйгээр өөрчлөгдсөн юм. Энэ номд өгүүлэх сургаалаар Эзэн Бурхан зүрхийг тань өөрчлөх болтугай гэж таны төлөө залбирья. Мөн таны амьдрал энэхүү сургаалаар болон таны төлөөх бидний үйлчлэлээр хэрхэн өөрчлөгдсөн тухай ч би сонсохыг хүсч байна.

Христ дотор таны ах,



Жон Бивэр



MESSENGER
INTERNATIONAL



MessengerX.com

ЖОН БИВЭР

САТАНЫ ҮРХИ

өстөн дайсныхаа

үхлийн занганаас

эрх чөлөөтэй амьдар

Дэлхий даяар 1,000,000 хувь хэвлэгдсэн

ЧИМЭЭГҮЙ ЦАГИЙН МАТЕРИАЛТАЙ

The Bait of Satan (Mongolian)
© 2021 John Bevere
www.MessengerInternational.org

This is a gift from Messenger International,
the Ministry of John and Lisa Bevere.

To contact the author: JohnBevere@ymail.com

Additional resources in (Mongolian) are available for
free download and video streaming at
MessengerX.com and on the **MessengerX app**

САТАНЫ УРХИ: Өстөн дайсныхаа үхлийн занганаас эрх чөлөөтэй амьдар
Жон Бивэр
© 2021 Жон Бивэр
www.MessengerInternational.org

Энэхүү номыг Христэч удирдагч нарт ҮНЭГҮЙ ТАРААХ зорилгоор
хэвлэсэн бөгөөд худалдан борлуулахыг хориглоно. Номын зохиогч Жон
Бивэр Монгол чуулганд бэлэг болгов.

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалаа
MessengerX.com болон **MessengerX app** -аас
шууд үзэх эсвэл утсандаа татаж авах боломжтой.

Зохиогчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com

Библийн ишлэл: Ариун Библи
© 1995, 1996, 1997, 1998, 1999, 2000 Монголын Библийн Орчуулгын Хороо
© 2004, Ариун Бичээс Библийн нийгэмлэг



App Store is a trademark of Apple Inc., registered in the U.S. and other countries.
Google Play and the Google Play logo are trademarks of Google LLC.

ЧИН СЭТГЭЛИЙН ТАЛАРХАЛ

Эзэний дараа орох, миний дотны найз, гэргий, Лизадаа талархаж байна. Чи минь үнэхээр журамт бүсгүй. Бидний амьдралын замыг холбосон Эзэн Бурхандаа би гүнээ талархаж байна. Энэхүү номыг эрхлэн гаргахад цаг наргүй өөрийгөө зориулсан чамдаа баярлалаа.

Аавын дөрвөн сайхан хүү Аддисон, Аустин, Александр болон Ардендаа талархаж байна. Энэ ном бүрэн дуусгах хүртэл аавтайгаа хамт байгаа цагаа золиослосон хөвгүүдээ баярлалаа. Зүрхний минь баяр хөөр шүү та дөрөв.

Энэ судалгаа сайн ном болно гэдэгт итгэж ном болгон гаргахад урам өгсөн анд Жон Масон, авьяас чадлаа дайчлан номыг хянан засварласан Дебора Поулалион болон энэ номын төсөл дээр ажилласан Карисма хэвлэлийн газрын бүхий л ажилтануудад талархаж байна.

Хамгийн дээд талархалыг төсөөлшгүй их бэлэг хайрлагч тэнгэрт оршигч Бурхан Аавдаа, нигүүлсэл, үнэн ба хайрыг харамгүй хайрлагч Эзэн Есүстээ, энэхүү төслийг эхнээс нь дуустал удирдсан Ариун Сүнс танд талархаж байна.

АГУУЛГА

Өмнөх үг	9
Оршил	13
1. Би ямар гомдчихоо юу?	17
2. Бөөн гомдол	25
3. Яахаараа надад ийм зүйл тохиолддог байна аа?	35
4. Аав аа, аав аа!	45
5. Сүнсний тэнүүлчид хэрхэн төрдөг вэ?	57
6. Бодит байдлаас нуугдахуй	69
7. Бат суурь	79
8. Шигшигдэх ёстой бүхэн шигшигдэнэ	91
9. Гомдоогч хад	107
10. Тэднийг гомдоохгүйн төлөө	123
11. Уучлал: Өгөхгүй бол авахгүй	133
12. Өшөө авах: Энэ бол уха	147
13. Урхинаас зайл	157
14. Зорилго: Эвлэрэл	167
Эпилоги: Үйлдэл болгохуй	177
Сатаны урхи номын “Чимээгүй цагийн материал”	179

ӨМНӨХ ҮГ

Энэ ном таныг амьдралын чинь хамгийн хэцүү үнэнтэй нүүрэлдүүлэх ном болох байх аа. Би энэ номыг бичсэндээ биш, харин өөрөө энэ замаар явж үзсэндээ хэлж байна. “Сатаны урхи” номоор хүний амьдралд тулгардаг “гомдол” хэмээх хүндхэн мэдрэмжинд хэрхэн хандах, үүнийг хэрхэн шийдвэрлэх талаар ярина.

Есүсийн дагалдагч нар тогтоож аваад, бусдад гэрчлэх олон гайхамшиг үзсэн. Тэд нүдгүй нь нүд орж, үхсэн нь амилахыг үзсэн. Тэд олон хүний амь амьдралд аюул занал болсон далайн шуургыг Есүс үгээрээ номхруулахыг ч үзсэн. Есүсийн гарт хэдхэн ширхэг талх, загас үржин, хэдэн мянган хүнийг хооллохыг ч тэд мэднэ. Есүсийн үйлдсэн гайхамшигийг жагсаавал дуусахгүй болохоор, Библид бүгдийг нь багтаах боломжгүй гэж хүртэл бичсэн.

Бурхан Есүсээр дамжуулан ийм бодитой, тодорхой ажиллаж байсан удаа түүхэнд өөр байхгүй. Энэ бүх гайхамшиг дагалдагч нарыг нэг ч эргэлзүүлээгүй. Гэтэл үйлчлэлийнхээ төгсгөл дээр “Хэрэв тэр чиний эсрэг өдөрт долоон удаа нүгэл үйлдчихээд, чам уруу долоон удаа эргэж ирж, “Би гэмшиж байна” гэвэл, түүнийг уучил” (Лук 17:3-5) гэж хэлсэн Есүсийн үг дагалдагч нарыг барьц алдуулжээ. Дагалдагч нар тэр даруй Есүсээс “Итгэлийг минь өсгөөч” хэмээн гуйсан. Элч нар сохрыг хараа

оруулах, үхэгсдийг амилуулах, тэнгисийг номхотгох зэрэг гайхамшиг үзэхдээ, итгэлээ өсгөх талаар гуйгаагүй атлаа өөрт нь буруу зүйл хийсэн нөхрөө уучлах талаар өгүүлэх үед гуйжээ.

Есүс “Бүдрэх чулуунууд ирэх нь зайлшгүй ч, харин бүдрүүлэгч нэгэн золгүй ээ!” (Лук 17:1) гэсэн. Хүнээс аль нэг гомдол авах нь тодорхой болов ч, гомдолд хэрхэн хандах нь л хамгаас чухал. Харамсалтай нь ихэнх хүмүүс гомдлын урхинд дорхноо ордог.

Энэ ном хэвлэгдсэнээс хойш арваад жил өнгөрчээ. Энэ номон дахь Бурханы үнэн үгээр амьдрал, гэр бүл, үйлчлэл нь эдгэрч ерөөгдсөн тухай захиа, талархал бидэнд ирсээр л байна. Танд урам болгох үүднээс би тэдгээрээс номдоо эш татаж орууллаа. Тэр олон хүний төлөө Бурхандаа талархаж, алдрыг нь өргөж байна!

Жишээлбэл, нэгэн удирдагч “Манай чуулганд том хагарал үүсч, ямар ч найдваргүй болоод байлаа. Гэтэл чуулганыхаа ахлагч бүрт “Сатаны урхи” номыг өгч уншуулснаас хойш бид хагарлын төлөө бус, эв нэгдлийн төлөө зогсдог, нэгэн цул чуулган болсон!” гэж бичиж билээ.

Энэ номоор мөн олон гэр бүл аврагдсан. Небраскад номлосны дараахан гэр бүлийн хоёр надтай уулзаад, эхнэр нь ингэж ярьсан юм: “Арваад жилийн өмнө би чуулганыхаа удирдлагад гомдсон. Би тэдний хийж байгаа зүйлд үл итгэж, хардаж сэрдэж, өөрийнхөө байр суурийг өмгөөлөн, тэднийг буруутгаж, байдгаараа хорссон. Миний энэ их хорслоос болж гэр бүл минь ч зовсон. Тэр бүү хэл, нөхөр маань надаас салахаар шийдсэн. Тэр үед нөхөр маань Есүст итгээгүй байсан болохоор, чуулганы хэрэг явдалтай хутгалдахыг хүсээгүй юм. Тэгтэл нэг хүн надад (хэн гэдгийг нь санахгүй байв) “*Сатаны Урхи*” номыг өгсөн юм. Сонирхолтой байсан болохоор, маналзуулаад л дуусгасан. Тэгээд удалгүй ном дээрх зааврын дагуу гомдол хорслоосоо чөлөөлөгдсөн юм. Миний амьдралд гарсан өөрчлөлтийг үзээд, нөхөр маань Эзэн Есүст амьдралаа өргөн, надаас салах санаагаа өөрчилсөн.” Нөхөр нь ч бас эхнэрийнхээ яриаг үг дуугүй, мишээсээр сонсож дуусгаад, гэр бүл, харилцаанд нь гарсан сайхан, сайхан өөрчлөлтийг нэмж гэрчилсэнсэн.

Бас өөр нэгэн гэрчлэл миний зүрхийг баясгаж билээ. Би Флоридагийн Наплетст үйлчилж байлаа. Номлохын өмнөхөн дунд эргэм насны, бууралдуу үстэй нэгэн хүн цугласан олны өмнө уйлж гарав. Тэр хүн “Насан турш Бурхан, бид хоёрын дунд

том хана байна гэж боддог байлаа. Хүмүүс цуглаанд Бурханы оршихуйг мэдэрсэн гэж ярихад, харин би юу ч мэдэрдэггүй байв. Залбираад ч, нэмэргүй. Гэтэл хэдэн долоо хоногийн өмнө надад “*Сатаны Урхи*” гэдэг номыг өгсөн юм. Би бүгдийг нь уншсан. Зургаан сартайд минь хаяж явсан ээждээ гомдож, түүнийг үзэн ядаж өсчээ би. Тэгээд 36 насандаа ээжтэйгээ хоёр дахь удаагаа утсаар ярихдаа, уйлсаар “Ээж ээ, намайг орхиж явсанд чинь би насан турш гомдсон” гэж хэлтэл, ээж “Хүү минь, ээж нь чамайг орхиж явсандаа насан турш өөрийгөө зүхсэн” гэж хариулсан” гэсэн юм.

Тэрбээр цааш нь “Би ээжийгээ уучилсан, ээж маань ч өөрийгөө уучилсан байх. Одоо бид хоёр эвлэрсэн” гэж ярив.

Тэгээд хамгийн гоё хэсэг нь “Харин одоо Бурхан, бид хоёрыг хааж байсан хана нурсан” гэдэг үг байлаа.

Тэр эрхэм ингэж хэлээд л уйлчихсан юм. Тэгээд “Би яг одоо Бурхан Аавынхаа өвөр дээр уйлж суугаа жаахан хүүхэд шиг л байна” хэмээн өмгөнөн хэлж билээ.

Гомдолд олзлуулахын бодит хүчийг би мэднэ ээ. Би ч гэсэн гомдолд олзлуулж, хайран амьдралаа үр дүнгүй өнгөрөөж байсан. Энэ бол онолын ном биш. Харин бодит хүнд зааж өгсөн Бурханы үнэн. Энд хэлсэн үг, өгүүлбэр бүрээр би өөрөө амьдарсан. Энэ ном таныг хүчтэй болгоно гэдэгт би итгэж байна. Итгэлээр өсөх бүрий Бурхан алдаршиж, амьдрал тань баяр хөөрөөр цалгиг! Бурхан таныг өгөөмрөөр ерөөг!

– *Жон Бивэр*

ОРШИЛ

Урхи, хавхаар амьтан барьж үзсэн хүн урхи нь амьтны нүдэнд харагдахгүй атлаа тухайн амьтныг татах ганц, хоёр зүйлтэй байдгийг мэддэг. Амьтан сонирхолыг нь татаж байгаа зүйлд анхаарч, урхинд орсноо ч мэдэхгүй явсаар, нэг л мэдэхэд урхинд унана.

Хүний сүнсийг ангуучлагч Сатан яг ийм арга замаар үхлийнхээ урхинд хүмүүсийг оруулдаг. Түүний урхи - шохоорхол татдаг, далд урхи.

Олон хүн Сатаны бүлэглэлийг ил тод ажиллагаатай гэж итгэдэг. Гэтэл Сатан заль мэхийн үүр, уурхай. Бүх ажлаа маш зальжин, чадварлаг, нарийн хийнэ. Тэр өөрийгөө гэрлийн элч мэт харагдуулж чадна гэснийг бүү маргаарай. Хэрэв бид Бурханы Үгээр сайн, мууг ялгахад суралцахгүй бол, түүний урхи ямар байдаг талаар ямар ч ойлголтгүй явна.

Сатаны байнга хэрэглэдэг, итгэгчдийн байнга унадаг нэгэн урхи нь гомдол юм. Зүгээр байгаа урхи үхлийн аюулгүй. Харин урхинд тавьсан өгөөшийг авах үед урхи аюултай болдог. Урхины өгөөш болох гомдол нь зүрхэнд хүрэх үед харилцаанд сэв сууж, амьдралд уур хилэн, шарх, хагарал, хорсол, хэрүүл маргаан, үзэн ядалт болоод биед халдах гэх мэт олон хор хохирол авчирна. Урхидуулсны үр дүнд доромжлол, довтлох, шархдуулах, хагарал

авчрах, салан тусгаарлах, харилцаа эвдэх, урвалт болоод итгэлийн амьдралаасаа няцах гэх мэт үр дагавар бий болно.

Гомдсон хүмүүс урхинд орсноо тэр бүр мэддэггүй. Тэд өөрт нь хүмүүс ямар буруу юм хийсэн дээр л хамгаас анхаардаг учраас л тэгдэг байх. Тэд бодит байдлыг байнга үгүйсгэдэг. Тийм үед дайсан нүд сохолж, зөвхөн өөр дээрээ л анхаарахад хүргэдэг.

Ном маань энэ урхийг таньж, үүнээс хэрхэн чөлөөлөгдөхийг зааж өгнө. Ямар нэг гомдол авахгүйгээр амьдрах ямар ч боломжгүй (Лук 17:1) гэж Есүс хэлсэн учраас, гомдлыг хэрхэн зөв шийдэхийг итгэгч болгон сурах ёстой.

Америкт ч, бусад улсад ч энэ талаар номлоход хүмүүсийн 50% нь шийдвэр гаргаж, гомдлын асуудлаа шийддэг. Хэдийгээр олон хүн шийдвэр гаргаж байгаа ч, цаана нь олон хүн суудал дээрээ бардам гэгч нь сууж үлддэг. Бардам зан бодит байдлаа хүлээн зөвшөөрөхөд саад болдог. Харин өөрийгөө даруусган эрх чөлөөнд хүрсэн хүмүүс эдгэрч, Ариун Сүнсээр дүүрч, олон жил хүсч мөрөөдөж байсан зүйлээ хормын төдийд хүлээн авдаг.

Хорьдугаар зууны төгсгөл гэхэд чуулган мэдлэгтээ хальжээ. Хэдий их мэдлэгтэй болсон ч, чуулган доторх хагарал ихэсч, удирдагч нарын харилцаа улам хөндийрсөн нь харамсаар. Хайрын хомсдол нь хагарлын шалтгаан ажээ. “Мэдлэг ихэрхэг болгож, хайр босгон байгуулдаг” (1Коринт 8:1). Энэ урхинд дэндүү олон хүн орсоор, сүүлдээ энэ нь хэвийн мэт үзэгдэх болов.

Христийг эргэж ирэхийн өмнө жинхэнэ итгэгчид урьд хожид байгаагүйгээрээ нэгдэнэ. Өнөөдөр үй олон эрчүүд, эмэгтэйчүүд гомдлын урхиас чөлөөлөгдсөөр байна. Үндэстнүүдийг даяар нь сэргээх сэргэлтийн оньс нь үүнд л оршино гэдэгт би итгэдэг. Бие биеэ хайрлах итгэгч нарыг харсан үл итгэгч нар урьд нь хараагүй байсан Христийг тэрхүү эв нэгдэл дундаас олж харна.

Номыг зүгээр бичих гэж бичдэггүй байх. Нэгдүгээрт - энэ талаар л бичих ёстой гэсэн чин хүсэл зүрхэнд бадарч, хоёрдугаарт - гомдлоос чөлөөтэй байхын үр дүнг амьдралдаа одоо ч үзсээр байгаа минь энэ номыг бичихэд хүргэсэн юм. Энэ номын гол санааг заасны дараа нэгэн пастор “Нэгэн зэрэг ийм олон хүн чөлөөлөгдөхийг хэзээ ч үзсэнгүй” гэж билээ.

Энэ бол дөнгөж эхлэл нь хэмээн Бурхан надад хэлсэн. Энэ номоор Ариун Сүнсний хүслийг дагасан олон хүн эрх чөлөөтэй

болж, эдгэрч, сэргээгдэх болно ч гэж хэлсэн. Энэ номыг уншиж байхад Зөвлөх, Туслах - Ариун Сүнс таныг амьдралд тань яг хэрэгтэй үнэн рүү хөтөлнө гэдэгт би итгэлтэй байна. Ариун Сүнсний илчлэх үнэн амьдрал, үйлчлэлд тань эрх чөлөөг авчирна.

Хамтдаа залбиръя:

Аав аа, Есүсийн нэрээр танаас гуйж байна. Энэ номыг уншиж байхад Ариун Сүнсээрээ Үгээ илчлээч. Таныг таньж мэдэж, Танд үйлчлэхэд саад болж байгаа ямар нэгэн зүйл зүрхний минь угт байх аваас, илчилж өгөөч. Сүнсээрээ намайг ятгаач, хүсэл зорилгодоо нигүүлсэн хөтлөөч. Энэ номыг уншихад Таны дуу хоолой надад хүрч, би Тантай улам дотносох болтугай!

ГОМДОЛД ХАНДАХ БИДНИЙ ХАРИУ БИДНИЙ ИРЭЭДҮЙГ ТОДОРХОЙЛНО.

Сатаны урхи ном бидний амьдрал, үйлчлэлийг өөрчилсөөн. Видео сургаалыг хорь гаруй удаа үзсэн байх. Номыг дахин дахин хэд хэдэн удаа уншсан. Энэхүү сургаалын видео болон номыг өөрийн амьдрал болон бусдын амьдралыг өөрчлөн хүчтэй болгохын тулд хэрэглэж байна. Энэ сургаал үнэхээр хүчтэй бас цаг үеэ олсон сургаал юм.

S.Q., CONNECTICUT

БИ ЯМАР ГОМДЧИХОО ЮУ?

*Бүдрэх чулуунууд ирэх нь зайлиггүй ч,
харин бүдрүүлэгч нэгэн золгүй ээ!*

Лук 17:1

Америк даяар аялан үйлчлэхдээ би, дайсны хэрэглэдэг үхлийн, зальт арга замыг ажиглаж мэдсэн юм. Үй олон итгэгчийг чөдөрлөж, харилцааг нь хөндийрүүлж, хүмүүсийг өөр хооронд нь холдуулдаг тэр арга нь гомдлын урхи байлаа.

Бурханд дуудагдаж, тослогдсон олон хүн энэ л урхиас болж сэтгэлдээ гомдол, шарх тээсээр, чөлөөтэй үйлчилж чадахгүйд хүрээд байхыг би ажигласан. Гомдоогч нь голдуу бусад итгэгчид. Ойр дотны хүний ийм гомдол нь урвалт мэт санагдана. Дуулал 55:12-14 дээр Давид ийнхүү гашууджээ: “Учир нь энэ бол намайг доромжилдог миний дайсан биш билээ. Тийм байсан бол би тэсэхсэн. Мөн энэ нь миний эсрэг өөрийгөө өргөмжилдөг намайг үзэн ядагч ч биш. Тийм байсан бол би түүнээс нуугдахсан. Гэвч энэ бол надтай нэг зиндаатай хүн болох чи, миний анд нөхөр бөгөөд миний дотнын найз билээ. Бид хамтдаа амттай яриа дэлгэж, Бурханы өргөөнд олон хүмүүсийн дундуур алхаж байсан.”

Тэрбээр тантай цуглаанд зэрэгцэн суудаг, хамтдаа дуулдаг, магадгүй сургаал номлодог хүн байж болно. Хамтдаа амарч аялж, олон нийтийн үйл ажилд оролцдог эсвэл нэг өрөөнд суудаг хүн ч байж болно. Эсвэл түүнээс ч илүү ойр дотно хүн

байж болох. Хамтдаа өсч, нууцаа ярьж, нэг өрөөнд хамт унтаж байсан хүн ч байж мэдэх. Харилцаа ойр байх тусам, гомдол төдий чинээ гүн тусах! Хамгийн ойр дотно байсан хүнээ хамгийн их үзэн яддаг тухай та мэдэх байх.

Гэр бүл салах шүүх хурал хамгийн хэрцгий байдгийг ямар ч өмгөөлөгч танд хэлнэ. Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй, хүн амины хэргийн талаар Америкт мэдээгээр байнга гардаг. Уг нь гэр бүл гэдэг хайрын сургууль баймаар. Хүн гэр бүлдээ л хамгаалалт, хангамж, өсч бойжих аюулгүй орчныг авч баймаар. Гэтэл гэр бүл гомдол, зовлонгийн үүр болох нь олонтаа. Хүн төрөлхтний түүхэн дэхь хамгийн цуст дайн бол ах нь дүүгийнхээ эсрэг, хүү нь аавынхаа эсрэг, хөрш нь хөршийнхээ эсрэг чиглэсэн, иргэний дайн байдаг.

Их, бага хэмжээгээр гомдох боломж нь харилцааны төрлүүд шигээ л хязгааргүй. Гэхдээ нэг үнэн хөдлөшгүй хэвээр: танд чухал хүмүүс л таныг шархуулна. Та тэдэнд өөрийгөө бүрэн зориулсан учраас, тэднээс ч ихийг хүсэн хүлээнэ. Хэдий чинээ хүсэн хүлээнэ, төдий чинээ хүнд унана.

Манай нийгэм хувиа хичээсэн нийгэм. Эр, эмгүй бүгд л хувийнхаа ашиг сонирхлыг харж, бусдын ашиг сонирхлыг юман чинээ бодохгүй, тийм л нийгэмд бид амьдарч байна. Гэхдээ үүнд гайхалтгүй. Сүүлчийн өдрүүдэд хүмүүс “Өөрсдийгөө хайрлагчид” болно (2Тимот 3:2) гэж Библи хэлдэг. Энэ үгийг итгэдэггүй хүмүүст хэлсэн гэж хүмүүс боддог ч, үнэндээ Паул итгэгчдэд бичсэн юм. Олон хүн шархалж, гомдож, хорссоор амьдарч байна. Тэд хүнд гомдсон! Гэтэл тэд Саганы урхинд орсноо мэдэхгүй явна.

Энэ бидний буруу юу? Хэнд ч гомдохгүйгээр амьдрах боломжгүй гэдгийг Есүс тодорхой хэлээд байхад, хэн нэгэнд гомдонгуутаа гайхаж, цочирдож, хөшдөг. Бид ганц өөрийгөө л хохирогч гэж боддог. Ийм хариу хандлага нь бидний дотор хорсол үндэслэх хөрс болж өгнө. Тиймээс бид гомдолд бэлтгэлтэй, хамгаалалттай байх ёстой. Учир нь үүгээрээ ирээдүйгээ шийднэ.

МЭХЛЭГЧ УРХИ

Лук 17:1 дээрх гомдол гэдэг үгийг Грекээр *скандалон* гэдэг. Энэ нь урхинд оруулагч өгөөшийн нэр. Хүнийг урхидахын тулд замд нь өгөөш тавьдаг гэсэн үг л дээ. Дайсан урхи хэрэглэдэг

талаар Шинэ гэрээ их өгүүлдэг. Гомдол нь хүмүүсийг олзлогч диаволын зэвсэг юм. Паул залуу Тимотод ингэж заажээ:

“Эзэний боол тэмцэл мөргөлдөөнд оролцох ёсгүй. Харин бүх хүнд эелдэг зөөлөн ханд. Заах чадвартай, буруудахад тэвчээртэй байж, *зөрөлдөгсдийг* төлөв байдал дотор засаж бай. Хэрэв магадгүй Бурхан тэдэнд үнэний мэдлэгт хүргэх гэмшлийг соёрхвол тэд ухаан орж, *диаволын торноос чөлөөлөгдөх буй*. Учир нь диавол *өөрийн хүслээр тэднийг хөдөлгөхийн тулд* тэднийг олзлон авсан байжээ.”

2Тимот 2:24-26

Хоорондоо хэрэлдэж, бие биеэ эсэргүүцэж байгаа хүмүүс энэ урхинд орж, чөтгөрийн хүслийг биелүүлэхээр олзлогдсон гэжээ. Гэхдээ хамгийн аюултай нь тэд өөрсдөө ч урхинд орсноо мэдэхгүй! Тэнэмэл хүү ухаан ордог шиг, тэр хүмүүс байгаа байдлаа харах хэрэгтэй. Тэд амнаасаа цэвэр бус, гашуун ус гаргаж байгаагаа ойлгодоггүй. Урхинд орсон хүн буруугаа зөв хэмээн бодсоор явдаг.

Нөхцөл байдлаас нь үл хамааран гомдсон хүмүүсийг хоёр ангилж болно: 1) жинхэнээсээ хохирсон хүн, 2) өөрийгөө хохирогч гэж итгэсэн хүн. Хоёрдугаар ангиллын хүмүүс өөрт нь шударга бус хандсан гэдэгт үнэн голоосоо итгэдэг. Гэтэл тэд буруу мэдээллээс дүгнэлт гаргасан байх нь элбэг. Эсвэл зөв мэдээллээс буруу дүгнэлт гаргасан байж болно. Ямартаа ч гомдогсдын ухаан харанхуйлдаг. Тэд бүхнийг таамаг, хардалт, сонссоноороо л өнгөц шүүнэ.

ЗҮРХНИЙ ЖИНХЭНЭ ДҮР ТӨРХ

Гомдлоор чөдөрлөдөг дайсны нэг арга нь гомдсон хүнийг бардамнуулах юм. Учир нь бардам зан нь бодит байдлыг үгүйсгэх боломж олгодог.

Би ч бас Бурханд үйлчилдэг хэд хэдэн хүнд голоо тасартал гомдож үзсэн. Хүмүүс надад “Тэд яаж чамд ингэж хандаж чадаж байна аа? Чамд хэцүү байгаа байх даа?” гэнэ.

Би ч өөдөөс нь шууд л “Зүгээр ээ. Юу гэж гомддог юм” гэж хариулна. Би гомдох нь буруу гэдгийг мэдэж байсан учраас, няцааж, дарж байжээ. Би өөрийгөө гомдоогүй гэдэгт итгэлтэй

байсан ч, гомдсон байв. Бардам зан миний зүрхний үнэн төрхийг нуужээ.

Үнэн мөнийг олоход бардам зан саад хийнэ. Харааг бүрэлзүүлнэ. Бүх юм сайн гэсэн өнгөлөн далдлах бодол юуг ч өөрчилж чадахгүй. Учир нь бардам зан зүрхийг хатууруулж, ухааны нүдийг бүрэлзүүлнэ. Бардам зан таныг жинхэнэ өөрчлөлт, эрх чөлөө авчирдаг гэмшлээс холдуулна (2Тимот 2:24-26-г үзнэ үү).

Бардамнал таныг хохирогчийн дүрд оруулдаг. Бардамнал “Тэд надад шударга бусаар хандсан, намайг буруугаар шүүсэн. Тиймээс ингэх нь миний зөв” гэх мэтчилэн үйлдлээ өмөөрөх бодолд л хүргэнэ. Та зүрхнийхээ үнэн төрхийг харж чадахгүй ч, Бурханаас *нуугдахгүй*. Тэр таны зүрхний жинхэнэ дүр төрхийг мэднэ. Хүмүүс танд шударга бус хандсан байлаа ч, та гомдох эрхтэй гэсэн үг бас биш. Хоёр буруу нийлээд зөвийг бүтээхгүй!

ЭМЧИЛГЭЭ

Есүс Библийн Илчлэл номд Лаодик дахь чуулганы үнэн дүр төрхийг хэлдэг. Тэд өөрсдийгөө баян, баяжсан тул дутах зүйл ер байхгүй гэж бодсон ч, үнэндээ “хөөрхийлөлтэй, өрөвдмөөр, ядуу, сохор, нүцгэн” (Илчлэл 3:14-20) байжээ. Тэд санхүүгийн давуу талаа, сүнсний давуу талтай андуурчээ. Зүрхний үнэн төрхөө харахад нь бардамнал садаа болжээ тэдэнд.

Өнөөдөр ч ийм хүн олон. Би бусад үйлчлэгч нарт гомдож явснаа харахгүй байсан шиг, олон хүн зүрхнийхээ жинхэнэ төрхийг хардаггүй. Гэтэл өөрийгөө хэрхэн хуурахаа болихыг Есүс Лаодикчуудад зааж өгчээ: Бурханы алтыг худалдаж аваад, зүрхнийхээ үнэн төрхийг харах.

Алт худалдан ав

Өөрийгөө хуурч мэхлэхээс чөлөөлөгдөхийн тулд хамгийн түрүүнд “Надаас галаар цэвэршүүлсэн алтыг аваарай” (Илчлэл 3:18) гэж Есүс заажээ.

Цэвэршүүлсэн алт нь зөөлөн, уян хатан, элдэв хольцгүй байдаг бол, зэс, төмөр, никель гэх мэт бусад металлын бүтэцтэй холилдсон алт өнгө муутай, уян хатан бус, хатуу төлөвтэй

байдаг. Ийм хольцтой алтыг хайлш гэх. Хайлшин дахь алтны хувь хэмжээ нь их байх тусмаа, уян хатан, зөөлөн, өнгөлөг байдаг бол, алтны хувь хэмжээ нь бага байх тусмаа, өнгө муутай, хатуу байна.

Энд зэрэгцээ шугам явж байна: Цэвэр зүрх яг цэвэр алттай адил зөөлөн, уян хатан байдаг. Еврей 3:13 дээр нүглийн мэхлэлээр зүрх хатуурна гэх! Бид гомдлын асуудлаа шийдэхгүй бол, нүглийн үр жимс болох хясах, уурлах, хорсоход хүрнэ. Эдгээр чанар нь бидний зүрхийг чангалж, хатууруулдаг. Яг л хольцтой алт шиг. Үүнээс болж уян зөөлөн чанар, мэдрэмж багасна. Тэгээд Бурханы дуу хоолойг сонсох чадвар маань бартаатай, ялгах хараа маань харанхуйлна. Энэ бол төгс хууран мэхлэлийн дэвсгэр билээ.

Алтыг цэвэршүүлэхдээ нунтаглаад, тусгай шингэнд хийнэ. Тэгээд хольцоо зууханд хийж, эрчтэй галаар хайлуулна. Тэр үед хайлш, бохир нь шингэнд татагдан, хөвж гардаг бол, алт нь (алт илүү хүнд жинтэй байдаг) ёроолдоо тунана. Дараа нь бохир буюу *хогийг* (шингэнтэй холилдсон зэс, төмөр, цинк зэргийг) зайлуулаад, илүү цэвэр металтай үлдэнэ.

Бурханы үгийг харцгаая:

Үзэгтүн, мөнгө шиг биш ч гэсэн Би чамайг цэвэршүүлсэн.
Би чамайг зовлонгийн зуухан дотор шалгасан.
Исаиа 48:10

Мөн ингэж хэлжээ:

Хэдийгээр та нар эдүгээ түр зуур шаардлагатай бол *элдвийн* зовлонг эдэлж байгаа ч гэсэн үүндээ үлэмж баярладаг. Ингэснээр та нарын итгэлийн шалгуур нь *галаар* шалгах боловч мөхөх алтнаас ч илүү үнэтэй байн, Есүс Христийн илчлэлт дээр магтаал, алдар, хүндэтгэлд хүрэх юм.
1Петр 1:6-7

Алтыг цэвэршүүлэхийн адил Бурхан элдвийн зовлон, бэрхшээл, гай гамшгийг ашиглан, бидний сэтгэл зүрхэнд холилдох үл уучлал, тэмцэл, хорсол, уур хилэн, атаархал гэх мэт зүйлээс биднийг цэвэрлэн, Бурханы хүсч буй зан чанарыг л үлдээдэг.

Зовлон бэрхшээлийн галгүй газар гэм нүгэл амархан үүрлэх. Муу хүн ч хөгжин цэцэглэж, баян тарган байхдаа бусдад эелдэг, өгөөмөр харагддаг бол, амьдралын хүнд бэрх өдрүүдэд зүрхнийх нь жинхэнэ төрх ил болно.

Хэзээ ч үзээгүй бэрх өдрүүд надад байсан. Тэр үед би хавийнхаа хүмүүст хатуурхаж, бүдүүлэг аашилдаг байв. Тиймээс ч тэд надаас дөлнө.

Би Эзэнд хандан “Миний хаанаас нь ийм их уур хилэн гараад байна? Миний хаана энэ их уур хилэн байсан юм бэ?!” гэж хашгирч билээ.

Гэтэл Эзэнд надад “Хүү минь, алтыг галаар цэвэршүүлэх үед хольц нь ил болдогтой л адил юм болж байна” гэж хариулж билээ. Тэгээд надад амьдрал өөрчилсөн нэгэн асуулт тавьсан юм: “Галаар шарахаас нааш алтыг гаднаас нь хараад, дотор нь юу байгааг *харж* чаддаг билүү?”

“Үгүй ээ” гэж би хариуллаа.

Бурхан “Харагдахгүй учраас байхгүй гэсэн үг биш” гэж хэлээд, цааш нь:

“Зовлон бэрхшээл чамайг гал шиг шарах үед дотор чинь байсан бохирдол ил гарч байна. Чамд харагдаагүй ч, Надад ил л байсан. Одоо чиний өмнө ирээдүйг чинь шийдэх сонголт байна. Чи юм л бол эхнэр, найз нөхөд, пастор, хамтран зүтгэгч нараа буруутгадаг, ууртай хэвээрээ үлдэх үү эсвэл нүглээ илчлэн гэмшиж, бохиросоо чөлөөлөгдөх үү?” гэж асууж билээ.

Зүрхнийхээ жинхэнэ дүр төрхийг хар

Мэхлэлээс чөлөөлөгдье гэвэл нөхцөл байдлаа зөв тодорхой харах хэрэгтэй гэж Есүс хэлсэн. Гомдсон хүн үргэлж өөрийгөө хохирогчийн дүрд, харин гомдоосон хүнээ буруутны дүрд тавьдаг. Тэр үедээ өөрийнхөө хорсол, үл уучлал, хилэн, атаа жетөөгөө зөвтгөх олон ч шалтгаан олдог. Тэр байтугай таныг гомдоосон хүний талаар *дурссаных* нь төлөө бусдыг эсэргүүцэх ч үе бий. Тийм учраас Есүс “харахын тулд нүдээ тослох нүдний тосыг Надаас худалдан ав” (Илчлэл 3:18) гэжээ. Юуг харах гэж? Үнэн төрхөө! Есүс дараа нь “гэмш” хэмээн тушаасан. Бусдыг буруутгахаа болихгүй юм бол, та үнэн зүрхнээсээ гэмшиж чадахгүй.

Бусдыг буруутгаж, өөрийгөө өмгөөлсөөр байгаа л бол, нүд маань сохор байна л гэсэн үг. Нүдэн дэхь дүнзээ аваагүй байж, нөхдийнхөө нүдэн дэхь үртсийг авна гэж байхгүй. Бид энэ үнэнийг ойлгохоос нааш, эрх чөлөөтэй болохгүй. Бурханы Сүнс биднийг нүглээсээ холдоосой гэсэндээ л нүглийг илчилдэг. Биднийг яллахын тулд бус, харин ойлгуулж ухааруулахын төлөө л тэр.

Би уншигч таныг зүрхнийхээ үнэн төрхийг олж хараад, олон жил хураасан гомдол шархаа тайлаасай гэж үнэн голоосоо хүсэн залбирч байна. Үнэнийг харж, гэмшихэд тээглэгч бардам зангаа таягдаж хая.

ГОМДСОН ИТГЭГЧ АЙДСААСАА БОЛООД НАСАН ТУРШДАА ЧӨЛӨӨТЭЙ БАЙЖ ЧАДАЛГҮЙ АМЬДАРДАГ.

Хорин жил ханилсан нөхөр минь, арван жилийн өмнө “надтай байхдаа аз жаргалгүй байсан” гэдэг шалтгаанаар салсан юм. Би тэр үед цөхрөнгөө барсан юм. Тэр явахдаа миний амьдралд үлдээсэн сэтгэлийн шарх, гологдсон сэтгэл, хэнд ч хэрэггүй мэт болсон мэдрэмжийг амьдралаасаа хаях гэж би их ч зовсон доо. Тэр хүнийг уучлах хүч хайрлаач гэж Бурханд гуйж ч байсан, уучилсан гэж бодож ч байсан. Гэхдээ л үлдээсэн шарх нь сэтгэлд аниагүй л байсан юм. Түүнийг харах болгонд сэтгэл минь өвддөг байлаа. “Сатаны урхи” номыг уншсаны дараа Ариун Сүнс зүрхэнд минь ийм бодол өгсөн юм: Салсан нөхөртөө очоод гомдол тээн явсаныг минь уучлаач гэж гуйх. Арван жилийн дараа анх удаагаа би түүнтэй ярьсан минь энэ. Уулзалтын дараа зүрхний минь шарх аньж, би бүрэн эрх чөлөөтэй болсон гэдэгтээ би одоо ч итгэдэг. Олон жил намайг боолчилсон сөрөг бодлоос намайг чөлөөлсөн Эзэн Бурхандаа би талархаж байна.

D. B., NEW YORK

БӨӨН ГОМДОЛ

Тэр үед олон хүн бүдрэх бөгөөд нэг нэгнээ тушааж, үзэн ядна. Олон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж олныг төөрөлдүүлнэ. Ёс бус байдал өссөнөөс болж олонх хүмүүсийн хайр хөрнө. Харин эцсээ хүртэл тэвчсэн нь аврагдах болно.

Матай 24:10-13

Матай номын энэ бүлэг дээр Есүсийн дагалдагч нар “Таныг ирэхэд ямар шинж үзэгдэх вэ?” гэж асуухад, Есүс дэлхийн төгсгөл үед бий болох шинж тэмдгийн талаар ярьжээ.

Бид Есүсийг ирэхийн өмнөх үед амьдарч байгаа болохоор аль өдөр ирэх талаар маргах нь утгагүй юм. Хэзээ ирэхийг нь зөвхөн Бурхан Аав л мэднэ. Гэхдээ Есүс биднийг тэр улирлыг танина гэсэн бөгөөд тэр улирал ирчихээд байна! Бидний амьдарч буй цагт чуулган, Израиль, байгаль дэлхийн талаар эш үзүүлсэн Есүсийн олон үг биелж байгааг та анзаарч байна уу? Тиймээс л Матай 24-ээр бүлэгт хэлсэнээр, Есүс удахгүй ирэхийг нь бид мэднэ.

Есүсийг ирэхийн өмнө өрнөх нэгэн шинж тэмдгийг анхаарна уу: “Тэр үед *олон хүн* бүдрэнэ” Цөөхөн биш, харин *олон хүн* бүдрэх буюу гомдоно.

Юуны өмнө “Тэдгээр гомдогсод гэж хэн бэ?” асуух хэрэгтэй байх. Энд итгэгчдийн тухай яриад байна уу аль эсвэл нийтийн талаар яриад байна уу? Цааш нь уншвал хэний тухай нь тодорхой болно: “Ёс бус байдал өссөнөөс болж олонх хүмүүсийн *хайр* хөрнө.” (Матай 24:12) Хайр гэдэг нь *аганэ* гэдэг Грек үг юм. Шинэ Гэрээ хайрыг хэд хэдэн үгээр хэлдэг боловч, голдуу *аганэ*, *филео* гэсэн хоёр үгийг хэрэглэдэг.

Филео нь анд нөхдийн хайрыг илэрхийлсэн үг. Энэ нь нөхцөл болзолтой, хариутай хайр. *Филео* хайр нь “Чи надад тусалбал, би чамд тусална” эсвэл “Энэ хүн надад яаж хандана, би түүнд тэгж л хандана” гэдэг хайр юм.

Нөгөөтэйгүүр, *аганэ* хайр нь хүүхдүүдийнхээ зүрхэнд цутгадаг Бурханы хайр болой. Есүсийн бидэнд харамгүй өгдөг тэр л хайр. Энэ хайр болзолгүй хайрладаг. Гүйцэтгэл, тэр бүү хэл хариу - бариу дээр суурилдаггүй хайр. Бүр эсэргүүцээд байхад ч өгсөөр байдаг хайр.

Бурхангүй бол, хүн аминч хайраар л хайрлаж чадна. Хариу хайрлахгүй, хариу барихгүй бол, өгч чаддаггүй хайраар. Харин *аганэ* хайр нь хариу барьсан ч, бариагүй ч, хайрладаг. Есүс загалмай дээр бидний нүглийг уучлахдаа, энэ л *аганэ* хайраа харуулсан. Тиймээс л Есүс “олны” тухай ярихдаа, *аганэ* хайр нь хөрсөн итгэгч хүмүүсийг хэлжээ.

Олон сар хамаг байдгаа зориулан байж хайрласныхаа хариуд хатуу үг, эсэргүүцэл үзэх үе надад байсан. Тэгсээр нэг өдөр би залхсан.

Тэгээд Бурханд “Гүйцээ. Та над хэлээд аль. Би тэр хүнд Таны хайрыг харуулах бүрий өөдөөс маань уур хилэн л чулуудах!” хэмээн гомдоллов.

Бурхан “Жон, чи Бурханы хайранд итгэх итгэлээ хөгжүүлэх хэрэгтэй” гэж хариулсан юм.

“Юу гэсэн үг вэ?” гэж асуулаа.

Тэгтэл Бурхан “Махан биед таригч нь махан биеэсээ ялзралыг хурааж авна” гээд “Сүнсэнд таригч нь Сүнснээс мөнх амийг хурааж авна. Сайныг үйлдэхдээ зүрхшээхгүй байцгаая. Учир нь хэрэв бид шантрахгүй байвал цаг нь болохоор хурааж авна” (Галат 6:8-9-ийг үзнэ үү) хэмээн тайлбарлав.

Бурханы хайрыг таригч нь Бурханы хайрыг хурааж *авна* гэдгийг харж байна уу? Сүнсний энэ хууль үйлчилдэг гэдэгт бид итгэх ёстой. Тарьсан үр минь хүссэн хугацаанд минь хурдан ургахгүй

байлаа ч, үр дүнгээ заавал өгнө гэдэгт бид бат итгэх ёстой. Үүнийг л Бурханы хайранд итгэх итгэлээ хөгжүүлэх гээд байгаа юм.

Эзэн цааш нь “Хамгийн хүнд цагт дотны нөхөр Иудас минь Надаас урваж, Петр Намайг няцааж, бусад нь бүр ор мөргүй болсон. Ганц Иохан л Намайг холоос дагасан. Би тэдэнтэй гурван жил хамт байж, хайрлахын дээдээр хайрлаж, хооллож, зааж сургасан. Даян дэлхийн нүглийн төлөө алуулахдаа, Би тэднийг уучилсан. Би Надаас урвасан нөхдөөсөө авахуулаад Ромын цэргүүдийг хүртэл бүгдийг нь чөлөөлсөн. Тэд надаас уучлал гуйгаагүй ч, Би тэднийг уучилсан. Би Бурхан Аавын хайранд итгэсэн.

Би тэдний дотор хожим хаанчлалын олон хөвгүүд, охидоос хурааж авах хайрыг тарьсан учраас л, үүнийг мэдэж байсан. Хайрын тахилын маань улмаас тэд Намайг хайрлах байсан.

Би тэдэнд “Дайснаа хайрла, хараагчийг ерөө, үзэн ядагчид сайныг үйлд, ашиглагч эсвэл хавчигч хүний төлөө залбир. Үүгээрээ чи Бурханы хүү гэдгээ харуулна. Бурхан Аав чинь хүмүүсийг сайн, муу гэж ялгалгүй, зулай дээр нь нарыг мандуулж, хурын усаар ундаалан ерөөдөг юм” гэж заасан.

“Хэрэв та нар өөрсдийг чинь хайрладаг хүмүүсийг хайрлавал, та нарт ямар шагнал байх вэ? Татвар хураагчид ч хүртэл үүнтэй адилыг хийдэг бус уу? Хэрэв та нар зөвхөн ах дүүстэйгээ мэндэлбэл, бусдаас илүү юу хийж байгаа юм бэ? Харь үндэстнүүд ч хүртэл мөн ингэдэг бус уу?” (Матай 5:44-47) гэж билээ.

ТОМ ХҮЛЭЭЛТ

Миний өгч байгаа хайр Сүнсээр тариалагдаж байгаа бөгөөд эцэстэй би тэр хайрын үрээ хурааж авахаа ойлгов. Хаанаас гэдгийг нь мэдэхгүй ч, ургац гарахдаа л гарна. Үүнийг ойлгосныхоо дараа нөгөө хүн хариу хайрлахгүй байсан ч, би үүнийг бүтэлгүйтэл гэж үзэхээ больж билээ. Энэ маань намайг нөгөө хүнийг бүр ч ихээр хайрлах эрх чөлөөтэй болгов!

Үүнийг итгэгч хүмүүс ойлгобол, бууж өгөхгүй бас гомдохгүй байх сан. Энэ бол хүний амьдардаг тэр хайр биш юм. Хүн - бид хүлээлт маань биелэхгүй бол, дороо гутардаг аминч хайраар л амьдардаг.

Хүлээлт тавьж байсан хүн маань навс гомдоох үе надад байсан. Хэдий чинээ хүлээлттэй байна - төдий чинээ том гомдоно.

Тэгвэл албатай учраас бус, зүгээр л ерөөе гэсэн хүнээсээ би юу ч горьдож хүлээхгүй. Харин харилцаатай хүмүүсээсээ тодорхой нэг үйлдэл шаардах үедээ бид гомдолд нээгддэг. Хүлээлт том байх тусам - төдий чинээ гомдоно.

ХАМГААЛАХ ХАНА?

Гомдсон ах дүүг буцаж эргүүлэх нь хүчирхэг хотыг эзлэн авахаас ч илүү хэцүү. Хэрүүл маргаан нь шилтгээний түгжээтэй хаалга мэт ажээ. Сургаалт үгс 18:19

Гомдсон ах, эгч дүүсийн сэтгэлийг эргүүлж авах нь бэхлэгдсэн хотыг эзлэхээс ч бэрх. Бэхлэлт хот хүчирхэг хана хэрмээр хамгаалагдсан байдаг. Хана хэрэм нь урилгагүй зочид, дайснаас хамгаалах зорилготой. Бүгд шалгангаар дамжиж байж нэвтэрнэ. Татвараа төлөөгүй хүн төлтлөө нэвтэрч чадахгүй. Хотод аюултай хүмүүсийг ч нэвтрүүлэхгүй.

Хүн гомдсон үедээ зүрхээ хамгаалж байна гээд яг ийм хана хэрэм босгодог. Тэд дахиад зүрхээ шархлуулчих бий гэж айсандаа, хүмүүстэй тун болгоомжтой харилцах. Ачийг маань хариулах ёстой хүн хариу барьтал нь хаалга үүдээ хаадаг. Тийнхүү бид өөрийнхөө талынханд л үүдээ тайлдаг хүн болж хувирна.

Гэвч “манай талынхан” ч гомдож болно. Гэх маягаар гомдол зузаарах бүрий хана хэрэм ч ургасаар, нэг л мэдэхнээ өөрийг маань хорих шорон болж хувирсан байна. Ийнхүү гаднаас ч хүн нэвтрэхгүй, дотроос ч өөрөө гарахгүй.

Гомдсон итгэгчдийн харц үргэлж дотогш чиглэнэ. Өөрийнхөө ашиг сонирхол, хувийнхаа харилцаанд л анхаарна. Хамаг анхаарлаа дахиж гомдохгүй байхад л тавина. Хэрэв бид гомдохгүй байх ёстой гэсэн нөхцөл тавьж бусадтай харилцдаг болчихбол, болзолгүй хайрын тухай бодоод ч хэрэггүй. Учир нь болзолгүй хайрлах нь бусдад өөрийгөө гомдоох *эрхийг* олгох явдал юм.

Хайр хэзээ ч амиа эрдэггүй. Гэтэл гомдсон хүн улам л амиа эрж, амиа бөөцийлдөг. Ингэж л хайр хөрдөг. Израилийн Галил нуур цутгал, урсгалтай учраас, тэнд амьдрал цэцэглэж, загас жараахай, ургамал ногоогоор дүүрэн. Галил нуур Иордан голд цутгаж, Иордан гол нь Мөхсөн тэнгист цутгадаг. Мөхсөн тэнгис нь цутгалтай болов ч, урсгалгүй. Тиймээс тэнд амьд амьтан,

ургамал байхгүй. Амьдрал цэцэглэдэг Галил нуурын цутгал Мөхсөн тэнгист хүрээд, амьгүй болдог шалтгаан нь Мөхсөн тэнгис гадагшаа урсгал, цутгалгүй байдагтай холбоотой. Үүний адил амьдралаас, бусдаас сайн сайхныг хүлээн авсан бол, түүнийгээ бусдад ч өгөөрөөр өгөх учиртай.

Тэгвэл гомдсон итгэгч хүн амь аваад байгаа хэрнээ айдсаасаа болоод өгч чаддаггүй. Үүнээсээ болоод амьтай атлаа гомдлынхоо шоронд буюу ханан дотроо гацаастай. Шинэ Гэрээн энэ хана хэрмийг бат цайз гэдэг:

Учир нь бидний байлдааны зэвсэг бол махан биеийнх биш, харин цайзуудыг эвдэж нураах Бурханы хүчит зэвсгүүд юм. Бид цэцэрхэл болон Бурханы мэдлэгийн эсрэг босогч аливаа өндөрлөг зүйлийг устгаж, ямар ч бодол санааг Христийн дуулгавартай байдалд олзлуулдаг. 2Коринт 10:4-5

Энэ бат цайз нь бидний мэдээллийг боловсруулах учирлан ойлгох ухааны үлгэр загварын тогтоц юм. Уг нь анх хамгаалах зориулалттай байдаг ч, Бурханы мэдлэг юмуу Бурханыг таньж мэдэх явдалтай тэмцэлддэг учраас, тамлал, завхралын эх үүсвэр болж хувирдаг.

Бид бүхнийг өнгөрснийхөө шарх, бүтэлгүйтэл, туршлагаар нэвтрүүлэхдээ, Бурханд итгэх боломжгүйг ойлгодог. Бид Түүний үгд үг гэж итгэдэггүй. Бид Бурханыг амьдралд маань тогтоосон хэн нэг этгээдийн жишгээр шүүдэг учраас, сайнд нь, итгэмжтэйд нь эргэлздэг. *Гэтэл Бурхан хүн биш!* Бурхан худал хэлж чадахгүй (Тооллого 23:19). Түүний зам бидний зам биш, Түүний бодол бидний бодол биш (Исаиа 55:8-9).

Гомдсон хүмүүс байр сууриа хамгаалах Бичээсийг олж чаддаг ч, энэ нь Бурханы Үгийн зөв хэрэглээ биш юм. Хайр байхгүйгээр Бурханы үгийг мэдэх явдал нь бардамнал, хуульчлал хоёроор хийлэгддэг учраас, сүйрүүлэх аюултай (1Коринт 8:1-3). Энэ нь биднийг үл уучлалаа гэмшихэд бус, харин өмөөрөхөд хүргэдэг.

Бурханы хайр үгүй мэдлэг нь мэхлэлд хүргэдэг учраас, энэ бүхэн нь биднийг мэхлэгдэх уур амьсгалыг бүрэлдүүлнэ.

Олон хүн гомдоно гэж хэлсэн хойноо Есүс: “Олон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж олныг төөрөлдүүлнэ” (Матай 24:11) гэсэн. Тэдгээр мэхлэгдэх хүмүүс нь хэн бэ? Хайр нь хөрсөн гомдогсод шүү дээ (Матай 24:12).

ХУУРАМЧ ЭШ ҮЗҮҮЛЭГЧ НАР

Есүс хуурамч эш үзүүлэгчийг “хонины арьс нөмөрсөн чоно” (Матай 7:15) гэсэн. Тэд (хонины арьс нөмөрч) итгэгчдийн дүр эсгэв ч, дотроо бол чоно. Хаана хонь байна - тэнд чоно байна. Тэд индэр дээр ч, сандал дээр ч байна. Тэд мэхлэж, шүүлтүүргүй болгохын төлөө илгээгдсэн, дайсны гар хөл. Тэднийг сургаал, эш үзүүллээр нь бус, үйлс, үр жимсээр нь таних ёстой. Тэд гоё ярьдаг ч, амьдрал үйлчлэлдээ гоё үр жимс гаргадаггүй. Номлодог бус, *амьдардаг* хүнийг л Христэд итгэгч буюу үйлчлэгч гэдэг юм.

Чоно сүргийн эрүүл, хүчтэй рүү нь дайралгүй, сул дорой, нялх нойтныг нь онилно. Ийм чонууд хүнд *хэрэгтэй* юмыг нь бус, сонсох *дуртай* юмыг нь ярьж өгдөг. Тэр хүмүүс эрүүл доктриныг бус, чихэнд чимэгтэй үгийг л хүсдэг. Паул сүүлчийн өдрүүдийн талаар ингэж хэлсэн:

Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ гэдгийг мэдэж ав. Учир нь хүмүүс... үзэн ядагчид, ... бурханлаг байдлын дүртэй байх боловч түүний хүчийг нь үгүйсгэдэг (болно). Чи ийм хүмүүсээс зайлсхийж яв ... Цаг нь ирнэ. Хүмүүс эрүүл сургаалыг тэвчихгүй болж, харин хүсэл нь тэдний чихийг гижигдэн, өөрсдийн хүслийн дагуу өөрсөдөө багш нарыг бөөгнөрүүлэх бөгөөд тэдний чих үнэнээс эргэж, үлгэр домгуудад хандах болно. 2Тимот 3:1-5; 4:3-4

Тэд бурханлаг буюу “Христэч” дүртэй боловч, хүчийг нь үгүйсгэнэ гэснийг тэмдэглээрэй. Яаж хүчийг нь үгүйсгэх билээ? Христ тэднийг үл уучлагчаас уучлагч болгон өөрчилж чадна гэдгийг няцаана. Тэд Есүсийн дагалдагч гэдгээрээ онгирч, “шинээр төрснөө” мэдэгдэв ч, үүгээрээ Христийн зан чанарыг төрүүлэхийн төлөө зүрхээ өвчүүлэхгүй.

МЭДЭЭЛЛИЙН ҮЕИЙНХЭН

Мэдлэгтэй хөөцөлдөв ч, сурсан зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхгүй учраас, амьдрал нь өөрчлөгдөхгүйг Паул хэдийн эш үзүүлэн бичжээ: “Тэд үргэлж суралцав ч, үнэний мэдлэгт хүрдэггүй” (2Тимот 3:7).

Паул өнөөдөр бидэн дээр ирсэн бол, хэлснээр нь болсон байхыг үзээд ямар их гашуудах бол. Итгэгч хүмүүс хэдэн зуу, мянгаараа Бурханы үгийн мэдлэгт хүрэх гэж өвөл зуны амралт, сургалт, семинар, конференцэд сууж байхыг Паул үзнэ. Улам илүү аминч, амжилттай амьдрах гэсэндээ “шинэ илчлэлтэй” хөөцөлдөж байхыг нь ч харна. Пасторууд “үнэний төлөө” нэг нэгтэйгээ шүүхдэлцэж байхыг ч үзнэ.

Христэч радио станц, хэвлэлийн газрууд Бурханы эрчүүд, эмэгтэйчүүдийг нэрээр усаар нь дуудаж байгаад, доромжлохыг үзэх байсан. Эзэнд итгэдэг гэдэг Карисматикууд уучлахаас татгалзсандаа, гомдлоос бултахын тулд сүмээс сүм хэсч явахыг үзнэ. Паул “Амиа бодсон хоёр нүүртнүүд ээ, гэмшиж, заль мэхээс чөлөөлөгд!” гэж бархирах байсан байх.

Та хичнээн сүүлийн үеийн семинар, Библийн сургуулиас шинэ илчлэлт авч, хичнээн ном уншиж, хичнээн цаг залбирч, суралцсан чинь хамаагүй. Та гомдоод, үл уучилсандаа нүглээ гэмшихгүй яваа бол, үнэний мэдлэгт хүрээгүй байна. Та өөрөө ч мэхлэгдсэн бөгөөд бусдыг ч хоёр нүүртэй амьдралаараа самууруулж байна. Ямар илчлэл авсан чинь хамаагүй - үр жимс чинь өөрийг өгүүлж байна. Та үнэнийг бус, худлыг гаргадаг гашуун усны ундарга болно.

УРВАЛТ

Тэр үед олон хүн *бүдрэх (гомдох)* бөгөөд нэг нэгнээ тушааж, *үзэн ядна*. Матай 24:10

Энэ үгийг дэлгэрүүлж үзье. Энд дамжлага өрнөж байна. Гомдол урвалтад, урвалт нь үзэн ядалтад хүргэх.

Гомдсон хүн хана хэрэм барьдаг тухай ярьсан. Бид өөрийгөө хамгаалахад л анхаардаг болно. Энэ нь урвалтад бэлэн болгоно. Бид урвахдаа, бусдыг буюу мэдээж таньдаг, мэддэг хүнээ золионд гаргаад, өөрийнхөө эрх ашгийг хамгаалдаг.

Ийнхүү итгэгч хүн өөр нэг итгэгчийг золионд гаргаад, өөрийнхөө биеэ, эрх ашгаа хамгаалах үед Бурханы хаанчлал дотор урвалт явагдана. Ойрын хүн байх тусам - урвалт аймшигтай байна. Урвалт нь гэрээгээ бүрэн нулимж байгаа явдал. Урвасан тохиолдолд - жинхэнэ гэмшил байхгүй бол, харилцаа сэргэхгүй.

Урвалт нь ноцтой үр дагавартай үзэн ядалт болж хувирдаг. Ах дүүгээ үзэн яддаг хүн алуурчинтай адил бөгөөд ийм хүний дотор мөнх амь үгүйг (1Иохан 3:15) Библи тодорхой хэлсэн.

Гэтэл өнөөдөр итгэгчдийн дунд гомдол, урвалт, үзэн ядалтын жишээ тасрахгүй байгаа нь даанч харамсалтай. Гэр бүл, сүм чуулганд нэг үзэгдэл бараг л ижил дасал болжээ. Пасторууд шүүхдэлцэхэд бид гашуудахаа больсон. Итгэдэг хосууд ч шүүхээр гэр бүлээ цуцлуулахад бид гайхахаа больсон. Чуулганд хагаралдаж, хуваагдаж л байдаг. Үйлчлэлийг улс төржүүлэх явдал ч хүчээ авсан. Үүнийг бараг л хаанчлалд юмуу чуулганд ашигтай гэж үзэх.

“Христэд итгэгч нар” бусад итгэгч нарт ашиглуулахгүй, гомдол авахгүй гэмээн эрхээ хамгаална. Бид Шинэ гэрээний ятгалгыг умартав уу?

Үнэн хэрэгтээ та нар бие биетэйгээ заргалдаж буй нь та нарын хувьд аль хэдийн сүйрэл мөн. Харин ч яагаад буруутгагдаж болдоггүй юм бэ? Харин ч яагаад мэхлэгдэж болдоггүй юм бэ? 1Коринт 6:7

Бид яахаараа Есүсийн үгийг мартаж чадав аа?

Харин Би та нарт хэлье. Дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир. Матай 5:44

Бид яахаараа Бурханы тушаалыг мартаж орхив оо?

Юуг ч өрсөлдөх сэтгэлээр, эсвэл бардам зангаар бүү хий. Харин даруугаар бие биеэ өөрөөсөө дээр гэж үзэж Филиппой 2:3

Бид яагаад хайрын хуулиар амьдрахгүй байна? Хууртсан байсан ч хамаагүй, бие биеийнхээ төлөө амиа зориулахын оронд яагаад юу юугүй урвадаг болов? Хайр хөрч, амиа эрдэг болсон учраас л тэр. Бид амиа бөөцийлөхдөө, өөрийгөө Бурханд бүрэн даатгаж чаддаггүй.

Есүсийг буруутгах үед Тэр бусдыг буруутгалгүй, сүнсээ жинхэнэ шүүгч Бурхан Аавдаа л даатгасан. Биднийг Түүний мөрөөр явахыг анхааруулсан.

Учир нь та нар энэхүү зорилгын төлөө дуудагдсан билээ. Яагаад гэвэл та нарыг Өөрийнхөө мөрөөр дагуулахын тулд та нарт үлгэр дуурайллыг үлдээн, Христ та нарын төлөө зовлон эдэлсэн. Тэр нүгэл үйлдээгүй, Түүний аманд ямар ч заль мэх олдоогүй. Тэр зүхэгдэж байхдаа, хариуд нь зүхээгүй. Тэр зовон тарчилж байхдаа заналхийлээгүй, харин шударгаар шүүдэг Нэгэнд Өөрийгөө даатгасаар байлаа.
1Петр 2:21-23

ЧАДАЛ ХАЙРЛАГЧ

Бид биедээ бус, Бурханд л найдах тэр газарт очих ёстой. Олон хүн амаараа Бурханыг эх үүсвэрээ гэдэг ч, өнчин хүүхдүүд шиг л амьдардаг. “Тэр бол миний Бурхан, миний Эзэн” гэх атлаа амьдралаа өөрөө атгасаар л.

Гомдлын *нүгэл* хичнээн ноцтой болохыг одоо ойлгов уу? Гомдлыг шийдвэрлэхгүй бол, үхэлд хүргэнэ. Гомдоох өдөөлтийн нүглийг эсэргүүцбэл, Бурхан ер бусын ялалт авчирна!

ХЭРЭВ ЧӨТГӨР БИДНИЙГ ДУРТАЙ ЦАГТАА УСТГАЖ ЧАДДАГ БАЙСАН БОЛ АЛЬ ХЭДИЙНЭЭ АРЧААД ХАЯЧИХ БАЙСАН.

Энэ номыг уншихаасаа өмнө би Бурхантай харилцаагүй байсан юм. Би аврагдсан ч гэлээ, Бурхан бид хоёрын хооронд ямар нэг юм тээглээд байдаг байв. Эзэний талаас ямар ч буруу байхгүйг мэддэг байсан ч, миний талаас чухам юуг буруу хийснээ ухаардаггүй байв. Нэг өдөр найз минь Жон Бивэрийн “Сатаны урхи” номыг бэлэглэсэн юм. Гэртээ очоод номоо уншлаа. Урьд нь уншиж байгаагүйгээрээ л уншив. Миний сүнс энэ номын хуудас бүрээс хэрэгтэй хоолоо идэх мэт шимтэж байлаа. Номын тэг дунд ороод гэнэтхэн нөгөөх тээглээд байсан юмаа олж харав. Энэ бол гомдлын сүнс байлаа.

- С. С., GEORGIA

З

ЯАХААРАА НАДАД ИЙМ ЗҮЙЛ ТОХИОЛДДОГ БАЙНА АА?

Иосеф тэдэнд хандаж

— ... *Та нар намайг хорлох гэсэн боловч Бурхан ...
түүнийг сайнаар эргүүлсэн юм.*

Эхлэл 50:19-20

Нэгдүгээр бүлэгт бид гомдсон хүмүүсийг: 1). Жинхэнээсээ хохирсон хүмүүс. 2). Өөрийгөө хохирогчид тооцох үл хохирогсод хэмээн хоёр ангилсан. Энэ бүлгээрээ эхний хүмүүсийн талаар ярьмаар байна.

Нэгэн асуултаар эхэлье: “Та үнэхээр хохирсон байлаа ч, гомдох эрхтэй юу?” Үүнд хариулахын тулд Иаковын хайртай хүү Иосефийг харъя. (Эхлэл 37-38-ыг үзнэ үү)

АЙМШИГ БОЛСОН ЗҮҮД

Иосеф Иаковын арван нэгдүгээр хүү байв. Аав нь түүнийг аминчилж, алаг дээл авч өгсөн явдалд ах нар нь эгдүүцэж, Иосефийг нүд үзүүрлэв. Бурхан Иосефт хоёр зүүд өгчээ. Эхний

удаа тэрбээр юүжилсэн тариа үзжээ. Түүний юүжилсэн тариа босоо зогсоход, түүнд нь ах нарынх нь юүжилсэн тарианууд мөргөв. Хоёр дахь зүүдэндээ Иосеф нар, сар, арван нэгэн од (Эдгээр нь аав, ээж, ах нарыг нь төлөөлнө) өөрт нь мэхийхийг үзсэн. Тэрбээр энэ зүүдээ ах нартаа хэлсэнд, ах нар нь баярлалдах нь бүү хэл, харин ч бүр үзэн ядсан.

Төдөлгүй арван ах нь аавынхаа сүргийг бэлчээхээр явжээ. Аав нь ах нарыг нь эргүүлэхээр Иосефийг араас нь явуулав. Ах нар нь Иосефийн барааг үзээд “Мөнөөх зүүдлэгч чинь айсуу. Түүнийг хорооё! Тэгээд зүүд нь яахыг харья! Биднийг захирах санаатай. Үхсэн хүн яаж захирахыг үзье!” хэмээн хуйвалджээ. Тэгээд гүнзгий нүхэнд хаяад, дүүгээ араатанд идүүлжээ хэмээн аавдаа итгүүлэхийн тулд дээлийг нь тастаад, амьтны цусанд хуггажээ.

Ах нар Иосефийг нүхэнд хаясан хойноо Египетийг зорих Ишмаелын жинчидтэй таарчээ. Тэгтэл Иуда: “Ах дүүс минь, сонсооч! Бид түүнийг нүхэнд хаячихбал ямар ч ашиг тусгүй. Харин боол болгоод зарчихбал, хөөрхөн мөнгөтэй болчихно. Тэр ч үхсэнээс ялгаагүй болж, бидэнд дахиж төвөг учруулахгүй. Түүний хувь ч биднийх болно!” гэж хэлжээ. Тийнхүү тэд дүүгээ хорин мөнгөн шекелээр худалдав. Тэд Иосефт гомдсондоо урваж, гэр бүл, өв хөрөнгөөс нь салгажээ. Иосефийг ингэтэл хорлосон хүмүүс нь түүний яс махны тасархай - төрсөн *ах нар* нь байсныг бүү мартаарай.

Америкчууд бид соёлын ялгаанаасаа болоод тэр эрчүүд ямар харгис хэрэг үйлдсэнийг ойлгохгүй байж мэдэх. Тэд дүүгийнхээ амиас бусдыг нь авчээ. Библийн цагт хүүтэй байх нь амин чухал байв. Хөвгүүд аавынхаа нэр алдрыг залгамжилж, өв хөрөнгийг нь өвлөнө. Иосефийн ах нар дүүгээ энэ бүхнээс нь хагацаажээ. Тэд Иосефийн нэрийг хугалж, нэр ч үгүй, ус ч үгүй, юу ч биш болгожээ. Иосефт байсан бүхэн өдгөө байхгүй болов.

Гадаад руу боолчлогдсон хүн үхэн үхэтлээ боолоороо үлдэнэ. Гэрлэх эмэгтэй нь ч боол болж, үр хүүхэд нь ч боол болно!

Боол болж төрөх хэцүү ч, аугаа ирээдүйтэй баян өв залгамжлагч болж төрчихөөд, хамаг бүхнээсээ хагацахтай харьцуулахад, гайгүй. Иосеф анхнаасаа л боол байсан бол арай амар байхсан. Гэтэл тэр яг л амьд үхдэл шиг болжээ. Магадгүй тэр “Үүний оронд ах нар минь намайг алчихсан бол...” гэж бодоо байх. Товчхондоо, Иосефийн ах нар дэндүү харгис хэрэг үйлджээ.

ЭРГЭЖ БОДОХ БОДОЛ

Та Иосефийн түүх хэрхэн төгссөнийг нь мэднэ. Үр дүнг нь мэддэг хүний хувьд энэ нь урам зоригийн түүх юм. Харин Иосефийн хувьд ийм байгаагүй. Түүний хувьд аавтайгаа хэзээ ч уулзахгүй, Бурханаас өгөгдсөн зүүд хэзээ ч биелэхгүй мэт харагдаж байсан. Иосеф харь улсад зарагдсан боол, харь хүний эзэмшил болжээ.

Иосеф Фараоны хамгаалалтын албаны дарга Потифар гэдэг хүнд зарагдаж, тэднийд арав гаруй жил зарцлагдав. Энэ хугацаанд тэрбээр ар гэрээсээ ямар ч сураггүй, аав нь түүнийг үхсэн гэж бодож байгааг ч ойлгосон. Гэр бүл нь түүнгүйгээр аж төрж л байсан. Аав нь түүнийг аварна гэсэн ямар ч найдвар байгаагүй.

Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр Иосеф эзнийхээ тааллыг олж, ивээлд нь багтаж, эзэн нь ч түүнийг гэрийнхээ даамлаар томилжээ.

Иосефийн амьдрал ийнхүү нааштай эргэж байтал, эзнийх нь гэргий нэгэн зүйлийг сэдэж байлаа. Тэрбээр Иосефийг таалж, түүнтэй унтахыг хүсчээ. Тэрбээр өдөр бүр Иосефийг хоргоож, Иосеф ч өдөр бүр түүнээс зугтаж байлаа. Нэг өдөр тэднийг хоёулхнаа гэргээ байтал, эзэгтэй нь Иосефийг буланд шахаж, өөртэй нь хэвтэхийг хүсчээ. Иосеф ч татгалзаж, санд мэнд гарч зугтахад, эмэгтэй бэлхүүснийх нь ороолтыг зуурсаар хоцрохдоо, шарандаа “Хүчин!” гэж чарлажээ. Потифар Иосефийг Фараоны гянданд хийв.

Фараоны гяндан өнөөгийн Америкийн шоронгоос газар тэнгэр шиг ялгаатай. Би хэд хэдэн шоронд үйлчлэхдээ, шорон гэдэг ямар аймаар газар болохыг харсан. Гэхдээ Америкийн шорон Египетийн гяндангийн дэргэд цэнгэлийн дээд байх. Египетийн гяндан бол ёлтойх ч гэрэлгүй, дасгал хийх ч газаргүй, гэрэл дулаангүй хар нүх, хавчиг өрөө. Нөхцөл нь аймшигтай төдийгүй, хүний ёсноос гажсан. Хоригдлуудыг амьтай төдий байлгахын тулд (1Хаад 22:27) талх усханаар залгуулж, амьдаар нь тамлаж, голтой нь хатаадаг байв.

Иосефийг гинжилж, дөнгөлсөн байсныг Дуулал 105:18 хэлдэг. Ийнхүү түүнийг үхэхийг хүлээж байв.

Иосеф Египет хүн байсан бол, суллагдах боломж гарч мэдэх байжээ. Гэтэл хүчингийн хэрэгт яллагдсан гадаад боолд суллагдах ямар ч боломж байгаагүй. Иосефт одоо үхэх л дутаж байв.

Ийм хар гянданд байгаа Иосефийн бодлыг та сонсож байна уу? *“Би Эзэндээ арван жил морь, нохой мэт зүтгэсэн.*

Гэргийгээс нь ч илүү үнэнч байсан. Би завхайрах нүглээс өдөр бүр зугтаж, Эзэн Бурхандаа болоод гэрийн эзэндээ үнэнч үлдсэн. Үүнийхээ төлөө хүртэх хувь маань шорон юм гэж үү?

Сайныг үйлдье гэхээр улам дорддог болтой! Бурхан яаж ийм зүйл зөвшөөрч чадав аа? Ах нар маань яаж надаас Бурханы амлалтыг дээрэмдэж чадав аа? Бидэнтэй гэрээ байгуулсан аугаа Бурхан миний төлөө яагаад юу ч хийсэнгүй вэ? Бидэнд хайртай, итгэмжтэй Бурхан Өөрийнхөө зарцын төлөө гар хумхилаа гэж үү? Яагаад би гэж? Би ийм хувь тавилан хүртэхээр юу хийсэн юм? Би Бурханы амлалтанд л итгэсэн шүү дээ.”

Иосеф иймэрхүү бодолтой тэмцэлдэж байсан гэдэгт би итгэлтэй байна.

Түүнд эрх чөлөө гэж байхгүй ч, түүнд тохиолдсон бүхэнд хэрхэн хандах сонголт нь байв. Тэрбээр ах нартаа хорсож, Бурханыг зүхсээр амлалтын бүх найдвараа гэж, амьд үлдэх сүүлийн шалтгаанаа хаях уу?

Бурхан үнэхээр бүхнийг хянадаг уу?

Бурхан түүнийг хамаг Египетийн захирагч болгохоор бэлгэж буй нь энэ, тэрбээр урвагч ах нарынхаа дээр эрх мэдлээ тогтооно гэдгийг Иосеф эцсээ хүртэл төсөөлөө ч үгүй гэдэгт би итгэл төгс байна. Иосеф туулсан зовлонгоороо дуулгавартай байхыг сурчээ. Ах нар нь ердөө л Бурханы мутрын нарийн зэмсэг байж. Иосеф зорилгоо биелтэл Бурханыг хайсаар, амлалтыг нь зуурсаар байж чадах болов уу?

Магадгүй Иосеф зүүдээ Бурхан түүнийг таалсны баталгаа гэж бодсон байх. Гэхдээ эрх мэдэл нь тусгаарлахын тулд бус, харин үйлчлэхийн тулд байдгийг тэрбээр сураагүй байж. Бид сургагдах үедээ Бурханы ямар аугаа вэ гэж харахаасаа илүү боломжгүй нөхцөл байдлаа л хардаг. Тэгээд цөхрөхдөө яллах хүн хайгаад, ийм байдалд оруулсан хүнийг хайж эхэлдэг. Чадах байсан атлаа зовлонгоос гэтэлгэсэнгүй гэж Бурханыг буруутгадаг.

Иосеф “Би Бурханы үгээр л амьдарсан. Би Бурханы байр суурь, мөн чанарын эсрэг нүгэл үйлдээгүй. Бурханы өгсөн зүүдийг л хэлсний төлөө ах нар минь надаас урваж, боол болгож зарсан! Аав минь намайг амьд гэдгийг мэдэхгүй учраас, Египетэд ирэхгүй” хэмээн байн байн бодоо байх.

Иосефийн хувьд хэргийн эзэд нь ах нар нь байв. Тэднээс

болж л Иосеф гянданд орсон. Магадгүй Иосеф Бурхан түүнийг зүүдэнд нь үзүүлсэн эрх мэдлийн байр сууринд тавьж, тэрбээр эрх хүчтэй хүн болсон бол, юмс яаж эргэхийг ургуулан бодоо л байх. “Тэд миний ирээдүйг ингэж баллаагүй байсан бол, бүх зүйл тэс өөр байх байсан.”

Ах, эгч дүүс маань яг ийм буруутгалын урхинд байнга унадаг. Жишээлбэл:

“Эхнэрээс болж л би үйлчилж чадсангүй. Тэр л саад хийж, мөрөөдлийг маань булшилсан.”

“Аав, ээжээс болоогүй бол, би өнөөдөр хүн шиг л аж төрж явах байлаа. Тэд л намайг ийм болгосон. Яахаараа хүмүүс хүн шиг аав, ээжтэй, яахаар би ийм аав, ээжтэй болчихдог юм? Аав, ээж хоёр салаагүй байсан бол, би ч өнөөдөр салахгүй амьдрах байсан.”

“Пастор миний бэлэг авъяасыг хориглоогүй байсан бол, би өнөөдөр эрх чөлөөтэй үйлчилж явах байлаа. Түүнээс болж би хувь тавилангаа биелүүлээгүй. Тэр л чуулганы хүмүүсийг миний эсрэг тухирсан.”

“Салсан нөхөр маань олигтой байсан бол, би хүүхдүүдтэйгээ санхүүгийн асуудалд орохгүй байх байлаа.”

“Тэр чуулганы хүүхнээс болж би удирдагч нарынхаа тааллыг алдсан. Түүний хов жив л намайг нэр хүндгүй болголоо.”

Энэ жагсаалт эцэс төгсгөлгүй хөвөрнө. Өөрийнхөө асуудалд өрөөлийг яллаж, тэр хүн л байгаагүй бол, хамаг зүйл чинь хачин сайхан байх байсан талаар төсөөлөх амархан. Таны гомдол, шарх тэднээс л болсон.

Гэхдээ би дараах зүйлийг тодруулмаар байна: *Ямар ч эрэгтэй, эмэгтэй нь, хүүхэд, чөтгөр нь таныг Бурханы хүслээс гаргахгүй! Таны хувь тавиланг Бурхан л атгадаг.* Иосефийн ах нар Бурханаас Иосефт өгсөн зүүдийг сөнөөх гэж оролдсон. Тэд Иосефийг зүйл дуусгалаа гэж санасан: “За, одоо цөмөөрөө нааш ир! Түүнийг алж, энэ нүхний нэгэнд хаяад, ... зүүд нь яахыг харцгаая” (Эхлэл 37:20). Тэд Иосефийг сүйрүүлэхийг хүссэн. Энэ нь тохиолдол бус, санаатай хэрэг байсан! Тэд түүнийг багтай зүйл дуусгажээ.

Ах нар нь Иосефийг зарах үед тэнгэрийн Бурхан Аав нь Хүү, Ариун Сүнс хоёр руугаа хараад: “Яадаг билээ? Тэдний юу хийснийг хараач. Иосефт хандсан төлөвлөгөөг маань сүйрүүлэв. Даруй нэг санаа олъё. Бидэнд жоор төлөвлөгөө байгаа билүү?” гэсэн гэж бодож байна уу?

Гэтэл олон итгэгч тэнгэрт яг ийм явдал болдог юм шиг л авирладаг. Аав нь Есүст “Есүс ээ, нэг итгэгч нөхөр нь худлаа хэлснээс болоод Жим ажлаасаа халагдчихлаа. Одоо яах уу? Чамд танил тал байна уу? Эсвэл “Есүс ээ, цаад Салли чинь 34 хүрчихлээ. Гэрлүүлчих хүн байна уу? Түүнтэй гэрлүүлэх гэж байсан залуу нь Саллигийн сайн найзтай нь гэрлэчихлээ. Тэр найз нь Саллигийн талаар цуу дэгдээж, залууг нь өөртөө урвуулчихаж” гэж хэлдэг гэж бодож байна уу? Инээдтэй сонсогдож байгаа ч, бид Бурханыг яг ингэдэг юм шиг л авирладаг.

Иосеф хэрэв өнөөгийн чуулганы хүмүүс шиг байсан бол, яах бол доо. Тэр өнөөгийн бидэн шиг байсан бол, яах байсан бол? Өшөө авах төлөвлөгөө боловсруулна. “Миний гарт ордог л юм бол, ална даа! Хийсэн хэргийнхээ төлөө хариугаа авна аа, та нар!” гэсэн бодлоор өөрийгөө өмөөрөх байсан.

Гэхдээ Иосеф ийм хандлагатай байсан бол, Бурхан түүнийг гянданаас гаргахгүй! Тэр яг ийм бодолтой шоронгоос гарсан бол, Израилийн арван аймгийн тэргүүнийг хороох байв. Тэдний дунд хожим Христийг төрүүлэх угсааны тэргүүн Иуда ч байх байв.

Тийм ээ, Иосефт хүншгүй хандсан тэдгээр хүмүүс Израилийн өвөг болсон! Гэтэл тэднээс үндэстэн мэндлэхийг Бурхан Абрахамд амласан байв. Тэднээр дамжин эцэстээ Эзэн Есүс мэндлэх байв! Иосеф гомдоогүй тул түүнд болоод ах нарт нь хандсан төлөвлөгөө бүтжээ.

ҮҮНЭЭС ДОР ЮМ ГЭЖ ХАА БАЙХАВ?

Гяндан Иосефийн хувьд шигшигдэх цаг байсан ч, нөгөөтэйгүүр бас боломж байв. Иосефтэй хамт хоригдож байсан хоёр хүн тун жигтэй зүүд зүүдэлжээ. Иосеф тэдний зүүдийг яг таг тайлж, тэдний нэг нь цаазлуулж, нөгөө нь сэргээгдсэн. Иосеф сэргээгдэж, Фараоны тааллыг олсон хүнээс өөрийг нь санаж явахыг захисан боловч, тэрбээр Иосефийг таг мартжээ. Иосефийн бас нэг боломж талаар болж, гомдох шалтаг нэгээр нэмэгдэв.

Бурханд ямагт төлөвлөгөө бий.

Гэтэл Фараон сэрдхийлгэм зүүд зүүдлэх болжээ. Илбэ жатгачид, цэцэд мэргэдийн нэг нь ч зүүдийг нь тайлж чадсангүй.

Яг тэр үед мөнөөх сэргээгдсэн зарц Иосефийг санав. Тэгээд шоронд байхад нь Иосеф хэрхэн түүний нөхөр, тэр хоёрын зүүдийг тайлсан тухай ярьжээ. Иосефийг Фараоны өмнө авч ирэхэд, тэрбээр Фараоны зүүд нь удахгүй нүүрлэх их ган гачгийг зөгнөснийг тайлаад, мэргэн чиглүүлэг өгчээ. Фараон тэр даруй Иосефийг Египетийн хоёрдугаар эрх мэдэлтнээр томилов.

Хожим дэлхий дээр их ган гачиг болоход, Иосефийн ах нар хоол хүнс хайж Египетэд иржээ. Иосеф ах нартаа өсөрхсөн бол, санаагаа гүйцэлдүүлэх сайхан боломж олдов. Иосеф тэднийг шоронд хатааж, тамлаж, бүр алсан ч, Египетийн хоёрдугаар том эрх мэдэлтнийг хэн ч яллахгүй. Фараон тэднийг тоох ч үгүй.

Гэтэл Иосеф тэднээс мөнгө авалгүй, буудай өгсөн. Дараа нь тэднийг гэр бүлээр нь Египетийн хамгийн сайхан газарт суурьшуулж, тарган сайхныг нь идүүлсэн. Иосеф өөрийг нь хараасан хүмүүсийг ерөөж, үзэн ядсан хүмүүст сайныг үйлджээ (Матай 5:44-ийг үзнэ үү).

Иосефийн ах нар юу хийхийг Бурхан өмнөөс мэдэж байсан. Бүр тэднийг төрөхөөс ч өмнө, Иосефт зүүд өгөхөөсөө ч өмнө мэдэж байсан.

Цаашаа яваад, Иосеф ах нартайгаа уулзахдаа, юу хэлснийг харцгаая: “Та нар намайг энэ газар худалдсандаа бүү санаа зов, бүү харамс. *Бурхан* амийг аврахаар та нараас өмнө *намайг илгээжээ*. Энэ нутагт хоёр жилийн турш ган гачиг болсон бөгөөд бас дахин таван жил газар хагалж ч чадахгүй, ургац хурааж ч чадахгүй. Бурхан их авралаараа та нарыг амьд үлдээж, үр удмыг чинь газар дэлхий дээр уламжлуулан үлдээхээр та нараас өмнө намайг илгээжээ. Тиймээс *намайг нааш нь та нар явуулаагүй, харин Бурхан явуулсан.*” (Эхлэл 45:5-8)

Мөн магтаалч юу хэлснийг үзнэ үү: “Тэрбээр тэр нутагт өлсгөлөнг дуудсан ирүүлсэн. Тэр талхны бүх нөөцийг үгүй болгосон. *Тэр тэдний өмнө нэг хүнийг буюу боол болон худалдагдсан Иосефийг илгээсэн*” (Дуулал 105:16-17).

Иосефийг хэн илгээсэн бэ? Ах нар нь уу, Бурхан уу? Бурхан илгээснийг бид гэрч нарын амаас сонслоо. Иосеф ч ах нартаа “Та нар намайг илгээгээгүй” гэсэн. Сүнс юу хэлснийг үз!

Танд хандсан Бурханы төлөвлөгөөг давдаг хүн ч, диавол ч байхгүй. Энэ үнэнийг ойлгож чадсан хүн чөлөөлөгдөнө. Гэхдээ таныг Бурханы хүслээс зайлуулж чадах нэг л хүн бий. Тэр нь та!

Израильчуудыг хар. Бурхан Израилийг Египетийн дарлалаас

Амлагдсан газар руу чөлөөлөхөөр Мосег илгээжээ. Жил гарантай цөлөөр хэссэнийхээ дараа тэд Канааныг тагнуулахаар илгээсэн овгийн удирдагч нарыг илгээсэн. Гэтэл тэд гомдол урсгасаар буцаж ирсэн. Тэд Канааны хавьгүй том, хавьгүй хүчирхэг цэрэг зэвсэгтэй улсуудаас сүрджээ.

Иошуа, Калев хоёроос бусад нь удирдагч нартайгаа санал нийлсэн. Бурхан тэднийг алах гэж л тэнд авчирчээ гэж үзсэн. Тэд Мосед бас Бурханд гомдов. Тэд бүтэн жил яг ийм маягаар аашилсаар ирсэн. Энэ гомдлоосоо болоод тэр үеийнхэн Бурханы өвлүүлэхээр амласан газрыг хэзээ ч үзээгүй билээ.

Бурханд халуун сэтгэлээр үйлчилдэг олон хүн муу хүнээс эсвэл ёс бус итгэгч хүнээс шарх аваад, хүнд байдалд ордог. Тэдэнд *үнэхээр* шударга бус ханджээ. Гэхдээ гомдол нь тэднийг Бурханы хүслээс гаргах гэсэн дайсны зорилгыг л биелүүлдэг.

Та гомдлоос чөлөөтэй байвал, Бурханы хүсэл дотроо үлдэнэ. Гомдбол, танаар дамжуулж хүсэл, зорилгоо гүйцэлдүүлэх гэсэн дайсны хоригдол болно. Тиймээс гомдлоос чөлөөтэй байх нь хавьгүй ашигтай.

Бидэнд тохиолдох юм бүрийг Эзэн тохиолдохоос нь ч өмнө мэдэж байдгийг санаарай. Диавол биднийг устгаж чадах байсан бол, хэдийнээ арчих байсан. Яагаад гэвэл дайсан хүмүүсийг голоосоо үзэн яддаг. Дараах ятгалгыг үргэлж санаж яваарай:

Та нарт учирсан сорилт нь хүнд тохиолддог л зүйл юм. Бурхан итгэмжит билээ. Тэр та нарыг хэрээс чинь хэтэрсэн хүчээр соригдохыг зөвшөөрдөггүй, харин сорилтыг тэсвэрлэж чадахын тулд сорилттой хамт мөн *гарах замыг* (нь) ч өгдөг юм. 1Коринт 10:13

“*Гарах замыг*” биш, “*гарах замыг нь*” гэж хэлснийг тэмдэглээрэй. Бидэнд тулгарах том, жижиг бэрхшээлийг Бурхан бүр өмнөөс мэддэг бөгөөд зугтах *замыг нь ч* бэлтгэж өгдөг юм. Хэрэв бид дуулгавартай байж, гомдлоос чөлөөтэй байвал, Бурханы төлөвлөгөө нурж байгаа мэт харагдах нь үнэндээ биелэлд хүргэх зам нь болж таардаг нь бүр ч гайхамшигтай.

Тиймээс гомдоод байлгүй, Бурханд үргэлж захирагдаж, чөтгөрийг хөө. Тэгвэл тэр зайлна (Иаков 4:7). Бид гомдохгүй байснаараа диаволыг эсэргүүцдэг. Зүүд, алсын хараа таны бодсоноос арай өөрөөр биелж болох ч, Бурханы Үг, амлалт

хэзээ ч хөсөрдөхгүй. Гагцхүү дуулгаваргүй байдал л биднийг амлалтаас хагацаана.

ӨӨР НЭГЭН УРВАЛТ

Иосеф шиг зовсон хүн цөөхөн байх. Мах цусны тасархай болсон *ахан дүүс* нь бус, *дайсан* нь байсан бол, хавьгүй зовиургүй тусах байсан. Ахан дүүс чинь урамшуулж, дэмжиж, хамгаалж, халамжлах ёстой хүмүүс. Үнэхээр ч Иосеф шиг зовсон хүн үгүй бус уу?

АХ ДҮҮДЭЭ АД ҮЗЭГДЭХ НЭГ ХЭРЭГ, ААВДАА АД ҮЗЭГДЭХ НЬ ТЭС ӨӨР ХЭРЭГ БҮЮУ.

Би дунд болон ахлах ангийн багш хүн. Саяхан Сатаны урхийг уншсан бөгөөд энэ ном миний амьдралд олон илчлэл авчирлаа. Би ангийнхандаа видео үзүүлсэнд Ариун Сүнс маш хүчтэй ажиллаж, сурагчид маань бүгдээрээ хэн нэгнийг гомдоосондоо гэмшиж, бие биеэсээ уучлал гуйсан юм. Энэ өдөр тухайн хичээлийн жилийн хамгийн сайхан өдөр байсныг олон хүүхэд хэлж билээ. Нэг сурагч аавтайгаа нилээд хүчтэй муудалцсаныхаа дараа эвлэрч бас нэгэн хүүхэд эмээгээсээ олсон шархаасаа эдгэрч эхэлжээ. Эзэн тэдгээр хүүхдүүдийн төлөө үнэхээр хүчтэй ажилласан шүү. Энэ номыг бичсэнд баярлалаа.

- R. F., INDIANA

4

ААВ АА, ААВ АА!

*Эцэг минь, ...надад хорон санаа, тэрслэх байдал
байхгүй бөгөөд би танд нүгэл үйлдээгүй гэдгийг лавтай
мэдэгтүн. Тийм атал та миний
амийг авахаар эрж байна.*
1Самуел 24:11

Дөнгөж сая бид ах нар нь Иосефийн амьдралыг сөнөөх гэж оролдсоныг үзлээ. Энэ урвалт хичнээн зовлон, шарх дагуулсныг ч мэдлээ. Магадгүй та ч бас иймэрхүү нөхцөлд байж болох. Танд хамгийн их хайр, дэм өгөх учиртай хүмүүс чинь танаас урвасан байж болох.

Тэгвэл энэ бүлгээрээ ахан дүүгийн урвалтаас долоон дор тохиолдлыг авч үзмээр байна. Ах дүүдээ нүд үзүүрлэгдэх нь нэг хэрэг бол, аавдаа нүд үзүүрлэгдэх нь тэс өөр хэрэг юм. Аав гэж хэлэхдээ, би гагцхүү махан биеийн аавыг бус, харин бидний дээр Бурханы томилсон удирдагчийг хэллээ. Бид тэднийг биднийг хайрлаж, сургаж, тордож, халамжлах ёстой хүмүүс гэж боддог.

ХАЙРТАЙ - ХАЛТАЙ ХАРИЛЦАА

Урвагч аавын жишээг Саул хаан, Давид хоёрын харилцаанаас үзье (2Самуел 16-31-ийг үзнэ үү). Энэ хоёр хүний амьдрал тэднийг биечлэн уулзахаас ч өмнө буюу Бурханы зөнч Самуел Давидыг Израилийн дараагийн хаанаар томилох үед огтлолцсон юм. Давид догдолж “Энэ чинь Саулыг тослосон хүн. Би чинь хаан болох нь байна шүү дээ!” гэж бодоо байх.

Тэр хооронд ордонд Саул Бурханд дуулгаваргүй байсныхаа төлөө муу сүнсэнд тамлуулж, зөвхөн босоо ятгын эгшигт л тайвширдаг байлаа. Тиймээс Саулын албатууд хуурын эгшгээрээ хааныг тайтгаруулах залуу хүнийг хайж, Иессегийн хүү Давидыг олжээ. Саул Давидыг өөртөө үйлчлүүлэхээр авчруулав.

Давид *“Бурхан одоо зөнчөөрөө амлалтаа биелүүлэх нь. Би очоод хааны тааллыг хүртэнэ. Энэ миний гараа байх”* гэж бодсон байх.

Цаг хугацаа өнгөрсөөр, нэгэн өдөр аав нь Давидад Филистинчүүдтэй дайтаж байгаа ах нартаа жаал зугаа юм хүргэж өгөхийг даалгав. Давид тулааны шугам дээр ирээд, Филистины аварга дайчин Голиат дөчин өдрийн турш Бурханы армийг элэглэн доромжилж байгааг олж мэджээ. Тэгээд энэ дайсныг дарсан хүнд хаан охиноо өгөхөөр ам гарсныг ч бас дуулав.

Давид Саул хаанаас тулалдах зөвшөөрөл авч, Голиатыг хөнөөгөөд, Саулын охиныг авав. Тэрбээр Саулын тааллыг олж, ордонд аж төрөх болов. Саулын ууган хөвгүүн Ионатан ч бас Давидтай андлалцжээ. Саулын Давидад даалгасан бүхэн дээр Бурханы мутар байж, хийсэн бүхэн нь цэцэглэж байв. Хаан ч Давидыг хөвгүүдтэйгээ хамт хааны ширээнээс зоог бариулах болов.

Давид ч тоймгүй баярлаа байх. Тэрбээр ордонд аж төрж, хааны ширээнээс зооглож, хааны хүргэн болж, хааны хүүтэй нөхөрлөж, хийсэн бүхэн нь цэцэглэж байна. Тэр бүү хэл, ард түмний ч хайрыг олов. Зөгнөл нүдэн дээр нь биелэхийг харсаар.

Саул Давидыг бусад зарц нараасаа аминчлан хайрлаж, аав нь болов. Саул өөрт нь зөвлөж, сургасаар, нэг өдөр үнэ хүндэтгэлтэйгээр хаан ширээнд зална гэдэгт Давид итгэлтэй байсан байх. Давид Бурханы итгэмжтэй байдал, сайн сайханд умбаж байв.

Гэтэл нэг л өдөр хамаг юм тонгоров.

Дайнаас харьж ирсэн Саул, Давид хоёрыг Израилийн

хотуудаас ирсэн эмэгтэйчүүд “Саул мянгыг хядаж, Давид арван мянгыг хядав” хэмээн дуулан бүжсээр угтжээ. Энэ явдал Саулын мэдрэлийг хөдөлгөж, тэр өдрөөс хойш Саул Давидыг үзэн ядах болов. Хоёр ч удаа Давидыг босоо ятга тоглож байхад нь алах гэж оролдсон.

Бурхан өөртэй нь биш, Давидтай хамт байгааг мэдсэндээ, Саул түүнийг алах гэж оролдсоныг Библи хэлдэг. Давид амиа авран зугтах ёстой болов. Явах газаргүй учраас, Давид цөл рүү зугтжээ.

Давид: “Юу болох нь энэ вэ? Бурханы амлалт биелэхийн даваан дээр үйрчихлээ. Миний зөвлөх одоо намайг алах нь. Би яах вэ? Саул бол Бурханы тосолсон зарц. Тиймд би түүнийг яаж ч чадахгүй. Тэр бол Бурханы хүмүүсийн дээрх хаан, Бурханы хүн. Бурхан яагаад энэ бүхнийг зөвшөөрнө вэ?” гэж бодсон байх.

Саул Израилийн гурван мянган шилдэг дайчныг дагуулан Давидыг элсэн цөл, уул хадаар элдэв. Тэд Давидыг алах гэсэн ганц л зорилготой.

Яг энэ үед Бурханы амлалт сүүдэр болжээ. Давид ордонд аж төрөхөө больж, хааны ширээнээс зооглохоо больсон. Тэрбээр хүйтэн агуйд хоног төөрүүлж, цөлийн араатны сэгээр хооллоно. Тэрбээр хааны ивээлд багтахгаа больж, нэгэн цагт мөр зэрэгцэн тулалдаж явсан цэргүүддээ хөөгдөж явна. Дулаан хөнжил, туслах зарц нар, эдлэх эрх ямбын аль нь ч байхгүй. Сүйт бүсгүй нь ч хүнийх болжээ. Давид нутаггүй хэсүүлчний ганцаардлыг эдлэв.

Диавол биш, Бурхан Давидыг Саулын гар дор тавьсан. Бурхан яагаад ийм зүйл төлөвлөв бас зөвшөөрөв? Төдөлгүй буцаагаад авчих байсан юм бол, яагаад Давидын өмнө энэ их тааллыг дэвсэв? Энэ бол Давидын хувьд Саулд төдийгүй Бурханд гомдох том боломж байв. Хариултгүй баахан асуулт нь Бурханы цэц ухаан, төлөвлөгөөнд эргэлзэх өдөөлтийг улам л сэвж байв.

Харин Саулын солиорол улам ахисаар, Давидыг ямар ч өртгөөр хамаагүй алахыг санаархсаар. Эцэстээ яахаас ч буцахаа байжээ. Ноб хотын тахилч нар Давидыг Саулаас зугтаж явааг огт мэдэлгүй, хааны албан ажлаар яваа хэмээн байр, хоол, Голиатын сэлмийг өгөөд, Эзэний тааллаар ерөөгөөд, үдэж гаргажээ.

Үүнийг мэдсэн Саул галзууртлаа уурлан, Эзэний наян таван гэмгүй тахилчийг хороогоод, Нобын бүх эрэгтэй, эмэгтэй хүн, хүүхэд, нялхас, нярай, үхэр, илжиг, хонь мал - хотыг бүхлээр

нь хүйс тэмтэрчээ. Тэрбээр Амалекчуудын эсрэг үйлдэх ёстой байсан зүйлээ ямар ч гэмгүй хотын эсрэг үйлдэв. Саул алуурчин болжээ. Бурхан яаж ийм хүнд Сүнсээ өгөв өө?

Нэгэн удаа Саул Давидыг Ен Гедийн цөлд явна гэдгийг дуулаад, гурван мянган дайчинтайгаа араас нь нэхэв гэнэ. Тэгээд Давидыг гүнд нь нуугдаж байгааг мэдэлгүй, нэгэн агуйн аман дээр түр амсхийжээ. Саул нөмрөгөө тайлаад, дэргэдээ тавив. Давид сэм гэтэж очоод, нөмрөгөөс нь огтолж аваад буцжээ.

Саулыг агуйгаас гарсан хойно Давид газар сөгдөн суугаад: “Аав аа! миний гарт байгаа өөрийнхөө дээлийн хормойг харагтун. ... надад *хорон санаа, тэрслэх байдал байхгүй* бөгөөд би танд нүгэл үйлдээгүй гэдгийг лавтай мэдэгтүн. Тийм атал та миний амийг авахаар эрж байна” (1Самуел 24:11) хэмээн хашхирсан.

Давид Саулыг “Аав аа, аав аа!” хэмээн дууджээ. Тэрбээр үнэндээ “Аав аа, миний зүрхийг хараач! Надад намайг хөнөөгч дайсан бус, харин намайг сургах удирдагч, аав минь хэрэгтэй байна!” гэж л хашхирчээ. Саул өөрийг нь алах гээд байхад ч, Давидын зүрхэндээ найдсаар байна.

ААВУУД ХААНА БАЙНА?

Христийн бие дотор маш олон хүн ингэж хашхирдаг. Тэдний дийлэнх нь Бурханы дуудлагатай, залуу хүмүүс юм. Тэд өөрийг нь дагалдуулж, хайрлаж, дэмжиж, урамшуулах аав хүнийг хайдаг. Тиймээс л Бурхан “эцгүүдийн зүрхийг хүүхдүүд рүү нь, хүүхдүүдийн зүрхийг эцгүүд рүү нь эргүүлнэ. Эс бөгөөс Би ирж, энэ нутгийг хараалаар цохино” (Малахи 4:6) гэсэн.

1940-50 онд манай үндэстэн аавуудаа (аав, удирдагч, үйлчлэгч) алдсан бөгөөд өнөөдөр энэ байдал улам дордсоор байна. Манай гэр бүл, корпорац, чуулганы олон удирдагч Саулын нэгэн адил залгамж үедээ бус, зорилгодоо л анхаардаг.

Энэ хандлагаасаа болоод тэд алсын хараагаа хүмүүст үйлчлэх зэмсэг гэж харах бус, харин хүмүүсийг алсын хараандаа хүргэх эх үүсвэр гэж хардаг. Тэгээд шархалсан амьдрал, нурсан хүмүүсийн өртгөөр алсын харааныхаа амжилтад хүрнэ. Энэ амжилтынхаа төлөө шударга ёс, өршөөл, үнэн, хайраа уландаа гишгэлж, мөнгө, тоо, үр дагавар дээр тулгуурлаж шийдвэрээ гаргана.

Үүнийхээ төлөө л тэд Саул Давидыг таалсан шиг авирлах. Яагаад гэвэл Саул хаанчлалаа бодож байсан. Удирдагч нар ч сайн мэдээг дэлгэрүүлэхийн төлөө л хүмүүст яг ингэж хандах нь бий.

Хичнээн олон удирдагч хар сэрээсээ болж удирдлага дорх хүмүүсээ зайлуулдаг билээ? Тэд яагаад хардана вэ? Яагаад гэвэл тэд Бурханд үйлчлээгүй, алсын хараандаа үйлчилж байгаа учраас тэр. Тэд яг л Саул шиг дуудлагадаа эргэлздэг бөгөөд энэ нь атаархал, бардам занг үржүүлнэ. Тэд бурханлаг, чадвартай хүмүүсийг олбол, өөрт ашиггүй болох хүртэл нь мөлжинө. Саул Давидыг аюул занал гэж харах хүртлээ түүний амжилтыг ашиглаж байгаад, сүүлдээ байр сууриас нь хусахаар барахгүй, бүр далдруулах шалтгаан хайсан.

Хариуцлага хүссэн залуу эрчүүд, бүсгүйчүүдтэй би маш их уулздаг. Тэд өөрсдийг нь зааж сургах удирдагчид захирагдахыг хүсдэг. Тэд ганцаарддаг. Тэд аав шиг хүнийг хүсдэг. Гэхдээ Бурхан Давидын дотор үйлдсэн зүйлээ тэдний дотор ч үйлдэхийн тулд тэдэнд шоовдорлогдож, ганцаардахыг зөвшөөрдөг. Сүнсний айлдаж буй үгийг анхааралтай сонс.

Саул өөрийг нь муу санаатай, тэрслүү хэмээн итгэсэн байх гэдэгт Давид зовнисон. Давид зүрхээ байн байн шалгаж: “Би юуг буруу хийв? Саулын сэтгэл яагаад ийм хурдан надаас эргэчихэв?” хэмээн асууж шалгаасан байх. Тиймээс л тэрбээр: “Зарим маань таныг алья гэсэн боловч би алахгүй гэсэн. Би зөвхөн таны дээлийн хормойг огтолж авсан. ... надад тэрслэх, хорон муу санаа байхгүй гэдгийг та лавтай харна буй за” (2Самуел 24:10-11-ийг үзнэ үү) гэж хашхирсан. Давид Саулд хайртайгаа баталж чадбал, Саул түүнийг дахин соёрхож, Бурханы амлалт биелнэ хэмээн санажээ.

Аавдаа юмуу удирдагчдаа ад үзэгдсэн хүн өөрийгөө ялладаг. Тэд “*Би яасан юм бэ? Миний зүрх бохир байв уу?*” гэдэг бодолдоо тарчилдаг. Заримдаа “*Манай удирдагчийг хэн миний эсрэг эргүүлчихэв ээ?*” ч гэж боддог. Тэгээд удирдагчдаа буруугүй гэдгээ зогсоо зайгүй батлах гэж зүдэрнэ. Үнэнч, үнэ цэнэтэй гэдгээ ойлгуулбал, дахин хайрлуулна гэж боддог. Гэвч хичээх тусам, улам л адлуулна.

МИНИЙ ӨШӨӨГ ХЭН АВАХ ЮМ БЭ?

Давид өөрийг нь алаагүйг үзэхдээ, Саул Давидын зөв сэтгэлийг ойлгоод, эрчүүдээ дагуулаад буцжээ. Давид *“Одоо л хаан намайг хүлээж авах нь. Одоо л Бурханы үг биелэх нь. Хаан миний зүрхийг харсан хойно хайрлах байх”* гэж бодсон байх.

Болоогүй шүү, Давид аа! Удалгүй Саул Давидыг Хачиллагийн ууланд явна гэдгийг нь дуулаад, дахиад л гурван мянган эрсээ дагуулаад араас нь элдчихсэн. Давид аргаа барсан байх. Давид энэ бүхэн үл ойлголцол биш, харин Саул зүгээр л түүнийг алах гэж байгааг ойлгосон. Саул Давидын зүрхийг мэдсэн атлаа алах гэж байжээ.

Давид, Абишай хоёр Саулын хуаран руу нэвтрэв. Бурхан цэргүүдийг нь гүн унтуулсан тул Давид, Абишай хоёр хамгаалагч нарт мэдэгдэлгүй явсаар, Саулд хүрчээ.

Тэгээд Абишай Давидыг ийн ятгав: “Бурхан өнөөдөр таны дайсныг гарт тань өгчээ. Тийм учраас энэ жадаар түүнийг нэг мөсөн газарт хатгаж алахыг надад зөвшөөрнө үү. Би хоёр хатгахгүй!” (1Самуел 26:8)

Абишайд Саулыг хөнөөх түмэн зөв шалтгаан байв. Нэгдүгээрт - Саул наян таван гэмгүй тахилчийг гэр бүлтэй нь хүйс тэмтэрсэн!

Хоёрдугаарт - Саул Давидын араас 3,000 хүнтэйгээ элдэж байсан. Дайснаа түрүүлж устгахгүй бол, дайсан чамайг устгана хэмээн Абишай дүгнэжээ. Энэ бол аргагүй хамгаалалт. Үүнийг ч бүх шүүх зөвшөөрнө!

Гуравдугаарт - Бурхан Самуелаар дамжуулан Давидыг Израилийн дараачийн хаанаар тосолсон. Давид зөгнөл биелэхийг үзэхээсээ өмнө үхэх гээгүй л юм бол, хууль ёсны эрхээ мэдэгдэх ёстой.

Дөрөвдүгээрт - Бурхан Давид, Абишай хоёрыг Саул дээр авчрахын тулд Саулын цэргийг нам унтуулсан. Эс бөгөөс юунд нам унтуулах билээ? Абишай Давидад дахиж ийм сайхан боломж олдохгүй гэж бодож байв.

Эдгээр нь Давидын хувьд сонсголонтой шалтгаан байлаа. Найзынх нь зүгээс хайрлаж буй утга төгөлдөр урмын үгс. Тиймээс Давид гомдсон байсан бол, өөрийгөө зөвтгөөд, Абишайд Саулыг алахыг тушаах байсан.

Гэтэл Давидын хариултыг үзнэ үү: “Түүнийг бүү ал. Эзэний тосолсон хүний эсрэг гар далайчихаад хэн гэм буруугүй үлдэж чадах вэ? ... Эзэн түүнийг заавал устгана эсвэл түүний үхэх өдөр ирнэ эсвэл тулалдаанд явж устгагдана.” (1Самуел 26:9-11)

Давид гэмгүй хүмүүсийн алсан бас өөрийг нь алах гэж яваа Саулыг алахгүй гэжээ. Давид өшөөг өөрөө авалгүй, Бурханы мутарт үлдээв

Мэдээж бүхнийг зүйл дуусгачихсан бол, Давидын хувьд ч, Израилийн хувьд ч амар байх байв. Улс орон нь хоньчингүй сүрэг шиг л дурын чонын хоол болж байгааг Давид мэдэж байсан. Давидад амиа хамгаалахгүй байх нь хэцүү байсан ч, галзуу хаанаас хайртай хүмүүсээ чөлөөлөхгүй байх нь бүр хэцүү байсан байх. Давид Саул өөрийг нь хөнөөхөөс нааш тайтгарахгүйг мэдсэн атлаа ингэж шийджээ.

Давид Саулыг эхний удаа амьд үлдээхдээ, цэвэр зүрхээ батлан харуулсан. Тэр бүү хэл, хоёр дахь хосгүй боломж гарах үед ч Давид Саулд гар хүрээгүй. Саул Эзэний тосолсон хүн учраас, Давид Саулын шүүхийг Эзэний гарт үлдээжээ.

Давид шиг сэтгэлтэй хүн өнөөдөр олон болов уу? Бид илдээр дүрэлцдэггүй ч, хэл гэдэг өөр илдээр хөнөөлдөг. “Амь ба үхэл нь хэл ярианы хүчинд оршдог” (Сургаалт үгс 18:21).

Гомдож шаралхсан сэтгэлээс цувсан үгээр чуулган тарж, гэр бүл салж, гэрлэлт сарниж, хайр мөхдөг. Бид найз, гэр бүл, удирдагчдаа гомдохдоо, эргээд тэднийг хорсол, хилэнгээр ирлэсэн үгээр харвадаг. Тэр хүмүүс гомдоосон нь багтай үнэн байж болох ч, хариу сэдэл нь цэвэр бус юм.

Сургаалт үгс 6:16-19 дээр “Ахан дүүсийнхээ дунд эвдрэл тараахыг Эзэн жигшдэг” гэдэг. Хүмүүсийн харилцааг салган бутаргах юмуу нэр төрийг гутаах зорилгоор ямар нэг зүйлийг давтаж байвал, энэ нь үнэн байсан ч хамаагүй, Эзэнд жигшүүртэй байна.

БУРХАН МАНАЙ УДИРДАГЧИЙН НҮГЛИЙГ ИЛЧЛЭХИЙН ТУЛД НАМАЙГ АШИГЛАЖ БАЙНА УУ?

Бурхан гэргий, бид хоёрыг одоогийн үйлчлэлд маань гаргахаас өмнө миний бие долоон жилийн хугацаанд туслах үйлчлэл

хийж, залуусын пастораар үйлчилсэн юм. Тэр үед надад болоод миний номлолд дургүй нэг хүн байв. Ер нь бол би ийм явдлыг тоодоггүй. Гэхдээ тэр хүн манай дарга байж таарав.

Бурхан залууст цэвэр бөгөөд зоригтой амьдрахыг хүчтэй сануулсан учраас, би ч энэ талаар итгэл дүүрэн номлов. Гэтэл даргын хүү нь манай бүлэгт явдаг байлаа.

Тэр залуугийн зүрхэнд итгэл үнэмшил бадарчээ. Нэг өдөр нөгөө залуу бидэн дээр уйлсаар ирээд, гэр бүлийнх нь амьдарч байгаа байдал миний уриалсан номлолд хүрэхгүй байгаад гутарч байгаагаа хэлэв.

Энэ явдлаас болоод бас бус хувийн зөрчлөөс болоод аав нь намайг арчиж хаяхаар шийджээ. Тэрбээр манай тэргүүн пастор дээр хилэгнэсээр явж очоод, намайг элдвээр гүтгэчихээд, дараа нь над дээр ирээд, пастор чамд дургүйцсэн, харин би чамайг хамгаалсан гэдэг байв. Тэр хүн наанаа инээж байгаад цаанаа намайг арчиж хаях санаатай байжээ.

Тэрбээр намайг халагдах ёстой гэж хэлж байхыг нь манай залуусын бүлгийн хэд хэдэн хүн сонссон байв. Энэ яриаг даргын хүү нь хорон санаалсандаа бус, зүгээр л гэртээ сонссоноо л давтах маягаар тараасан байв. Би цухалдаж бас самуурч гүйцэв. Дарга дээрээ явж очоод, энэ тухай хэлтэл, тэрбээр тэргүүн пастораас сонссон үгээ л давтсан гэлээ.

Хэдэн сар өнгөрсөн ч, байдал дээрдсэнгүй. Мөнөөх хүн тэргүүн пастор, бид хоёрын дунд ч яс хаяв. Тэрбээр үнэндээ надад төдийгүй, бүх пасторт дургүй байжээ.

Гэр бүл маань тэр чуулганд үлдэх эсэхээ ч мэдэхгүй, байнгын дарамтанд байв. Тэр үед бид байшин худалдаад авчихсан, гэргий маань бие давхар, өөр очих газаргүй байлаа. Би ажил хайхыг хүссэнгүй. Учир нь Бурхан намайг энэ чуулганд авчирсан болохоор, би хоёрдагч төлөвлөгөөгүй, эндээ л үйлчилнэ гэдэгт баг итгэж байлаа.

Гэргий маань дэлбэ үсэрдгийн даваан дээр ирээд байв: “Жон, тэд чамайг хална аа. Бүгд л тэгж байна.”

Харин би гэргийнхээ амыг “Тэд намайг ажилд аваагүй. Тиймээс Бурханы зөвшөөрөлгүйгээр халж чадахгүй” хэмээн таглаж байв. Гэргий маань намайг нөхцөл байдлыг үгүйсгэлээ гэж үзээд, ажлаасаа өөрөө гарахыг гуйж байлаа.

Эцэстээ намайг халах тушаал гарав. Тэргүүн пастор чуулганы залуусын бүлэгт өөрчлөлт гарах талаар зарлалаа. Би мөнөөх удирдагчтай үүссэн зөрчлийн талаар тэргүүн пастортайгаа

ярилцаагүй л байлаа. Пастор мөнөөх удирдагч, бид хоёртой яг маргааш нь уулзахаар товлосон байв. Тэгтэл Бурхан надад биеэ өмөөрч болохгүйг маш тодорхой сануулсан юм.

Маргааш нь иртэл, пастор өрөөндөө ганцаараа сууж байсанд би гайхав. Тэрбээр над руу хараад: “Жон, Бурхан чамайг энэ чуулган руу явуулсан. Тиймээс би ч чамайг явуулахгүй” гэдэг байгаа.

Дотор онгойсон гэж. Бурхан намайг эцсийн даваан дээр хамгаалжээ.

Пастор надад “Тэр удирдагч яагаад чамайг элдэвлээд байгаа юм? Заавал учраа олоорой” гэлээ.

Энэ уулзалтын дараа би, миний үүрэг хариуцлагын талаар мөнөөх удирдагчийн гаргасан бичгийг хүлээж авсан нь түүний жинхэнэ сэдлийг илчилсэн нотолгоо бичиг болсон юм. Би ч үүнийг нь бариад, тэргүүн пастор дээрээ давхиж ороход бэлэн байлаа.

Тэр өдөр би дотоод дарамтаа ялахын тулд сөгдөн суугаад дөчин таван минут залбирав. “Бурхан минь, тэр ямар шударга бус, атгаг санаатай хүн бэ? Энэ байдлыг нь илчлэхгүй бол, тэрбээр үйлчлэлийг нурааж ч мэднэ. Түүний хэн болохыг би пастортаа хэлэх ёстой!” хэмээн давтсаар байв.

Тэгээд түүнийг илчлэх зорилгоо цааш нь ингэж зөвтгөлөө: “Миний тайлагнах зүйлс нь хоосон сэтгэл мэдрэмж биш, харин нотолгоотой баримт. Тэр этгээдийг одоо л зогсоохгүй бол, явуургүй үйлдэл нь чуулган даяар тархаж мэднэ.”

Эцэстээ цөхрөөд: “Бурхан минь, Та надаар үүнийг хийлгэхийг хүсэхгүй байна. Тийм үү?” хэмээн бувтналаа.

Энэ үгийг хэлтэл Бурханы амар тайван зүрхийг минь сүлэв. Би ч гайхшран толгой сэгсэрлээ. Бурхан надаар ийм зүйл хийлгэхийг хүсэхгүй байгааг мэдсэн тул нотолгоогоо холуу хаяв. Хожим үйл явдлыг арай бодитоор харахдаа, би үйлчлэл дэхь хүмүүсийг хамгаалах бус, хувийнхаа өшөөг л авах санаатай байснаа ухаарч билээ. Мэдээлэл маань үнэн байсан ч, санаа сэдэл маань цэвэр бус байжээ.

Цаг хугацаа өнгөрсөөр, нэг өдөр би ажил эхлэхээс өмнө цуглааныхаа гадаа залбирч байтал, нөгөө хүн машинаасаа бууж байхыг харлаа. Бурхан намайг өөрийгөө даруусган, түүн дээр оч гэх шиг болов. Би ч шууд л: “Үгүй шүү, Эзэн минь. Тэр өөрөө л над дээр ирэг. Хэргийн эзэн чинь тэр шүү дээ” хэмээн биеэ өмөөрлөө.

Тэгээд үргэлжлүүлэн залбирсан ч, Эзэн надад өөрийгөө даруусган очиж уулзахыг дахин сануулах нь баттай болсон тул

би өрөөнөөсөө түүн рүү яриад, явж очив. Миний ярьж байгаа юмс, ярьж байгаа байдал Бурханы шийдлээс өмнөх байдлаасаа тэс өөр болсон байлаа.

“Би таныг шүүмжилж, шүүсэн” хэмээн үнэнээ хүлээгээд, түүнээс чин сэтгэлээсээ уучлал хүсэв.

Дарга шууд зөөлөрч, бид хоёр цаг гаруй хөөрөлдлөө. Тэр өдрөөс хойш дарга өөр пасторуудтай үргэлжлүүлэн дайсаар байсан ч, намайг довтлохоо больсон юм.

Зургаан сарын дараа намайг томиллолтоор явсан хойгуур даргын бүх булхай тэргүүн пасторт ил болсон байлаа. Тэдгээр нь надтай хамаагүй, харин үйлчлэлийн бусад талбар дээр гаргасан асуудал байжээ. Тэрбээр миний санаснаас хавьгүй ноцтой юм хийж явсан бөгөөд тэр дороо халагдсан байв.

Шүүх буусан. Гэхдээ миний гараар биш. Дарга намайг унагах гээд өөрөө түүндээ унажээ. Гэхдээ би гуяа алгадаж гүйгээгүй ээ. Харин ч даргынхаа төлөө, гэр бүлийнх нь төлөө үнэн голоосоо гашуудсан юм. Би түүний зовиурыг мэдэж байлаа. Учир нь би өөрөө түүний гар дор чамгүй зовсон.

Яагаад гэвэл би даргаа зургаан сарын өмнө уучилсан учраас, түүнийг хайрлаж, ийм юм болохыг хүсэхгүй байв. Жилийн өмнө түүнд уурлаж байхдаа халагдсан байсан бол, магадгүй баярлах л байсан байх. Тэгэхэд л би угжаад байсан гомдлоосоо бүрэн чөлөөлөгдсөнөө мэдэж билээ. Өөрийгөө даруу болгон, өшөө авахаас татгалзсан нь намайг гомдлын шоронгоос чөлөөлөх түлхүүр болжээ.

Жилийн дараа би түүнтэй онгоцны буудал дээр тааралдсан юм. Түүнийг хармагц, дотроос Бурханы хайр хүрч, гүйж очоод, тэвэрч авч билээ. Амьдрал нь сайн байгааг сонсоод, үнэн голоосоо баясав. Олон сарын өмнө оффис дээр байхдаа, өөрийгөө даруусган очиж уулзаагүй байсан бол, онгоцны буудал дээр таарахдаа эгцэлж ч харж чадахгүй өнгөрөх байсан байх. Сүүлд уулзсанаас хойш хэдэн жил өнгөрсөн ч, би одоо хүртэл түүнийг Бурханы хүсэл дотор сайн сайхан яваасай л гэж хүсдэг.

Давид Саулыг Бурханаар шүүлгэсэн нь тун мэргэн шийдвэр байжээ. Та “Бурхан зарц Саулаа хэнээр дамжуулж шүүсэн юм бэ?” гэж асууж магадгүй. Филистчинчүүдээр. Саул ба түүний хөвгүүд филистинчүүдтэй тулалдаж яваад, алуулсан. Давид энэ мэдээг дуулаад баярлаагүй, харин гашуудсан.

Нэгэн хүн Давидын тааллыг горьдсондоо, өөрийгөө Саулыг

алсан гэж худал гайхуултал, Давид “Чи Эзэнийг тослосон хүнийг алахаар яаж гар сунгаж зүрхлэв?” гэж хэлээд, цаазлахыг тушаасан байдаг (2Самуел 1:14-15-ыг үзнэ үү).

Дараа нь Давид Саулын болоод хөвгүүдийнх нь гэгээн дурсгалыг хүндэтгэн дуу зохиожээ. Тэгээд Филистинчүүдийг баярлуулахгүйн тулд тэдний гудманд дуулахыг хориглосон. Тэрбээр Саулын алуулсан газар хурын ус бүү бууг, өвс ургамал ч бүү ургаг гэсэн. Тэгээд Саулын төлөө гашуудахыг Израиль даяар тушаажээ. Гомдсон хүн ингэдэггүй юм. Гомдсон хүн “Хохь чинь!” гэдэг юм.

Үүгээр барахгүй Давид Саулын удмаас үлдсэн ганц хүнийг хөнөөлгүй, ивээлдээ авч, газар, хүнс өгч, хаан ширээнээсээ зоог бариулдаг болгожээ. Гомдсон хүн ингэх үү?

Давид хэдийгээр аав шахуу хүндээ нүд үзүүрлэгдсэн ч, түүнийг үхсэн хойно нь ч үнэнч үлджээ. Таныг хайрладаг удирдагч, багшдаа үнэнч үлдэх нь нэг хэрэг бол, таныг сүйрүүлэх санаатай хүнд үнэнч байх нь тэс өөр хэрэг. Та Бурханы зүрхийг дагадаг хүн байх уу эсвэл өшөөгөө өөрөө авах уу?

**БУРХАН ЗАРЦЫНХАА
ӨШӨӨГ АВАХ ЗӨВ.
ЗАРЦ ӨӨРИЙНХӨӨ
ӨШӨӨГ АВАХ БУРУУ.**

Ноён Бивэр, би таны Сатаны урхи номыг нэг суурин дээр
уншлаа! Яах аргагүй миний уншсан шилдэг номын нэг.

- P. A., MISSOURI

5

СҮНСНИЙ ТЭНҮҮЛЧИД ХЭРХЭН ТӨРДӨГ ВЭ?

6Тэрээр хүмүүстээ

—ЭЗЭН байгаа тул, ЭЗЭНий тосолсон өөрийн эзэнд би ийнхүү хандан, тэр ЭЗЭНий тосолсон хүн тул түүний эсрэг гараа сунгасан ийм хэрэг надаас хол байг хэмээн өгүүлэв. 7Давид ингэж өгүүлээд хүмүүсээ ятган, Саул уруу дайрахыг тэдэнд зөвшөөрсөнгүй. Саул ч босож, агуйгаас гарч, замдаа гарав.

1Самуел 24:6-7

Өнгөрсөн бүлгээр бид Давид аав шахуу хүндээ ад үзэгдсэн тухай үзсэн. Давид бурууг өөрөөсөө л хайсан. Би буруу явдлаараа Саулын зүрхийг урвуулсан уу, түүний зүрхийг хэрхэн буцаах вэ гэж л бодсон. Саул өөрийг нь газрын хөрснөөс арчих гээд байхад л, Давид Саулыг амьд үлдээж, үнэнч сэтгэлээ баталж байсан.

Газар сөгдөн, толгой бөхийн мэхийгээд “Гарт минь атгаг санаа ч, урван тэрслэл ч байхгүй. Таны эсрэг нүгэл үйлдээгүйг минь хараач” хэмээн Саул руу хашхирсан байдаг.

Давид удирдагчдаа үнэнч болохоо баталж аваад, жаал уужирчээ. Гэвч удалгүй бүр ч аюумшигтай мэдээ дуулав: Саул бас л түүнийг хөнөөхөөр айсуу. Гэвч Бурхан Саулын цэргүүдийг гүн унтуулаад, хамт яваа нөхөр нь одоо түүнийг хөнөөе гэж ятгаад байхад ч, Давид өөрийг нь хөнөөх гэж яваа тэр хүн рүү гар далайхаас таггалзсан. Бурхан тэр их цэргийг үнэндээ өөрийнх нь зүрхийг шалгах зорилгоор л гүн унтуулсан гэдгийг Давид мэдэрчээ.

Бурхан Давидыг Саулыг залгамжлахын тулд хүний амиар өөрөө өөртөө хаанчлал байгуулах нь уу эсвэл Бурхан түүнд мөнхийн зөвт сэнтий байгуулахыг нь хүлээх нь үү гэдгийг нь л харахыг хүсчээ.

Хайртууд минь, хэзээ ч өөрийн өшөө хонзонг бүү ав. Харин Бурханы уур хилэнд зай гарга. Учир нь «Өшөө авалт нь Минийх, Би буцааж төлнө» гэж Эзэн хэлэв» гэж бичигджээ.
Ром 12:19

Бурхан зарцынхаа өшөөг авах нь зөв, зарц нь өөрийнхөө өшөөг авах нь буруу юм. Саул өс хонзонгоо өөрийн биеэр авахыг санаархсан. Тэр арван дөрвөн жилийн турш журамт Давидыг алахаар хөөж, тахилч нарыг гэр бүлтэй нь алсан.

Давид унтаж буй Саулын толгойд зогсохдоо, чухал даалгавартай тулжээ. Энэ нь Давидыг хоньчны даруу зүрхээ тээсээр байна уу эсвэл бас нэгэн итгэлгүй Саул болох уу гэдгийг илчлэх байв. Давид Бурханы зүрхийг дагадаг хүнээрээ үлдэх үү? Зөвт Бурханыг хүлээж байхаар өөрийн гараар шийдчих нь анхандаа амар харагддаг.

Бурхан үйлчлэгч нарынхаа дуулгавартай байдлыг шалгадаг. Тэрбээр албаар биднийг үйлдлээ шашны болоод нийгмийн жишгээр хаацайлан зөвтгөж болмоор нөхцөлд оруулдаг. Тэгээд бусдыг буюу ялангуяа бидний дотны хүмүүсийг “өөрийгөө өмгөөл” хэмээн биднийг ятгахыг зөвшөөрдөг. Тиймээс бид өөрийн биеэр өшөө авснаараа нэр төрөө ч аварч, бусдыг ч хамгаална гэж бодно. Гэхдээ энэ нь Бурханы арга зам биш. Энэ бол дэлхийн ухаан. Энэ нь газрын, махан биеийн арга.

Би даргынхаа булхайг илчлэхээр зэхэж байхдаа “Би л илчлэхгүй бол, тэрбээр бусдыг зовооно, би үнэнийг л хэлж байна, би хэлэхгүй бол, хэн хэлэх билээ?” гэдэг бодолтой өөд уруугүй тэмцэлдэж байсан юм.

Гэхдээ Бурхан чухам намайг л шалгах гэсэндээ тэр мэдээллийг өгснийг нь өнөөдөр би мэднэ. Би намайг устгахаар эрэлхийлж байгаа хүн шиг болох уу? Эсвэл түүнийг гэмшбэл, Бурхан Өөрөө шүүх юмуу нигүүлсэг гээд орхих уу?

БУРХАН ЗАВХАРСАН УДИРДАГЧИЙГ ЯАЖ АШИГЛАЖ ЧАДАЖ БАЙНА АА?

“Бурхан яаж хүмүүсийн дээр тийм бузар булай, завхарсан удирдагчийг тавьдаг байна аа?” гэж хүмүүс асуудаг.

Тэгвэл Самуелын хүүхэд насыг хар (1Самуел 2-5-ыг үзнэ үү). Бяцхан Самуелыг диавол биш, харин Бурхан Өөрөө завхарсан тахилч Елигийн болоод түүний хоёр хүү болох тахилч Хофни, Финехас нарын дор тавьжээ. Тэр хоёр хүмүүсийн өргөлийг түрэмгийлэн авдаг, майхан сүмийн үүдний эмэгтэйчүүдтэй садарладаг, үнэхээр бузар хүмүүс байв.

Та ийм үйлчлэгчийн дор үйлчилж байна гээд төсөөл дөө. Ели эмэгтэй хүн залбирч байгааг ч танихгүй, согтуурлаа хэмээн буруутгаж явсан, сүнсний юмст тийм л мэдрэмжгүй үйлчлэгч байв. Тэрбээр гахай шиг бүдүүн байсан. Чуулганы удирдагчаар томилсон хөвгүүд нь чуулган дотор садарлаж байхад, Ели юу ч хийгээгүй.

Өнөөдөр бол ихэнх итгэгч нар ийм удирдагчид гомдож, уулзсан хүн бүртээ муулаад, өөр цуглаан руу яваад өгнө. Харин энэ бүх завхрал дунд бяцхан Самуел юу хийсэн нь хайр хүрмээр: “Бяцхан хөвгүүн Самуел Елигийн өмнө Эзэнд үйлчилж байв” (1Самуел 3:1).

Гэхдээ энэ завхрал зорьсондоо хүрчээ: “Тэр үед Эзэний үг ховор, үзэгдэл ч цөөн байв” (1Самуел 3:1). Бурхан Еврейчүүдээс холдсон гэлтэй. Бурханы дэнлүү хараахан унтраагүй үед бяцхан Самуел өөр чуулганд очиж хүндэтгэсэн үү? Тэрбээр ахлагч нар дээр очиж, Елигийн бөгөөд хөвгүүдийнх нь булайг илчилсэн үү? Тэрбээр Елиг хөвгүүдтэй нь пасторын үйлчлэлээс буулгахаар зөвлөл байгуулсан уу? Үгүй, Самуел Эзэнд үйлчилсэн!

Бурхан Самуелыг тэнд тавьсан бөгөөд тэрбээр Елигийн болоод түүний хөвгүүдийн нүгэлд буруугүй байв. Самуел тэнд шүүхийн төлөө бус, үйлчлэхийн төлөө байжээ. Ели бол түүний биш, Бурханы зарц, Бурхан зарцынхаа асуудлыг Өөрөө шийднэ гэдгийг Самуел мэдэж байв.

Үр хүүхэд нь аавыгаа засдаггүй. Аав нь үр хүүхдээ засах үүрэгтэй. Бурханы бидэнд сурга гэж өгсөн хүмүүсийг бид сургах ёстой. Энэ бол бидний үүрэг хариуцлага. Адилхан төвшинтэй хүмүүсээ бид ахан дүүсээ хэмээн урамшуулж ятгах ёстой. Харин яг одоо бүгдээрээ бидний дээрх эрх мэдэлтнүүдийг хэрхэх ёстойг сурна.

Самуел Бурханы тослогдсон үйлчлэгчийг шүүж засалгүй, үг дуугүй үйлчилжээ. Ели Самуелаас Бурхан урьд шөнө ямар зөн үг өгснийг асуух үед л Самуел цорын ганц удаа зэм үг хэлсэн нь өөрийнх нь үг бус, Бурханы үг байв. Хүмүүс энэ үнэнийг ухаарбал, чуулган үнэхээр өөр байх байлаа.

ЧУУЛГАН ЦАЙНЫ ГАЗАР БИШ

Өнөөдөр хүмүүс чуулганыхаа удирдагчид дургүй байвал шууд л хаяж явдаг. Магадгүй пасторынхаа өргөл авч байгаа арга барилд эсвэл мөнгөө зарцуулж буй арга ухаанд эсвэл номлолд дургүй бол, шууд л яваад өгнө. Эсвэл пастор нь их хэцүү хатуу хүн л гэнэ, түүнийг дотор нь орсон юм шиг сайн мэддэг л гэнэ. Энэ гомдлын жагсаалт хэзээ ч дуусахгүй. Асуудалтай нүүр тулж, найдвараа тээхийн оронд хүмүүс аль болох асуудал зөрчилгүй амар тайван газрыг л барааддаг.

Цорын ганц төгс пастор бол Есүс гэдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Тэгвэл та яагаад асуудалтайгаа нүүр тулж шийдэхийн оронд зугтана вэ? Эдгээр зөрчлийг түрүүлж хазаарлахгүй бол, бид гомдол тээж хоцорно. Заримдаа эш үзүүлэх үйлчлэлийг маань хүлээж аваагүйн маань төлөө бид өө сэвгүй удирдлагатай газрын эрэлд гардаг.

Тухайлбал, би өнгөрөгч 14 жилийн хугацаанд хоёр өөр мужийн хоёр чуулганы л гишүүн явлаа. Надад удирдлагадаа гомдох нилээд олон боломж байсан (Ихэнх нь миний өөрийн алдаа, төлөвшөөгүй зангаас болсныг хэлэх хэрэгтэй). Надад удирдлагаа муулж, шүүмжилж, хаяж явах боломж байсан. Гэхдээ явах нь хариулт биш байв. Нэгэн удаа байдал ид хурцдаж байх үед Эзэн надад Бичээсээрээ ийн хэлэв: “Би чамайг чуулганаасаа явбал ингэж л яваасай гэж хүсч байна.”

Учир нь чи баяртайгаар гарч явж, *амар тайвнаар* хөтлүүлнэ.
Исаиа 55:12

Ихэнх хүмүүс ингэж явдаггүй. Тэд чуулганыг юу дуртайгаа сонгож авдаг цайны газар гэж санадаг бөгөөд асуудал үүсээгүй нөхцөлд л үлдэж! Гэхдээ энэ бүхэн нь Библийн сургаалтай таарахгүй байна. Хаана, ямар чуулганд явахаа та шийддэг юм биш. Бурхан шийднэ! Библи “... Бурхан та бүхний хүссэнчлэн эрхтэн бүрийг биед байрлуулжээ” гэж хэлээгүй. Библи “*Бурхан Өөрөө хүссэнчлэн эрхтэн бүрийг биед байрлуулжээ*” (1Коринт 12:18) гэж хэлдэг.

Та Бурханы хүссэн газарт байвал, диавол таныг гомдоож тэндээс чинь холдуулахыг хүсэх нь лавтай. Диавол Бурханы эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг Бурханы суулгасан газраас нь сугалахыг хүсдэг. Тэгээд таныг сугалж чадвал, диавол зорилготоо хүрнэ. Харин хэрэв та хамгийн хурц зөрчил дунд ч хөдлөшгүй байж чадвал, диаволын төлөвлөгөөг нураана.

АЮУЛТАЙ ХУДАЛ

Би нэг цуглаанд нилээд хэдэн жил явсан юм. Тэр цуглааны пастор нь Америкийн шилдэг номлогч нарын нэг байлаа. Би анх тэнд очихдоо номхон суугаад л, түүний амнаас гарах библийн сургаалыг амьсгаа даран сонсдог байв.

Цаг хугацаа өнгөрсөөр би мөнөөх пастортай арай ойр ажиллах болсон тул өө сэвийг нь ч олж үздэг болов. Түүний гаргаж буй үйлчлэлийн зарим шийдвэрт эргэлздэг болов. Тэгээд пасторыгаа юм л бол шүүж, шүүмжилдэг болсон тул миний дотор гомдол суурьшаад авчээ. Түүнийг номлох үед би ямар ч онгод, тосолгоо хүлээж авахаа байж, номлол нь надад хүрэхээ болив.

Тэгтэл манай чуулганд үйлчилдэг өөр нэгэн найз гэр бүл маань яг энэ асуудалтай тулгарчээ. Бурхан тэднийг чуулганаас илгээж, тэд өөрийнхөө үйлчлэлийг эхлүүлэх нь тэр. Тэд бид хоёрыг хамт явахыг хүслээ. Тэд биднийг зөрчилдөж байгааг мэдэж байв. Тиймээс явж дуудлагаа биелүүл хэмээн урамшууллаа. Тэгээд пасторын, гэргийнх нь, удирдагч нарынх нь бурууг хэлэлцэв. Бид биесээ хөөрхийлсөөр, урхинд улам л шигдэж, улам л цөхөрч байлаа.

Тэд бидний төлөө чин сэтгэлээсээ санаа тавьж байв. Гэвч бидний яриа гомдол, гонсгор байдал дээр маань л тос нэмээд байв. Сургаалт үгс 26:20 “Түлээ дутбал гал унтарна. Хов жив зөөгч байхгүй бол хэрүүл маргаан намжина” гэдэг. Тэдний яриа нь үнэн мэдээлэл боловч, тэдний дотор ч, бидний дотор ч гомдлын галд түлээ нэмж байсан учраас, Бурханы мэлмийд буруу байв.

“Чи бол Бурханы хүн. Тиймээс л энэ газарт ингэж зовж байна” гэсэн үг нь чихэнд чимэгтэй байлаа.

Гэргий, бид хоёр хоорондоо: “Үнэхээр ч бид энэ хэцүү байдлаасаа гарах ёстой. Хоёр найз маань бидэнд хайртай. Тэд бидний пастор болог. Тэдний чуулганы хүмүүс биднийг, бидний үйлчлэлийг хүлээж авна” гэж ярилцав.

Тэгээд чуулганаа орхиж, мөнөөх хосын чуулганд явж эхэлсэн боловч, хэдхэн сар л болсон юм. Бид асуудлаасаа зугтсан боловч, зөрчилдсөөр л байгаагаа харлаа. Сүнсэнд маань баяр хөөр байхгүй. Бид өөрсдөө орхиж явсан тэр “асуудал” болчих бий гэсэн айдас биднийг нөмрөв. Бид Сүнстэй хамт урсаж чадсангүй. Сүүлээрээ шинэ пастор, гэргий хоёртой нь ч харилцаа маань ганхаж эхлэв.

Эцэстээ би хуучин чуулгандаа эргэж очих ёстойгоо мэдсэн юм. Хэдийгээр бид өөр газарт илүү хайрлуулж, хүлээн зөвшөөрөгдөж болох ч, эргэж ирэхдээ дахин Бурханы хүсэл дотор орсноо мэдэв.

Тэгтэл Бурхан: “Жон, Би чамайг энэ чуулганаас яв гэж хэзээ ч хэлээгүй. Чи гомдсондоо л явсан!” гэж хэлж намайг цочоов.

Энэ нь нөгөө хосын биш, бидний алдаа байж. Тэд бидний зовлонг ойлгож, өөрснийхөө зүрхэн дэхь асуудлыг ч шийдэх гэж хичээж байж. Хүн Бурханы хүслээс гарбал, ямар ч чуулганд тус, ерөөл болж чадахгүй. Бурханы хүслээс гарбал, сайн сайхан харилцаа ч гажина. Бид Бурханы хүслээс гарсан байжээ.

Гомдсон хүмүүс нөхцөл байдалдаа мэдрэмж үзүүлж, Бурхан хэлээгүй байсан ч хамаагүй, зөв гэж харагдсан зүйлээ л хийдэг. Бид мэдрэмж үзүүлэхээр бус, үйлдэхээр дуудагдсан.

Бид Бурханд дуулгавартай байж, Түүнийг хайх үед Бурхан хариулахгүй байвал, хариулт нь юу болохыг та мэдэх үү? Бурхан магадгүй “Наанаа үлд, юугаа ч битгий өөрчил” гэж л байгаа байх.

Бид дарамтанд орохоороо, биднийг тайтгаруулах үгийг

Бурханаас хайж эхэлдэг. Гэтэл Бурхан биднийг устгахын төлөө бус, харин төлөвшүүлж, шинэчилж, хүчирхэгжүүлэхийн тулд таагүй нөхцөл байдалд оруулах!

Сарын дотор би хуучин чуулганыхаа пастортай уулзаж, шүүмжлэмтгий, эсэргүү загнасныхаа төлөө уучлал гуйсанд, тэрбээр намайг өгөөмөр сэтгэлээр уучилсан юм. Бидний харилцаа бэхжиж, миний зүрхнээс дахин баяр хөөр ундрал. Би дахиад л пасторынхаа үгээр тэжээгдэж, тэр чуулгандаа дахиад олон жил болсон билээ.

СУУЛГАГДСАН НЬ Л ЦЭЦЭГЛЭНЭ

Дуулал 92:13: “Эзэний өргөөнд суулгагдсан тэд бидний Бурханы хашаанд цэцэглэнэ.”

Эзэний өргөөнд “суулгагдсан” нь л цэцэглэхийг тэмдэглэнэ үү. Алив ургамлыг гурван сар тутамд шилжүүлэн суулгаад байвал, яах уу? Ургамлын үндэс нь цочирч, ургамал соёолж, цэцэглэхгүй гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Хэрэв үргэлжлүүлэн шилжүүлэн суулгаад байвал, ургамал хямарч, үхнэ!

Олон хүн үйлчлэлээ хөгжүүлэх гэж нэг чуулганаас нөгөө рүү, нэг үйлчлэлээс нөгөө рүү яваад л байдаг. Бурхан тэднийг хэн ч хүлээн зөвшөөрдөггүй, урамшуулдаггүй газар тавьбал, тэд амархан гомдоно. Хийсэн ажилтай нь хүмүүс санал нийлэхгүй байвал, гомдоод, яваад өгнө. Тэд зан чанарынхаа дутагдлыг хардаггүй бөгөөд Бурхан тэднийг дарамтаар дамжуулан шинэчилж, төлөвшүүлэх гээд байгааг ухаардаггүй.

Мод ба ургамлын жишээгээр дамжуулж Бурхан юу зааж байгааг сурцгаая. Жимсний модыг суулгасны дараа энэ мод усан бороо, халуун нар, хүчит салхинд нүдүүлнэ. Хэрэв нялх мод ярьж чаддаг бол “Намайг эндээс аваач! Аагим халуун, хүчтэй салхи, хүйтэн бороогүй газар тавиагч” гэж хэлэх байх.

Цэцэрлэгч модны үгэнд орбол, модыг аврах бус, алж орхино. Мод үндсээрээ хөрс рүү улам шигдэж, халуун нар, усан бороог даван туулдаг. Тулгарч байгаа бэрхшээл нь эцэстээ модны тогвортой байдлын үндэс болдог. Модыг хүрээлэх элемент, хатуу ширүүн нөхцөл нь модыг амьдралын өөр эх үүсвэр хайхад хүргэдэг байна. Тэгээд нэг өдөр тэр мод ямар ч хар шуурга үр жимсийг нь тасалдуулашгүй бүдүүн мод болно.

Олон жилийн өмнө би цитрус жимсний нийслэл болох Флоридад аж төрдөг байлаа. Өвөл хүйтэн байх тусам, чихэрлэг жүрж ургадгийг Флоридачууд сайн мэднэ. Бид ч бас сүнсний эсэргүүцлээс зугтаж алга болоод байхгүй бол, үндсийн систем маань улам гүнзгийрэн, бэхжиж, үр жимс маань Бурханы мэлмийд чихэрлэг бөгөөд арвин байж, бүгдэд хүрэлцэнэ! Бид үр жимсгүйгээсээ болоод суга татуулдаг бус, харин Эзэний мэлмийг баясадаг, боловсорсон мод болно (Лук 13:6-9-ийг үзнэ үү). Биднийг төлөвшүүлэхийн тулд Бурханы ашиглаж буй юмсаас бид зугтах ёсгүй.

Ариун Сүнсээр хөглөгдсөн магтаалч Давид гомдол - Бурханы хууль - бидний сүнсний өсөлтийн хооронд хүчтэй уялдаа тогтоожээ:

Эзэний хуульд баярлаж; Түүний хуулийг өдөр шөнөгүй тунгаан бясалгадаг хүн ерөөлтэй еэ! Дуулал 1:1-2

Дараа нь Дуулал 119:165 дээр тэрбээр Бурханы хуульд хайртай хүмүүст илүү ухаарал хайрлажээ:

Таны хуулийг хайрлагчид агуу амар амгалан байдаг бөгөөд тэднийг юу ч *гомдоохгүй*.

Тэгээд нэгдүгээр бүлгийн гуравдугаар ишлэлд энэ хүний хувь тавиланг хэлжээ:

Тэрбээр урсгал усны дэргэд тарьсан *мод* адил билээ. Тэр мод цагтаа үр жимсээ ургуулдаг бөгөөд навчис нь ч хатдаггүй.

Өөрөөр хэлбэл, бэрхшээл дунд ч Бурханы Үгийг хайрлахыг сонгодог хүн гомдлоос сэргийлнэ. Тэрбээр үндэс нь Сүнсний хангаж өгдөг хүч, тэжээл рүү тэмүүлдэг модтой адил юм. Тэр хүн сүнснийхээ гүн дэхь Бурханы худгаас ундаална. Энэ нь түүнийг дайсагнал нь үр жимс авчрах өөрчлөгч хүчин зүйл болдог цэгт хүргэнэ. Халлелүяа!

Одоо бид Есүсийн айлдсан үр тарианы сургаалын тайлбарыг ойлгодог боллоо.

Үүнчлэн эдгээр нь чулуурхаг газарт унагсад бөгөөд тэд үгийг сонсоод тэр даруй баяртайгаар хүлээн авдаг. Өөрсдөд нь бат үндэс байхгүй, харин тэд түр зуурынх бөгөөд дараа нь үгнээс болж зовлон, хавчлага тохиолдоход тэд *тэр даруй унадаг (гомддог)*. Марк 4:16-17

Та Бурханы танд сонгож өгсөн газрыг орхибол, үндсийн систем чинь муудаж эхэлнэ. Та өөрийгөө лав үндэслүүлээгүй учраас, дараагийн удаа танд дайсагналаас зугтчих нь амар байна. Тэгсээр та бэрхшээл юмуу дайсагналыг давах өчүүхэн юмуу эсвэл ямар ч хүчгүй болох болно.

Тэгээд хүмүүсийн хандлагаас айж сүрдэж, нэг газраас нөгөө рүү тэнэж явдаг сүнсний бадарчин болно. Жинхэнэ сүнсний үр жимс гаргах чадвар чинь хатангиршсан тул та амиа хойхоолсон амьдралынхаа тойрогтоо зөрчилдөж, бусдын үр жимсний хаягдлаар л амьдарна.

Адамын хөвгүүд Каин, Абел хоёрыг л хар. Каин гарынхаа үр жимсийг буюу усан үзмийнхээ үр жимсийг Эзэнд өргөл болгон авчирчээ. Энэ үр жимсийг асар их хөдөлмөрөөр ургуулсан. Газраа хайрга чулуу, хагархай хугархайгаас цэвэрлэж, хөрсөө боловсруулж, үрээ суулгаж, усалж, бордож, хамгаалсан. Каин Бурханд маш хичээнгүй үйлчилсэн. Гэхдээ энэ нь Бурханы арга замд дуулгавартай үйлдэл бус, харин өөрийнх нь л золиос байжээ. Энэ нь Бурханыг Өөрийнх нь нигүүлслээр бус, харин хүний хүчээр хүндэтгэх хүндэтгэлийг билэгдэж байв.

Нөгөөтэйгүүр, Абел дуулгавартай байдлынхаа өргөлийг буюу сүргийнхээ ууган төлийг бөгөөд өөхийг өргөсөн. Тэрбээр өргөлөө Каин шиг хуруу хумсаа хуйхалж байж авчраагүй ч, нандигнаж авчирсан. Аав, ээжийнх нь нүцгэн биеэ инжрийн навчаар халхалсан үйлдэл нь нүглээ нуух гэсэн хүмүүний үйлсийг л билэгдэж байсныг тэд хоёулаа л сонссон. Гэтэл Бурхан Адам, Ева хоёрыг гэмгүй малын арьсаар бүтээхдээ, хүлээн зөвшөөрөгдөх өргөл гэж юу байдгийг харуулжээ. Адам, Ева хоёр нүглээ хүлээн зөвшөөрөгдөхгүй аргаар халхалснаа өөрсдөө ч мэдээгүй байж. Харин Бурхан арга замаа үзүүлэхэд, тэд ч, хүүхдүүдэд нь ч мэдэж авчээ.

Каин Бурханы зөвлөгөөг авалгүйгээр, тааллыг нь олох гэж оролдсон байна. Гэтэл Бурхан түүнд Өөрийнх нь параметр дор (Абелын золиос) байгаа хүмүүсийг л хүлээж авдаг бөгөөд “сайн

муугийн мэдлэгийн” ноёрхол дор хийгдсэн зүйлийг (Каины шашинлаг үйлс) хүлээж авдаггүй болохоо харуулсан. Тэгээд Каинд сайныг үйлдбэл, Бурханд таалагдана, харин амийг сонгохгүй бол, нүгэл түүнийг эрхшээнэ гэжээ.

Каин Бурханд гомдсон. Тэрбээр гэмшин зөвийг үйлдэж, үүгээрээ зан чанараа бэхжүүлэхийн оронд Бурханд гомдож, уурласан уураа Абелд гаргаж, амийг нь хөнөөжээ. Бурхан Каинд ингэж хэлсэн:

Газар амаа ангайж, чиний гараас дүүгийн чинь цусыг авсан тул чамд газраас хараал хүрч, чамайг газар хагалахад газар *чамд дахин үр жимсээ хайрлахгүй*. Чи газар дэлхий дээр *хэрэн тэнүүчлэгч* болно. Эхлэл 4:11-12

Каин Бурханд таалагдахгүй байх гэсэн хамгийн том айдсаараа л өөрийгөө хөөджээ. Бурханы тааллыг олох гэж оролдсон тэр зүйлээ эдүгээ өөрийн гараар хараажээ. Цус урсгасан явдал нь эдүгээ хараал буулгажээ. Газар цаашид түүнд хүчээ өгөхгүй. Үр жимс нь үлэмж хөдөлмөрийн үр дүнд л ургана.

Гомдсон итгэгч нар үр жимс ургуулах чадвараа өөрийн гараар тасддаг. Есүс үр тарианы сургаалт үлгэртээ зүрхийг хөрсөөр зүйрлэсэн. Каины тариан талбай үр жимсгүй болсон шиг, хүний гомдсон зүрх хорслоор хордож, үр жимсгүй болдог. Гомдсон хүмүүс амьдралдаа гайхамшиг, хэлээр ярих, хүчтэй номлол үздэг. Гэхдээ эдгээр бэлэг нь Сүнсний бэлэг болохоос, үр жимс биш. Бид үр жимсээрээ шүүгдэхээс биш, бэлгээрээ шүүгдэхгүй. Бэлэг өгөгддөг бол, үр жимс боловсордог.

Каин хийсэн зүйлээсээ болж бадарчин болно гэж Бурхан айлдсаныг анхаарна уу. Өнөөдөр чуулганууд сүнсний бадарчдаар дүүрэн. Тэд гомдол тээсээр, бэлгийг нь хүлээж аваад, шархыг нь эдгээгээд өгөх төгс чуулганы эрэлд зорилгогүй тэнүүчилсээр.

Тэд өөрийгөө хавчигдаж буй хохирогч гэж үздэг. Тэд орчин цагийн Иеремиа шиг л “Бүгдээрээ Бурхан, бид хоёрын эсрэг” гэж боддог. Тэд үг авдаггүй. Тэд миний хэлдгээр “Бүгдээрээ миний эсрэг” гэдэг хавчигдагчийн хам шинжтэй. Тэд өөрийгөө хавчигдаж буй, Бурханы ариун хүн, эш үзүүлэгч хэмээн аргадаг. Тэд бүгдийг хардаж сэррдэг. Каин яг л ингэсэн. Түүний үгийг үз дээ:

... би Таны хараанаас далд орж, газраар хэрэн тэнүүлчлэгч болно. *Надтай уулзсан хэн боловч намайг ална.* Эхлэл 4:14

Каин бүгдээрээ намайг алах гэж байна гэсэн хавчигдагчийн хам шинжтэй байж! Өнөөдөр ч ялгаагүй. Ийм хандлагатай хүмүүс өөрчлөх шаардлагатай амьдралынхаа талбарыг харж чаддаггүй. Тэд олноос хөндийрч, хүчирхийллийг хөхүүлсэн янзтай биеэ авч явдаг.

Адайр хүн хувийн хүслээ эрж хайдаг бөгөөд хамаг саруул ухааны эсрэг тэрсэлнэ. Сургаалт үгс 18:1

Бурхан биднийг хэзээ ч өөр хоорондоо тусгаар аж төрөхөөр бүтээгээгүй. Хүүхдүүд нь бие биедээ санаа тавьж халамжилж байхад Бурхан дуртай. Биднийг өөрийгөө эвийлж, аз жаргалаа бусдаас нэхэхэд Бурхан дургүй. Бурхан биднийг гэр бүлийнхээ идэвхитэй гишүүн байгаасай гэж хүсдэг. Ганцаардмал хүн Бурханы бус, өөрийнхөө л хүслийг хайдаг. Тэрбээр зөвлөгөө авдаггүй бөгөөд заль мэхэнд нээгддэг.

Би Бурхан хувь хүнийг сургаж, сэргээхээр дууддаг, тусгай улирлын талаар яриагүй, харин өөрийгөө хорьчихдог хүмүүсийн талаар ярьж байгааг минь ойлгоорой. Тэд чуулганаас чуулган руу, харилцаанаас харилцаа руу тэнэж, өөрийнхөө ертөнцөд тусгаарлагдана. Тэд өөртэй нь санал нийлээгүй хүмүүсийг буруу бөгөөд өөрийнхөө дайсан гэж үздэг. Тэд тусгаарлалтаараа өөрийгөө хамгаалж, өөрийнхөө цогцлоосон орчиндоо л аюулгүй. Тэд зан чанарынхаа доголдолтой нүүр тулдаггүй. Бэрхшээлтэй нүүрэлдэхийн оронд зүгээр л шалгалтаас зугтана. Бусадтай үүссэн зөрчлийг шийдвэрлэх үед л төрдөг зан чанарын хөгжил нь алдагдаж, гомдлын тойрог дахин эхэлнэ.

ГОМДЛОО ТОРДДОГ ХҮН БУСДЫГ БУРУУТГАДАГ УЧРААС ӨӨРИЙНХӨӨ ЗАН ЧАНАРЫН АЛДААГ ХАРДАГГҮЙ.

Миний хань бид хоёр олон жил бусдад гомдож, шархалж явлаа. Хэдийгээр бид хоёр олон жил нэгэн онцсайн цуглаанд итгэмжтэй явсан боловч, яваандаа хүн бүхэн л бидэнд дургүй байгаа юм шиг санагдаж, ганц хоёрхон найзтай, ганцаардмал байдалд оров. Тэгтэл таны Сатаны урхи номыг уншаад бүх зүйл өөрчлөгдөх нь тэр. Би өөрийнхөө үл уучлал, гомдолтой нүүр тулж, Бурханы тусламжтай чөлөөлөгдсөн!

- C. G., BELFAST, IRELAND

6

БОДИТ БАЙДЛААС НУУГДАХУЙ

*... тэд үргэлж суралцавч, үнэний мэдлэгт
хэзээ ч хурч чадахгүй.*

2Тимот 3:7

Хүмүүс надаас: “Би чуулганаасаа эсвэл үйлчлэлээсээ яг хэзээ нь явах вэ? Байдал хэр дордож байж явах уу?” гэж их асуудаг. Хариуд нь би: “Хэн таныг одоогийн чуулган руу чинь илгээсэн бэ?” гэж асуудаг.

Дийлэнх нь “Бурхан илгээсэн” гэж хариулна. Тэгэхээр нь би: “Бурхан илгээсэн юм бол, Бурхан чөлөөлтөл битгий яв!” гэж хэлдэг.

Бурхан яв гэж хэлбэл, үйлчлэлийн нөхцөл байдал чинь ямар байсан ч хамаагүй, та амар тайвнаар гарч явах болно.

Учир нь та баяртайгаар гарч явж, амар тайвнаар хөтлүүлнэ.
Исаиа 55:12

Таны явдал бусдын үйлдэл, авир дээр бус, харин Сүнсний удирдамж дээр үндэслэнэ. Тиймээс юмс муудсан учраас, үйлчлэлээ орхиж явдаг юм биш.

Биднийг гомдсон, шүүмжтэй сүнстэй явуулах нь Бурханы төлөвлөгөө биш. Энэ бол Бурханы удирдамж дээр тулгуурласан

үйлдэл бус, зүгээр л мэдрэмж үзүүлж байгаа хэрэг юм. Ром 8:14 дээр “Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм” гэдэг. “Хүнд нөхцөл байдалд мэдрэмж үзүүлж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд юм” гэж хэлээгүйг тэмдэглээрэй.

Шинэ гэрээ хүүг *текнон*, *хуиос* гэдэг хоёр Грек үгээр нэрлэдэг. *Текнон* нь “биеэс төрсөн хүүг”¹ нэрлэдэг үг.

Ууган хүү Аддисон маань Лиза, бид хоёрын дундаас төрсөн учраас л миний хүү болсон. Түүнийг амаржих газар баахан нярайн дунд байхад нь зан чанарыг нь хараад л Жон Бивэрийн хүү байна гэж хэн ч хэлэхгүй. Найз, гэр бүлийнхэн маань ч бугуйвчийг нь харахаас нааш миний хүүг таниагүй. Аддисон бол Жон, Лиза хоёрын *текнон*.

Ром 8:15-16 дээр *текноны* тухай ярьдаг. Бид үрчлэлийн Сүнсийг хүлээн авсан учраас, “Биднийг Бурханы хүүхдүүд (*текнон*) гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг” гэжээ. Хүн Есүс Христийг Эзэнээ болгохдоо, шинэ төрөлтөөр дамжин Бурханы хүүхэд болдог (Иохан 1:12-ыг үзнэ үү).

Шинэ гэрээнд хөвгүүдийг бас *хуиос* гэдэг. Шинэ гэрээ энэ үгийг “аав, ээжийнхээ зан чанарыг харуулдаг учраас, хүү нь хэмээгдэх нэгэн”² гэх утгаар их хэрэглэдэг.

Аддисон өсөхийн хэрээр яг л аав шигээ төрхтэй, ааш араншинтай болов. Аддисоныг зургаатай байхад Лиза, бид хоёр өвөө, эмээтэй нь орхиод, аяллаар явсан юм. Ээж маань Лизад “Аддисон аавыгаа өвчжээ” гэж хэлсэн гэдэг. Би зургаатай байхдаа, яг л тэгж аашилдаг байж. Аддисон өсөх тусмаа, улам л аавтайгаа адил болсон юм. Эдүгээ Аддисон биеэс маань төрсөн учраас төдийгүй, аавтайгаа адилхан зан чанар, хувь чанартай учраас, Жон Бивэрийн хүү мөн.

Тиймээс товчхондоо, *текнон* нь “төлөвшөөгүй хөвгүүд, нярай” гэсэн утгатай бол, *хуиос* нь “төлөвшсөн хөвгүүд”³ ажээ.

Ром 8:14-ийг дахин харъя: “Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд (*хуиос*) юм.” Гагцхүү төлөвшсөн хөвгүүд л Бурханы Сүнсээр удирдуулдгийг бид тодорхой харж байна. Төлөвшөөгүй Христэд итгэгч хүмүүс Бурханы Сүнсний удирдамжийг дагах магадлал багатай, ихэвчлэн тулгарсан нөхцөл байдалдаа мэдрэмжээр юмуу ухаанаараа ханддаг. Тэд Бурханы Сүнсний удирдамжаар үйлдэж хараахан сураагүй байдаг.

Аддисоныг биеэр өсөхийн зэрэгцээ зан чанарынх нь өсөлт өрнөв. Төлөвших тусам, би түүнд илүү том үүрэг хариуцлага даалгана. Аддисон төлөвшихгүй байх нь буруу. Бурхан биднийг нялхаараа үлдээсэй гэж хүсдэггүй.

Хүүг маань зан чанараар өсгөсөн нэгэн зам нь бэрхшээл байв. Аддисон сургуульд ороод хэдэн дээрэлхүү жаалтай учирсан юм. Тэр дүрсгүй хүүхдүүдийн миний хүүд гаргаж байгаа зарим нэг үйлдэл, үгийг сонсохоор, очоод үзүүлээд өгмөөр болдог байлаа. Гэхдээ энэ буруу гэдгийг би мэднэ. Миний оролцоо Аддисоны өсөлтөд садаа хийнэ.

Тиймээс гэргий, бид хоёр гэртээ хүүгээ сургууль дээрх хавчлагад нь дасгалжуулан, зааж зөвлөдөг байв. Аддисон зовлон дундаа аав, ээжийнхээ зөвлөгөөг дагахдаа, өссөн юм.

Энэ явдал Бурханы сургаалтай яг таардаг. Библи “Тэр [Есүс] Хүү [Хүиос] нь байсан хэрнээ *зовсон* зүйлсээсээ дуулгавартай байдалд суралцсан” (Еврей 5:8) гэдэг.

Биеийн өсөлт нь цаг хугацааны үйл ажиллагаа юм. Хоёр настай хүүхэд хоёр метр байхгүй нь тодорхой. Оюуны өсөлт нь сурлагын үйл ажиллагаа юм. Сүнсний өсөлт нь цаг хугацааны ч, сурлагын ч бус, дуулгавартай байдлын үйл ажиллагаа юм. Петрийн үгийг харцгаая.

Иймээс Христ нэгэнтээ махан биеэрээ зовсон тул та нар ч гэсэн ижил зорилгоор өөрийгөө зэвсэглэ. Яагаад гэвэл *махан биеэрээ зовсон нь нүгэл хийхээ больсон*. 1Петр 4:1

Нүгэлхийхээ больсон хүн нь Бурханы төлөвшсөн, дуулгавартай хүүхэд мөн. Тэр өөрийнхөө бус, Бурханы замыг сонгодог. Есүс зовсон зүйлээрээ дуулгавартай байдалд суралцсан бол, бид хүнд хэцүү нөхцөл байдлаар дамжин дуулгавартай байдалд суралцдаг. Бид Ариун Сүнсний хэлсэн Бурханы үгийг дагахдаа, зөрчил, зовлонгийн цагтаа өсч төлөвшдөг. Үүний гол оньс нь Бичээсийн талаарх бидний мэдлэг биш, харин дуулгавартай байдал юм.

Чуулганд хорин жил явчихсан, Библийг хаанаас нь ч ишлэж чаддаг, хэдэн мянган сургаал сонссон, олон олон ном уншсан атлаа сүнсний живхээ тайлаагүй хүмүүс чуулганд олон байдгийг одоо л бид ойлголоо. Тэд бэрхшээлтэй тулгарах бүрийдээ Бурханы Сүнсээр хариулахын оронд өөрийнхөө арга замаар өөрийгөө хамгаалах гэж оролддог.

“Тэд үргэлж суралцавч, үнэний мэдлэгт хэзээ ч хүрч чадахгүй” (2Тимот 3:7). Тэд хэрэгжүүлдэггүй учраас, үнэний мэдлэгт хэзээ ч хүрдэггүй.

Бид өсч төлөвших гэж байгаа л бол, амьдралдаа үнэнийг нэвтрүүлэх ёстой. Үнэнийг дуулгавартай дагалгүйгээр дан ухаанаараа хүлээн зөвшөөрч болохгүй. Тасралтгүй сурсаар байв ч, дуулгаваргүй учраас, хэзээ ч төлөвшихгүй.

ӨӨРИЙГӨӨ ӨМГӨӨЛӨХҮЙ

Өөрийгөө өмгөөлж, дуулгаваргүй авирлахын түгээмэл нэгэн шалтаг нь гомдол билээ. Гомдлоо өмөөрсөн хүн өөрийгөө өмгөөлж байна гэсэн хуурамч мэдрэмж тээдэг. Гомдсон хүн өрөөлийг буруутгадаг учраас, өөрийнхөө дутагдлыг олж үзэхгүй. Тэд гагцхүү бусдын алдааг л харахаас биш, хэзээ ч өөрийнхөө дүр, төлөвшилгүй байдал, нүгэлтэйгээ нүүрэлдэхгүй. Тиймээс энэ боломжоор дамжуулж таны дотор зан чанар хөгжүүлэх Бурханы зүтгэл талаар болно. Гомдсон хүн гомдлынхоо эх үүсвэрээс дөлж, эцэстээ зугтаад, сүнсний бадарчин болдог.

Саяхан нэгэн эмэгтэй надад нэг чуулганаас нөгөө рүү явсан найзынхаа тухай ярьсан юм. Тэгээд шинэ пастораа оройн зоогт урьжээ. Хооллож байх зуураа пастор нь түүнээс өмнөх чуулганаасаа яагаад явсныг нь асуутал, эмэгтэй өмнөх чуулганыхаа удирдлагын түмэн алдааг тоочжээ.

Энэ бүхнийг сонссон пастор нь эмэгтэйг тайвшруулах гэж оролдож. Миний туршлагаар бол, тэр пастор эмэгтэйг Бурханы үгээр урамшуулж, шүүмж, шархаасаа эдгэрэхийг сэнхрүүлсэн бол, зөв болох байсан. Бүр боломжтой бол, Бурхан амар тайвнаар явуулах хүртэл нь өмнөх чуулгандаа эргэж очихыг санал болгох байж.

Бурхан хүмүүсээ амар тайвнаар явуулах үед та явж байгаа шалтгаанаа бусдын өмнө зөвтгөх дарамтгүй байна. Та өмнөх чуулганыхаа асуудлыг шүүмжилж, илчлэх ч дарамтгүй байна. Хэсэг хугацааны дараа тэр эмэгтэй шинэ пастортаа болоод түүний удирдлагад ч яг л өмнөх чуулгандаа хандсан шигээ хандахыг нь би мэдэж байна. Бид зүрхэндээ тээсэн гомдлоороо л бүхнийг шүүнэ.

Энэ нөхцлийг яг оноод хэлчихсэн хуучны нэгэн сургаалт

үлгэр байдаг сан. Зэрлэг Баруунд хүмүүс дөнгөж суурьшиж эхэлж байхад нэгэн сэргэлэн хөгшин шинэ хотын гаднах уулан дээр тухалжээ. Зүүн Зүгээс шинэ суурьшигчид ирэхдээ, хамгийн түрүүнд мөнөөх хөгшинтэй уулзан, шинэ хотын иргэдийн талаар сонирхож асууна.

Хөгшин өөдөөс нь “Та нарын ирсэн хот чинь ямар байв?” гэж асууна.

Зарим нь “Бидний ирсэн хот аймаар муухай. Гэмгүй хүмүүсийг дарладаг, бүдүүлэг, хов жив тараагч, худалч, хулгайч, луйварчдаар дүүрсэн дампуу хот” гэж хариулахад, хөгшин “Энэ хот ч ялгаагүй” гэж хариулдаг байв.

Гийчид өөрсдийг нь бас нэгэн муухай хотоос аварсан хөгшинд талархаад, цааш яваад өгнө.

Тэгтэл өөр нэгэн бүлэг хүмүүс ирээд: “Танай шинэ хот чинь ямар вэ?” хэмээн хөгшинөөс асуужээ.

Өөдөөс нь хөгшин: “Харин та бүхэн ямар хотоос ирэв?” гэж лавлав.

Тэд “Манай хуучин хот чинь гайхамшигтай хот байхгүй юу! Тэнд эрхэм сайхан анд нөхөд маань бий. Бүгд л бие биеэ халамжилдаг учраас, хэн ч юугаар ч дутахгүй. Нэгэнд нь мундаг санаа төрбөл, бүгд л ханцуй шамлан туслана. Ийм нөхдөө орхиж явах амаргүй шийдвэр байсан ч, бид ирээдүй үеийнхээ төлөө Баруун руу хоригдол болон ирлээ” гэнэ.

Сэргэлэн өвгөн өмнөх бүлэгт хэлсэн үгээ л хэлэв: “Энэ хот ч ялгаагүй.”

Нөгөө хүмүүс: “Хөөх, тэгвэл энд суурьшъя!” хэмээн хөл хөөрцөг болов.

Хүмүүс хуучин харилцаагаа харж буй нүдээрээ л ирээдүйгээ жинлэдэг.

Та хуучин чуулганаасаа юмуу харилцаанаасаа яаж явна, шинэ харилцаанд яг тийм янзаараа хөл тавина. Иохан 20:23 дээр Есүс: “Та нар хэний нүглийг уучилна, тэд уучлагдана. Та нар хэний нүглийг үл уучилна, тэд үл уучлагдана” гэж айлдсан.

Бид бусдад гомдож, эсэргүүцлийг тээхдээ, хүмүүсийн нүглийг хадгалдаг. Хэрэв бид аль нэг чуулганаас эсэргүүцэж, хорссоор явбал, удаах чуулгандаа яг л тийм хандлагаар очно. Тэгээд асуудал үүсэх үед дараагийнхаа харилцааг амархан орхино. Бид шинэ харилцааныхаа асуудалтай төдийгүй мөн өнгөрсөн харилцааныхаа шархтай давхар давхар тулгардаг.

Салсан хүмүүсийн 60-65 хувь нь дахиж гэрлэсэн нөхцөлд дахин салдаг гэсэн статистик бий. 4 Хүн эхний гэрлэлтээ орхисон тэр л янзаараа хоёр дахь гэрлэлтийн амьдралдаа хөл тавьдаг. Эхний нөхөр, эхнэртээ гомдсон гомдол нь тухайн хүнийг хоёр дахь гэрлэлтээ босгон байгуулахад нь саад хийнэ. Тэд бусдыг буруутгахдаа, өөрийнхөө дүр, алдаатай зан чанарыг хардаггүй. Дээрээс нь тэд дахин шархдахаас айх айдастай болжээ.

Энэ зарчим гэрлэлт ба салалтаар хязгаарлагдахгүй, бүх харилцаанд хэрэгжинэ. Тухайлбал, өмнө өөр нэг үйлчлэгчийн төлөө ажиллаж байсан нэгэн хүн манай үйлчлэлийн багт нэгдсэн юм. Тэрбээр өмнөх удирдагчдаа гомдсон болов ч, тэр явдлаас хойш нилээд цаг хугацаа өнгөрсөн бөгөөд Эзэн надад түүнд хамт ажиллах санал тавихыг хэлээд байх шиг санагдав. Би түүнийг гомдлоо ялах явц дундаа л яваа гэж бодлоо.

Тэгээд түүний өмнөх удирдагч руу утасдаад, нөгөө хүнийг ажилд авах санаагаа хэлэв. Удирдагч нь намайг дэмжиж, зөв нүүдэл хэмээлээ. Учир нь тэр удирдагч намайг тэдний хэн, хэнийх нь төлөө санаа тавьж байгааг мэдэж байв. Тэгээд нөгөө хүн манай багт байхдаа бүрэн эдгэрнэ гэдэгт итгэлтэй байгаагаа хэлсэн юм. Би ч тэр хоёрын эдгэрэл, сэргэлтийн төлөө залбирч байгаагаа хэллээ.

Гэтэл нөгөө хүн манай үйлчлэлд оров уу үгүй юу шууд л асуудал үүсэв. Ярилцав ч, асуудал хэсэгхэн хугацаанд л намжина. Тэрбээр өмнөх харилцаагаа даван туулж чадахгүй байх шиг л байлаа. Тэр явдал түүнийг ахин дахин эргэж, тамлаж байв. Тэр байтугай намайгаа ч өмнөх удирдагч шиг нь үйлдэж байна хэмээн яллав.

Миний хувьд, түүний ажил бус, эрүүл саруул байдал нь хавьгүй чухал байлаа. Би түүнийг эдгэрэхийг л харахыг хүсч байсан учраас, өөр ямар ч ажилтандаа олгодоггүй онцгой эрхийг олгодог байв.

Гэвч тэр хүн хоёрхон сарын дараа ажлаасаа гарч билээ. Урьдынхтайгаа яг адил нөхцөлд ороод: “Жон, би дахиж хэзээ ч үйлчлэхгүй” гэж хэлээд, яваад өгсөн юм.

Би ч түүнийг ерөөгөөд л, явахыг нь хараад л үлдэж билээ. Бид түүнд болоод түүний гэргийд хайртай. Мэдээж тэрбээр бусад талбар дээр амжилтанд хүрч болох ч, хамгийн гол нь баг дуудлагатай талбараа хаяж явсан нь харамсаад барашгүй.

Түүнийг явсны дараа надад хэцүү байсан учраас, би Эзэнийг хайв. “Эзэн минь, бид хоёр тийм сайхан санаа нийлж байхад, тэр яагаад ийм хурдан явчихав аа?”

Харин хэдэн долоо хоногийн дараа Эзэн нэгэн цэцэн пастораар дамжуулж энэ асуултад маань хариулсан юм: “Хүн хэрэв Бурханы нүүрэлдүүлэхийг хүсч буй нөхцөл байдлаас зүрхээрээ зугтаагаад байвал, Бурхан түүнийг биеэрээ зугтахыг нь зөвшөөрдөг.”

Тэгээд тэр Иезебелээс зугтсан Елиагийн түүхийг өгүүлэв (1Хаад 18-19-ийг үзнэ үү). Елиа Баал, Ашерагийн муу ёрын зөнчдийг цаазалсан. Учир нь тэд Иезебел хатны ширээнээс зооглодог, улс үндэстнийг шүтээнд урвуулсан хүмүүс байв. Иезебел энэ тухай дуулуутаа, Елиаг хорин дөрвөн цагийн дотор ална хэмээн занажээ.

Бурхан Елиаг Иезебелтэй нүүрэлдүүлэхийг хүссэн болов ч, Елиа зугтчихсан. Тэрбээр үхье хэмээн залбирахдаа тултлаа урам алдсан. Елиа даалгавар биелүүлэх нөхцөлгүй болчихсон байв. Бурхан тэнгэрэлчээ илгээн, Елиаг хоёр жигнэмэгээр хооллоод, түүнийг Хороб уул руу дөчин өдөр, дөчин шөнө гүйлгэжээ.

Елиаг зорьсон газартаа ирэхэд нь Бурхан хамгийн түрүүнд: “Елиа, чи энд юу хийж явна?” гэж асуужээ.

Хачин асуулт гэлтэй. Өөрөө эхэлж Елиаг хооллож, зугтахыг зөвшөөрчихөөд, хүрээд ирэхээр нь: “Энд юу хийж явна?” ч гэх шиг. Бурхан Елиаг бэрх байдлаас зугтдаг хүн болохыг нь мэдэж байж. Тиймээс хэдий хүсээгүй ч, зугтахыг нь зөвшөөрчээ.

Дараа нь Бурхан Елиад айлдруун: “Яв, Дамаскийн цөл рүү явах замаараа буц. ...Нимшийн хүү Иехүг Израилийн хаанаар томилон тослож бас Абел-мехолагийн Шафатын хүү Елишаг өөрийнхөө оронд эш үзүүлэгчээр томилон тосло” (1Хаад 19:15-16). Елишагийн болон Иехүгийн үйлчлэлээр мөнөөх бузар хатны муу ёрын тогтолцоо сөнөжээ (2Хаад 9-10). Энэ даалгаврыг Елиа бус, харин түүний тослон томилсон залгамжлагч нар нь гүйцэлдүүлсэн юм.

Тэр цэцэн пастор надад ингэж хэлж билээ: “Бид зүрхэндээ бэрх нөхцөлтэй нүүрэлдэхгүй гээд шийдчихбэл, Бурхан хүсэхгүй байсан ч, биднийг чөлөөлнө.”

Дээрхтэй яг адилхан тохиолдол Тооллого 22 дээр байдгийг хожим би санав. Балаам өндөр шагнал хүссэндээ, Израилийг хараахыг хүсдэг.

Тэрбээр эхлээд Бурханаас явж болох эсэхийг асуухад, Бурхан Балаамыг явуулах хүсэлгүй байгаагаа хэлсэн. Тэгтэл Моабын ханхөвгүүд бүр ч их алт, хүндэтгэл амласаар ирсэнд, Балаам дахиад л Бурханаас шалсан. Балаамыг илүү их шагнал, хүндэтгэлтэй болгохын төлөө Бурхан санаагаа өөрчилнө гэдэг инээдтэй хэрэг болов ч, энэ удаа Бурхан түүнд явахыг зөвшөөрчээ.

Бурхан яагаад санаагаа өөрчлөв? Бурхан санаагаа *өөрчлөөгүй*. Балаам өөрөө явахаар шийдсэн учраас, Бурхан хориогүй юм. Тиймээс л Балаамыг явсанд Бурхан хилэгнэжээ.

Ямарваа зүйлийн талаар Бурхан хэдийнээ хүслээ хэлчихээд байхад, бид Түүнийг шалсаар байвал, энэ нь Бурханы эх төлөвлөгөөг сөрсөн, бидэнд таагүйгээр эргэх явдал байсан ч, Бурхан бидэнд дураараа үйлдэхийг зөвшөөрнө.

Бурханы төлөвлөгөө биднийг зугтаадаг шарх, хандлагатайгаа мөргөлдөхөд хүргэдэг маань үнэн. Гэхдээ бид өөрийг маань илүү хүчтэй болгох яг тэр зүйлээсээ л зугтах. Бид гомдлоо шийдвэрлэхээс татгалзсанаараа, асуудлаас чөлөөлөгдөхгүй. Хэсэгхэн л амсхийнэ үү гэхээс асуудлын үндэс хэвээрээ л хоцорно.

Дээрх залууг ажилд авсан туршлага маань надад гомдол ба харилцааны талаар нэгийг сургасан юм. Нэг харилцааг гомдол, хорсолтой орхисон хүнтэй эрүүл саруул харилцаа тогтоох бараг боломжгүй. Эхлээд эдгэрэх шаардлагатай. Тэрбээр хуучин удирдагчаа уучилсан гэж гүрийж байсан ч, хэрэг дээрээ мартаагүй байжээ.

Хайр алдаа эндлийг мартдаг учраас, ирээдүйн төлөөх найдвараар дүүрэн байдаг. Хэрэв бид гомдлыг үнэхээр ялсан бол, эвлэрлийг л эрэлхийлнэ. Цаг нь биш байвал, хүлээгээд, эвлэрэх боломжийг хайдаг.

Миний нэг ухаантай найз: ““Халуун уснаас хаширсан нохой хүйтэн уснаас ч халширдаг” гэдэг хуучны мэргэн үг буй” гэж билээ. Хичнээн хүн түлэгдсэн явдлаа уучилж чадахгүй учраас, сэнгэнэсэн сайхан хүйтэн уснаас айж явдаг билээ?

Есүс бидний шархыг эдгээхийг хүсдэг. Гэхдээ энэ нь амархан зам биш учраас, бид энэ замаас аль болох зайлсхийдэг. Өөрийгөө үгүйсгэдэг, дарууслын зам л сүнсний төлөвшил, эдгэрэлд хүргэнэ. Энэ нь танд үлэмжийн хор хохирол учруулсан хүний сайн сайхны төлөө гаргах шийдвэр болой.

Бардам зан энэ замаар явж чадахгүй, гагцхүү адлагдсан ч хамаагүй амар тайвныг тогтоох хүсэлтэй хүн л явна. Энэ бол амь руу хөтөлдөг зам.

БУРХАНЫ ОРШИХУЙД СУРДАГ ЗҮЙЛИЙГ ХҮНИЙ ОРШИХУЙД СУРАХГҮЙ.

Сатаны урхи номыг уншаад Бурханы талаарх бодол маань бүхлээрээ өөрчлөгдлөө. Би амьдралдаа нилээд хүнд шархадсан бөгөөд энэ ном байгаагүй бол гомдлын урхиндаа мөнхөд үлдэх байсан.

- F. N., MALAYSIA

7

БАТ СУУРЬ

Тийм учраас Эзэн Бурхан ийн айлдруун: “Үзэгтүн. Би Сионд нэг чулууг тавина. Тэр нь шалгагдсан бөгөөд бат тавигдсан суурийн булангийн үнэт чулуу юм. Түүнд итгэгчийг яаруулахгүй.

Исаиа 28:16

Түүнд итгэгч нь яарахгүй. Яаруу явдалтай хүний суурь нь зүй зохистой суурилагүй учраас, тогтворгүй. Тэрбээр шуурга, хавчлага, шүүх дунд амархан найгаж, дайвдаг. Жишээлбэл Симон Петрийг харъя.

Есүс Цезарь Филиппийн нутагт хөл тавиад дагалдагч нараасаа “Хүмүүс Хүний Хүүг хэн гэж ярьж байна?” (Матай 16:13) гэж асуужээ.

Хэд хэдэн дагалдагч нь Есүсийн талаарх хүмүүсийн бодлыг дуулгав. Есүс ч тэдний яриаг гүйцэт сонссоноо тэдэн рүү хараагаа өргөөд “Тэгвэл та нар Намайг хэн гэж хэлэх вэ?” (15-аар ишлэл) хэмээн зог тустал асууж орхив.

Үүнийг сонсоод ихэнх дагалдагч нь баахан балмагдсан байдалтай, хэлэх ч үггүй дэмий л ангайж зогссон гэдэгт би эргэлзэхгүй байна. Бусдын санаа бодлыг ам уралдан ярьж

байсан мөнөөх хөөрүү хүмүүс нам болжээ. Магадгүй тэд хэзээ ч энэ талаар бодож байгаагүй байх. Ямар ч байсан тэд хариулж мэдэхгүй байгаагаа ухаарсан.

Есүс ч хамгийн сайн хийдэг зүйлээ л хийжээ. Тэрбээр асуултаараа дагалдагч нарынхаа зүрхний байршлыг оношлов. Есүс тэднийг мэддэг ба мэддэггүй зүйлтэй нь нүүрэлдүүлжээ. Тэд Есүсийг хэн болохыг зүрхэндээ байгуулахын оронд бусдын үзэл бодлоор амьдарч байв. Тэд өөрийн биеэр нүүр тулахыг хүсээгүй.

Есүсийн Петр нэрийг хайрласан Симон л ганцаараа үүнд хариулжээ. Тэрбээр “Та бол Христ, амьд Бурханы Хүү” (Матай 16:16) хэмээн хэлж орхив.

Хариуд нь Есүс “Бариона Симон оо, чи ерөөлтэй еэ! Учир нь үүнийг чамд мах цус биш, харин тэнгэр дэхь Миний Аав илчилсэн юм” (17-аар ишлэл) хэмээсэн.

Есүс Симон Петрт хэн үүнийг илчилснийг хэлжээ. Симон Петр энэ мэдлэгийг бусдын санаа бодлоос юмуу сурсан мэдсэн зүйлээсээ олсон бус, харин Бурхан Өөрөө үүнийг түүнд илчилжээ.

Симон Петр Бурханы юмсаар өлсөж цангаж байж. Тэр байнга асууж шалгаадаг байсан. Бусад арван нэг нь харж байхад, тэр л усан дээр алхсан. Тэрбээр бусдын бодлоор явдаг нэгэн биш байж! Симон Петр шууд л Бурханы амаас сонсохыг хүсдэг байв.

Есүсийн илчлэгдсэн энэ мэдлэгийг Петр мэдрэмжээрээ олж аваагүй, харин өлсөж цанган эрэн хайсных нь хариуд зүрхэнд нь гялбасан бэлэг байжээ. Симон Петрийн үзэж харсан зүйлийг олон хүн үзэж харсан болов ч, тэд Бурханы хүслийг мэдэхийн төлөө Петр шиг өлсөж цангаагүй юм.

Июхан 2:27 дээр “Та нарын түүнээс авсан тосолгоо нь та нарын дотор байдаг бөгөөд өөрсдөд чинь заах хэн нэгэн та нарт хэрэггүй. Харин Түүний тосолгоо нь та нарт бүхнийг заадаг бөгөөд тэрхүү тосолгоо нь худал биш, үнэн...” гэдэг.

Яг энэ тосолгоо Симон Петрт нэгийг зааж өгчээ. Тэрбээр бусдын үгийг сонссон болов ч, Бурханы илчилсэн зүйлийг харахаар дотогш өнгийжээ. Та Бурханаас илчлэлийг хүлээж авсан л бол, хэн ч таныг савлаахгүй. Бурхан танд ямар нэг зүйлийг илчилсэн л бол, даян дэлхий юу гэх нь хамаагүй. Тэд таны зүрхийг өөрчилж чадахгүй.

Есүс Симон Петрт болоод бусад дагалдагч нартаа “Энэ хадан дээр [Бурханы илчилсэн мэдлэг дээр] Би Өөрийн чуулганыг босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны (тамын) хаалга

дийлэхгүй” (Матай 16:18) гэсэн. Тэгэхээр Бурханы Үг дотор бат суурь байхыг бид тодорхой харж байна. Дээрх тохиолдолд, энэ нь Есүс бол Бурханы Хүү гэдэг Петрийн ухаарал байв.

ҮГ АСАХ

“Намайг номлож байхад, миний дуу хоолойн доторх Бурханы дуу хоолойг сонс” гэж би хүмүүст байнга хэлдэг юм. Хүмүүс бид Бурханы дуу хоолойг ч сонсох завгүй, номлолын тэмдэглэл хөтлөх ажилдаа түүртдэг. Энэ нь бидэнд Бичээсийн талаар оюуны буюу толгойн мэдлэг л өгнө.

Бид гагцхүү толгойн мэдлэг эзэмшбэл, дараах хоёр зүйл болно: (1) сэтгэлийн хөөрөл юмуу хөдлөлдөө автана; эсвэл (2) оюуны мэдлэгтээ чөдөрлөгдөнө. Есүс ийм суурь дээр чуулганаа байгуулдаггүй. Есүс чуулганаа цээжилсэн ишлэл дээр бус, илчлэгдсэн Үг дээр барина гэв.

Бид тосолгоотой номлогчийн номлолыг сонсохдоо юмуу номыг нь уншихдаа, сүнсэнд маань тэсрэх үг, өгүүлбэрийг хайх ёстой. Энэ чинь Бурханы бидэнд илчилж буй Үг. Энэ үг бидэнд гэрэл, сүнсний ойлголт өгнө. “Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг. Тэдгээр нь энгийн хүмүүст ухаарал хайрладаг” (Дуулал 119:130). Бурханы Үг бидний тархинд бус, зүрхэнд орохдоо л асч гэрэлтдэг юм.

Номлогч нэг зүйлийн талаар ярьж байхад, Бурхан надад тэс өөр зүйлийг асаах явдал бишгүй тохиолддог. Нөгөөтэйгүүр, Бурхан номлогчийн амаас гарсан яг тэр үгийг тослоход, тэр үг нь миний дотор тэсрэх тохиолдол ч бий. Аль, аль тохиолдолд энэ нь Бурханы надад илчилсэн Үг юм. Энэ л биднийг (ойлголтгүй) энгийнээс (ойлголтоор дүүрэн) төлөвшил рүү өөрчилдөг. Бидний зүрхэнд ассан үг нь Есүсийн чуулганаа байгуулах суурь болно.

Есүс Бурханы илчлэгдсэн үгийг хадтай зүйрлэжээ. Хад бол тогтвортой байдал, хүч чадлын хад юм. Бид элсэн дээр болоод хадан дээр барьсан хоёр байшингийн үлгэрийг мэднэ. Хоёр байшинг хавчлага, шүүх, дайрлага нүдэхэд, элсэн дээрх байшин нурж, хадан дээрх байшин үлдсэн.

Заримдаа бидний Бурханаас сонсдог зүйл Библид байдаггүй. Жишээ нь “Би хэнтэй гэрлэх үү? Хаана ажиллах уу? Аль чуулганд явах уу?” гэх мэт. Энэ бүх шийдвэр дээр бидэнд

Бурханы илчлэгдсэн Үг байх хэрэгтэй. Бурханы илчлэгдсэн үг байхгүй бол, шийдвэр маань тогтворгүй суурин дээр байна.

Бурханы Сүнсний илчилсэн зүйлийг хэн ч булааж чадахгүй. Бид бүх зүйлийг Бурханы илчилсэн үг дээр л суурьлуулах ёстой. Үүнгүйгээр бид шүүх, зовлонгийн өмнө амархан нугарна.

Үгийг сонсоод баярлав ч, зүрхэндээ үндэслүүлэхгүй байх талаар Есүсийн хэлсэн үгийг дахин санаарай. Тэр хүн Бурханы үгийг хөл хөөрцөг болон хүлээн авчээ.

...тэд үгийг сонсоод даруй баяртайгаар хүлээн авдаг. Өөрсдөд нь баг үндэс байхгүй, харин тэд түр зуурынх бөгөөд дараа нь үгнээс болж зовлон, хавчлага тохиолдоход тэд тэр даруй унадаг (гомддог). Марк 4:16-17

Үндэс гэдэг үгийг *суурь* гэдэг үгээр сольж болно. Эдгээр нь хоёулаа ургамлын юмуу бүтцийн хүч чадлын эх үүсвэр, тогтворжуулалтыг тодорхойлдог. Бурханы илчлэгдсэн Үг дээр суурьяагүй хүн гомдлын шуурганд хамгийн түрүүнд хамуулна.

Өнөөдөр хичнээн хүн Есүсийн дагалдагч нар шиг байдаг вэ? Тэд бусдын үг, номлолоор л амьдардаг. Тэд Сүнснээс зөвлөгөө юмуу гэрчлэл хайлгүй, шууд л бусдын санаа бодол мэдэгдлийг үнэн шиг хүлээж авдаг. Бид Бурханы илчилсэн зүйл дээр л амьдарч, илчилсэн үгийг л мэдэгдэх ёстой. Үүн дээр л Есүс чуулганаа байгуулдаг.

Миний нэг нарийн бичиг эмэгтэй чуулганд үйлчилдэг нэгэн залуутай хачин сайхан болзож байв. Өдөр өнгөрөх тусам, улам л дотносож, хүн бүр л тэр хоёрыг удахгүй гэрлэнэ гэдэгт итгэл дүүрэн хүлээж, тэд ч амьдрал болгохоор шамдаж байлаа.

Нэгэн бүтэн сайны орой тэргүүн пастор тэднийг дуудаж уулзаад “Эзэн та хоёрыг гэрлэнэ хэмээн айлдлаа” гэв.

Маргааш өглөө нь манай нарийн бичиг ажлынхаа өрөөнд дүүлсээр орж ирээд надаас: “Та бид хоёрын гэрлэлтийг батлаж өгөөч” гэлээ. Би ч дуртайяа зөвшөөрч, тэдэнтэй уулзах цаг товлов.

Гэхдээ нэг л таагүй байв. Тэднийг миний өрөөнд орж ирэх үед сүнс маань тавгүйцэж эхлэв. Би нарийн бичиг рүүгээ хараад, энэ эрэгтэй Бурханы чамд сонгож өгсөн хүн гэдгийг баттай мэдэж буй эсэхийг нь асуутал, тэрбээр толгой дохиод “Эргэлзээгүй мөн” гэлээ.

Би залуу руу хараад: “Чи энэ бүсгүйтэй гэрлэх нь Бурханы хүсэл мөн гэдэгт итгэлтэй байна уу?” гэтэл, залуу толгой гудайн: “Мэдэхгүй” гэж хэлэх шиг итгэл муутайхан сэгсэрлээ.

Тэгэхээр нь би тэдэн рүү хараад, залууд нь: “Би та хоёрыг батлахгүй. Та хоёрт хэн эш үзүүлж, юу гэж хэлсэн нь хамаагүй. Хичээн хүн та хоёрыг заяаны хань гэсэн нь ч падгүй. Хэрэв Бурхан чиний зүрхэнд хүслээ илчлээгүй бол, энэ гэрлэлт бүтэхгүй.

Хэрэв та хоёр Бурханы төгс хүсэлгүйгээр гэрлэбэл, шуурга шуурах үед (харин шуурга заавал шуурна) чамд “Би өөр хүнтэй гэрлэсэн бол ингэж зовох байсан болов уу? Бурханы хүслийг баттай мэддэг байж. Занганд орчих гэж. ...” гэж бодогдоно.

Тэгээд зүрх чинь эцэж, чи гэрлэлт рүү чинь халдах дайсантай тулалдаж чадахгүй. Чиний санаа хуваагдаж, зам мөр чинь тогтворгүй болно.”

Тэгээд дахиж уулзах шаардлага тул тэднийг гаргаж өгөв. Эрэгтэй нь уужирч, эмэгтэй нь гомдов. Дараагийн долоо хоногийн турш ажил дээр тун эвгүй уур амьсгал тогтов. Гэхдээ би үнэнийг хэлэх ёстой байснаа мэдэж байлаа. Энэ нь бүсгүйн хувьд сорилын үе байжээ. Хэрэв тэр залуу үнэхээр л түүний нөхөр гэдгийг Бурхан тэр бүсгүйд илчилсэн бол, тэрбээр Бурханд болоод надад гомдохгүй. Би бүсгүйд залуу нь Бурханаас үг хүлээж автал, зай тавьж өгөөд, хүлээ гэж хэлэв. Тэр ч үгэнд орлоо.

Гурван долоо хоног өнгөрч, тэд надтай дахин уулзахыг хүсэв. Үүнийг сонсоод, дотроос гижигдэх шиг л болов. Тэднийг өрөөнд орж ирмэгц, залуу нь над руу оч бутарсан нүдээр хараад: “Энэ эмэгтэй Бурханаас заяасан хань минь гэдэгт би бат итгэлтэй байна!” гэлээ. Долоон сарын дараа тэд гэрлэсэн юм.

Бурхан таныг байх ёстой харилцаа, чуулганд чинь тавьсныг мэдэж байх үед дайсан таныг барагтай гаргаж хаяж чадахгүй. Та Бурханы илчлэгдсэн Үг дээр суурилах учраас, ямар ч боломжгүй зөрчил дундуур дайраад л гарна.

ӨӨР СОНГОЛТ БАЙХГҮЙ

Гэргий, бид хоёр гэрлээд, эхний таван жил үнэхээр зүдэрсэн юм. Бид бие биеэ аймшигтай хүнд шархлуулж байсан учраас,

дахиж урьдынх шигээ хайрлаж дурлаж чадахгүй л гэж бодогдож байлаа.

Гэхдээ биднийг нэг зүйл зангидаж байв: Бидний хэн, хэн маань Бурхан бидний гэрлэлтийг томилсныг мэдэж байлаа. Тиймээс бид хоёр салахыг сонгоогүй. Бурхан биднийг эдгээж, өөрчилнө гэсэн ганц л сонголт бидэнд байлаа. Тиймдээ л яаж зовиурлаж байсан ч, бид хоёр энэ үйл явцад бүрэн зориулагдсан юм.

Би буюгаад өгмөөр болох үедээ гэрлэлтэд маань хандсан Бурханы амлалтыг санадаг байлаа. Бидний нэгдэлд зориулж Бурханы урлаж, тогтоосон зүйлийг би хаяж зүрхлэхгүй.

Гэргий, бид хоёрт өгсөн Бурханы нэгэн амлалт нь бидний хамтын үйлчлэл байв. Анх энэ амлалтыг хүлээж авах үед бараг л *“Тэр ч тодорхой!”* гэж л бодогдож билээ.

Гэтэл гэрлэлтийн дайнд эцэж цуцсандаа, сүүлээрээ нүд минь Бурханы амлалтыг тодорхой харахаа болиод байсан ч, би тэр амлалтыг тавьж явуулахаас татгалзсан юм. Гэрлэлтийн амьдралд маань нэвтэрсэн бардамнал, тэмцлээс болоод хүний найдвар минь тасарсан ч, зүрхэнд минь ер бусын амьдралын үр амьсгалсаар байв. Тэр амлалт л хэрэгцээт цагт бидний зангуу, суурь болов.

Эцсийн дүнд Бурхан бидний гэрлэлтийг эдгээгээд зогсохгүй, улам батжуулсан юм. Бид бие биеэ уучилж, уучлалаасаа суралцсанаараа өссөн. Эдүгээ бид хоёр мөр зэрэгцэн үйлчилдэг. Гэргий минь миний янаг хайр, дотно найз төдийгүй, хамгийн найдвартай түнш болой. Би түүндээ хэн хүнээс илүү найддаг.

Эхний хүнд хэцүү таван жилийн дараа Бурхан бидний хэн хэний маань амьдралд байгаа өө сэвийг үзсэн бөгөөд эдгээр нь харилцаагаар маань дамжин гэрэлд гарсныг би ухаарч билээ.

Тэгээд эрэгтэй, эмэгтэй хоёрыг нэгдүүлэгч Бурханы цэц ухаанд сөгдсөн юм. Би Лизатай учрахаасаа өмнө гэрлэх бүсгүйнхээ төлөө хичээнгүйлэн залбирдаг байлаа. Энэ нь сайн мэдээг дуулгавартай дагах шийдвэрийг маань удаалах, амьдралын маань хоёр дахь том шийдвэр байв. Тэгээд хань ижлийнхээ сонголтын төлөө залбирч, хүлээснийхээ ачаар би бусад хүмүүс шиг гэрлэлтийн асуудалгүй амьдарна гэж боддог байлаа. Гэнэн байж дээ!

Би Бурханы надад сонгож өгсөн эмэгтэйд бүх зүрхээрээ дурласан. Гэхдээ тэр эмэгтэй бас миний дотор бүгсэн аминч, төлөвшилгүй занг ил гаргасан. Нилээд ч юм гарав! Гэргийгээ буруутгаж, салах замаар зөрчлөөс зугтсан бол, миний балчир зан гомдол нэртэй хуурамч хамгаалалтын бас нэгэн давхаргын

дор булшлагдах байж. Гэрлэлтэд зориулсан Бурханы Үгийг мэдэж байсан маань л намайг хаяж явахаас зогсоосон билээ.

Яг одоо би энэ бүлгийн гол агуулгаас жаахан гажих хэрэгтэй байна. Үүнийг уншаад та магадгүй: *“Би гэрлэхдээ аврагдаагүй байсан”* гэж бодож байж мэдэх.

Тэгвэл танд Бурхан ингэж айлдруун: “Эхнэр нь нөхрөөсөө салж болохгүй гэж гэрлэсэн хүмүүст хандан би биш, Эзэн тушаадаг. (Хэрэв салбал дахин гэрлэхгүй байг эсвэл нөхөртэйгээ эвлэрэг.) Нөхөр нь эхнэрээсээ салж болохгүй. ... Ах дүү нар аа, хэн юун дотор дуудсагдсан байна, түн дотроо хүн бүр Бурхантай хамт үлд (1Коринт 7:10-11, 24).

Гомдлын занганаас болж савлахгүйн тулд гэрлэлтийн гэрээний энэ үгийг зүрхэндээ суулга. Тэгээд Бурханаас гэрлэлтийн амьдралдаа үгээ илчлэхийг гуй.

Зарим чинь итгэдэг байсан ч, Бурханы хүсэл дор гэрлээгүй байж болох. Тиймээс гэрлэлтийн амьдралаа Бурханы ерөөлийг нэвтрүүлэхийн тулд Бурханы зөвлөгөөг хайгаагүй явдлаа гэмшбэл, Бурхан уучилна. Хоёр буруу зөвийг бүтээдэггүйг мэд. Гомдлоос болж гэрээгээ цуцлах нь хариулт биш. Тэгээд гэрлэлтдээ хандсан Бурханы Үгийг хай.

ХАД

Бурханы илчлэгдсэн Үг нь бидний амьдрал, үйлчлэлээ байгуулах хад юм. Хүмүүс аль нэг чуулганд юмуу үйлчлэлд хэсэгхэн хугацаанд байснаа л ярьдаг. Тэд Бурханы удирдамжаар бус, бэрхшээлээр хөдөлдөг нь даанч гашуудмаар. Тэд бүгдийг буруутгаж, муу муухай хандуулснаа л ярьж, шийдвэрээ зөвтгөнө. Гэхдээ энэ гаргалгаа нь тэднийг өөрийнхөө зан чанарын доголдол, гомдлоо олж харахаас нь хаадаг бас л нэгэн заль мэхийн давхарга юм.

Тэд одоогийн үйлчлэл юмуу чуулганаа “Бурхан одоогоор намайг энд байлгаж байгаа” эсвэл “түр зуурын” гэх маягаар тайлбарлах. Нэг хүн бүр “Би энэ чуулганд зээлээр ажиллаж байгаа” гэж ярихыг хүртэл сонсож явлаа. Байдал бишидсэн нөхцөлд зугтах замаа бэлтгэж байгаа нь тэр. Шинэ газарт очлоо ч, тогтох суурьгүй тэднийг тэнгисийн салхи ганц үлээгээд л дараагийн боомт руу тууна.

БИД ХААШАА ЯВАХ ВЭ?

Бүгдээрээ Есүс дагалдагч нараасаа хүмүүс Өөрийг нь хэн гэж ярьж байгаа талаар асуухад, Бурханы илчлэгдсэн хүсэл дотор л тогтвортой байдал оршдгийг харсан жишээ рүү дахин нэг буцъя. Симон Петрийг үзье.

Симон Петр зүрхэнд нь Бурханы илчилсэн зүйлийг гаргаж хэлсний дараа Есүс түүнд: “Чи бол Петр. Энэ хадан дээр Би чуулганаа босгох бөгөөд түүнийг Үхэгсдийн орны хаалга дийлэхгүй” (Матай 16:28) гэсэн буй.

Есүс Симоны нэрийг Петр хэмээн өөрчилжээ. Энэ тун чухал. Учир нь Симон гэдэг нь “сонсох”¹ гэсэн утгатай бол, Петр нь (Грекээр *петрос*) “чулуу”² гэсэн утгатай нэр. Тэгэхээр Бурханы илчлэгдсэн Үгийг зүрхэндээ сонссон тулдаа л тэрбээр хад болжээ. Хадан дээр баригдсан гэр ямар ч хүчтэй салхинд зогсоод л үлдэнэ.

Энд буй *хад* гэдэг үг нь “ургаа хад”³ гэсэн утга бүхий *петра* гэдэг Грек үгээс үндэстэй. Эдүгээ Петр дээрээ байшин сүндэрлүүлэх материал болсныг Есүс хэлжээ.

Хожим Петр: “Иймд амьд чулуу мэт болсон та нар...” (1Петр 2:5) хэмээн бичсэн. Чулуу нь ургаа хадны хэсэг юм. Илчлэгдсэн Үгийн хад дотор хүч чадал, тогтвортой байдал, эрх хүч оршдог бөгөөд үүнийг хүлээж авсан хүний амьдралд үр жимс ургана. Тэрбээр Бурханы амьд Үг болох Есүс Христийн хүчээр хүчирхэгждэг.

Элч Паул: “Учир нь тавигдсан ганц суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй” (1Коринт 3:11) гэж бичсэн. Хэрэв бид Бурханы амьд Үг болох Есүсийг хайх аваас, Тэр илчлэгдэж, бид ч байгуулагдана.

Есүсийн газар дээр өнгөрөөсөн сүүлчийн өдрүүдэд багийнх нь амьдрал улам л хэцүү болсныг Иохан 5:16 дээр хэлдэг. Шашны удирдагч нар болоод Иудейчүүд Есүсийг хавчиж, алахыг завдсан. Байдал хурцдаж, хүмүүс Түүнийг хүчээр хаан болгох гэж оролдох үед Есүс татгалзаад, яваад өгсөн (Иохан 6:15-ыг үзнэ үү).

“Тэр яагаад явчихав? Энэ чинь Есүсийн хувьд ч, бидний хувьд ч сайхан боломж” хэмээн дагалдагч нар гайхшаа барж, зовнио байх. Шуурга ширүүссээр.

“Бид энэ хүнийг дагах гэж ар гэрээ орхиж, аж амьдралаараа дэнчин тавьсан. Түүнийг ирэх ёстой Нэгэн мөн гэдэгт итгэсэн. Мөн гэдгийг нь Иохан баптист ч мэдэгдсэн, Цезарийн Филипт байхдаа Петр ч хэлэхийг нь сонссон. Энэ хоёр хүн гэрчилсэн. Гэтэл Есүс яагаад удирдагч нарын дургүйг хүргэнэ вэ? Яагаад Өөрийгөө дэгээднэ вэ? Яагаад дагалдагч бидэндээ: “Итгэлгүй үеийнхэн, Би та нарыг хичнээн тэвчих ёстой вэ?” гэж хатуурхана вэ?”

Есүсийг дагах гэж хамаг юмаа орхисон тэр харцуулын дотор гомдол бүлэгнэж эхлэв.

Тэгтэл Есүс аймшигтай “гаж” сургаал зааж орхив: “... та нар Хүний Хүүгийн махыг идэхгүй, цусыг нь уухгүй л бол та нарын дотор амь байхгүй” (Иохан 6:53).

“Энэ чинь одоо гээч вэ? Арай дэндэнэ ээ!” хэмээн тэд мэл гайхав. Үүгээр барахгүй Есүс Капернаум дахь синагогийн удирдагч нарын нүүрэн дээр баахан юм ярьчихсан. Тэгээд дагалдагч нарын тэвчээрийн нугас тас!

Тэд үүнийг сонсоод, дагалдагчдаас олонх нь - Энэ чинь хэцүү үг байна. Үүнийг хэн сонсож чадах вэ? гэцгээв. Иохан 6:60

Үүнд нь Есүс юу гэж хариулсныг тэмдэглэнэ үү:

Харин Есүс үүний тухай дагалдагч нарынхаа дургүйцэн шивнэлдэхийг мэдээд, тэдэнд: “Энэ нь та ныг бүдрүүлчихэв үү?” гэв. Иохан 6:61

Өөрийнх нь дагалдагч нар шүү дээ! Есүс үнэнээс ухралгүй, тэдгээр хүмүүстэй нүүрэлдсэн. Тэдний зарим нь худлаа суурин дээр байгааг Есүс мэдсэн. Есүс тэр суурийг нь ил болгоод, зүрх рүүгээ өнгийх боломжийг тэдэнд олгожээ. Гэвч тэд Симон Петр шиг юмуу үнэний төлөө өлсдөг дагалдагч нар шиг байсангүй. Тэгээд хэрхэн хариу үйлдэнийг нь үзнэ үү:

Үүнээс болж Түүний дагалдагчдаас олон хүн зайлан явж, цаашид Түүнтэй хамт явсангүй. Иохан 6:66

“Цөөхөн” бус, “олон” хүн явсан гэж байгааг тэмдэглэнэ үү. Тэд чинь Цезарь Филиппийн нутагт “Таныг зарим нь баптисм хүртээгч Иохан, зарим нь Елиа, харин зарим нь Иеремиа эсвэл

эш үзүүлэгчдийн нэг гэж ярьдаг” (Матай 16:14) гэж хэлсэн байлтай. Тэд Бурханы илчлэгдсэн Үг дээр суурилаагүй байжээ.

Гомдол нь тэднийг өнөөгийн олон хүний хийдэг зүйлийг хийхэд буюу зүгээр яваад өгөхөд хүргэжээ. Тэд өөрийгөө мэхлэгдсэн, хохирсон гэж үзэж байсан ч, үнэндээ үгүй байв. Нүд нь аминч хүсэл дээрээ л тунаж байсан тэд үнэнийг хараагүй юм.

Харин одоо Есүс арван хоёртойгоо нүүр тулах үед Симон Петр яасныг үзнэ үү:

Есүс арван хоёртоо “Та нар бас явахыг хүсч байна уу?” гэхэд, Симон Петр Түүнд -Эзэн минь, бид хэн рүү явах юм бэ? Мөнх амийн үгс Танд байна. *Та бол Бурханы Ариун Нэгэн мөн* гэдэгт бид итгэцгээсэн мөн таньж мэдэцгээсэн” гэжээ. Иохан 6:67-69

Есүс арван хоёртоо: “Та нар л битгий яваач! Дийлэнх ажилчид маань явчихлаа. Би та наргүй яах юм бэ?!” гэж хэлээгүй. Есүс: “Та нар ч бас явмаар байна уу?” хэмээн шууд тулгасан.

Симон Петр ч бас бусдын л адил дотроо гомдолтой тэмцэлдэж байсан ч, тэрбээр: “Эзэн минь, бид хэн рүү явах юм бэ?” гэж хэлсэн.

Петр ч бас сонссон зүйлдээ самуурсан л байх. Гэхдээ түүний дотор бусдад байхгүй нэгэн мэдлэг байв. Цезарь Филипийн нутагт Петр Есүс бол “Амьд Бурханы Хүү” (Матай 16:16) гэдэг илчлэлийг хүлээж авсан болой.

Тэгэхээр, Петр ид бэрхшээл дунд байхдаа зүрхэндээ үндэслэсэн зүйлийг гаргаж хэлжээ: “*Та бол Бурханы Ариун Нэгэн мөн* гэдэгт бид итгэж бас таньж мэдэцгээсэн.” Тэрбээр яг энэ үгээ Цезарь Филипийн нутагт хэлсэн. Петр - Бурханы амьд Үгийн бат хад дээр тогтсон чулуу байв. Тиймээс Петр гомдохгүй.

ДАРАМТАН ДОРХ ХАРИУ ҮЙЛДЭЛ

Бэрхшээл, шалгалт нь хүний *байршлыг* тогтоодог гэж би хэлдэг. Өөрөөр хэлбэл, таны сүнсний байршлыг тодорхойлдог. Зүрхний чинь үнэн төрхийг илчилнэ. Дарамт дор хэрхэнэ - тэр чинь л *та мөн*.

Та элсэн дээр үнэт материал, уран барилгачдаар таван давхар, тансаг харш бариулжээ. Нар гийж байгаа цагт танай харш ид хаваа гайхуулан данхайна.

Гэтэл хавирганд нь ганц давхар, энгийн нэг байшин танай харшийн сүр жавхланд бут цохиулан шовойх нь хөөрхийлөлтэй харагдана. Гэхдээ тэр байшин танд үл харагдах хадан дээр баригджээ.

Салхи шуургагүй байгаа цагт таван давхар харшийн сүр бараа дийлдэшгүй. Гэтэл хүчит шуурга дэгдэж, таван давхар байшин ганхан, нурав. Харш хэд хэдэн зөөлөн шуургыг даасан ч, хар шуургыг барсангүй. Харин ганц давхар, жижиг байшин хар шуурганд өртсөнгүй. Байшин том байх тусмаа, сүйрэл нь хүнд байна.

Чуулганы зарим хүмүүс Цезарь Филипийн нутагт том дуугарсан ч, хожим илчлэгдсэн дагалдагч нартай л адил байдаг. Тэд “таван давхар” итгэгч шиг хүчтэй, тогтвортой, үзэсгэлэнтэй харагддаг. Тэд хэдэн тооны дунд зэргийн, зөөлөн салхийг давчихаж ч чадна. Харин хүчтэй шуурга ирбэл, шууд байршлаа өөрчилнө.

Амьдралаа бусдын үг дээр бус, Бурханы илчилсэн Үг дээр л байгуулаарай. Эзэнийг эрэн хайж, зүрхээ чагна. Хүмүүс хийж байна гэдэг шалтгаанаар юуг ч бүү хэл, бүү хий. Бурханыг хайж, зүрхэнд чинь асаасан үг дээр бат зогс!

ДАЙСАН УСТГАХЫН ТУЛД СЭГСЭРДЭГ. ХАРИН БУРХАН ӨӨР ЗОРИЛГОТОЙ.

Сатаны урхи номын төлөө Бурханд талархъя. Би амьдралаа өөрчлөхийн төлөө мацаг барин залбирч байлаа. Гэтэл Эзэн намайг энэ мессеж рүү хөтлөж, амьдралыг минь орвонгоор нь өөрчилсөн юм. Энэ номыг удирдагч хүн бүр унших хэрэгтэй.

- С. Р., NEW ZEALAND

8

ШИГШИГДЭХ ЁСТОЙ БҮХЭН ШИГШИГДЭНЭ

Тэр “Би дахиж нэг удаа зөвхөн дэлхийг бус, тэнгэрийг ч мөн сэгсэрнэ” гэж амласан. “Дахиж нэг удаа” гэдэг нь үл ганхуулагдах юмс нь үлдэхийн тулд бүтээгдсэн ганхуулагдах юмс нь зайлуулагдахыг хэлж байгаа юм.

Еврей 12:26-27

Есүс чуулганаа Бурханы илчлэгдсэн Үг дээр л байгуулдгийг өмнөх бүлгээр сурлаа. Бусад дагалдагч нь гомдоод яваад, Симон Петр үлдсэнийг ч мэдлээ. Есүс Петрт Өөрийг нь орхиж явах боломж олгоод байхад ч, Петр зүрхэндээ суулгагдсан зүйлийг л хэлжээ.

Одоо тэгвэл Симон Петрт Есүсээс урвасан шөнө нь ирсэн өөр нэгэн шалгалтыг авч үзье.

Есүс 12 элч нартайгаа суугаад, талархал өргөн, Эзэний зоог барьж байснаа, пал хийсэн мэдэгдэл хийжээ: “Харин үзэгтүн. Надаас урвагч нэгний гар Миний хамт ширээн дээр байна. Учир нь үнэхээр Хүний Хүү оноогдсоноороо явж байна. Харин Түүнээс урвагч нь золгүй еэ!” (Лук 22:21-22) Аймаар мэдэгдэл! Биднийхээр бол, Есүс бөмбөг дэлбэлчихжээ.

Энэ урвалтыг Есүс Өөрөө анхнаасаа л мэдэж байсан ч, хамгийн анх дагалдагч нартаа дуулгасан нь энэ байв. Есүстэй хамт гараагаа эхэлж, мөр зэрэгцэж явсан хүн дотно хүн нь Түүнээс урвана гэдэг үг тэдний дунд ямар айдас хүйдэс авчирсныг төсөөлж чадах уу?

Тэгээд тэд “Бидний хэн нь ийм зүйл хийх юм бол?” (23-аар ишлэл) гэдгийг хэлэлцэж эхлэв. Тэд ийм аймшигтай зүйл үйлдэх зүрхтэн тэдний дунд байна гэдэг цочроонд автжээ. Гэхдээ тэдний мөрдлөгө цэвэр сэдэлтэй байгаагүйг ярианых нь төгсгөл харуулдаг. Тэд аминч, бардам гэгч нь сэдлээр мөрдлөгөө явуулжээ. Дараагийн ишлэлийг нь үзнэ үү:

Тэрчлэн тэдний дунд хэн нь хамгийн агуу нь байх талаар ч маргаан дэгджээ. Лук 22:24

Бодоод үз дээ: Есүс дөнгөж сая дагалдагч нартаа яг одоо нэг ширээнд сууж байгаа нэг хүн нь удалгүй Түүнийг тэргүүн тахилч нарт тушаагаад, цаазын ял өгч, Ромчуудын гарт тушаан, элэг доог хийж, тамлан гарчлааж, ална гэж хэлсэн.

Дагалдагч нар түүнийг хэн болохыг нь таалцаж байснаа, сүүлдээ хэн нь мундаг болохоороо уралдаж гарчээ. Энэ нь юмаа булаалдаж байгаа жаалууд шиг л, ичмээр хэрэг байв. Тэд эрх хүч, эзэн суудлаа л булаалдсанаас биш, Есүсийг ер бодоогүй. Санаандгүй буумгүй, бэртэгчин байдал!

Би Есүсийн оронд байсан бол, тэднээс миний хэлснийг сонссон эсэх, энэ бүхэн тэдэнд хамаатай эсэхийг нь асуух байсан байх. Энэ явдлаас бид Эзэнийхээ хайр, тэвчээрийг дахиад л харах. Есүсийн оронд ихэнх хүмүүс: “Муусайнууд, зайлцгаа! Намайг ингэтэл зовж байхад, та нар амиа бодно гэнэ ээ!” гэж хэлэх байсан байх. Үүнээс илүү гомдох завшаан үгүй!

Дагалдагч нарын дунд хэн маргаан дэгдээснийг бараг шууд хэлэхээр дээ: Бүлэг дундаа арай чанга зан чанартай, түрүүлж дуугардаг - Симон Петр.

Тэрбээр магадгүй ганцаараа усан дээгүүр алхсанаа бусаддаа дор нь сануулаа байх. Эсвэл Есүсийг хэн болох илчлэлийг хамгийн түрүүнд хүлээж авсан түүхийг сэргээж өгөө байх. Тэгээд хувирлын уулан дээр Есүс, Мосе, Елиа гурвыг үзсэнээ бас дахин дурьдаа байх.

Петр арван хоёр дундаа хамгийн аугаа нь гэдэгтээ итгэл төгс

байсан. Гэхдээ энэ итгэлтэй байдал нь хайраас соёолоогүй, бардамналын зангуу байв.

Харин Есүс тэднийг тойруулан хараад, хаанчлалын хөвгүүд шиг бус, зүгээр л харчуул шиг авирлаж байгааг нь хэлжээ: “Харь үндэстнүүдийн хаад ард олноо ноёрхдог бөгөөд эрх баригчид нь “Буянтнууд” хэмээгддэг. Харин та нар тийм байж болохгүй. Та нарын дотроос хамгийн агуу нь хамгийн өчүүхэн нь мэт болог, удирдагч нь зарц мэт байг. Ширээнд тухлагч, үйлчлэгч хоёрын хэн нь агуу вэ? Ширээнд тухлагч нь биш гэж үү? Харин Би та нарын дунд үйлчлэгч мэт байдаг” (Лук 22:25-27).

ШИГШИХИЙН ЗОРИЛГО

Хэдийгээр Симон Петр Есүсийг хэн болох талаар жинтэй илчлэл хүлээж авсан ч, Христийн зан чанар, даруу чанараар хараахан амьдраагүй байв. Петр өнөөгийнхөө аж амьдрал, үйлчлэлийг өнгөрсөн амьдралынхаа ялалт, бахархал дээр л босгож байв. Гэтэл Паул бидэнд Христ дээр л суурилаарай гэж заасан (1Коринт 3:10).

Симон Петр Бурханы хаанчлалд шаардлагатай материалаар бус, хүчирхэг хүсэл, өөртөө итгэх итгэлээрээ л барьжээ. Түүний зан чанар өөрчлөгдөх шаардлагатай байгааг Петр мэдээгүй. Түүний сэдэл нь “амьдралын бардамналаас” ургажээ (1Иохан 2:16).

Бардам бахдал нь Христ доторх хувь тавилангаа биелүүлэх чинээнд хүртэл хүчтэй байж чадахгүй. Энэ бардам занг нураахгүй бол, эргээд эзнээ нураана. Бурханаар тослогдсон Люсифер гэдэг нэгэн херуб бардам зангаасаа болж сүйрсэн тухай Езекиел 28:11-19 дээр буй.

Харин одоо Есүс Петрт юу айлдсаныг үзье:

Симон оо, Симон оо, үзтүгэй, чамайг улаан буудай мэт шигшихийн тул Сатан зөвшөөрөл гуйсан. Лук 22:31

Бардам зан дайсанд Петрийн дотор нэвтэрч, шигших үүд нээжээ. Энд **синиазо** гэдэг Грек үгийг шигших гэж орчуулсан байна. Энэ нь “хүний итгэлийг нурж унатал нь тултал сорих дотоод сэгсрээ; шигшүүр, инжирт хийж шигших”¹ гэсэн утгатай.

Хэрэв Есүс чуулганд явдаг олонхийн бүлэг шиг сэтгэхүйтэй байсан бол: “Залуус аа, диаволын дайралтыг таслан зогсоохын төлөө залбирья. Сатан бидний хайрт Симон руу дайрах нь байна!” гэж залбирах байсан. Гэтэл Есүс юу хийлээ?

Гэсэн ч итгэл чинь сульдахгүйн тулд Би чиний төлөө залбирсан. Чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул гэхэд Лук 22:32

Есүс Симон Петрийг нурж унатал нь шигших хүчтэй шигшүүрээс зугтаалгахын төлөө бус, харин итгэл нь энэ үйл явцыг даваад гарахын төлөө залбирчээ. Симон Петр энэ сорилтоос хувь тавилангаа биелүүлж, ахан дүүсээ хүчирхэгжүүлэх чадалтай, цоо шинэ зан чанарыг олно гэдгийг Есүс мэдэж байв.

Сатан Симон Петрийн итгэлийг мөхтөл нь сэгсчих зөвшөөрөл авчээ. Дайсан Бурханы олон гайхамшигтай илчлэлийг хүлээж авсан тэр эрийн үлэмж хүчин чадлыг бүр мөсөн арчих санаатай байж. Харин Бурхан энэ сэгсрээг өөр зорилгоор ашиглах санаатай байсан бөгөөд мэдээж Бурхан диаволыг ямагт чаддаг. Бурхан Симон Петрийн шигшигдэх *шаардлагатай* бүхнийг нь шигшихийг дайсанд зөвшөөрчээ.

Сэгсрэх нь таван зорилготой байдгийг Бурхан Лизад зааж өгсөн юм:

1. Суурьтай нь холбох.
2. Үхмэл зүйлийг нь зайлуулах.
3. Боловсорсон ургацыг нь хураах.
4. Сэрээх.
5. Хэзээ ч салахгүй болтол нь нийлүүлж холих.

Амиа хичээсэн зан, бардамналаас соёолсон бодол сэтгэлгээ, зүрхний хандлага цэвэрлэгдэнэ. Тэр хүчтэй сэгсрээний дараа Симон Петрийн нөгөө өөртөө итгэлтэй байдал ор мөргүй арилж, гагцхүү Бурханы бат бөх суурь л тогтож үлдэх байв. Тэрбээр жинхэнэ нөхцөл байдлаа сэхээрч, үхмэл зүйл нь зайлж, боловсорсон үр жимс нь хураагдаж, жинхэнэ суурьтайгаа холбогдоно. Тэрээр дураараа дургихаа больж, Эзэнийхээ мэдэлд очно.

Петр Есүсийн үгийг эрэлхэгээр сөрсөн: “Эзэн минь, Тантай хамт шоронд ороход ч, үхэхэд ч би бэлэн байна.” Энэ бол Сүнснээс бус, өөртөө итгэлтэй байдлаас төрсөн мэдэгдэл. Тэр удахгүй яаж сэгсчүүлэхээ төсөөлөх ч үгүй байжээ.

ИУДАС, СИМОН ХОЁРЫН ЯЛГАА

Зарим хүн Петрийг адгийн аманцраас цаашгүй байсан гэж боддог. Гэхдээ цэцэрлэгт цэргүүд Есүсийг баривчлахаар ирэх үед Петр илдээ суга татан, тэргүүн тахилчийн зарцын чихийг тас цавчсан (Иохан 18:10). Дайсандаа бүслэгдчихээд ийм аймшиггүй юм хийдэг “адгийн амьтан” тийм ч олон биш байх. Петр зоригтой, хүчтэй хүн байсан. Гэхдээ тэрбээр сэгсрэгдээгүй байсан тул хүч нь Бурханы даруу байдал дотор бус, хувийнх нь зан байдал дээр суурилж байж.

Гэтэл бүх явдал Есүсийн зөгнөснөөр л болов. Есүсийн төлөө үхсэн ч чадна хэмээн тангараглаж, цэргүүдийн өмнө илд эргүүлсэн, хүчтэй, зоригтой “сэлмэн Петр” маань бяцхан зарц охинтой нүүрэлдэхдээ сүрдэж, Есүсийг танихгүй, мэдэхгүй хэмээн гүрдийж.

Эрчүүдийг том зүйл бус, голдуу жижиг сажиг зүйлс л юу ч үгүй сэгсэрч орхидог. Бардам зангаасаа болж л бид ийм байдалд ордог гэх үү.

Петр Есүсийг танихгүй хэмээн дахин хоёр удаа булзсан. Тэр даруй тахиа донгодож, Петр ч гашуудан мэгшив. Тэрбээр хамаг бардам зангаасаа нүцгэрч, өөрийгөө ингээд л дууслаа гэж боджээ. Гэтэл түүнд одоо Сүнсний илчилж өгсөн зүйлээс өөр юу ч үлдээгүйг Петр ухаараагүй байж.

Симон Петр, Иудас хоёр олон талаараа адилхан байсан. Ялангуяа тэр хоёр хоёулаа Есүсээс амьдралынх нь сүүлийн амин чухал өдөр урвасан. Гэхдээ тэр хоёрт нэг чухал ялгаа байв.

Иудас хэзээ ч Есүсийг таньж мэдэх гэж Симон Петр шиг улайрч байгаагүй. Иудас Есүсийн дотор суурилаагүй байжээ. Иудас хамаг байдгаа орхиод Есүсийг дагаж, бүр хавчигдаж хяхагдаж явсныг нь үзбэл, тэрбээр Есүст хайртай байжээ. Тэрбээр чөтгөрийг хөөж, өвчтэйг эдгээж, сайн мэдээг номлосон (Есүс 11 хүнийг бус, 12 хүнийг номлож, эдгээж, чөлөөлөх үйлчлэлд илгээснийг бүү мартаарай). Гэхдээ Иудас энэ бүхнийг

Есүсийг хайрласандаа юмуу Түүнийг хэн болохыг мэдсэндээ хийгээгүй ажээ.

Иудас анхнаасаа л өөр сэдэлтэй байсан, энэ сэдлээ ч гэмшээгүй. “Түүнийг та нарт тушаавал, та нар *надад юу өгмөөр байна?*” (Матай 26:15) гэдэг үгээс нь түүний зан чанарыг таньж болно. Иудас давуу талаа ахиулахын тулд худал ярьж, бялдуучилсан (Матай 26:25). Тэр Есүсийн үйлчлэлийн сангаас хувьдаа хэрэглэсэн (Иохан 12:4-6) гэх зэрэг. Тэр Эзэнтэй гурван жил хагас хамт байхдаа Түүнийг ер таньж мэдээгүй.

Петр, Иудас хоёр хоёулаа хийсэн хэрэгтээ гэмшсэн. Гэхдээ Петрт байсан тэр суурь Иудаст байгаагүй юм. Иудас Есүсийг таньж мэдэх гэж улайраагүй учраас, Есүс ч түүнд илчлэгдээгүй. Хэрэв Иудас Есүсийг хэн болохыг мэдсэн бол, Түүнээс хэзээ ч урвахгүй байх байлаа. Хүчит шуурга түүний амьдралыг дайран, хамаг юмыг нь сэгсэрч, хуу хамав!

Түүнээс урвасан Иудас Түүний яллагдсаныг хараад харуусаж, гучин мөнгөн зоосоо ахлах тахилч нар болоод ахлагчдад буцаан өгч,

— Би гэм зэмгүй цуснаас урваснаараа нүгэл үйлдлээ гэхэд тэд

—Энэ бидэнд хамаагүй, өөрөө мэд гэв. Иудас мөнгөн зооснуудыг ариун газарт чулуудаад, явж, өөрийгөө дүүжилжээ. Матай 27:3-5

Иудас хийсэн хэргээ ухаарч, голоосоо гэмшсэн. Гэхдээ тэр Христийг хэн болохыг ч мэдээгүй, хэнээс хэр хэмжээнд урваснаа ч ухаараагүй. Тэр ердөө: “Би гэм зэмгүй цуснаас урваснаараа нүгэл үйлдлээ” л гэсэн. Иудас Есүсийг Симон Петр шиг мэддэг байсан бол, Эзэнийхээ сайныг мэддэг учраас, эргэж очоод, гэмшиж, хайр энэрлийг нь хүртэх байв. Гэтэл амиа хорлочихсон. Амиа хорлох нь Бурханы нигүүлслээс тусгаар амьдрах бас л нэг хэлбэр юм. Иудас Эзэнийг гурван жил дагаад сэгсрүүлэхэд, түүнд ямар ч суурь байгаагүй нь ил болжээ.

Маш олон хүн “гэмшлийн залбирал” хэлж, чуулганд явж, зүтгэлтэй үйлчилж, Библи судладаг. Хэдийгээр тэд амаараа Эзэнийг хүлээн зөвшөөрдөг ч, энэ бүхнээ Есүсийг үнэндээ хэн болохыг нь огт мэдэхгүйгээр л хийдэг. Тэгээд хүнд цохилтод өртөх үедээ Бурханд гомдож, харилцаа холбоогоо тасална.

Тэд “Бурхан миний төлөө юу ч хийдэггүй! Би Христэд итгэх

гэж үзсэн ч, амьдрал маань шал дордлоо!” Эсвэл “Би Бурханаас зөндөө л гуйлаа. Гэтэл Тэр миний төлөө юу ч хийсэнгүй!” гэдэг. Тэд амьдралаа Есүст өргөдөггүй, харин өөрийнхөө хувийн эрх ашгийн төлөө Түүнтэй зэрэгцээд л байдаг. Тэд Есүсээс авахын төлөө үйлчилж бас амархан гомддог. Есүс тэдний талаар ингэж хэлсэн:

Үүнчлэн эдгээр нь чулуурхаг газарт унагсад бөгөөд тэд үгийг сонсоод тэр даруй баяртайгаар хүлээн авдаг. *Өөрсдөд нь бат үндэс байхгүй*, харин тэд түр зуурынх бөгөөд дараа нь үгнээс болж зовлон, хавчлага тохиолдоход тэд тэр даруй *унадаг (гомддог)*. Марк 4:16-17

Эдгээр хүмүүст суурь байхгүй учраас, амархан гомддог гэж хэлснийг тэмдэглээрэй. Тэгвэл бид юун дээр үндэслэх вэ? Хариулт нь Ефес 3:16-18 дээр байна. Бид хайран дээр л үндэслэх, суурилах ёстой.

Есүс “Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас өөр агуу хайр байхгүй” (Иохан 15:13) гэсэн. Бид найддаггүй хүнийхээ төлөө амиа өгч чадахгүй. Бид Эзэнийг сайн мэдэхгүй бол, Түүнд амь амьдралаа зориулж чадахгүй. Бид Бурханы мөн чанар, зан чанарыг мэдэж, ойлгох ёстой. Тэр биднийг хорлож хохироох юу ч хийхгүй гэдэгт бид баттай байх учиртай.

Бурхан бидэнд сайныг л хүсдэг. Тухайн үедээ гонсоймоор байсан ч, итгэл алдахгүй байвал, тэр нь үнэндээ бидний хувьд хамгийн зөв байсныг харах болно. Бурхан бол хайр; Түүнд амиа хичээх санаа, ямар ч муу муухай байхгүй. Сатан л биднийг устгадаг.

Бид амьдралаа голдуу ойрын шилээр хараад байдаг. Энэ нь жинхэнэ дүрсийг мурийлгаж сарийлгадаг. Бурхан бидний нөхцөл байдлын дотоод талыг хардаг. Хэрэв бид нөхцөл байдлыг өөрийнхөө хязгаарлагдмал өнцгөөс л хараад байвал, хоёр зүйл болно.

Нэгдүгээрт - Бурхан биднийг ид цэвэрлэж байхад бид нэг бол Бурханд эсвэл Бурханы зарцад гомдож мэдэх. Хоёрдугаарт - бид дайсандаа амархан мэхлэгдэж мэдэх. Сатан тухайн үедээ тун зөв санагдах зүйл ашиглаж болох ч, эцэстээ биднийг алж устгах ганц л зорилго тээдэг. Бид Бурханд найдбал, Аавынхаа хайр халамжаас тасрахгүй. Өөрийгөө халамжлах өдөөлтөд ч автахгүй.

БУРХАНЫ ЗАН ЧАНАРТ НАЙДАХУЙ

Дайсан хэзээ нэг өдөр Бурханы зан чанарын талаарх бидний бодлыг булингартуулж, Бурханд найдах найдлагыг маань таслахаар оролдоно. Тэр Еден цэцэрлэгт Евагаас: “Та нарт энэ цэцэрлэгт байгаа *бүх модны жимснээс идэж болохгүй* гэж Бурхан үнэхээр хэлсэн үү?” (Эхлэл 3:1) гэж асуухдаа, энэ ажлаа л хийсэн. Тэр Бурханы зан чанар руу дайрч, эрэмдэглэхийг хүсэхдээ, Бурханы тушаалыг гуйвуулжээ.

Бурхан “Тэгээд ЭЗЭН Бурхан тэр хүнд тушаан ийнхүү өгүүлэв. Чи энэ цэцэрлэгийн *аль ч модны жимсийг дураараа идэж болно*. Харин чи сайн мууг мэдүүлэгч модны жимснээс огт идэж болохгүй. Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ!” (Эхлэл 2:16-17) хэмээн айлдсан.

Могой үнэндээ Евад: “Бурхан чамаас хамаг сайн сайхнаа харамлаж байна” гэж л хэлжээ.

Гэтэл Бурхан “Нэгээс бусдыг нь чөлөөтэй идэж болно” гэж айлдсан. Бурхан ганцаас бусад бүх жимсийг, тэр бүү хэл цэцэрлэгийг бүхлээр нь хүнд эдлүүлэхээр өгсөн.

Могой Евад “Бурхан чамайг боддоггүй. Тэр чамаас ямар гоё зүйл нууж байгаа гэж бодно. Тэр чамайг бодсон шиг чинь хайрладаггүй. Тэр тийм ч сайн Бурхан биш болтой!” гэж хэлэхдээ, Бурханыг харах эмэгтэйн харааг мушгин гуйвуулжээ. Эмэгтэй мэхлэгдэж, Бурханы талаарх худалд итгэсэн. Тийнхүү Бурханы Үг амь байхаа больж, хууль болсон учраас, нүгэл үйлдэх хүсэл бадарсан. “Нүглийн хүч нь хууль юм” (1Коринт 15:56).

Дайсан өнөөдөр ч ингэж ажилладаг. Тэрбээр Бурхан Аавынх нь зан чанарыг үр хүүхдэд нь мушгин гуйвуулдаг. Хүн бүр амьдралдаа хайрлахыг мэддэггүй, амиа хичээсэн аав, багш, даргатай юмуу засаг захиргаатай нүүр тулдаг. Бурхан эрх мэдлийн ноён оргил учраас, Түүнийг эдгээр эрх мэдлийн кадруудаар төсөөлөх амархан.

Дайсан Бурхан Аавын маань зан чанарыг махан биеийн аавын маань зан чанараар яаж эрэмдэглэхийг яруу тод үзүүлдэг. Гэхдээ Есүсийг эргэж ирэхээс өмнө аавуудын зүрх сэтгэл үр хүүхдүүд рүүгээ эргэнэ (Малахи 4:6) гэдэг. Бурханы зан чанар эсвэл мөн чанар Түүний удирдагч нараас харагдаж, энэ нь эдгэрэлд хүргэх өөрчлөлт болно.

Бурхан юу ч хийсэн эсвэл хийгээгүй бай, энэ нь таны сайн сайхны төлөө бөгөөд Тэр таныг хорлох юм хэзээ ч хийхгүй гэдгийг мэдсэн хүн өөрийгөө Бурханд баяр хөөр, эрх чөлөөтэй зориулдаг.

Өөрийгөө Есүст бүрэн өргөж, Түүний хайр халамжинд даатгуулсан хүн өөрөө өөрийнхөө мэдлийнх биш болсон учраас, гомдолд өртөхгүй. Харин шархалж гомдсон хүмүүс нь голдуу Есүсийг Өөрийг нь бодож ирсэн бус, Түүний гарыг харж ирсэн хүмүүс байдаг.

Ийм хандлагатай хүн амархан гомдоно. Өөр дээрээ төвлөрөх явдал нь хүний харааг богиносгодог. Ойрын хараатай хүн нөхцөл байдлаа итгэлийн нүдээр харж чадахгүй. Тэгвэл амьдралаа тэр чигээр нь Есүст тавиад өгчихсөн хүн Есүсийг танин мэдсээр л, Түүний баяр хөөрийг улам л эдэлсээр байна. Хэзээ ч чичрэхгүй, хэзээ ч сүйрэхгүй.

Бодит орчин, нөхцөл байдлаар дүгнэдэг хүн амархан гомддог. Энэ бол Сүнсний нүдээр харах явдал яав ч биш. Бурхан ер нь бол миний тогтоосон аргаар юмуу цагаар хөдөлдөггүй. Гэхдээ эдүгээ би эргээд харахдаа, тухайн тохиолдол бүрээс Бурханы цэц ухааныг олж хардаг.

Заримдаа үр хүүхэд маань бидний хүмүүжүүлэх арга ухаан, үүний цаадах учир зүйг ойлгодоггүй. Бид цэц ухаан суулгах үүднээс арай томд нь тайлбарлах гэж хичээдэг ч, төлөвшөөгүй үрс маань үл ойлгох юмуу санал зөрөх нь бий. Гэхдээ тэд хожим нь заавал ойлгоно. Эсвэл энэ явдал тэдний дуулгавартай зан, хайр, өсөлт төлөвшлийг шалгах сорил ч байж болох. Тэнгэрийн Аав минь яг л ийм байдаг. Ийм тохиолдолд итгэл “Би ойлгохгүй ч, итгэж байна” гэдэг.

Еврей 11:35-39 дээр Бурханы амлалт биелэхийг хэзээ ч үзээгүй атлаа хэзээ ч урваагүй хүмүүсийн талаар бичжээ: “Эмэгтэйчүүд өөрсдийн үхэгсдийг амилалтаар буцаан авч байв. Зарим хүмүүс илүү дээр амилалтад хүрэхийн тулд золилтыг хүлээж авалгүй тамлагдсан юм. Зарим нь доромжлогдон, ташуурдуулсан. Тийм, бас гинжлэгдэн, хоригдож байлаа. Тэд чулуугаар шидүүлэн, соригдож, тас хөрөөдөгдөн, илдэнд хөнөөгдөж, хонь ямааны арьс нөмрөн явж, хоосон тарчиг байн, зовж, ад үзэгджээ. Тэд цөл, уул, агуй болоод газрын нүх сүвээр тэнүүчлэн байлаа. Тэдний хувьд дэлхий зохисгүй байжээ. Итгэлээрээ тэд бүгдээрээ сайн гэрчлэлийг олоод, амлагдсаныг хүлээн аваагүй аж.”

Тэд ямар ч үнэ өртөг төлсөн бай хамаагүй, гагцхүү Бурханыг л хүсчээ. Тэд Бурханы амлалт биелэхийг харж чадалгүй үхэхдээ ч Түүнд итгэсэн. Тэд гомдоогүй!

Бурханд ийм халуун хайртай, итгэдэг хүн суурь, үндэстэй байна. Ямар ч хүчтэй салхи шуурга нь түүнийг ганхаахгүй. Энэ нь хүчтэй зан чанараас юмуу хүслээс төрдөг зүйл бус, харин өөртөө тавих итгэлээ таягдаж, Бурханд итгэлээ өгсөн бүхэнд өгөгддөг нигүүлслийн бэлэг юм. Гэхдээ та өөрийгөө бүрэн даатгахын тулд амьдралыг тань атгаж буй Нэгэнийг сайн мэдэх ёстой.

НИГҮҮЛСЭЛ ДАРУУ ХҮНД ӨГӨГДДӨГ

Симон Петр өөрийгөө хамгийн аугаа нь хэмээн хөөрөхөө больжээ. Тэр өөр дээрээ тавьдаг итгэлээ гэсэн. Түүний мөнөөх их сэтгэлийн хүч тэнхээ нь нэг их бөх бат биш болохыг Петр тодорхой харж, даруу зан суув. Ийнхүү тэрбээр Бурханы нигүүлслийг хүртэх төгс нэр дэвшигч болжээ. Бурхан даруу хүнд нигүүлслээ хайрладаг. Даруу зан бол нигүүлслийн болзол юм. Тэрбээр захидалдаа “Залуус аа, та нар мөн түүнчлэн ахлагчиддаа захирагд. Та бүгд бие биедээ даруу хандах байдлаар өөрсдийгөө хувцасла. Учир нь Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг, харин даруу хүнд нигүүлслээ өгдөг” (1Петр 5:5) гэж бичсэн байдгаас үзбэл, Петр даруу занг яс махаараа ойлгожээ.

Петр бууж өгөхийн даваанд тулсан. Үүнийг нь Магдалын Мариад айлдсан тэнгэрэлчийн үгээс харж болно: “Харин явж, Түүний шавь нар болон *Петрт* “Есүс та нараас өмнө Галил уруу явна. Яг л айлдсаных нь дагуу та нар тэнд Түүнийг харах болно” гэж хэлээрэй гэлээ” (Марк 16:7). Тэнгэрэлч Петрийг нэр заан дурьджээ. Петр живдгийн даваан дээр ирсэн ч, дотор нь Бурханы суурь байсаар байжээ. Энэ суурь сэгсрэлтээр нурах бус, улам бэхжив.

Есүс Петрийг өршөөгөөд зогсохгүй, дахин сэргээсэн. Нилээд хүчтэй сэгсчээг давж гарсан энэ эрхэм эдүгээ чуулганы нэгэн чухал дүр болоход бэлэн болжээ. Тэрбээр Есүсийг цовдолсон хүмүүсийн нүүрэн дээр нь Эзэн амилсан хэмээн зоригтой тунхагласан юм. Зарц охиноос сүрдэж явсан энэ хүн хожим улсын зөвлөлийн өмнө эр мэдэл, эр зоригтой шүүгдсэн юм.

Петр олон жил үнэнчээр үйлчлээд, эцэстээ цовдлуулсан гэж түүх хэлдэг.2 Тэрбээр өөрийгөө Эзэнтэйгээ адил үхлээр үхэх зохисгүй нэгэн хэмээн зүтгэсэн учраас, уруу нь харуулж хаджээ. Тэр айхаа больжээ. Петр үнэхээр Хадан суурин дээр бат байгуулагдсан чулуу байв.

Хүний зүрхэнд юу байгааг - Бурханд эсвэл бусдад гомдох эсэхийг амьдралын бэрхшээл ил болгох. Шалгалт нэг бол таныг Бурханд юмуу найздаа гомдоход хүргэнэ эсвэл улам хүчтэй болгоно. Шалгалтыг давсан хүний үндэс улам гүн шаагдаж, таныг болоод таны ирээдүйг улам тогтвортой болгоно. Шалгалтанд унасан хүн гомдох бөгөөд яваандаа хорссоор хорссоор ялзарч дуусна.

ЭЗЭН БИ ТАНД ҮЙЛЧИЛСЭН, ГЭТЭЛ ЯАГААД...?

Намайг пастор байх үед манай залуусын цуглаанд найз нөхдийнхөө хүндэтгэлийг хүлээсэн, арван дөрвөн настай, хурц ухаантай нэгэн хүү байсан юм. Тэрбээр гялалзсан сурагч, гарамгай тамирчин байв. Хүү Бурханы төлөө шатаж, төсөл бүрт сайн дураараа итгэмжтэй үйлчилж, бидэнтэй хамт илгээлтээр явж, уулзсан хүн бүртээ Есүсийн тухай ярьдаг байв.

Нэг хэсэг хүү өдөр бүр 4 цаг залбирдаг байв. Тэгээд Эзэнээс сонссон олон сайхан зүйлээ бусадтай хуваалцана. Түүний яриа үргэлж бусдыг мялаадаг байв. Тэрбээр Бурханд үйлчлэхээр дуудагдсан гэдгээ мэдэгдэж, хорин нас хүрэхээсээ өмнө пастор болох мөрөөдөлтэй байлаа. Хүү үнэхээр л юунд ч дийлдэшгүй ургаа хад мэт байсан юм.

Би тэр хүүг хайрлаж, дуудлагыг нь хүлээн зөвшөөрч, хичээнгүйлэн сургадаг байсан ч, нэг л зүйлд зовниж байв: хүү өөртөө хэт итгэлтэй санагддаг байлаа. Түүнд хэлмээр байв ч, аман дээр гарч ирээд л... буцаагаад л залгичихна. Гэхдээ би өөрчлөлт ирэхийг мэдэж байв. Тэрбээр үе үе нилээд хүчтэй шуурганд цохиулсан болов ч, хүчтэй хэвээрээ л байлаа. Түүнийг ийнхүү харгис хатуу шүүх дундуур шүд зуун давж гарахыг нь харахдаа, би өөрийнхөө дүгнэлтэнд эргэлзсэн юм.

Хэдэн жил өнгөрөв. Хүү хол газар руу нүүж, би ч бүтэн цагаар аялж үйлчилдэг болов. Гэхдээ бид хоёр харилцаа

тасарсангүй. Хэзээ, хэрхэн гэдгийг нь мэдэхгүй ч, хүү Бурханы мутраар элдүүлж, зөөлрөх цаг ирнэ гэдгийг би мэдэж байв. Ингэж байж л хүү хувь тавилангаа биелүүлнэ. Симон Петрийн шигшигдсэнтэй л адил үйл явц болно.

Хүүг арван наймтай байхад аав нь хорт хавдар тусав. Аав нь эдгэрнэ гэдэгт итгэн, хүү ээжтэйгээ мацаг барин залбирав. Хүмүүс ч түүнтэй нэгдэв. Хэдхэн сарын өмнө аав нь Эзэнд итгэж, амьдралаа өгчээ.

Аав нь муудсаар байв. Намайг Алабамад үйлчилж байтал, гэргий маань залгаж, нөгөө хүүтэй ярихыг санд мэнд дуулгав. Би хүүтэй яриад, түүнд урам хэрэгтэй байгааг мэдлээ.

Би үйлчлэлээ дуусгаад, шөнөжин давхисаар үүрийн дөрвөн цагт гэрт нь очив. Аавынх нь бие маш муу байсан бөгөөд эмч нар түүнийг хэдхэн өдрийн л настай гэжээ. Аав нь ярьж, харилцаж ч чадахгүй байлаа.

Аав нь заавал эдгэрч босно гэдэгт залуу итгэл дүүрэн байв. Би тэдний гэр бүлийн төлөө үйлчлээд, хэдэн цагийн дараа буцлаа. Маргааш нь хүү байдал бүр дордсоныг дуулгав.

Лиза, бид хоёр тэр даруй залбирлаа. Лиза Бурханаас Есүс хүүгийн аавыг гэрт нь аваачихаар дэргэд нь зогсож байгаа үзэгдэл үзэв. Гучин минутын дараа хүү утасдаад, аав нь өнгөрсөн тухай дуулгалаа. Тэр урьдын адил хүчтэй л сонсогдож байв. Гэхдээ энэ бол зөвхөн эхлэл байв.

Тэр орой хүү аавынхаа талаар дуулгахаар найзууд руугаа утасдтал, найзууд нь утсаа авахдаа цурхиран уйлцгааж байжээ. Залуу тэднийг аавынх нь талаар яаж дуулсан юм бол хэмээн гайхтал, тэд хүүгийн аавын талаар огт мэдээгүй, харин дөнгөж сая хамгийн сайн найз нь ослоор үхсэн учраас, уйлцгааж байжээ. Ийнхүү хүү нэг өдрийн дотор аав, найз хоёроо зэрэг алдсан байна.

Сэгсрээ эхлэв. Хүү уурлаж, гонсойж, сүүлдээ зүгээр л гөлийв. Түүнийг Бурханы оршихуй орхижээ гэлтэй.

Хэдэн сарын дараа залуу гэртээ харьж явахдаа, зам тээврийн осолтой таарчээ. Хүү түргэн тусламжийн сургалтанд суусан байсан учраас, туслахаар зогсов. Хоёр машинд байсан бүх хүмүүс түүний дотны нөхөд байв. Хүүг туслах гэж хичээх хооронд хоёр нөхөр нь гар дээр нь нас баржээ.

Хүүгийн тэвчээр тас үсрэв. Тэрбээр модон дотор гурван цаг Бурхан руу: “Та хаана байна? Та миний Тайвшруулагч гээ биз дээ? Гэтэл надад ямар ч тайтгарал алга!” хэмээн хашхирчээ.

Бурхан түүнээс нүүрээ буруулчихсан гэлтэй л байв. Гэхдээ энэ үед анх удаа залуугийн өөрийнх нь хүч нуржээ.

Залуу: “Яалаа гэж ийм юм зөвшөөрч байгаа юм?” хэмээн Бурханд уурлаж. Тэрбээр пастортаа, гэр бүлдээ эсвэл надад уурлаагүй. Тэр Бурханд итгэл алдарч, уурлажээ. Хамгийн хэрэгтэй үед нь Бурхан түүнийг хөсөрдүүлжээ.

“Эзэн, би танд бүхнээ зориулан үйлчилсэн. Гэтэл Та намайг орхисон!” Өөрт нь үйлчилснийх нь төлөө Бурхан түүнд өртэй хэмээн залуу санажээ.

Олон хүн их, бага хэмжээгээр шарх, гомдол тээдэг. Олон хүн Бурханд гомддог. Түүний төлөө хийсэн бүхнийг нь Бурхан харгалзаж үзэх ёстой гэж тэд итгэдэг.

Тэд буруу сэдлээр Бурханд үйлчилж байна. Бид Бурханд бидний төлөө хийх зүйлсийнх нь төлөө үйчлэх бус, харин зүгээр л Бурханы Өөрийнх нь төлөө бас бидний төлөө үйлдсэн бүхнийх нь төлөө л үйлчлэх ёстой. Биднийг чөлөөлөхийн тулд үйлдсэн бүхнийх нь төлөө бид Бурханд ямар их өртэй болохыг гомдсон хүмүүс ойлгодоггүй. Тэд ямар үхлээс чөлөөлөгдсөнөө мартдаг. Тэд мөнхийн хараагаар бус, махан биеийн нүдээр л хардаг.

Мөнөөх залуу чуулганд явахаа больж, нохойн замаар орж, баарны байнгын зочин болов. Гутарсан залуу Эзэнийг бодохыг ч, мэдэхийг ч, санахыг ч хүссэнгүй.

Гэхдээ тэрбээр зүрхнийхээ угт зэм мэдэрч байсан тул ийм янзтай хоёр долоо хоногоос илүү явж тэсээгүй байна. Гуулин залгичихсан аятай хүнд байсан ч, тэрбээр бүтэн зургаан сар Эзэндээ эргэж очилгүй, хатуурхжээ. Бурханы оршихуй ч сураггүй.

Жил өнгөрөв. Бурхан амьдралд нь ажилласаар байгааг хүү хэд хэдэн удаа харжээ. Хүү Бурхан дээр эргэж очсон ч, энэ удаа байдал тэс өөр болжээ. Хүү даруусчээ. Эзэн түүнийг хэзээ ч орхиогүй болохоо шалгалтын дараа хүүд харуулжээ. Хүү сүнсээр сэргэсэн хойноо итгэлээ өөр дээрээ бус, Бурханы нигүүсэл дээр тавьж сурчээ.

Жил хагасын дараа хүү надад огт мэдээгүй нэгэн зүйл түүнд байсныг мэдсэнээ ярьж билээ: “Би бүх харилцаандаа хөнгөмсөг ханддаг, зан чанаргүй хүн байжээ. Аав минь надад хүний нүдэнд эр хүн шиг хүчтэй явахыг л сургасан. Би Бурханы хүссэн замаар өсөөгүй байж. Эзэн намайг тэр янзаар минь орхиогүйд талархаж байна.

Гэхдээ би баар сав хэсч, архи дарсанд согтуурсандаа бус,

Ариун Сүнснээс нүүр буруулсандаа л хамгийн их харамсаж байна. Би Түүнд дэндүү хайртай. Бидний харилцаа хэзээ ч ийм дотно байгаагүй.”

Түүний амьдрал навсайтал сэгсрэгджээ. Өөртөө итгэх итгэл нь ч ховхорч. Гэхдээ Симон Петргэй адил хүүгийн суурийг юу ч ховхолж дийлсэнгүй. Эдүгээ манай залуу амьдрал, үйлсээ бардам зангаар байгуулахын оронд Бурханы нигүүлслээр сүндэрлүүлж яваа.

Гомдол нь сул тал, зан чанарын хугархайг илчилдэг. Тэгээд бидний голдуу хүчтэй гэж харж байсан хэсэг маань далд өөтэй болж таардаг. Хүчтэй салхи өнгийг нь хуулахаас нааш, тэр өө байсаар л байна. Элч Паул “Учир нь *махан биедээ түшиглэдэггүй*, Бурханы Сүнсээр мөргөж, Христ Есүсээр сайрхдаг бид бол жинхэнэ хөвч хөндүүлэгсэд билээ” (Филиппой 3:3) гэсэн.

Бид хүний хүчээр мөнх настай юу ч бүтээж чадахгүй. Хэлэхэд ч амархан л даа. Гэхдээ л энэ үнэнийг дотроо гүн үндэслүүлэх нь тэс өөр асуудал буюу.

ЕСҮС ХҮМҮҮСИЙГ ГОМДООХГҮЙ ГЭЖ ҮНЭНИЙГ ХӨСӨРДҮҮЛЭЭГҮЙ.

“Сатаны урхи” ном хоёр нүдийг маань тайлж өглөө. Би нөхөртэйгээ хамт Бурханд үйлчилдэг бөгөөд Эзэн бид хоёрын харилцаа тун сайн байгаа гэж би боддог байлаа. Гэтэл 15 жилийн турш авга эгчдээ тээж яваа хорсол маань намайг хамаг байдгаас маань салгаж болохыг ухаарлаа. Христэд итгэдэг хүн уучлах ёстой гэдгийг бид бүгдээрээ л сурдаг. Гэхдээ таны ном намайг өнгөрсөн амьдралын маань шархтай нүүрэлдүүлэхээс өмнө энэ үнэнийг зүрхэндээ хүлээж аваагүй явжээ.

- R. M., TENNESSEE

ГОМДООГЧ ХАД

Энэ нь Сударт

“Харагтун. Би Сионд сонгогдсон,

Булангийн үнэт чулууг тавина.

Түүнд итгэгч хүн ичгүүрт орохгүй”

хэмээн бичигдсэн байдаг. Тиймээс итгэгч та нарт энэ

нь үнэт. Харин үл итгэгчдэд

“Барилгачдын голсон чулуу нь булангийн чулуу болов”

гээд “Бүдрүүлэх Чулуу, тээглэх Хад болсон юм”

гэжээ. Тэд үгэнд дуулгаваргүй байдгаас болж бүдэрдэг

бөгөөд энэ нь тэдэнд тогтоогдсон аж.

1Петр 2:6-8

Өнөөдөр *итгэх* гэдэг үгийн утга суларчээ. Ихэнх хүний хувьд энэ нь тодорхой нэг баримтыг хүлээн зөвшөөрөх явдал бөгөөд дуулгавартай байдалтай ямар ч хамаагүй байдаг. Гэтэл дээрх хэсэгт *итгэх* ба *дуулгаваргүй байдал* нь эсрэг тэсрэг хоёр зүйлийг төлөөлж байна.

Бичээс “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16) гэдэг. *Итгэх* гэдэг

үгийн талаарх үзлээсээ болоод хүмүүс “бид зүгээр л Есүсийг байсан, Голгот дээр алуулсан, одоо Бурхан - бидний харилцаа хэвийн болсон гэдэгт итгэхэд л болно” гэж боддог. Иймхэн шаардлагатай юм бол, чөтгөрүүд ч тун дажгүй итгэгчид болох байх. Бичээс “Бурхан бол ганц гэдэгт чи итгэдэг. Энэ чинь сайн хэрэг. *Чөтгөрүүд ч мөн үүнд итгэдэг* бөгөөд чичирдэг” (Иаков 2:19) гэдэг ч, чөтгөрүүд аврагдахгүй.

Бичээст *итгэх* гэдэг үг нь зүгээр нэг оршин байдгийг хүлээн зөвшөөрөх юмуу баримтыг зөвшөөрөхөөс хавьгүй гүн утгатай. Дээрх ишлэлийн агуулгыг нь дагах юм бол, итгэхийн гол бүтэц нь дуулгавартай байдал болж таарч байна. Тиймээс дараах байдлаар уншиж болох нь байна: “Тиймээс *дуулгавартай дагадаг* та нарт энэ нь үнэт. Харин *дуулгаваргүйд нь* “Барилгачдын голсон чулуу нь булангийн чулуу болов” гээд “*Бүдрүүлэх Чулуу, тээглэх (гомдоогч) Хад* болсон юм.”

Захирч буй хүнийхээ зан чанарыг мэддэг, хайрладаг бол, дуулгавартай дагах хэцүү биш. Зарчмыг юмуу сургаалыг хайрлах хайр бус, харин Есүс Христийг Өөрийг нь хайрлах хайр нь Эзэнтэй тогтоох харилцааны маань суурь билээ. Тэр хайр байрандаа байхгүй бол, бид амархан гомдож, бүдэрнэ.

Бурханы барилгачдаа болгохоор дуудсан Израильчууд Бурханы гол булангийн чулуу болох Есүсийг эсэргүүцсэн. Тэд Хуучин гэрээний сургаалдаа л дуртай байсан. Тэд өөрсдийнхөө тайлбарт дуртай байсан. Үүгээрээ тэд эрх ашгаа хамгаалж, бусдыг захиргааж байв. Гэтэл Есүс тэдний үхэн хатан зууралдах хуульчлалтай нь халз тулаад: “Та нар Судруудыг судалдаг. Учир нь тэдгээрийн дотор мөнх амь бий гэж та нар боддог. Тэдгээр нь Намайг гэрчилдэг билээ” (Иохан 5:39) хэмээн учирласан.

Бурхан анхнаасаа л олон хөвгүүд охидтой болж, тэдэнтэйгээ харилцахыг хүссэнийг тэд ойлгоогүй. Тэд өөрсдөө л захирч, ноёлохыг хүссэн. Тэд хуулийг харилцаанаас дээгүүр харж байж. Тэд үнэгүй өгсөн зүйлээс татгалзаж, гавъяа байгуулж байж олж авахыг дээр гэж үзжээ. Тиймээс Бурханаас үнэгүй өгсөн бэлэг буюу тэдний амьдралын найдвар хийгээд аврал болсон Есүс Христ тэдний хувьд “бүдрүүлэх чулуу бөгөөд гомдоогч хад” болжээ.

Сүм дотор Симеон нярай Есүсийг өргөөд “Харагтун, энэ Хүүхэд Израильд олныг унагах, босгох болон эсэргүүцэх

тэмдгийн төлөө томилогджээ” (Лук 2:34) хэмээн зөгнөсөн. Унах ба босох гэснийг тэмдэглэнэ үү. Энэ дэлхийд энх тайван авчрах учиртай Нэгэн нь илгээгдсэн хүмүүстээ илд авчирч (Матай 10:34), барилгачдын золиос болгосон хүмүүст (тухайн үеийн үйлчлэгч хүмүүст) амьдрал авчирна гэжээ.

ГОМДООГЧ ЕСҮС

Хүүхдийн цуглаанд Есүсийг төөрсөн хонио мөрөн дээрээ дүүрээд сүрэг рүүгээ ирж буй Хоньчноор байнга дүрсэлдэг байж билээ. Эсвэл Есүс жаахан хүүхдүүдийг элгэндээ наагаад, “Би чамд хайртай” хэмээн эелдгээр инээмсэглэх зураг ч бий. Эдгээр нь үнэн боловч, бүтэн дүр зураг биш юм.

Тэр л Есүс Фарисайчуудыг “Могойнууд аа, хорт могойн удам аа, тамын шийтгэлээс та нар яаж зугтаах вэ?” (Матай 23:33) хэмээн зандарсан. Түүнчлэн мөнгө солигч нарын ширээг хөмрөөд, хөөж туусан (Иохан 2:13-22). Аавыгаа оршуулчихаад ирэхийг хүссэн хүнд “Үхэгсдийг үхэгсдээр нь оршуулуул. Харин чи явж, Бурханы хаанчлалыг газар бүр тунхагла” (Лук 9:59-60) гэж хэлсэн гэх мэтчилэн тоочоод л байвал, тоочоод л байна.

Сайн харах юм бол, Есүс үйлчлэх хугацаандаа олон хүнийг гомдоожээ. Хэдхэн жишээ л авч үзье.

Есүс Фарисайчуудыг гомдоов

Есүс тэр удирдагч нарыг олон гомдоосон. Тэд гомдсондоо Есүсийг загалмайд хадсан. Тэд Есүсийг үзэн ядсан.

Гэхдээ Есүс тэднийг хайрласандаа л: “Зальхай хүмүүс ээ, Исаиа та нарын тухай зөв эш үзүүлсэн юм. Ингэхдээ “Энэ ард түмэн Намайг амаараа хүндэлдэг. Гэвч тэдний зүрх Надаас алс хол байдаг. Тэд хүнээс гарсан тушаал зааврыг сургаж, Надад дэмий хоосноор мөргөж байна” (Матай 15:7-9) хэмээн үнэнийг нь хэлсэн юм. Гэтэл энэ мэдэгдэл тэднийг гомдоожээ.

Үүний дараа дагалдагч нар нь Есүсээс юу гэж асуусныг тэмдэглэнэ үү:

Энэ үгсийг тань сонсоод фарисайчууд *гомдсоныг* Та мэдэв үү? гэжээ. Матай 15:12

Есүсийн хариултыг үзье:

Тэнгэрлэг Эцэгийн минь тариагүй алив ургамал үндсээрээ сугалагдана. Тэднийг орхи. Тэд бол сохруудыг удирддаг сохрууд юм. Хэрэв сохор нь сохроо удирдвал, тэд хоёул нүхэнд унах болно. Матай 15:13-14

Гомдол үнэндээ Аавынх нь тариагүй хүмүүсийг цэвэрлэдгийг Есүс харуулжээ. Зарим хүн чуулган, үйлчлэлд нэгддэг ч, Бурханы хүн юмуу эсвэл Бурханаар илгээгдээгүй байж болно. Үнэнийг номлох үед гардаг гомдол нь тухайн хүний жинхэнэ сэдлийг илчилж, тэднийг үндсээрээ булгарахад хүргэдэг.

Би янз бүрийн чуулганаар зочлохдоо, чуулганаа орхиж явсан ажилчин, гишүүнийхээ араас гашуудах пасторыг олон харсан. Тэд бол ихэнх тохиолдолд үнэнийг номлож, амьдарч байгаа арга маягтай нь нүүр тулах үед дургүйцсэн хүмүүс байдаг. Тэд чуулганыг тал бүрээр шүүмжлээд, эцэстээ яваад өгдөг.

Чуулганы хаалгаар орж ирсэн болгоныг тогтоож үлдээхийн тулд эрт орой хэзээ нэгэн цагт үнэнийг уландаа гишгэх ёстой болно. Тиймээс би пасторуудад: “Та үнэнийг номлохдоо хүмүүсийг гомдооно. Тэд үндсээрээ ховхорч, явах болно. Тэдний араас бүү гашууд. Оронд нь Бурханаас илгээсэн хүмүүсийг бойжуул” гэж хэлдэг юм.

Зарим удирдагч хүмүүсээ алдахаас айсандаа нүүрэлдэхээс зайлсхийдэг. Ялангуяа чуулганд их өргөл өгдөг эсвэл чуулгандаа юмуу нийгэмдээ нэр нөлөө бүхий хүмүүстэй. Зарим нь олон жил хамт байсан нөхрөө гомдоохоос эмээдэг. Тэгээд эцсийн эцэст пасторууд Бурханаас даалгасан хонин сүргийг хамгаалж, өсгүүлэхийн тулд өгсөн эрх мэдлийг алддаг.

Намайг дөнгөж пастор болоод байхад нэг ухаантай хүн: “Эрх мэдлээ бүү алдаарай. Эс бөгөөс хүн үүнийг чинь булаагаад, чиний эсэг ашиглана шүү” гэж захиж билээ.

Самуел бол үнэнийг хэний ч өмнө, тэр бүү хэл хааны ч өмнө хөсөрдүүлэхгүй, Бурханы хүн байв. Саул Бурханы үгийг зөрчихөд, Бурхан Самуельг Саултай нүүрэлд гэж тушаасан. Самуел нүүрэлдсэн. Харамсалтай нь Саул Эзэний үгийг үнэн гэмшлээр хүлээж авалгүй, хүмүүсийн нүдэнд харагдах байдалдаа л зовнижээ. Самуельг явах үед Саул хормойноос нь зуураад, тасдаж авсан. Тэр үед Самуел: “ЭЗЭН өнөөдөр танаас Израилийн хаанчлалыг таслан авч, түүнийг танаас

илүү сайн, таны хөршид өгөв” (1Самуел 15:28) гэж хэлсэн нь Саулыг балмагдуулав.

Самуел Саулд үүнийг хүсээгүй. Самуел Саулын төлөө гашуудсан. Самуел өөрөө Саулыг хаанаар тослож, сургаж, хаан ширээнд залсан. Самуел Саулын нөхөр байсан. Гэтэл Самуелын гашуудалд Бурхан юу айлдсаныг харъя: “Би Саулыг Израилийн хаан байлгахаас нэгэнт *татгалзсан* учир чи хэдий хүртэл Саулын хойноос гашуудах юм бэ? *Эвэртээ тос дүүргээд* явагтун. Би чамайг Бетлехемийн хүн Иесси уруу илгээе. Учир нь Би түүний хөвгүүдийн дундаас Өөртөө хааныг сонгосон билээ” (1Самуел 16:1).

Самуелын хувьд цаашид шинэ тос, тосолгоогоор үргэлжлүүлэн өсөхийн тулд Бурханы хайр, шүүх төгс болохыг ойлгох ёстойг Бурхан Самуелд хэлжээ. Бурхан Саулыг голоод байхад, Самуел Саул руу эргэж буцаад байсан бол, шинэ тостой болохгүй байх байж. Самуел гашуудсаар байсан бол, урагшлахгүй байх байж.

Чуулганаас явчихсан хүнийхээ араас гашуудаад суудаг эсвэл найз нөхөр учраас, нүүрэлдэж чаддаггүй пасторын тосолгооны тос нь хатна. Зарим үйлчлэл үхэж, зарим нь амьтай мэт харагдана. Тэд өөрөө ч мэдэлгүй Бурхантай тогтоох харилцааг бус, хүнтэй тогтоох харилцааг сонгожээ.

Есүс Өөрийг нь орхиж явсан хүмүүсийн араас нэхэл болсныг Библи өгүүлдэггүй. Есүс Аавынхаа хүслийг л биелүүлэхийг хүссэн. Ингэснээрээ ч илүү олон хүнтэй болох байв.

Би Сүнсээр дүүрэн урсгал чиглэлийн нэгэн чуулганд номлосноо хэзээ ч мартахгүй. Бид түншлээд жил болж байлаа. Эхний бүтэн сайны өглөө би гэмшил, анхны хайраа буцааж сэргээх талаар энгийн үг номлов. Надад эсэргүүцэл мэдрэгдсэн ч, би энэ үгийг хэлэх ёстойгоо мэдэж байлаа.

Цуглааны дараа пастор нь надад: “Чиний номлох зүйлийг Бурхан надад харуулсан. Гэхдээ хүмүүс маань ийм номлолд арай л бэлэн байсангүй” гэж хэлэв.

Тэгтэл Ариун Сүнсний сануулгаар гэргий маань: “Энэ чуулганы пастор хэн бэ? Та юу, Есүс үү?” гэж асуусан юм.

Пастор толгой гудайгаад: “Нээрээ л сарын өмнө Эзэн надад яг ингэж хэлсэн. Энэ хүмүүс ямар даацтайг ч мэдэж байгаагаа хэлсэн” гэв. Тэгээд чуулганых нь гуравны нэг нь цуглаан, хөгжим, номлолыг өөрчлөхийг хүсдэггүй “хуучуул” гэдгийг ярьсан юм.

Бид түүнийг хүчтэй байж, Эзэний үгэнд орохыг урамшуулав.

Бид дахин дөрвөн цуглаан хийсэн бөгөөд цуглаан ирэх тусам улам хүндэрсээр байлаа. Тэр хотоос явахдаа би, элс залгичихсан юм шиг л гарч явав. Учрыг ч олсонгүй. Улам л хүндэрсээр, улам л тавгүйтсээр.

Ер нь бол ямар нэгэн чуулганаас явах үед зүрх минь баяр хөөрөөр цалгидаг. Тиймээс би юун буруудсаныг ойлгохгүй байлаа.

Тэгээд Эзэнтэй хоёулхнаа байх цаг гармагц, би Бурханаас “Аав аа, би буруу юм хийчихсэн үү? Миний сүнс яагаад ийм дарамттай байна вэ? Би пасторынхаа эрх мэдлийг давруулсан уу?” гэж асуув.

Гэтэл Бурхан ердөө л “Та нарыг хүлээн авахгүй хүмүүсийн хувьд, хотоос нь гарч явахдаа тэдний эсрэг гэрчлэл болгон хөлийнхөө тоосыг сэгсрэн унага” (Лук 9:5-ыг үзнэ үү) гэсэн юм.

Энэ үг намайг мэл гайхшруулав. Тэгээд залбирсаар шалгаасаар байсан болов ч, “Хөлийнхөө тоосыг гөв” гэдгээс өөр үг дуулсангүй.

Тиймээс би Эзэний үгэнд орлоо. Тэгээд хоёр дахь гутлынхаа өсгийнөөс өргөх үед дарамт ууршиж, зүрхэнд минь баяр хөөр нэвтрэв. Би дахиад л гайхангаа: “Эзэн минь, тэр хүмүүс над руу дайраагүй, намайг хотоос хөөж гаргаагүй. Тэгээд яагаад?” гэлээ.

Эзэн тус чуулганы олон удирдагч, хүмүүс үгийг нь эсэргүүцснийг надад харуулав.

“Тэдэнд жаахан цаг өгөөч” хэмээн би гуйлаа.

“Би тэдэнд дахиж тавин жил өгсөн ч, тэд өөрчлөгдөхгүй. Тэд сонсохгүй байхаар зүрхэндээ шийдсэн.”

Удирдагч нь Бурханыг дагахын оронд буулт хийж, хүмүүстэй эвтэй байхыг илүүд үзжээ. Түүний эвэр шинэхэн тосоор сэлбэгдэхээ больжээ. Өөрөөр хэлбэл, тэрбээр гаднаасаа Сүнсээр дүүрэн харагдав ч, Бурханы оршихуй, хүч чадлаар дутаж байж. Хожим тэрбээр пасторынхаа ажлаас гарч, чуулган нь хэд дахин жижгэрснийг дуулж билээ.

Есүс хэнд ч захирагдаагүй. Хүмүүс эсэргүүцэж, гомдол гаргасан ч, Есүс үнэнийг л ярьсан. Хэрэв та хүнд таалагдахыг хүсбэл, Бурханы тосолгоо тан дээр буухгүй. Хүмүүс гомдоно уу байна уу хамаагүй, Бурханы Үгийг л ярьж, хүслийг л биелүүлэхийг зүрхнээ шийдээрэй.

Есүс нутаг усныхнаа гомдоов

Есүс нутагтаа үйлчлэхээр ирсэн ч, олон хүмүүст хүргэсэн эрх чөлөө, эдгэрлээ тэдэнд хүргэж чадаагүй. Хүмүүс юу гэж ярилцсаныг үзнэ үү:

Энэ чинь мужааны хүү биш бил үү? Эхийг нь Мариа, дүү нарыг нь Иаков, Иосеф, Симон, Иуда гэдэг биш бил үү? Охин дүү нар нь бүгд бидэнтэй хамт байгаа биз дээ? Тэгвэл энэ хүн тэр бүхнийг хаанаас авав? гэцгээв. Тэд Түүнд гомдов. Харин Есүс тэдэнд

—Эш үзүүлэгч нь төрөлх нутаг, гэрийнхнээсээ өөр газар л хүндлэгддэг юм гэж айлдав. Матай 13:55-57

Назарын харчууд, хүүхнүүд: “Энэ хэн болчихоод ийм том ярина вэ? Бид түүнийг мэднэ. Тэр энд өссөн. Ах захаа мэдэхгүй. Тэр чинь мужааны л хүү. Албан ёсоор сургагдаагүй” гэцгээжээ.

Есүс хүмүүсийг гомдоохгүйн тулд үнэнийг хөсөрдүүлээгүйг дахин хэлье. Хотынхон Есүсийг хаднаас түлхэж алахдаа тултлаа хилэгнэжээ (Лук 4:28-30). Амь насанд нь аюул тулгараад байхад ч Есүс үнэнийг л ярьсаар байсан. Өнөөдөр бидэнд ийм л эрчүүд, эмэгтэйчүүд хэрэгтэй!

Есүс гэр бүлээ гомдоов

Есүст гэр бүлийнхэн нь ч гомдсон. Гэр бүл нь Есүсийн үйл хэргээс болж үзэж байгаа дарамтанд дургүйцжээ. Тэд Есүсийн авир, үйлдэлд итгэж ядаж байв:

Үүнийг сонсоод хамаатнууд нь Есүсийг авчрахаар явав.

Учир нь хүмүүс Түүний тухай

—Тэр Өөрийн ухаан мэдрэлээ алджээ гэж ярьж байлаа ...

Есүсийн эх болон дүү нар нь ирээд гадаа зогсож, Түүнийг дуудуулахаар хүн оруулав. Есүсийг олон хүн тойрон сууж байлаа. Тэд Түүнд

—Хараач. Ээж болон дүү нар тань Таныг хүлээгээд гадаа байж байна гэхэд, Тэр тэдэнд хариулан

—Хэн Миний ээж, [Миний] дүү нар юм бэ? гээд, Өөрийг нь хүрээлэн суугчдыг хараад,

—Миний ээж болон Миний дүү нарыг харагтун. [Яагаад гэвэл] Бурханы хүслийг биелүүлэгч хэн боловч Миний ээж

болон дүү нар минь юм гэж айлдав. Марк 3:21, 31-35

Гэр бүлийнхэн нь Есүсийг солиорч гэж боджээ. Есүсийн гэр бүлийнхэн нь Түүнийг батлан даахаар ирсэн гэж Бичээс тэмдэглэсэн. Хамаатан садан гэдэг нь Есүсийг нэгэн айлд номлож байхад нь эрэл сурал болсоор ирсэн ээж, дүү нар нь байсныг Марк хэлдэг. Иоханы Сайн мэдээ ч “Есүсийн дүү нар нь хүртэл Түүнд итгээгүй байжээ” (Иохан 7:5) гэдэг.

Есүсийг ойр дотныхон нь эсэргүүцснийг олон хүн ухаардаггүй. Гэхдээ тэрбээр гэр бүлийнхээ тааллыг хайгаагүй. Есүс тэдний хүслээр хөдлөөгүй. Хүмүүст таалагдсан, таалагдаагүй, Есүс Аавынхаа төлөвлөгөөг л биелүүлжээ.

Хүн нэн ялангуяа хань, гэр бүлээ гомдоохоос эмээсэндээ, Есүсийг дагахаас татгалзаж байхыг би олон харсан. Үүнээсээ болоод итгэлээ хаях юмуу дуудлагаа тултал биелүүлдэггүй.

Намайг дахин төрөх үед Ромын католик итгэлтэй гэрийнхэн маань миний шинэ итгэлийн баяр хөөрийг хуваалцаагүй юм. Өсч өндийсөн сүмээ орхиж байгаад нэн ялангуяа ээж маань жигтэйхэн дургүйлхэв. Мэдээж Бурханд хайртай, сайхан Католик хүмүүс олон чиг, Бурхан намайг дуудаж байгааг би мэдэж байлаа.

Дараа нь Бурханд үйлчлэх шийдвэрээ мэдэгдэх үед хоёр дахь том цохилт буув. Тухайн үед би Пердю Их сургуулийг механик инженерийн мэргэжлээр дөнгөж дүүргээд байсан тул аав, ээж хоёр надад их найдлага тавьж байжээ. Эзэний надаас хүсэх юмс миний дотны хүмүүсийг гомдоохыг би мэдэж байлаа. Олон ч жил хэцүү байв. Үл ойлголцох юм ч олон байв. Гэхдээ тэднийг яаж уурласан ч, би Есүсийг дагахаар шийдчихсэн байлаа.

Эхлээд би тэднийг Сайн мэдээгээр дайрах гэж оролдов. Католик сүмд явснаар аврагдахгүй гэж тулгасаар, хамаг мэдрэлийг нь барав. Энэ ухаалаг арга байгаагүй юм. Тэгтэл Бурхан надад эхлээд тэдний өмнө итгэгч хүн шиг амьдарч, сайн үйл хэргээ харуулахыг зааж өгөв. Гэхдээ би гэр бүлдээ таалагдах гэсэндээ үнэнийг хөсөлдүүлдэггүй хэвээрээ л байлаа.

Өнөөдөр аав, ээж хоёр маань намайг тал бүрээр дэмждэг бөгөөд хамгийн их дайгсан өвөө маань өөд болохоосоо хоёр жилийн өмнө буюу 89 насандаа ер бусаар аврагдсан юм.

Ээж, дүү нар нь Есүсийг элий балай болжээ гэж бодсон. Гэхдээ Есүс Аавдаа дуулгавартай байсны улмаас тэд аврагдаж,

дүү Иаков нь Пентекост өдөр дээд өрөөнд тэргүүн элч нарын нэг болсон юм.

Бид гэр бүлээ баярлуулах гэсэндээ Бурханы үгнээс гараад байвал, өөрийнхөө шинэ тосолгоог бараад зогсохгүй, гэр бүлээ аврагдахад нь садаа хийнэ.

Есүс ажилчдаа гомдоов

Есүст гомдсон дагалдагч нар нь хэрхсэн талаар бид өмнөх бүлгээрээ дэлгэрэнгүй үзсэн. Энэ явдлыг Есүсийн нүдээр дахин харъя:

Тэд үүнийг сонсоод, дагалдагчдаас олонх нь
—Энэ чинь хэцүү үг байна. Үүнийг хэн сонсож чадах вэ? гэгцгээв. Харин Есүс үүний тухай дагалдагчдынхаа дургүйцэн шивнэлдэхийг мэдээд, тэдэнд
—*Энэ нь та нарыг бүдрүүлчихэв үү (гомдоочихов уу)?* гэв.
...Үүнээс болж Түүний дагалдагчдаас олон хүн зайлан явж, цаашид Түүнтэй хамт явсангүй. Иохан 6:61-66

Байдал хүнд байв. Шашны удирдагч нар Есүсийг алахаар хуйвалдаж, нутгийнхан нь эсэргүүцэж, гэр бүл нь солиорсонд тооцож байтал дээрээс нь ихэнх ажилчид нь гомдоод яваад өгсөн. Гэвч Есүс буулт хийгээгүй. Есүс үлдсэн хүмүүст ч явмаар байвал, яваарай гэжээ.

Есүс Аавынхаа төлөвлөгөөг биелүүлэхээс өөр зүйл бодоогүй. Есүс тэр өдөр ганцаархнаа үлдсэн ч, зүрхээ өөрчлөхгүй байх байв. Тэрбээр Аавыгаа дагахаар шулууджээ.

Есүс дотны нөхдөө гомдоов

Бетаны Лазар гэгч эр өвчтэй байлаа. Бетан бол Марта, түүний дүү Мариа хоёрын тосгон болой. Мариа бол Эзэнийг тосоор тослоод, Түүний хөлийг үсээрээ арчсан тэр эмэгтэй байв. Түүний ах Лазар нь өвчтэй байв. Тиймээс эгч дүүс Есүст хүн илгээж
—Эзэн минь, хараач, Таны хайрладаг хүн өвдөв хэмээн хэлүүлэв. Иохан 11:1-3

Есүс Марта, Мариа, Лазар гуравт хайртай байсан. Тэд маш дотно нөхөрлөдөг байв. Гэтэл Лазарыг өвдсөнийг дуулаад Есүс хэрхсэнийг үзнэ үү:

Лазарын өвдсөнийг сонсоод, Есүс байсан газраа хоёр хонов.
Иохан 11:6

Лазар өвчнөөрөө үхэхийг Есүс илчлэлээр мэдэж байжээ. Үхэл тоглоом биш. Гэхдээ Есүс тухайн газраа дахин хоёр хоног саатжээ. Тэгээд явсаар Бетанд ирэхэд, Лазар хэдийнээ амьсгаа татсан байв.

Марта, Мариа хоёр Есүст “Эзэн, Та энд байсан бол миний ах үхэхгүй байх байсан” (Иохан 11:21-32) гэсэн. Өөрөөр хэлбэл, тэд: “Та юунд эрт ирсэнгүй вэ? Эрт ирсэн бол, ахыг маань аварч чадах байсан!” гэжээ.

Хоёр бүсгүй гомдсон л байх. Тэд Есүст даруй хэл дуулгаж байхад, Есүс бүтэн хоёр хоног саатсан. Есүс тэдний санаснаар хөдлөөгүй. Есүс хамаг юмаа хаяад гүйлгүй, Ариун Сүнсний удирдамжийг дагажээ. Ариун Сүнсний удирдамж л хамгийн зөв. Гэтэл тухайн үед Есүс ер санаа тавьсан шинжгүй харагдаж байна.

Олон үйлчлэгч хүмүүст захирагддаг.

Пастор нь яваад өгсөн нэгэн Сүнсээр дүүрэн чуулганы зөвлөлийн гишүүн надад: “Бидэнд шаардлагтай бол өглөө гэрт маань хүрч ирээд уулздаг, хэрэгцээг маань хангадаг пастор л хэрэгтэй” гэж билээ.

Харин надад “*Та Ариун Сүнсээр хөтлүүлдэг бус, дураар тань хөдөлдөг, дагалдан баясагчийг л олно доо*” гэж бодогдож билээ. Тэр цуглаан жил хагасын дотор дөрвөн пастор сольсон гэдэг.

Намайг залуусын пастор болоод зургаан сар болж байтал, нэг залуу уулзаад: “Та миний найз болох уу? Өмнөх пастор, бид хоёр найзууд байсан” гэсэн юм.

Миний өмнөх пастор залуустайгаа дотно нөхөрлөж, үйл ажиллагаан дээр төвлөрч ажилладаг байжээ. Тиймээс тэр залуугийн надаас хүсч байгаа зүйл тодорхой байлаа. Ер нь зөвлөлийн гишүүд пастораасаа үүнийг л хүсдэг.

Би мөнөөх залууд Матай 10:41 дээрх Есүсийн үгийг ишлээд: “Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг хүлээн авах хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна. Зөвт хүнийг зөвт хүний нэрээр хүлээн авах хэн боловч зөвт хүний шагналыг хүлээн авна”

гэж хэлэв.

Тэгээд түүнээс: “Чи олон найзтай биз?” гэж асуулаа.

“Олон.”

“Тэхдээ чи ганц л залуусын пастортай биз дээ?”

“Тийм ээ.”

“Тэгвэл чи найзын шагналыг авмаар байна уу, пасторын шагналыг авмаар байна уу? Учир нь чи намайг хэн гэж хүлээж авна - Бурханаас түүнийгээ л хүлээж авна.”

Тэр миний санааг ойлгов. “Би залуусын пасторын шагналыг авмаар байна.”

Олон үйлчлэгч хүмүүсийн хүслийг биелүүлэхгүй бол, гомдоож, дэмжлэгийг нь алдана гэж айдаг. Тэд хүмүүсийг гомдоохоос айх айдасдаа чөдөрлүүлдэг. Тэд Бурханаар бус, хүмүүсээр удирдуулдаг. Үүнээс нь болоод чуулганд ч, гишүүдийнх нь амьдралд ч мөнхийн үр дүн гардаггүй.

Есүс Иохан баптистыг гомдоов

Иохан баптист хүртэл Есүст гомдох өдөөлттэй тулгарчээ.

Шавь нар нь Иоханд энэ бүхний тухай мэдүүлжээ. Иохан шавь нараасаа хоёрыг нь дуудаж,

—Та ирэх ёстой Нэгэн мөн үү, эсвэл бид өөр нэгнийг хүлээх үү? гэж асуулгахаар Эзэн уруу илгээв. Тэд Есүс дээр ирээд,
—Баптизм хүртээгч Иохан биднийг Тань уруу илгээж “Та ирэх ёстой Нэгэн мөн үү, эсвэл бид өөр нэгнийг хүлээх үү?” гэж асуулгаж байна гэжээ. Лук 7:18-20

Байзаарай. Иохан яагаад Есүсээс “Та нөгөө ирэх ёстой Мессаиа мөн үү?” гэж асуув. Иохан чинь өөрөө Түүний замыг бэлтгэн: “Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хургыг харагтун!” (Иохан 1:29) хэмээн айлчлалыг нь зарлаагүй билүү? Тэрбээр бас: “Би Түүнийг таниагүй. Харин усаар баптизм хүртээлгэхээр намайг илгээсэн Тэр “Хэний дээр Сүнс тагтаа мэт буун ирж тогтохыг чи харна, Тэр бол Сүнсээр баптизм хүртээгч мөн” гэж надад айлдсан юм” (33-аар ишлэл) гэж хэлээ биз дээ? Тэр байтугай “Тэр өсөж, харин би буурах ёстой” (Иохан 3:30) гэж ч хэлсэн. Тухайн үед Есүсийг хэн болохыг мэдэж байсан цорын ганц хүн нь Иохан л байсан. (Симон Петрт хараахан илчлэгдээгүй байв)

Тэгээд яагаад Есүсээс “Та Мессаиа мөн үү эсвэл бид өөр Нэгэнийг хүлээх үү?” гэж асуудаг билээ?

Өөрийгөө Иоханы оронд тавиад үз. Та Бурханы үйл хэргийг төлөөлж байгаа хүн. Та мянга мянган хүний төлөө үйлчилсэн. Та улс даяараа хамгийн далайцтай үйлчлэл хийсэн. Золиос гаргана гэж яадгийг яруу тодоор харуулсан. Дуудлагаа дээд зэргээр биелүүлэхийн тулд гэрлээгүй. Цөлд царцаа, зэрлэг зөгийн балаар хооллож, байнга мацаг барьсан. Фарисайчуудтай үзэлцэж, чөтгөр шүгэлсэн хэмээн яллуулж явсан. Бүх амьдралаа айсуй Мессаиагийн замыг бэлтгэхэд л зориулсан.

Гэтэл одоо та шоронд оржээ. Бүр нилээд удсан. Таны бэлтгэсэн хүмүүс одоо Назарын Есүст л анхаарах болсон тул таныг эргэж тойрох ч хүн цөөхөн. Таны дагалдагч нар ч тэр Хүн рүү яваад өгсөн. Танд ганц, хоёр хүн л үйлчилнэ. Тэд таныг эргэж ирэхдээ, нөгөө Хүн болоод Түүний дагалдагч нар танаас тэс өөрөөр амьдарч байгааг дуулгана. Татвар хураагч, нүгэлтнүүдтэй идэж уудаг л гэнэ. Саббатыг зөрчдөг, мацаг барьдаггүй л гэнэ.

Танд: “Яах аргагүй Түүнд дээр Сүнс тагтаа мэт буусан л юм даа. Мессаиа ийм юм хийнэ гэж үү?” хэмээн бодогдоно.

Хар шоронд хатаж суугаа хүний гомдол зузаарна уу гэхээс хөнгөрөхгүй: “Хамаг амьдралаараа замыг нь бэлтгэсэн Хүн маань намайг нэг ч эргэсэнгүй! Ийм юм байж болох уу? Мессаиа мөн л юм бол, яагаад намайг эндээс гаргахгүй байгаа юм? Би ямар буруутай юм?”

Тэгээд та хамгийн итгэмжтэй хоёр дагалдагчаа Есүс рүү илгээгээд: “Та мөнөөх ирэх ёстой Нэгэн мөн үү эсвэл бид өөр нэгэнийг хүлээх ёстой юу?” гэж асуулгана.

Гэтэл Есүс Иоханд юу гэж хариулсныг үзнэ үү:

Яг тэр үед Есүс олон хүмүүсийг өвчин эмгэгээс нь ангижруулж, бузар сүнснийг нь зайлуулж байлаа. Сохорсон олон хүнд Тэр хараа оруулжээ. Тэр тэдэнд

—Та нар явж, Иоханд юу харж, сонссоноо хэл. Сохор нь хараа орж, доголон нь алхаж, уяман нь цэвэршиж, дүлий нь сонсож, үхэгсэд нь амилж, ядуу нэгэнд нь сайн мэдээ тунхаглагдав. *Надаас болж бүдрээгүй (гомдоогүй) нэг нь ерөөлтэй еэ!* гэв. Лук 7:21-23

Есүсийн хариулт эш үзүүллийн чанартай байв. Есүс Иоханы сайн мэддэг Исаиа номоос эш татжээ. Исаиа 29:18, 35:4-6, 61:1-ээр хэсэг нь Иоханы дагалдагч нарын Есүсийг “байцаахаар” хүлээж байхдаа сахиж байсан бүхнийг өгүүлэв. Тэд Есүсийг Мессаиа болохыг гэрчлэн харсан. Гэхдээ Есүс үгээ үүгээр дуусгаагүй. Тэрбээр “Надаас болж бүдрээгүй (гомдоогүй) нь ерөөлтэй еэ” хэмээн нэмж айлдруун.

Есүс: “Иохан минь, чи өнөөдөр чамд тохиож байгаа юмсыг ч, Миний ихэнх арга замыг ч ойлгохгүй байгааг чинь Би мэднэ. Гэвч чиний санаагаар үйлдээгүйн төлөө Надад бүү гомд” гэжээ. Есүс Иоханыг өнгөрсөн бөгөөд өөрийнх нь амьдрал, үйлчлэл дээрх Бурханы арга замыг хүнийхээ ухаанаар дүгнэхгүй байхыг ятгажээ. Өнөөдөр ч бид мэддэггүйтэй адил, тухайн үед Иохан Бурханы бүрэн зураглал, төлөвлөгөөг мэдээгүй. Гэтэл Есүс түүнийг: “Чи Миний тушаалыг биелүүлсэн. Чиний шагнал аугаа байна. Гагцхүү Надад гомдох урхиас чөлөөлөгд!” хэмээн урамшуулжээ.

ӨРШӨӨЛГҮЙ ГОМДОО

Есүст гомдох шалтгаан Бурханы үйлчлэлд иж бүрэн бэлтгэгдсэн (Иохан шиг) хүнд ч гарч болно. Гэхдээ Есүст үнэхээр хайртай бөгөөд итгэдэг хүн Бурханы зам биднийхээс өндөр гэдгийг ойлгон, гомдолтой тэмцдэг.

Түүнчлэн та Бурханы Сүнснийг дагах үед хүмүүс танд гомдоно. Иохан 3:8 дээр Есүс “Салхи дуртай газраараа үлээдэг. Чи дууг нь сонсовч, салхийг хаанаас ирж, хааш одогийг мэддэггүй. Сүнснээс төрсөн хүн бүр үүнтэй адил байдаг” гэсэн.

Таныг Сүнсээр хөдлөхийг зарим хүн ойлгохгүй. Зүрхэндээ тээсэн үнэнээ хүмүүсийн таагүй хандлагаар бүү бохирло. Хүмүүсийн хүслийн төлөө Сүнсний урсгалыг бүү тасал. Петр үүнийг их товч тодорхой хэлсэн:

Иймээс Христ нэгэнтээ махан биеэрээ зовсон тул та нар ч гэсэн ижил зорилгоор өөрсдийгөө зэвсэглэ. Яагаад гэвэл махан биеэрээ зовсон нэгэн нь нүгэл хийхээ больсон. Энэ нь биеэрээ амьдрах үлдсэн хугацаандаа цаашид хүний хүсэл тачаалын төлөө бус, харин Бурханы хүслийн төлөө

амьдрахын тулд юм. 1Петр 4:1-2

Бурханы хүслийн төлөө амьдарч байгаа хүн хүмүүний хүслийг биелүүлж чадахгүй. Үүнээсээ болж махан биеэр зүдэрнэ. Есүсийг шашны удирдагч нар л хамгаас зовоосон. Шашныхан Бурханыг өөрсдийнх нь дөрвөлж дотор л ажилладаг гэж боддог. Тэд өөрсдийгөө л Бурханы “талынх” гэж боддог. Хоёр мянгаад жилийн тэртээ Эзэн маань Сүнсээр хөтлүүлэхдээ, шашны хүмүүсийг гомдоосон бол, Түүнийг дагадаг хүмүүс ч гомдоох нь лавтай.

Үүний шилдэг жишээ бол элч Паулын хавчлага юм. “Цаад Паул чинь шашны удирдагч нартай нийлээд, аврагдахын тулд хөвч хөндүүлэх ёстой гэх зэргээр загалмайн Сайн мэдээг завхруулж явна” гэсэн худал мэдээ Галатын зарим хүмүүст хүрчээ. Гэтэл Паул асуудлыг газар дээр нь шийдсэн.

“Намайг хар даа. Би шашны удирдагч нараас болоод явсан газар бүрийдээ нүд үзүүрлэгдэж явна. Хэрэв би хөвч хөндүүлэхийг номлосон бол тэд намайг ингэх үү? Загалмай нь авралд хүрэх цорын ганц зам гэдэг үнэн баримтаас болж олон хүн гомддог ч, энэ нь үнэн учраас, би үүнээс өөр юу ч номлохгүй!” (Галат 5:11)

Сайн мэдээний үнэнийг доромжилж байгаа нөхцөлд ямар ч өршөөлгүй гомдоо. Бид ямар ч үнээр хамаагүй, Бурханы Сүнсийг дагаж чадах эсэхээ зүрхэндээ урьдчилан шийдчихсэн байх ёстой. Тийнхүү сонголтоо хэдийнээ хийчихсэн хүн дарамтанд орох үедээ сонголт хийх шаардлагагүй байна.

ЕСҮС ААВЫГАА ДАГАСНЫХАА ТӨЛӨӨ
ЗАРИМ ХҮНИЙГ ГОМДООСОН. ГЭХДЭЭ
ӨӨРИЙНХӨӨ ЭРХ АШГИЙН ТӨЛӨӨ
ХЭЗЭЭ Ч ХЭНИЙГ Ч ГОМДООГООГҮЙ.

Би саяхан Сатаны урхи номыг уншлаа. Тэгээд энэ ном
намайг хэзээ ч чөлөөлөгдөхгүй хэмээн бодож явсан
талбараас маань бүрэн чөлөөлсөн гэдгийг л хэлэх гэсэн
юм. Миний амьдралыг өөрчилсөн ийм хүчтэй ном
бичсэнд тань баярлалаа!

- C. R., TENNESSEE

ТЭДНИЙГ ГОМДООХГҮЙН ТӨЛӨӨ

Иймд цаашид бид бие биеэ шүүхээ больё. Харин ч та нар ах дүүдээ бүдрүүлэх чулуу, эсвэл саад тотгор тавихгүй байя гэж шийдэгтүн.

Ром 14:13

Есүс аялж үйлчлэхдээ, хичнээн олон хүнийг гомдоосныг бид мэдлээ. Бараг л очсон газар бүрийдээ хэн нэгнийг гомдоосон. Тэгвэл энэ бүлгээрээ нөгөө талыг нь ярьмаар байна.

Есүс дагалдагч нараа дагуулаад Капернаумд иржээ. Тэд үйлчлэлийнхээ нэг тойргийг гүйцээчихээд, жаахан амсхийх шаардлагатай байв.

Капернаум тэдний хувьд үйлчлэлийнх нь бааз байж.

Тэнд байтал Петр дээр нэгэн сүмийн татвар хураагч хүрч ирээд: “Танай багш татвар төлдөггүй юм уу?” гэж асуужээ (Матай 17:24).

Петр “төлдөг” гэж хариулчихаад, Есүстэй уулзахаар явж. Есүс татвар хураагчийн хүсэлтийг хүлээж байсан учраас, Симон Петрээс: “Симон оо, газрын хаад хэнээс гаалийн эсвэл

албан татвар авдаг вэ? Хөвгүүдээсээ юү, гадны хүмүүсээс үү?” гэж асуужээ.

“Гадны хүмүүсээс” гэж Петр хариулав.

“Тэгвэл хөвгүүд нь чөлөөлөгдсөн байх нь” (Матай 17:25-26).

“Хөвгүүд нь чөлөөлөгдсөн” гэдэг санааг л Есүс Петрт ойлгуулжээ. Тэд татвар төлөх ёсгүй, харин татвар авдаг, ордонд аж төрдөг хүмүүс. Хөвгүүд хаан ширээнээс зооглож, язгууртны хувцсаар гоёж, үнэ төлбөргүй, эрх дураараа эдэлж хэрэглэнэ.

Татвар хураагч сүмийн татварыг хураадаг. Гэхдээ сүмийн хаан буюу эзэн нь хэн бэ? Хэний төлөө сүмийг барьсан бэ? Хариулт нь: Бурхан Аав. Петр саяхан Есүс бол “амьд Бурханы Хүү Христ” гэдэг илчлэлийг хүлээж авсан.

Үүн дээр нь үндэслэн Есүс Петрээс: “Хэрэв би сүмийн Эзэний Хүү юм бол, сүмийн татварыг төлөхгүй байх ёстой биш үү?” гэж асуув. Мэдээж төлөх ёсгүй. Төлөхгүй байх нь зүйд нийцнэ. Гэтэл Есүс Симон Петрт юу гэж хэлэхийг үзнэ үү:

Гэвч бид *тэднийг гомдоохгүйн тулд* чи тэнгис уруу явж, дэгээ хая. Эхний барьсан загасны амыг нээж үзвэл дөрвөн драхмын нэг зоосыг олно. Түүнийг авч Миний өмнөөс болон өөрийнхөө өмнөөс тэдэнд аваачиж өг гэж айлджээ.

Матай 17:27

Есүс дөнгөж сая эрх чөлөөгөө баталсан. Гэхдээ бусдыг гомдоохгүйн тулд Петрт: “Зүгээр л төлчихье!” гэжээ. Тэрбээр төлөхгүй байх эрхтэй хэдий ч, Симоныг явж загас бариад, барьсан загасныхаа амыг нээвэл, мөнгө олно гэсэн. Бурхан Аав нь татварын мөнгийг нь хүртэл бэлдэж өгчээ.

Есүс бол газар дэлхийн Эзэн. Бурханы хүү. Тэрбээр газар дэлхий дээрх бүх зүйлийг бүтээсэн бөгөөд бүгдийг захирдаг. Тиймээс загасны аманд мөнгө байгааг мэдэж байсан. Есүс Бурханы Хүү учраас, мөнгөний төлөө ажиллах шаардлагагүй. Тийм болов ч, бусдыг гомдоохгүйн тулд Тэрбээр татвараа төлжээ.

Энэ чинь өмнөх бүлэгт баахан амьтныг хайр найргүй гомдоосон тэр Есүс мөн үү? Тэрбээр татвар төлөх шаардлагагүй гэдгээ баталсан атлаа “Тэднийг гомдоохгүйн тулд зүгээр л төлчихье!” гэжээ. Жаахан тогтворгүй ч юм шиг? Эсвэл...? Хариулт нь удаах ишлэл дээр байна.

Тэр үед шавь нар нь Есүс уруу ирж,
—Тэнгэрийн хаанчлалд хэн хамгийн агуу нь байх вэ? гэж асуужээ. Тэр нэгэн хүүхдийг Өөр уруугаа дуудаад, тэдний дунд зогсоож айлдсан нь

— Үнэнээр Би та нарт хэлье. Та нар өөрчлөгдөж, хүүхдүүдтэй адил болохгүй бол, тэнгэрийн хаанчлалд орохгүй. Иймээс хэн өөрийгөө энэ хүүхэд адил даруу болгоно, тэр нь тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь болно. Матай 18:1-4

Түлхүүр ишлэл нь “өөрийгөө даруу болгосон хүн” гэдэг үг болой. Үүнийгээ Есүс дараах үгээрээ дэлгэрүүлжээ:

Та нар тэгж болохгүй. Харин та нарын дунд хэн чинь агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог. Үүнчлэн Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд амиа олны төлөө золиос болгон өгөхөөр ирсэн билээ гэв. Матай 20:26-28

Ер бусын мэдэгдэл байна! Есүс үйлчлүүлэхээр бус, үйлчлэхээр иржээ. Тэр эрх чөлөөтэй. Тэр хэнд ч, ямар ч өргүй. Хэнд ч захирагдахгүй. Гэхдээ Есүс эрх чөлөөгөө үйлчлэлд зориулахаар шийджээ.

ҮЙЛЧЛЭХЭЭР ЧӨЛӨӨЛӨГДСӨН

Шинэ гэрээ Бурханы хүүхдүүд - биднийг Ахыгаа дуурайж, Түүнтэй ижил хандлагатай байхыг ятгадаг.

Ах дүү нар аа, та нар эрх чөлөө уруу дуудагдсан юм. Гэхдээ та нар эрх чөлөөгөө махан биеийн төлөөх таатай боломж болгож бүү ашигла. Харин бие биедээ хайраар үйлчил.
Галат 5:13

Эрх чөлөө нь өөрөөр *завшаан* юм. Амьд Бурханы хүүхдүүд бид эрх чөлөөгөө буюу завшаанаа өөрийнхөө төлөө ашиглаж болохгүй. Эрх чөлөө нь бусдад үйлчлэхийн төлөө өгөгдсөн билээ. Үйлчлэл эрх чөлөө өгдөг, харин боолчлол хүлдэг. Боол нь үйлчлэх *албатай* хүн, харин үйлчлэгч нь үйлчлэхийн төлөө

амьдардаг хүн. Боолын хандлага ба үйлчлэгчийн хандлагын зарим ялгааг үзье:

- Боол ёстой - үйлчлэгч хүсэлтэй.
- Боол хийх ёстойгоо л хийнэ - үйлчлэгч хүчин чадлаа тултал ашиглана.
- Боол нэг бээр явдаг - үйлчлэгч нэмэлт бээр явдаг.
- Боол булаалгадаг - үйлчлэгч өгдөг.
- Боол хүлээстэй - үйлчлэгч эрх чөлөөтэй.
- Боол эрх чөлөөнийхээ төлөө тэмцдэг - үйлчлэгч эрх дархаа хойш тавьдаг.

Дуртай дургүй үйлчилж байгаа итгэгч нарыг би зөндөө харсан. Тэд харамлаж өргөдөг, гоншигнож татвараа төлдөг. Тэд чөлөөлөгдсөн хуулийнхаа боол хэвээрээ л. Зүрхэндээ боол хэвээрээ л.

Хамгийн аюултай нь энэ хуулийг Шинэ гэрээний Бичээсээс гаргаж авчээ. Тэдэнд Есүсийн тушаалаа өгсөн “сүнс” нь байдаггүй. Тэд үйлчлэхийн төлөө чөлөөлөгдсөнөө ухаарсангүй. Тиймээс тэд бусдын тусын тулд бус, өөрийнхөө төлөө тэмцээр.

Ийм хандлагатай хэрхэн тулахыг Паул Ром, Коринтод бичсэн захидалдаа тод харуулсан. Тэр хүмүүсийн эрх чөлөөг идэш уушны асуудлаар хөнджээ. Паул тэднийг “Итгэлээр сул нэгнээ хүлээж ав. Ингэхдээ түүний бодол санааных нь талаар бүү зарга хий. Бүх юмыг идэж болно гэж итгэдэг хүн байдаг. Харин сул нэгэн нь ногоо иддэг” (Ром 14:1-2) хэмээн ухаажуулсан байна.

Есүс амаар орсон нь бус, амаар гарч байгаа нь бузарладгийг тодорхой тайлбарласан. Тэрбээр ингэж мэдэгдэхдээ, итгэгч хүний хувьд бүх хоолыг цэвэр болгожээ (Марк 7:18-19).

Зарим итгэгч нар итгэлээр сул бөгөөд шүтээн өргөсөн идээг идэхээс айсандаа мах идэж чадахгүй байгааг Паул хэлсэн. Есүс энэ талаар хэлсэн боловчиг, тэр хүмүүс сэвтэй сэтгэлээр мах идэж чадахгүй байж.

Иймд шүтээнүүдэд өргөсөн юмсыг идэх талаар гэвэл энэ ертөнцөд шүтээн гэдэг нь байдаггүй бөгөөд ганцаас өөр Бурхан байхгүйг бид мэднэ ... бидний хувьд ганц Бурхан, Эцэг байна. Бүх юм Түүнээс гарсан бөгөөд бид Түүний төлөө юм. Мөн ганц Эзэн Есүс Христ байна. Бүх юм Түүгээр байгаа бөгөөд бид ч Түүгээр байгаа юм. Харин энэ мэдлэг бүх

хүнд байдаггүй ажээ. Зарим хүмүүс өнөөг хүртэл шүтээнд дассан учир шүтээнд өргөсөн тахил гэж бодож идсэнээрээ өөрсдийнхөө мөхөс мөс чанарыг бузарладаг ажээ.

1Коринт 8:4,6-7

Тэдгээр чуулганы хүчтэй итгэгч нар нь сул итгэгч нарынхаа нүдэн дээр мөнөөх сэвтэй махыг нь идчихдэг байжээ. Тэгээд хэдийгээр Есүс бүх хоолыг ариутгасан ч гэлээ, дээрх явдлаас болж асуудал дэгдсэн байна. Итгэл султай нь нөгөө махыг харахаараа, шүтээний идээ будааг санаад салахгүй. Хүчтэй итгэлтэй нь шүтээн юу ч биш гэдгийг мэддэг болохоороо, сэвгүй сэтгэлээр иднэ.

Гэхдээ тэд ахан дүүсээ гомдоочих бий гэхээсээ илүү Шинэ гэрээний итгэгчийн эрхээ л урьтал болгосон байв. Тэд өөрийн мэдэлгүй, сул ахан дүүсийнхээ зам дээр бүдрээх чулуу тавьсан байжээ. Үйлчлэгч хүний зүрх ийм хандлагатай байж болохгүй. Одоо Паул тэдэнд юу гэж хэлснийг үзье:

Иймд цаашид бид бие биеэ шүүхээ больё. Харин ч та нар ах дүүдээ бүдрүүлэх чулуу, эсвэл саад тотгор тавихгүй байя гэж шийдэгтүн ... Учир нь Бурханы хаанчлал бол идэх болон уух явдал нь биш, харин Ариун Сүнс доторх зөвт байдал, амар тайван хийгээд баяр баясгалан нь юм. Ром 14:13,17

Паул “Хаанчлал нь Ариун Сүнс доторх зөвт байдал, амар тайван, баяр хөөр болохыг санацгаая” гэжээ. Энэ бүх эрх нь шинэ итгэгчийг гомдоожээ. Хүчтэй итгэгч нар нь эрх чөлөөгөө үйлчлэх бус, эдлэх “эрхийнхээ” суурь болгожээ. Тэд Шинэ гэрээний эрх чөлөөгөө мэддэг байсан. Гэхдээ хайр үгүй мэдлэг нь устгадаг.

Тэд энэ асуудалд Есүсийн зүрх сэтгэлээр хандаагүй. Есүс амиа хойш тавьж, үйлчлэхийг үлгэрлэн харуулахын тулд сүмийн татварын тал дээр Өөрийнхөө эдлэх эрхийг Петр тэргүүтэй дагалдагч нартаа батлан харуулжээ. Тэрбээр эрх чөлөө эдлэх эрхээ шаардах лиценз болгож, бусдыг гомдоож бүдрээхийг хэзээ ч хүсээгүй.

Христийн үйлчлэх зүрх сэтгэлийг тээгээгүй атлаа Христ дотор эдлэх эрхээ мэддэг хүмүүст Паул ингэж сэрэмжлүүлжээ.

Иймд мөхөс ах дүү чинь чиний мэдлэгээс болж үрэгдэж байна. Түүний төлөө л Христ үхсэн юм шүү. Ийнхүү ах дүүсийнхээ эсрэг нүгэл хийж, тэдний мөхөс мөс чанарыг шархлуулснаараа чи Христийн эсрэг нүгэл хийж байгаа юм. I Коринт 8:11-12

Бид эрх чөлөөгөө нүгэл үйлдэхэд ашигладаг. Яаж? Сул дорой итгэлтэй хүмүүсийг шархлуулж, Христийн бяцхан нэгнийг гомдоож, бүдрээснээрээ.

ЭРХЭЭ ХОЙШ ТАВИХ

Есүс сүмийн татварын тал дээрх эрхээ мэдэгдээд, дараа нь дагалдагч нартаа даруу байдал хамгийн чухал болохыг онцгойлон сургажээ.

Харин хэн Надад итгэгч эдгээр багачуудаас нэгийг нь бүдрүүлнэ, түүний хувьд хүзүүндээ тээрмийн хүнд чулуу зүүгээд тэнгисийн гүнд живсэн нь дээр. Бүдрүүлэх сааднуудынхаа улмаас ертөнц золгүй еэ! Юу гэвэл бүдрүүлэх саад ирэх нь зайлшгүй бөгөөд харин бүдрүүллийг гүйцэлдүүлэгч тэр хүн золгүй еэ! Хэрэв гар чинь, эсвэл хөл чинь чамайг бүдрүүлбэл, тас цавчин хая. Хоёр гартайгаа, эсвэл хоёр хөлтэйгөө мөнхийн галд хаягдсанаас гаргүй, эсвэл хөлгүйгээр аминд орох нь чамд дээр. Хэрэв нүд чинь чамайг бүдрүүлбэл, ухаж хая. Хоёр нүдтэйгээр галт тамд хаягдсанаас нэг нүдтэй аминд орох нь чамд дээр. Та нар эдгээр багачуудын нэгийг нь ч бүү басамжил. Би та нарт хэлье. Тэнгэр дэх тэдний тэнгэр элч нар нь тэнгэрт байгаа Миний Эцэгийн нүүрийг байнга хардаг юм. Матай 18:6-10

Матайн энэ бүлэг бүхлээрээ гомдлын талаар л өгүүлдэг. Шинэ гэрээгээр олгосон завшаан байсан ч хамаагүй, нүгэлд хүргэх бүх зүйлээс салахыг Есүс тодорхой хэлжээ. Сул ахан дүүг чинь нүгэлд хүргэж байгаа юм байвал, огтлоод хая.

Тэгвэл энэ номын өмнөх бүлэг дээр Есүс Өөрөө яах гэж түмэн амьтныг гомдоосон юм бол хэмээн та гайхаж байж мэдэх. Хариулт нь маш энгийн. Есүс Аавынхаа үгэнд орж, бусдын төлөө үйлчилсэндээ л зарим хүнийг гомдоосноос биш, эдлэх

ёстой эрхийнхээ төлөө хэнийг ч гомдоогоогүй.

Саббат өдөр хүнийг эдгээчихлээ гэж Фарисайчууд гомдсон. Аавынхаа үнэнийг номлосны улмаас, дагалдагч нар нь гомдсон. Лазар ахыг нь бушуу ирж эдгээсэнгүй, саатлаа гэж Марта, Мариа хоёр гомдсон. Харин Есүс Өөртөө үйлчлэхийн төлөө хэн нэгнийг гомдоосон талаар та хаанаас ч уншихгүй.

Паул Коринтод бичсэн захидал дээрээ энэ талаар сэрэмжлүүлжээ.

Харин та нарын энэ эрх мөхөс хүмүүст бүдрүүлэх чулуу болох вий гэдэгт санаа тавь. 1Коринт 8:9

Эрх чөлөө нь бидэнд өөрийнхөө амийг хойш тавьж, үйлчлэхийн төлөө өгөгдсөн билээ. Бид нураах бус, барьж босгох ёстой. Мөн өөртөө наагаад байгаарай гэж ч эрх чөлөө бидэнд өгөгдөөгүй. Бид эрх чөлөөг ингэж ашигладаг учраас л, өнөөдөр Христэд итгэдэг хүмүүсийн амьдрал олон хүнийг гомдоодог.

1Коринт 8:9 дээрх сэрэмжлүүлгийг дахин нэг сонсоно уу: “Харин та нарын энэ эрх мөхөс хүмүүст бүдрүүлэх чулуу болох вий гэдэгт санаа тавь.”

Бид энэ тушаалыг хэрхэн зөрчдөг талаар нэгэн жишээ хэлье. Индонез руу хийсэн хоёр дахь аяллаараа би гэргий, хүүхдүүд, хүүхэд асрагчаа дагуулж явсан юм. Тэгээд Балигийн Денпасар ресорт дээр ирэв.

Биднийг урьсан чуулганы ахлах биднийг хотын маш их чимээ хөдөлгөөнтэй дүүрэгт байрладаг, жижигхэн зочид буудалдаа буулгав. Бид холын аялалдаа ядарч, нойр хүрч байлаа. Шөнөжин ноход хуцаж, бид ч сэрвэлзээд унтаж чадалгүй, шөнийг өнгөрөөсөн болсноос биш, амарч чадсангүй.

Маргааш нь Жава руу явж, тэндээ хоёр долоо хоног битүү үйлчлэв. Хоёр долоо хоноход ганц л өдөр чөлөөтэй байсан нь аялалд зориулагдав. Нэг удаа бүр хорин дөрвөн цагийн дотор гучин мянган хүнтэй чуулганд 5 удаагийн цуглаан хийж билээ.

Буцахдаа бид дахин Балигаар дайрах хуваарьтай байв. Пастор биднийг дахиад л мөнөөх ахлагчийн гэрт хононо гэхэд нь тийм ачаалалтай арван дөрвөн хоногийг давсан бид нэг их хөөрцөглөсөнгүй.

Жавагаас Бали руу явдаг өглөөний цайн дээр нэгэн сайхан хатагтай бидэнд Балигийн хамгийн тансаг зочид буудалд

хонох төлбөрийг нь бүрэн төлөх санал тавив. Бид сайхан газар хононгоо, жаахан амрахыг хүссэн учраас, ихэд хөөрцөглөв.

Ачаагаа зэхэхээр ресторанаас гарах үед Лиза тэр хатагтайн саналыг хүлээж авахад тайван бус байгаагаа хэллээ. Орчуулагч бид хоёр Лизаг ятгаж дөнгөв. Гэтэл Жавагаас Бали руу нисэх замдаа тэрбээр дахиад л энэ нэг л зөв санагдахгүй байна гэлээ.

Би түүнийг сонсоогүй нь тун мунхаг явдал болсон юм. Би түүнд чуулган яах ч үгүй дээ, бүх юм сайхан болно гэлээ. Биднийг Балид ирэхэд Лиза надаас дахин нэг удаа гуйсан болов ч, би хайхраагүй юм.

Би пастортай уулахдаа, нэгэн эмэгтэй бидэнд хонох газар санал болгосон тул ахлахын буудалд хонох шаардлагагүй болсноо хэлэв. Тэрбээр барайгаад явчихсан тул би түүнээс учрыг нь асуулаа.

Аз болоход тэрбээр овоо нээлттэй хүн байсандаа “Жон минь, ингэж болохгүй. Цаадуул чинь та нарт зориулаад өрөө хадгалчихсан учраас, хүмүүст сул өрөө байхгүй гээд хэлчихсэн байгаа” гэсэн юм.

Ийнхүү би тэр хүмүүсийн сайхан сэтгэлийг хайхралгүй, нэгэн пасторыг гомдоочихов. Эцэстээ бид нөгөө хатагтайн саналаас татгалзаад, ахлахын буудалд хонож билээ.

Эзэн миний хандлагыг зассан л даа. Би тэр пасторыг гомдоосон. Эрхээ эдлэх хүсэл маань ахан дүүг маань гомдоосон бөгөөд би нүгэл үйлджээ. Би уучлал эрж, тэр ч намайг уучилсан. Би дахиж ёстой тийм сургамж авахыг хүсэхгүй.

ХЯНАН ТОХИОЛДУУЛАХ ШАЛГАЛТ

Элч Паул Ром захидалдаа Бурханы зүрх сэтгэлийг нэг өгүүлбэрээр хэлжээ:

Тиймд амар тайванг тогтоодог болон бие биеэ босгон байгуулдаг зүйлсийн хойноос мөшгөцгөөе. Ром 14:19

Бид хувийнхаа эрхийн төлөө хүнийг бүдрүүлэхгүйг зорих ёстой. Бүр Бичээс зөвшөөрөөд байсан ч тэр. Харин: “Энэ зүйл надад тустай юу, хүнд тустай юу?” гэж асуу.

Бүх юмс зөвшөөрөгддөг, харин бүгд тустай биш. Бүх юмс зөвшөөрөгддөг, харин бүгд босгон байгуулдаггүй. Хэн ч өөрийн ашгийг бүү эр, харин бусдынхыг эрэг ... Иймээс та нар идэж, уухдаа, эсвэл юу ч хийсэн Бурханы алдрын төлөө бүхнийг хий. Иудейчүүдэд ч, грекчүүдэд ч, Бурханы чуулганд ч хэрэг төвөг бүү учруул. Яг надтай адил байгтун. Хүмүүсийг аврагдаасай гэсэндээ би *өөрийн ашгийг бус*, харин олны ашгийг хайн, бүхний дотор бүх хүний таалалд нийцүүлдэг. 1Коринт 10:23-24, 31-33

Ариун Сүнс энэ Бичээсийн хэсгээр амьдралын чинь хэсэг бүрийг дагуулаг. Бусдын бус, өөрийнхөө төлөө байх далд сэдэл, санааг чинь ил болгохыг Ариун Сүнсэнд зөвшөөр. Юу ч гарч ирсэн бай, таныг хүмүүсийн үйлчлэгч болгох сорилыг нь хүлээж ав.

Эрх чөлөөгөө эрхээ баталгаажуулахын төлөө бус, бусдыг чөлөөлөхийн төлөө ашигла. “Үйлчлэл муучлагдах вий хэмээн бид хэнд ч юугаар ч саад тавьдаггүй” (2Коринт 6:3) гэж бичсэн Паул ч өөрөө ийм л зарчмаар амьдарсан билээ.

УУЧИЛЖ ЧАДДАГГҮЙ ХҮН ӨӨРӨӨ БУРХАНЫ ӨМНӨ ТӨЛЖ БАРАШГҮЙ ӨРТЭЙГЭЭ МАРТЖЭЭ.

Сатаны урхи ном манай гэрийн номын санд хэдэн жил хэвтсэн юм. Нэг өдөр аваад уншлаа. Тэгээд миний дотор суурьшаад удаж байгаа сүнсийг шууд танив. Ариун Сүнс намайг энэ номыг уншихад хөтлөснийг би эргэлзээгүй мэдэв. Унших тусам улам л баталгаажлаа. Чуулган дээр манай пастор бусдыг уучлах шаардлагатай хүмүүсийг урагш гарч ирэхийг ятган уриалав. Би бусдыг, ялангуяа аавыгаа уучлахаар шууд л урагш гарлаа. Тэгээд ааваасаа уучлал хүссэн юм. Тэр намайг уучилсанд би баяртай байна! Энэ номыг бичсэнд баярлалаа!

- R. P., VIRGINIA

УУЧЛАЛ: ӨГӨХГҮЙ БОЛ АВАХГҮЙ

Тийм учир Би та нарт хэлье. Та нар юуны төлөө залбирч, гуйж байна, түүнийгээ авсан гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр чинь ёсоор болно. Та нар залбиран зогсохдоо, хэрэв хэн нэгний эсрэг ямар нэгэн юм чамд байгаа бол уучил. Тэгвэл тэнгэр дэх Эцэг чинь мөн та нарын хилэнцийг уучлах болно. [Харин хэрвээ та нар уучлахгүй бол, тэнгэр дэх Эцэг чинь мөн та нарын хилэнцийг уучлахгүй гэв].

Марк 11:24-26

Номынхоо үлдсэн хэсэгт бусдыг уучлахаас татгалзахын үр дагавар дээр, үүнээс хэрхэн чөлөөгдөх дээр анхаарлаа хандуулмаар байна.

Есүс “Хэрэв та нар хүмүүсийн алдааг уучилбал тэнгэрлэг Эцэг тань та нарыг мөн уучилна” гэдэг үгээ хэлэх гэж л хэлсэн билээ. Эдүгээ бид бодолгүйгээр ярьдаг соёлд аж төрж байна. Тиймээс бусдын хэлж ярьж байгаад ч итгэдэггүй. Хүний үгийг нухацтай авч үздэггүй.

Энэ бүхэн нь хүүхэд наснаас л эхэлдэг. Аав, ээж нар хүүхэддээ: “Дахиад ингэбэл бай - бай хийнэ шүү” гэдэг. Харин хүүхэд нь дахиад тэгэхээр барахгүй, хэд хэдэн удаа ч тэгдэг. Тэгэх тоолонд нь аав, ээж нь хүүхдээ нөгөө янзаараа л зандарна. Шийтгэлээ гэхэд, нэг бол хэлснээсээ зөөлөн шийтгэнэ, үгүй бол уурандаа хэт ширүүлнэ.

Аль, аль хариу үйлдэл чинь таныг хэлсэндээ хүрдэггүй эсвэл хэлсэн үг чинь худлаа гэсэн ойлголтыг хүүхдэд өгнө. Эрх мэдэлтний хэлж байгаа үг бүр нь үнэн байх албагүйг хүүхэд мэдэж авна. Тиймээс тэрбээр хэзээд нь эрх мэдэлтний үгд нухацтай хандахдаа эргэлздэг. Энэ хандлага түүний амьдралын тал бүрт тархана. Тэрбээр багш, найз, удирдагч, даргаа яг энэ үзлээр нэвтрүүлж харна. Насанд хүрэх үедээ үүнийг хэвийн л зүйлд тооцдог болсон байна. Одоо тэрбээр зүгээр л сул амлалт, мэдэгдэл хийдэг болжээ.

Би танд жирийн л харилцан ярианы жишээ өгье л дөө. Жижигээ хавьд уулзаагүй Томоо гэдэг танилтайгаа тааралджээ. Тэрбээр яарч явсан болохоороо: “Энэ чинь Томоо юу даа? Би яарч явдаг. Яадаг билээ?” гэж бодно.

Тэд мөргөлдөнө.

Тэгээд Жижигээ: “Ахтай таарсан нь яасан сайн хэрэг вэ! Эзэн алдаршиг” гэнэ.

Тэр хоёр жаал ярилцав. Тэгээд Жижигээ яарч явсан болохоороо: “Хоёулаа нэг сайхан хоолонд орох юм сан” гэж хэлээд сална.

Нэгдүгээрт - яарсан Жижигээ Томоог хараад огт баярлаагүй. Хоёрдугаарт - “Эзэн алдаршиг” гэж хэлэхдээ Жижигээ Эзэний талаар ердөө ч бодоогүй. Гуравдугаарт - Жижигээ Томоотой сайхан ярьж суух ямар ч санаагүй байсан. Тэрбээр Томоогоос бушуухан шиг, аятайхан салах гэсэндээ л ингэж хэлжээ. Тиймээс Жижигээгийн хэлсэн үг бүр нь зүгээр л хоосон үг байв.

Ийм яриа өдөр болгон хаа сайгүй өрнөдөг. Хүмүүс ямар ч санаагүй юмсаа хэлдэг. Тиймээс хүний үгэнд хэзээд нь итгэх, хэзээд нь итгэхгүйг мэдэх гэж зовдог нь аргагүй.

Гэтэл Есүс биднийг Өөрийнх нь үгд нухацтай хандаасай гэж хүсдэг. Бид Түүний үгд бусад эрх мэдэлтний үгд ханддаг шигээ хандаж болохгүй. Тэр бол за гэвэл ёогүй Бурхан. Бид итгэхгүй байсан ч, Тэр итгэмжтэй хэвээрээ. Тэрбээр манай соёл, нийгмээс цойлж гарсан, шулуун шударга, үнэний жишгээр

алхдаг. Тиймээс Есүс: “Хэрэв та нар уучлахгүй бол, тэнгэр дахь Аав тань та нарын гэмийг уучлахгүй” гэдэг үгээ тоглоогүй, жинхэнээсээ хэлсэн юм шүү.

Үүгээр барахгүй, Есүс үүнийг Сайн мэдээнд нэг бус, нилээд олон давтсан нь энэ анхааруулгыг цохон тэмдэглэсэн хэрэг байж.

Учир нь, хэрэв та нар хүмүүсийн алдааг уучилбал тэнгэрлэг Эцэг тань та нарыг мөн уучилна. Харин хэрэв та нар хүмүүсийг уучлахгүй бол Эцэг тань мөн та нарын алдааг уучлахгүй. Матай 6:14-15

Шүүгдэхгүйн тулд бусдыг бүү шүү. Яллагдахгүйн тулд бусдыг бүү ялла. Уучлагтун, тэгвэл та нар ч мөн уучлагдана. Лук 6:37

Бид өртөнгүүдээ уучилсны адил бидний өрийг мөн уучлаач.
Матай 6:12

“Хэдэн итгэгч өөрийг нь гомдоосон хүнийг уучилдаг шигээ Бурханаар уучлуулахыг хүсдэг бол?” хэмээн бодогдох. Гэтэл тэд яг ийм л маягаар уучлагдах ажээ. Чуулган дотор үл уучлал газар авсан учраас, бид Есүсийн үгд нухацтай ханддаггүй. Гэхдээ газар авсан байна уу, үгүй юу хамаагүй, үнэн хэзээ ч өөрчлөгдөхгүй. Бид өрөөлийг уучилж, чөлөөлж, сэргээсэн арга маягаараа л эргээд өөрөө уучлагдана.

Би нэгэн Филиппин үйлчлэгчийн ер бусын гэрчлэлийг сонссон юм. Тэр хүнтэй өмнө хамтран үйлчилж явсан нөхөр маань надад түүний амьдралын талаарх нийтлэлийг үзүүлсэн юм.

Тэр хүн бизнесийн амжилтынхаа улмаас амьдралд нь хандсан Бурханы дуудлагыг олон жил хойш тавьжээ. Мөнгө ч их олж. Эцэстээ тэрбээр дуулгаваргүй байдлынхаа шанг хүртэн, зүрхний дутагдлын улмаас эмнэлэгт хүргэгджээ.

Тэрбээр мэс заслын ширээн дээр амьсгал хураагаад, тэнгэрийн улсын хашааны үүдэнд зогсов. Түүний өмнө Есүс зогсоод, дуулгаваргүй байдалтай нь нүүрэлдүүлэхэд, тэрбээр Эзэнээс дахиад амьдрах боломж өгбөл, Танд үйлчилье гэж гуйжээ. Эзэн ч зөвшөөрч.

Бие рүү нь буцааж илгээхээсээ өмнө Эзэн тэр хүнд тамын

үзэгдлийг үзүүлжээ. Гэтэл хадам ээж нь тамын галд шатаж байх юм гэнэ.

Нөгөө хүн мэл гайхаж. Тэгээд: “Хадам ээж маань “гэмшлийн залбирал” хэлсэн, чуулганд явдаг Христэд итгэгч биз дээ? Тэгээд яахаараа тамд байдаг билээ?” гэж Эзэнээс асуужээ.

Харин Эзэн хадам нь хамаатнаа уучлаагүй учраас, өөрөө ч уучлагдаагүйг хэлжээ.

УУЧЛАЛ БА СҮНСНИЙ ӨСӨЛТ

Лиза, бид хоёр ч бас үйлчлэх хугацаандаа үл уучлалын олон зангыг үзсэн. Би Индонезид анх үйлчлэхдээ, нэгэн чинээлэг бизнесмэний гэрт байрлав. Түүний гэр бүл миний үйлчилсэн чуулганд явдаг ч, аврагдаагүй байв.

Намайг тэнд байх долоо хоногт эхлээд гэргий нь, дараа нь нөхөр нь, эцэст нь гурван хүүхэд нь аврагдаж, чөлөөлөгдөж, гэр бүлийнх нь уур амьсгал орвонгоороо эргэж, үлэмжийн баяр хөөрөөр цалгив.

Тэд намайг гэргийтэйгээ Индонезид дахин ирнэ гэдгийг дуулаад, гэртээ урьсан төдийгүй, гурван хүүхэд, асрагчийн маань онгоцны тасалбарыг ч төлөхийг санал болгов.

Бид тэр чуулганд арван удаа үйлчилж билээ. Би гэмшил, Бурханы оршихуйн талаар номлосон юм. Цуглаан болгон дээр Бурханы оршихуй хальж, энд тэндгүй хүмүүс мэгшиж, уйлж, чөлөөлөгдөв.

Нөгөө гэр бүл ч энэ үйлчлэлийг хүртэв. Нөхрийнх нь ээж тэр хотод аж төрдөг учраас, цуглаан бүрт сууна. Үүнээс гадна тэр хатагтай манай хэдэн хүүхдийн онгоцны тасалбарт ихээхэн мөнгө хандивласан юм.

Долоо хоногийн сүүлээр мөнөөх хатагтай миний нүд рүү цоо ширтсэнээ: “Жон, би яагаад Бурханы оршихуйг хэзээ ч мэдэрдэггүй юм бэ?” гэж асуув.

Бид өглөөний цайгаа ууж дуусгаад байсан болохоор, бусад маань ширээнээс хэдийн босцгоосон байлаа.

“Би таны бүх цуглаанд суусан. Хэлсэн бүхнийг чинь анхааралтай сонссон. Гэмшихээр урагш гарсан. Гэхдээ Бурханы оршихуйг нэг ч мэдрээгүй. Би ер нь Бурханы оршихуйг хэзээ ч мэдэрч байгаагүй” гэж ярив.

Би түүнтэй жаал ярилцаад: “Таныг Бурханы Сүнсээр

дүүрэхийн төлөө залбирья” гэж хэллээ. Тэгээд түүн дээр гар тавиад, Ариун Сүнснийг хүлээж авахын төлөө залбирсан болов ч, ямар ч оршихуй мэдрэгдсэнгүй.

Тэгтэл Эзэн сүнсэнд минь өгүүлэв: “Тэр нөхрийгөө уучлаагүй. Нөхрийгөө уучил гэж түүнд хэл.”

Би түүний дээрээс гараа авлаа. Тэгээд нөхөр нь хэдийн өөд болсныг мэдэж байсан ч, түүн рүү хараад: “Эзэн надад таныг нөхрөө уучлаагүйг харууллаа” гэсэнд хатагтай:

“Тийм ээ, тэр үнэн. Гэхдээ би түүнийг уучлахын төлөө чадах бүхнээ хийсэн” гэж хэллээ.

Тэгээд нөхөр нь түүнийг яаж зовоосон аймшигтай, аймшигтай явдлыг ярьж өгөхөд үед би тэр хатагтайн дотоод зөрчлийг ойлгох шиг болов.

Гэхдээ би түүнд: “Та нөхрөө өөрийнхөө хүчээр уучилж чадахгүй. Асуудлаа Бурханы өмнө аваачаад, эхлээд таныг уучлахыг Бурханаас гуй. Тэгвэл та нөхрөө уучилж чадна. Та нөхрөө тавьж явуулмаар байна уу?” гэж хэллээ.

Хатагтай: “Хүсч байна” гэж хариулав.

Би түүнийг энгийн залбирлаар хөтөлсөн юм: “Тэнгэрийн Аав минь ээ, нөхрөө уучлаагүйн минь төлөө намайг өршөөхийг би Танаас Есүсийн нэрээр гуйж байна. Эзэн минь, би түүнийг өөрийнхөө хүчээр уучилж чадахгүй. Би өмнө бүтэлгүйтсэн. Гэхдээ яг одоо би Таны өмнө нөхрөө зүрхнээсээ уучилж, тавьж явуулж байна.”

Ингэж хэлмэгц хацраар нь нулимс асгав.

“Гараа өргөөд, хэлээр ярь” хэмээн ятгатал, тэрбээр анх удаа маш яруу сайхан тэнгэрийн хэлээр залбирч гарлаа. Хоолны ширээний ард бид хоёр Бурханы маш хүчтэй оршихуйд орон, алмайран биширч байлаа. Түүнийг таван минут гарантай уйлаад тайгарах үед бид хоёр хэсэг ярилцаад, дараа нь би түүнийг Бурханы оршихуйг үргэлжлүүлэн эдлэхийг урамшууллаа. Намайг явахад, хатагтай Эзэнийг хүндэтгэсээр үлдэв.

Энэ тухай хүү, бэр хоёр нь дуулаад, ёстой мэл гайхсан юм. Хүү нь ээжийнхээ уйлахыг хэзээ ч хараагүй ажээ.

Хатагтай өөрөө ч хамгийн сүүлд хэзээ уйлснаа санасангүй. “Нөхөр маань өөд болох үед ч би уйлаагүй” гэж билээ.

Хатагтай тэр оройн цуглаан дээр усан баптим хийлгэсэн юм. Тэгээд гурван өдрийн турш царай нь мишээл, гэрлээр гийв. Өмнө түүнийг инээж байсныг би ер санадаггүй юм. Тэрбээр

уучлаагүй учраас, үл уучлалынхаа хоригдол болсон байжээ. Харин нөхрөө уучилж, тавьж явуулмагцаа Эзэний хүчийг хүлээн авч, оршихуйг нь үзжээ.

ӨСТ ЗАРЦ

Матай 18 дээр Есүс үл уучлал, гомдол хүнийг хэрхэн чөдөрлөдгийг илүү ухварлан тайлжээ. Гомдоогч ахан дүүтэйгээ хэрхэн эвлэрэхийг Есүс дагалдагч нартаа зааж өгсөн байна (Бид эвлэрлийн талаар хожуу ярилцана).

Петр Есүсээс: “Эзэн, ах дүү маань миний эсрэг нүгэл үйлдэхэд би хэдэн удаа түүнийг уучлах вэ? Долоон удаа юу?” (Матай 18:21) гэж асуусан. Петр өөрийгөө нилээд өгөөмөр хандлаа л гэж боджээ.

Петр туйлширдаг хүн. Петр л: “Эзэн, энд байгаа маань бидэнд сайн боллоо. Хэрэв Таныг хүсвэл энд гурван цацар барьж өгье. Нэгийг нь Танд, нэгийг нь Мосед, нэгийг нь Елиад зориулъя” (Матай 17:4-ийг үзнэ үү) гэж хэлж байсан. Тэгвэл одоо Петр өөрийгөө нилээд том загналаа л гэж боджээ. *“Долоонтаа уучлах хүсэл минь Эзэний маань бахыг хангах буй за.”*

Гэтэл Есүсийн хариулт түүнийг цочроосон. Петрийн өгөөмөр хэмээн үзсэн хэмжээг Есүс үлээчихсэн: “Би чамд долоон удаа гэж хэлэхгүй. Харин *дал дахин долоон удаа* гэж хэлье” (Матай 18: 21-22). Өөрөөр хэлбэл Бурхантай адил эцэсгүй уучлах.

Дараа нь Есүс энэ санаагаа сургаалт үлгэрээр тодруулав.

Иймээс тэнгэрийн хаанчлалыг боолуудтайгаа тооцоо хийхийг хүссэн нэгэн хаантай зүйрлэж болно. Тэр тооцоо хийж эхлэх үед арван мянган талантын өртэй нэгийг нь түүн уруу аваачив. Матай 18:23-24

Есүсийн өгүүлсэн хэм хэмжээг төсөөлөхийн тулд эхлээд талант гэж юу болохыг мэдэх хэрэгтэй. Талант нь хэмжүүрийн нэгж байв. Үүгээр алт (2Самуел 12:30), мөнгө (1Хаад 20:39) тэргүүтэй үнэт метал, эд барааг хэмждэг байж. Тэгвэл энэ сургаалт үлгэр дээр өр ширийг төлөөлсөн учраас, алт юмуу мөнгө зэрэг арилжааны нэгжийн талаар ярьсан гэж үзэж болохоор байна. Тухайлбал, алт гэж үзье.

Нэг талант нь ойролцоогоор 75 паундтай (34 кг) тэнцэнэ (2Хаад 5:23). Арван мянган талант нь 750,000 паундтай буюу 375 тоннтой тэнцэнэ. Тэгэхээр тэр зарц хаандаа 375,000 тонн алтны өртэй байжээ.

Орчин цагт нэг унц алт ойролцоогоор 375 доллар гэж бодбол, өнөөгийн зах зээл дээр талант алт нь 450,000 доллар, 10,000 талант алт нь 4.5 тэрбум доллар болох нь байна. Тэгэхээр, зарц хаандаа 4.5 тэрбум долларын өртэй байж!

Гол нь тэр зарц хэзээ ч төлж барагдуулахааргүй, их өртэй байсныг л Есүс цохон тэмдэглэжээ:

Харин түүнд өрөө төлөх юм байхгүй тул эзэн нь түүнийг эхнэр, хүүхдүүдийнх нь хамт хамаг юмтай нь худалдаад өрийг нь барагдуулахыг тушаажээ. Боол нь сөхрөн унаж, сунан мөргөөд түүнээс “Намайг тэвчин хүлцэнэ үү. Би танд бүгдийг буцааж төлнө” гэж гуйхад тэрхүү боолын эзэн нь түүнийг ихэд өрөвдөөд суллаж, өрийг нь хэлтрүүлжээ. Матай 18:25-27

Энэ сургаалт үлгэр гомдолтой ямар хамаатай болохыг авч үзье. Гомдол гарах тоолонд өрийн данс үүсдэг. “Үүнийхээ төлөө төлнө өө” гэдэг үгийг та сонссон байх аа. Тэгвэл уучлал нь өрийг хүчингүй болгодог.

Зарцынхаа хэзээ ч төлж барагдуулахгүй, их өрийг цуцалсан хаан нь бидний Бурхан Аав болой. Колоссай 2:13-14 дээр “Та нар гэм нүглүүд болон махан биеийн хөвч хөндөх ёслолоосоо болж үхсэн байхад Тэр бидний бүх гэм нүглийг уучлаад, та нарыг Түүнтэй хамт амьд болгосон бөгөөд бидний эсрэг зарлигуудаас бүрдсэн, бидэнд дайсагнаж байсан өрийн дансыг (үүнтэй хамт *өрийн сертификатыг*) хүчингүй болгов. Тэр үүнийг загалмайд хадаж, замаасаа зайлуулжээ”¹ гэдэг.

Бидний уучлуулсан өр төлж барашгүй их өр байжээ. Бид Бурханы өмнөх өрөө хэзээ ч төлж барахгүй байв. Бидний зөрчил дуусахгүй байж. Гиймээс л Бурхан бидэнд авралыг бэлэглэсэн. Есүс бидний өрийн сертификатыг төлж, хаасан. Зарц, хаан хоёрын харилцаа Бурхан - бидний харилцаатай зэрэгцээ ажээ.

Харин өнөөх боол гаагш гараад, өөрт нь зуун денарын өртэй байсан өөрийнхөө анд нөхөр болох нэгэн боолыг олж хараад,

барьж боомилоод “Өрөө төл!” гэв. Матай 18:28

Денар нь ажилчин хүний нэг өдрийн цалин болно.2 Өнөөгийн ханшаар - зуун денар нь ойролцоогоор 100 доллар болох байх. Цааш уншъя:

Харин найз боол нь сөгдөн, түүнээс “Намайг тэвчин хүлцээч. Чамд буцааж төлнө” гэжээ. Мөнөөх нь үүнийг хүсээгүй учраас явж, найзыгаа өрөө буцааж төлөх хүртэл нь шоронд хориулав. Матай 18:29-30

Өршөөгдсөн боолд өөр нэгэн боол нь жилийн цалингийн гуравны нэгтэй тэнцэх хэмжээтэй өртэй байжээ. Цалингийнхаа гуравны нэгийг алдах ямар байх уу? Гэхдээ энэ хүн өөрөө 4.5 тэрбум долларын өрөө уучлуулсныг санаж байна уу?

Хүмүүсийн бие биедээ гомдох гомдлыг Бурханы өмнөх бидний зөрчилтэй харьцуулах нь яг л 4,000 долларыг 4,5 тэрбум доллартай харьцуулахтай ижил юм. Хүн танд хүншгүй хандсан байж болох ч, энэ нь Бурханы өмнө таны гаргасан зөрчлийн дэргэд даанч өчүүхэн хэрэг юм.

Тан шиг зовсон хүн байхгүй мэт санагдаж байж болох. Гэхдээ Есүс яаж зовсныг ухаарахгүй байна уу? Тэрбээр гэмгүй, ялгүй хурга байгаад алуулсан.

Уучилдаггүй хүн ямар их өрөө уучлуулснаа мартжээ. Есүс таныг мөнхийн үхэл, тамлалаас чөлөөлснийг ухаарбал, өрөөлийг үг дуугүй уучилна (Хэрхэн уучлахыг 13-аар бүлэгт үзнэ).

Мөнхийн галт нуур шиг аймшиг үгүй. Тэнд чөлөөгүй байхгүй, өт хорхой нь үхэхгүй, гал нь унтрахгүй. Бурхан таныг Хүү Есүс Христийнхээ үхлээр өршөөхөөс өмнө бид ийм л газарт очих тавилантай байж. Халлелүяа! Уучлах хэцүү байвал, там бодитой гэдгийг, таныг тамаас аварсан Бурханы хайрыг сана.

ИТГЭГЧ НАРТ ХАНДСАН СУРГАМЖ

Сургаалт үлгэрээ үргэлжлүүлье:

Түүний бусад найз боолууд нь болсон явдлыг хараад ихэд

гуныж, эзэн дээрээ очоод болсон бүгдийг мэдэгджээ. Тэгтэл эзэн нь нөгөө боолыг дуудаад: “Бузар муу боол чи, надаас гуйсан тул би бүх өрөөс чинь хэлтрүүлсэн. Би чамайг өршөөсний адил чи ч бас өнд нөхөр болох тэр боолыг өршөөх ёстой байсан бус уу?” хэмээгээд. Матай 18:31-33

Есүс энэхүү сургаалт үлгэрээрээ үл итгэгч хүмүүсийн тухай яриагүй, хааны зарц нарын тухай ярьсан. Тэр боол хэдийнээ их өрөө уучлуулж (аврагдаж), эзнийхээ “зарц” хэмээн дуудуулж байв. Түүний уучлаагүй хүн нь мөн л түүний нэгэн адил “зарц” байжээ. Тэгэхээр, энэ нь уучлахаас татгалзсан итгэгч хүний хувь тавилан гэж ойлгож болно.

... өрөө бүгдийг нь буцааж төлөх хүртэл нь зандалчинд тушаажээ. Та нарын хэн ч ах дүүгээ зүрх сэтгэлээсээ уучлахгүй бол Миний тэнгэрлэг Аав ч та нарт мөн тэгж хандана гэлээ. Матай 18:34-35

Эдгээр ишлэл нь 3 зарчмыг зааж байна.

1. Үл уучлагч боол зандалчны гарт очсон.
2. Тэрбээр анхны өрөө төлөх ёстой болсон: 375 тонн алтыг.
3. Ахан дүүсийнхээ алдааг уучлаагүй хүнд Бурхан Аав адил хандана.

1. Үл уучлагч боол зандалчны гарт очсон.

Вебстерийн толь бичиг тамлалыг “биеийн юмуу оюун санааны зовлон тарчлаан” болоод “шийтгэх, хүчлэх эсвэл садистик таашаалаа хангахын төлөө хүндээр, хурцаар өвтгөх”-ээ хэмээн тайлбарлажээ.

Энэ тамлалыг чөтгөрийн сүнснүүд гүйцэтгэдэг. Хэрэв хүн бусдыг уучлахгүй бол, тэрбээр итгэгч байсан ч хамаагүй, Бурхан түүний бие, ухаан санааг зовоож тарчлаах зөвшөөрлийг “зандалчдад” олгодог. Зарим хүн хичнээн залбирсан ч ерөөсөө эдгэрч, тайвширч, чөлөөлөгддөггүй. Учир нь тэд бусдыг зүрхнээсээ уучилдаггүй, тавьж явуулдаггүй.

Эмч, эрдэмтэд үл уучлал, хорслыг артрит, хорт хавдар зэрэг тодорхой өвчинтэй холбож үздэг. Мөн сэтгэцийн өвчин ч бас хорсол, үл уучлалтай уялдах нь олонтаа.

Хүн голдуу бусдыг уучлахаас татгалздаг боловч, заримдаа өөрийгөө уучлахаас татгалзах нь ч бий. Есүс “...чиний эсрэг ямар нэг юм ах дүүд чинь (хэн нэгэнд) байвал...” гэсэн (Матай 5:23). Хэн нэгний тоонд та ч багтана! Бурхан таныг уучлаад байхад, та Бурханы уучилсан хүнийг уучлахгүй юу?

2. Үл уучлагч боол анхны өрөө төлөх ёстой болсон.

Тэрбээр боломжгүй зүйлийг үйлдэх шаардлагатай болжээ. Өөрөөр хэлбэл, Есүсийн Голгот дээр төлсөн өрийг төлөх шаардлагатай болсонтой л адил. Бид авралаа алдана.

“Байзаарай, гэмшлийн залбирал хэлж, Есүст амьдралаа өргөсөн хүн авралаа хэзээ ч алдахгүй гэж бодсон юмсан” гэж үү?

Та тэгж итгэдэг юм бол, Петр яагаад ингэж хэлснийг тайлбарлана уу?

Хэрэв тэд ертөнцийн бузар бусармагаас Эзэн ба Аврагч Есүс Христийн мэдлэгээр ангижирсныхаа дараа тэдгээрээр дахин урхидуулан дийлдвэл тэдний хувьд сүүлчийн байдал нь эхнийхээсээ бүр дордох болно. Учир нь зөвт байдлын замыг мэдээд, өөрсдөд нь өгөгдсөн ариун тушаалуудаас нүүр буруулан эргэснээс *энэ замыг мэдээгүй байсан нь тэдэнд дээр байх байсан.* 2Петр 2:20-21

Петр Есүс Христ доторх авралаар нүглээс (дэлхийн бохирдлоос) аврагдсан хүмүүсийн тухай ярьжээ. Гэтэл тэд дахин нүгэлдээ орооцолдож (энэ нь үл уучлал байж болох), үүндээ дийлджээ. Дийлдсэн гэдэг нь тэд Эзэн дээр эргэж очоод, санаатай үйлдсэн нүглээ гэмшээгүй гэсэн үг. Зөвт байдлаас нүүр буруулах нь зөвт байдлыг огт мэдэхгүй байхаас дор гэдгийг Петр хэлжээ. Өөрөөр хэлбэл, Бурхан мөнх амийн бэлгийг хүлээж авчихаад, дараа нь үүнээсээ бүр мөсөн урваж байснаас хэзээ ч аврагдаагүй байх нь дээр гэжээ.

Иуда ч бас чуулган доторх “хоёр дахь удаагаа үхсэн” хүмүүсийн талаар ярьсан (Иуда 12-13). Хоёр дахь удаагаа үхнэ гэдэг нь та нэгэнтээ Христ үгүй үхмэл байгаад, Түүнд итгэн амьд болчихоод, дараа нь Түүний замаас нэг мөр салснаараа, дахиж үхсэн гэсэн утгатай.

Олон хүн Есүс дээр ирээд, биеэ зөвтгөн ингэж хэлнэ: “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгуудыг үзүүлж байсан биш билүү?” Тэгэхэд нь Есүс тэдэнд “Би та нарыг огт танихгүй юм байна. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ (Матай 7:22-23). Тэд Есүсийг мэддэг байсан. Тэд Есүсийг Эзэн хэмээн дуудаж, Түүний нэрээр гайхамшиг үйлдсэн. Гэтэл Есүс тэднийг таниагүй.

Есүс хэнийг таних вэ? Элч Паул: “Харин хэрэв хүн Бурханд хайртай бол, тэр хүн Түүгээр танигдсан байна” (1Коринт 8:3) гэжээ. Бурхан Өөрт нь хайртай хүмүүсийг танина.

Та: “Би Бурханд хайртай. Зүгээр намайг гомдоосон энэ ахдаа/дүүдээ л хайргүй” гэж хэлж болох. Тэгвэл “Хэрэв хэн нэгэн нь “Би Бурханыг хайрладаг” гэж хэлчихээд, ах дүүгээ үзэн яддаг бол, тэр хүн худалч. Учир нь харж байгаа ах, дүүгээ хайрладаггүй нэгэн, хараагүй Бурханыг хайрлаж чадахгүй” (1Июхан 4:20) гэж бичигдсэн байдаг тул, та Бурханд хайргүй бөгөөд өөрийгөө л мэхэлж байна. Мэхлэгдсэн хүн нь өөрийгөө зөв гэдэгт үнэн голоосоо итгэдэг учраас, мэхлэл аймшигтай зүйл. Үгийг дагахаас татгалзагч нь зүрхээ хуурдаг.

Тэнгэрт орно гэж найдсан “олон хүн” татгалзсан хариу дуулина бас сүүлчийн өдрүүдэд олон хүн гомдоно (Матай 24:10) гэж Есүс хэлсэн нь сонирхолтой биш үү? Энэ хоёр бүлэгт нэг ижил хүмүүс багтах юм биш байгаа?

Зарим итгэгч хүн үл уучлалдаа тарчилсандаа, үхээд өгбөл, амарна гэж найддаг байх. Гэхдээ энэ худлаа юм. Бид үл уучлалыг яг одоо шийдэхгүй л бол, төлж барашгүй өрөө төлөх ёстой болж мэднэ.

3. Хичнээн гүн шархалсан байсан ч хамаагүй, бусдыг зүрхнээсээ уучлахыг хүсээгүй хэнд ч Бурхан адил хандана.

Есүс энэ сургаалыг бидний орой руу оруулахыг хүсчээ. Дагалдагч нар нь асуухаас нааш Есүс бараг нэг ч сургаалт үлгэрээ тайлбарладаггүй байсан. Гэтэл энэ удаа Тэрбээр ул уучлагч хүмүүс дээр ямар харгис, хатуу шийтгэл буух талаар асуулт ч хүлээлгүй хэлж өгсөн юм.

Түүнчлэн уучлахгүй бол, уучлагдахгүй гэдгийг Есүс өөр

олон удаа хэлсэн. Тэр бидэнтэй адилгүй гэдгийг бүү мартаарай. Тэр хэлсэн л бол хийнэ.

Гэтэл чуулганд ингэдэггүй. Чуулган дотор үл уучлалыг элдвээр хөхүүлэн дэмждэг. Үл уучлалыг гомосекс, завхайрал, хулгай, согтуурал гэх мэт нүглээс хөнгөлж тооцдог. Гэхдээ үл уучилдаг хүмүүс ялгаагүй л бусад нүгэлтнүүдтэй адил хаанчлалыг өвлөхгүй.

Зарим нь үүнийг аймаар хүнд үг байна гэж магадгүй. Гэхдээ би үүнийг аймшигтай шүүхийн бус, нигүүлслийн болоод сэрэмжлүүлгийн үг гэж хардаг. Та одоо Ариун Сүнсний үгэнд орж, жинхэнээсээ гэмшин уучлагдмаар байна уу? Эсвэл хожим гэмшээд ч нэмэргүй болсон үед эс уучлагдан, Эзэнээс: “Зайл” гэдэг үг сонсмоор байна уу?

БУСДАД ДАХИН АШИГЛУУЛАХ ЭРСДЭЛД ОРОХ БАЙСАН Ч БУСДААС ӨС ХОНЗОН АВАХ НЬ ТАНААС ХОЛ БАЙГ.

Сатаны урхи номд дуулгавартай байдлын талаар бичсэн нь гайхалтай. Энэ бол хэдхэн өдрийн дотор уншиж дуусгах хугацаанд Эзэний Сүнс надтай “ажилласан” үнэхээр тосолгоотой ном. Энэ ном миний амьдралыг орвонгоор нь эргүүлсэн юм. Би гомдлын гинжнээс суллагдсан бөгөөд зүрх, бодол, сэтгэл хөдлөлөө чөлөөтэй байлгахын төлөө одоо ч үргэлжлүүлэн ажилласаар байна.

- L. M., SOUTH CAROLINA

ӨШӨӨ АВАХ: ЭНЭ БОЛ УРХИ

*Хэнд ч хэзээ ч бузар мууг бузар муугаар бүү хариул.
Бүх хүний өмнө юу нь зөв болохыг л
харгалзан үзэж бай.*

Ром 12:17

Үл уучлах нь яг хэн нэгний эсрэг өр тооцохтой адил гэдгийг бид өмнөх бүлгээр сурлаа. Хүнд гомдсон хүн нөгөө хүнээ өөрт нь өртэй боллоо гэж үздэг. Тэрбээр аль нэг хэлбэрийн төлбөр шаардаад унадаг.

Манай шүүхийн систем хохирогчийн өшөөг авахын төлөө оршдог. Хүмүүс өрөө олж авахын төлөө шүүхэд ханддаг. Хүн хэн нэгнээс болж хохирсон нөхцөлд хүний шүүх “Тэд хийсэн хэргийнхээ төлөө хуулийн өмнө ирж, буруутай нөхцөлд ялаа эдэлнэ” гэдэг. Үл уучлагч зарц нөгөө боолоосоо өрөө төлөхийг шаардсандаа, гомдлоо нэхэмжилж, шүүхэд ханджээ. Гэхдээ энэ нь зөвт байдлын арга зам биш юм.

Хайртууд минь, хэзээ ч өөрийн өшөө хонзонг бүү ав. Харин Бурханы уур хилэнд зай гарга. Учир нь «“Өшөө авалт нь Минийх, Би буцааж төлнө” гэж Эзэн айлдав» гэж бичигджээ.
Ром 12:19

Бурханы хүүхдүүд бидний хувьд өөрсдөө өшөө авах гэж оролдох нь буруу. Гэхдээ уучлахаас татгалзах нь яг ингэхтэй адил юм. Бид хүсч, хайж, төлөвлөсөөр өшөөгөө авдаг. Бид өрөө бүрэн төлүүлэхээс нааш уучлахгүй бөгөөд нөхөн олговор авах эсэхээ өөрөө л шийднэ. Бидэнд учруулсан бурууг засах гэж оролдсоноороо, бид өөрийгөө шүүгч болгодог. Гэтэл бид үүнийг мэднэ:

Хууль Тогтоогч ба Шүүгч нь зөвхөн ганц байдаг бөгөөд Тэр нь аварч, устгаж ч чадна. Харин хөршөө шүүгч та хэн юм бэ? ... Ах дүү нар аа, та нар өөрсдөө шүүгдчихгүйн тулд бие биеийнхээ эсрэг бүү гомдолло. Харагтун, шүүгч хаалган дээр зогсож байна. Иаков 4:12; 5:9

Бурхан бол Шүүгч. Тэр шударгаар шүүнэ. Мөн зөвийн дагуу ч шагнана. Бурууг үйлдсэн хүн үнэн голоосоо гэмшбэл, түүний өр Есүсийн Голгот дээрх үйлсээр цагаадна.

Та: “Гэхдээ тэр хүн Есүсийг биш, намайг хохироосон!” гэж хэлж болно.

Тийм ээ, гэхдээ та Есүст учруулсан хохирлоо мэдэх үү? Тэр ямар ч гэм зэмгүй атлаа нүгэлт хүн бүрийн нүглийг үүрч, цаазлуулсан. Хүн бүр Бурханы газрын хуулиас өндөр хуулийг зөрчсөн. Шударгаар шүүх юм бол, бид бүгдээрээ ертөнцийн дээд шүүхийн мутраар цаазын ял авах ёстой.

Таныг яагаа ч үгүй байхад, хорлож хохироосон байж болно. Гэхдээ та үзсэн хохирлоо хүлээж авсан уучлалтайгаа харьцуулбал, газар тэнгэр шиг ялгаа гарна. Үзсэн хор хохирол чинь таны өрөөс дуслыг ч барагдуулахгүй! Гомдолтой байгаа бол, та ямар нигүүлсэлд багтсанаа умартжээ.

ӨШ ХОНЗОНД СААРАЛ ТАЛБАР ГЭЖ БАЙХГҮЙ

Хуучин гэрээнд, та намайг хохироох аваас, би эргээд таныг хохироох эрхтэй байж. Өр нэхэж, мууг муугаар хариулахыг зөвшөөрдөг байв (Леви 24:19; Гэтлэл 21:23-25-ыг үзнэ үү). Тэр үед хууль хамгийн хүчтэй байж. Есүс ч чөлөөлөхөөр хараахан үхээгүй байв.

Тэгвэл Шинэ гэрээний итгэгч нарт Есүс хэрхэн тушаав?

«Нүдийг нүдээр, шүдийг шүдээр» гэснийг та нар дуулсан. Харин Би та нарт хэлье, хар санаатай хүнийг бүү эсэргүүц. Харин хэн баруун хацрыг чинь алгадна, түүнд нөгөө хацраа бас тавьж өг. Хэрэв хэн нэг хүн чамтай заалдаж, цамцыг чинь авахыг хүсвэл дээлээ бас түүнд өг. Хэн нэг хүн чамайг нэг бээр газар явахыг хүчилбэл түүнтэй хамт хоёр бээр яв. Чамаас гуйсан хүнд өг, чамаас зээлэхийг хүссэн хүнээс бүү зайлсхий. Матай 5:38-42

Есүс өшөө хорслоо тайлах саарал талыг устгажээ. Үнэндээ бүр эргээд өөрөө бай болохгүйн тулд өөрийн биеэр өшөө авахаас хол явах ёстой гэжээ.

Өөрийн биеэр өшөө авах гэж оролдсон хүн өөрийгөө шүүгчээр томилдог. Матай 18 дээрх үл уучлагч боол найзыгаа шоронд хийхдээ ийм зүйл хийжээ. Гэвч эргээд өөрөө өрөө төлж дуусгатлаа зандалчны гарт очиж, гэр бүл нь зарагдсан юм.

Бид жинхэнэ Шүүгчид байр суурийг нь тавьж өгөх ёстой. Тэр шударгаар шагнана. Тэр л шударгаар өшөө авна.

Намайг Флоридагийн Тампагийн нэгэн чуулганд гомдлын талаар номлосны дараа нэг эмэгтэй надтай уулзаад, хуучин нөхрийнхөө хийсэн болгоныг уучилсан тухайгаа ярьсан юм. Гэхдээ тэрбээр намайг сонсож байхдаа, дотроо ямар ч амар тайвангүй, түгшүүртэй байгаа нь харагдав.

Би түүнд зөөлнөөр: “Та нөхрийгөө уучлаагүй байна” гэж хэллээ.

“Үгүй ээ, би уучилсан. Би уйлан байж уучилсан.”

“Та уйлсан байж болно. Гэхдээ түүнийг тавьж явуулаагүй байна.”

Гэсэн ч хатагтай намайг буруу ярьж байна, нөхрөө уучилсан хэмээн зөрсөөр байлаа:

“Би түүнээс юу ч хүсэхгүй. Би түүнийг тавьж явуулсан.”

“Нөхөр чинь яасныг яриач” хэмээн би асуулаа.

“Нөхөр, бид хоёр нэг чуулганд пастораар үйлчилдэг байлаа.

Гэтэл нөхөр маань чуулганы нэгэн хүүхэнтэй нөхцөөд, намайг гурван хүүтэй минь хаяад явчихсан.” Эмэгтэй мэлмэрээд л явчихав. “Нөхөр маань Бурхан түүнийг гэр хүүхэнтэй суулгахыг хүсч байтал, тэрбээр надтай сууснаараа Бурханы хүслээс гажсан

байж гэсэн. Тэр хүүхэн түүний үйлчлэлийг дэмждэг, харин би чангаадаг гэсэн. Намайг шүүмжлэгч гэсэн. Тэгээд салалтдаа намайг буруутгачихаад, яваад өгсөн. Тэр хэзээ ч ирж буруугаа хүлээгээгүй.”

Тэр нөхөр яриангүй өөрөө ч мэхлэгдэж, гэргий, үр хүүхдээ ч асар их гомдоожээ. Түүний овлигогүй үйлдлээс болж, гэргий нь үлэмж хохирсон бөгөөд нөхрийгөө эргэж ирээд, өрөө төлөхийг хүлээж байжээ. Тэр өр нь нөхөн олговор юмуу хүүхдийн тэтгэмж биш байв. Учир нь нөхөр нь үүнийгээ төлдөг байв. Эхнэрийнх нь төлүүлэхийг хүссэн өр нь нөхөр нь буруугаа хүлээгээд, гэргийнхээ зөв байсныг хүлээн зөвшөөрөх явдал байв.

“Та нөхрөө хүрч ирээд, таны биш, тэдний буруу байсныг хүлээгээд, уучлал эрэхээс нааш уучлахгүй юм байна. Энэ төлөгдөөгүй өр таныг чөдөрлөжээ” гэж би хэллээ.

Хэрэв Есүс биднийг Түүн дээр ирээд: “Таны зөв, бидний буруу байж. Биднийг өршөөгөөч” хэмээн өршөөл эртэл хүлээсэн бол, загалмай дээрээс биднийг *уучлахгүй* байсан. Есүс загалмай дээр өлгөөстэй байхдаа: “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна” (Лук 23:34) хэмээн хашхирсан. Есүс биднийг нүглээ хүлээн, хүрч очихоос өмнө уучилсан. Элч Паул бидэнд: “Ингэхдээ нэг нэгнээ хүлцэж, бие биеэ уучилж, хэрэв хэн нэгэнд чинь нөгөөгийнхөө эсрэг гомдол байвал та нарыг Эзэн уучилсны адил та нар бас уучил” (Колоссай 3:13). “Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биеэ уучлан, нэг нэгнээ энэрэн уян зөөлөн сэтгэлээр ханд” (Ефес 4:32) хэмээн анхааруулсан билээ.

Би мөнөөх эмэгтэйд: “Та нөхрөө хүрч ирээд миний буруу, чиний зөв байж гэж хэлэхээс нааш уучлахгүй” гэж хэлтэл, хоёр хацраар нь нулимс бөмбөрөв. Хүсээд байгаа зүйл нь нөхрийнх нь түүнд болоод хүүхдүүддээ учруулсан шархны дэргэд өчүүхэн зүйл гэлтэй. Гэхдээ тэрбээр “хүний шүүхээр” чөдөрлүүлжээ. Эмэгтэй өөрийгөө шүүгчээр томилоод, өр нэхэх эрхээ мэдэгдэж байв. Энэ гомдол нь түүний шинэ нөхөртэйгээ тогтоох харилцаанд нь ч саад болжээ. Түүнчлэн хуучин нөхөр нь пастор байсан учраас, эмэгтэй эдүгээ бусад эрэгтэй эрх мэдэлтэнтэй ч харилцаж чадахаа болжээ.

Есүс бидний зүрхний нөхцлийг хөрстэй жиших нь олонтаа. Бидэнд Бурханы хайранд газардаж, үндэслэхийг анхааруулсан. Тэр цагт Бурханы Үгийн үр зүрхэнд маань үндэслэн ургасаар, эцэстээ

зөвт байдлын үр жимс ургуулна. Энэ үр жимс нь хайр, баяр хөөр, амар тайван, тэвчээр, эелдэг, сайн сайхан, итгэмжтэй, зөөлөн, биеэ хянан захирах чанар болой (Галат 5:22-23-ыг үзнэ үү).

Гэхдээ юу тарина - хөрс түүнийг л ургуулна. Өр, үл уучлал, гомдол тарьбал, Бурханы хайрын оронд тэс өөр үндэс ургана. Үүнийг хорслын үндэс гэнэ.

Францис Франжипани хорслыг яг онож тодорхойлсон байдаг: “Хорсол нь гүйцэлдүүлээгүй өс хонзон юм.”¹ Бид өс хонзонгоо ханатлаа аваагүй цагтаа хорссоор байна.”

Еврей номын бичээч энэ сэдвийг шууд хэлдэг:

Бүх хүнтэй эвтэй бахыг болон ариусгалыг мөшгөгтүн. үүнгүйгээр хэн ч Эзэнийг үзэхгүй. Хэн чинь Бурханы нигүүлсэлээс салахгүйн тулд болон ямар ч *хорслын үндэс* урган хор учруулан, түүгээр *олон хүн бузарлагдахгүйн* тулд сэрэмжил. Еврей 12:14-15

“Олон хүн бузарлагдах” гэдэг үгийг тэмдэглэнэ үү. Энэ олон хүн нь Есүсийн ярьсан, мөнөөх сүүлийн өдрүүдэд гомдох хүмүүс биш үү? (Матай 24:10-ыг үзнэ үү)

Хорсол нь үндэс юм. Үндсийг усалж, хамгаалж, тэжээж, анхаарч, арчилж тордбол, улам л гүнзгийрч, улам л бүдүүрнэ. Даруй шийдэхгүй бол, таслах хэцүү болно. Гомдлын хүч ургасаар байна. Тиймээс л “Уурласан ч нүгэл бүү үйлд. Та нарын уур хилэн дээр нар бүү жаргаг” (Ефес 4:26-г үзнэ үү) гэдэг. Тэгээд зөвт байдлын үр жимсийн оронд уур, эсэргүүцэл, атаархал, үзэн ядал, хэрүүл, хагарал үүснэ (Матай 7:19-20-ийг үзнэ үү).

Гомдлоо тайлж, амар тайвныг эрэлхийлдэггүй хүн эцэстээ бузартахыг Библи хэлдэг. Ийм замаар сайхан хүн үл уучлалын хороор завхардаг.

ИРЭЭДҮЙН ХАНХҮҮ СҮЙРСЭН НЬ

Саул Давидаас урвасан ч, Давид Саул хаанд үнэнч хэвээрээ үлдсэнийг бид номынхоо эхээр үзсэн. Хоёрын хоёр боломж олдсон ч, Давид өөрөө өшөө авахыг эрэлхийлээгүй. Давид Бурханы зүрхийг дагадаг хүн байв. Саул, тэр хоёрын асуудлыг

Давид Бурханд даатгажээ. Бурхан Саулыг шүүх үед ч Давид баясаагүй. Тэрбээр Саулд хорсоогүй учраас, түүний үхэлд гашуудсан юм.

Саулын дараа Давид хаан болжээ. Тэрбээр улсаа хүчирхэгжүүлж, цэргээ бэхжүүлж, эдийн засгаа хөгжүүлж, хаан ширээгээ батжуулав. Олон хатад, үр хүүхэдтэй болсны ууган нь Амнон, гуравдугаарх нь Абсалом байлаа.

Гэтэл Амнон эцэг нэгтэй охин дүү Тамарт цээртэй хэрэг үйлджээ. Тамар нь Абсаломын төрсөн дүү байв. Амнон өвдсөн дүр эсгэн, ааваасаа Тамарыг илгээж зоог бариулахыг хүсчээ. Тамар хүсэлтийг нь биелүүлтэл, Амнон зарц нараа гаргаж байгаад Тамарыг хүчиндэв. Гэвч дараа нь Тамарт гутаж, нүднээсээ зайлуулжээ. Амнон хааны онгон гүнжийг бузарлаж, амьдралыг нь шившиглэв (2Самуел 13-ыг үзнэ үү).

Абсалом Амнонд юу ч хэлэлгүй, охин дүүгээ гэртээ авчраад асрав. Гэхдээ Абсалом Амноныг Тамарыг бузарласанд нь үзэн ядаж байлаа.

Аав нь Амноныг шийтгэнэ хэмээн Абсалом найдав. Давид хаан Амноны хийсэн хэргийг дуулаад хилэгнэсэн боловч, арга хэмжээ авсангүй. Аавынх нь шударга ёсыг гүйцэлдүүлээгүй явдал Абсаломд хүндээр тусав.

Хааны эрх танхи, онгон гүнж явсан Тамар эдүгээ нүүр хийх газаргүй болжээ. Тэрбээр түмний хайр харцыг булаасан, гоо охин байсан л байх. Гэтэл одоо онгон биш учраас, хүнтэй ч гэрлэж чадахгүй, олноос цэрвэн амьдарна.

Дэндүү шударга бус явдал. Тамар хааныхаа тушаалаар Амноныг эргэж тойрч яваад хүчиндүүлсэн. Түүний амьдрал барагдчихаад байхад, хэргийн эзэн нь юу ч болоогүй юм шиг л явна. Энэ хэргийн жинг Тамар ганцаар үүрч, амьдрал нь нуранги болжээ.

Охин дүүгийнхээ гашуудлыг Абсалом өдөр болгон шахуу харсаар. Хааны гүнжийн төгөлдөр амьдрал хар дарсан зүүд болжээ. Абсалом аавыгаа хөдлөх болов уу хэмээн жил хүлээсэн ч, Давид хаан хөдөлсөнгүй. Абсалом аавдаа гомдож, Амноныг үзэн ядав.

Ийнхүү хоёр жил хорссоны эцэст Абсалом Амноныг алахаар хуйвалджээ. Абсалом магадгүй *мэдэлтэй нь хөдөлдөггүй юм бол, өөрөө дүүгийнхээ өшөөг авна аа* гэж бодоо байх.

Абсалом хааны хөвгүүдэд зориулж найр хийжээ. Абсалом

сэжиг ажиггүй ирсэн Амноныг хөнөөчихөөд, Гешур руу зугтсан. Гэхдээ ордноос хол байх хоорондоо аавдаа бүр ихээр дүрэлзэн гомдов.

Абсаломын бодол хорслоор хордож, Давидын өстөн болсон ч, битүүхэндээ аавыгаа дуудах байх гэж горьдсоор байжээ. Гэтэл Давид нэг ч дуудаагүй нь гал дээр тос нэмсэн байна.

Абсалом магадгүй ингэж бодоо байх: *Аавыг оройлон дээдэлдэг хүмүүс түүний жинхэнэ занг мэдэхгүй байна. Тэр бол Бурханы нэрээр халхавч хийсэн, амиа хоохойлогч. Саулаас ч дор! Саул Амалекчуудын хааныг, хэдэн тарган хонь малтай нь үлдээснийхээ төлөө хаан ширээгээ алдсан. Гэтэл аав өөрт нь морь, нохой мэт зүтгэдэг цэргийнхээ гэргийтэй нөхцөж, үүнийгээ нуух гэсэндээ, журамт цэргээ бүрэлгэсэн. Аав өөрөө алуурчин, завхай хүн учраас л, Амноныг шийтгээгүй! Тэгээд энэ явдлаа Иехува Бурханы нэрээр хаацайлна.*

Абсалом Гешурт 3 жил амьдрав. Амноны хойноос гашуудах Давидын сэтгэл тайтгарах үед Иоаб Давидыг Абсаломыг эргүүлж авчрахыг ятгаж дөнгөжээ. Гэхдээ Давид Абсаломтай уулзсангүй. Хоёр жилийн дараа Давид дахин Абсаломыг таалж, бүх эрх дархыг нь эргүүлж олгосон ч, Абсаломын гомдол тайлагдсангүй.

Абсалом дүр эсгэхийн мэргэжилтэн байв. Тэрбээр Амноныг алахаасаа өмнө: “Харин Абсалом Амнонд энэ хэргийн талаар сайн муу юу ч ярьсангүй. Охин дүү Тамарыг нь доромжилсон учир, Амноныг Абсалом үзэн ядаж байв” (2Самуел 13:22) гэдэг. Үзэн ядалт, хор хорслоо Абсалом шиг хав дарж чаддаг хүн цөөхөн байх.

Абсалом гомдол, шүүмжлэлээсээ болоод гомдолтой хүмүүсийг өөртөө татаж эхлэв. Тэрбээр хүмүүсийн гомдолд чих тавин, өөрийгөө Израильд зориулжээ. Абсалом би хаан байсан бол, аж амьдрал арай өөр байх сан хэмээн халаглах болжээ. Хаан нь тэднийг сонсохгүй хэмээн Абсалом ард түмний хэргийг шүүдэг болов. Магадгүй Абсалом өөрийгөө шударга ёсыг үзээгүй хүн гэж бодсондоо, хүмүүсийг хэргийг шүүсэн байх.

Абсалом үнэхээр хүмүүст санаа тавих мэт харагдаж байлаа. Абсалом Израилийн зүрхийг Давидаас булаасан гэж Библи хэлдэг. Гэхдээ Абсалом үнэхээр ард түмнийг бодсон уу эсвэл өөрийг нь гомдоосон Давидыг авч хаях арга зам хайж байв уу?

АЛДААНЫ МЭРГЭЖИЛТЭН

Абсалом Израилийг байлдан дагуулж, Давид хааны эсрэг босоход, Давид хаан амиа авран Иерусалим руу зугтав. Абсалом юу юугүй хаант улсаа байгуулах нь гэмээр харагдаж байлаа. Гэтэл хэдийгээр Давид Абсаломд гар битгий хүрээрэй гэж хичээнгүйлэн захисан ч, Абсалом Давидыг хөөж яваад алуулжээ.

Үнэндээ Абсаломыг хорсол, гомдол нь л хороосон юм. Хаан болох хувьтай, дүүрэн хүчин чадалтай залуу ааваасаа нэхсэн өрөө цуцлаагүй учраас, ид насан дээрээ завхарч төгсжээ.

Чуулганы удирдагчийн туслахууд удирдагчдаа гомдох нь түгээмэл. Төдөлгүй тэд удирдагчийнхаа өө сэв бүрийг эсвэл удирдагчийнхаа томилсон хүнийг нэг бүрчлэн шүүмжлэхийн мэргэжилтэн болно. Тэд гомддог. Хараа нь сарнидаг. Бурханаас тэс өөрөөр харж эхэлдэг.

Тэгээд эргэн тойрныхоо хүмүүсийг мөнөөх шударга бус удирдагчаас аврах даалгавартай болно. Тийнхүү уурласан, сэтгэл дундуур, үг дуулдаггүй хүмүүсээр хүрээлүүлээд, яах ийхийн зуургүй чуулганыг юмуу үйлчлэлийг салган бутаргана. Абсалом шиг л.

Заримдаа тэдний ажиглалт үнэхээр зөв байна. Магадгүй Давид Амноныг шийтгэх *ёстой* байж. Магадгүй удирдагчийн алдаа байж. Гэхдээ шүүгч нь та юу, Эзэн үү? Зөрчил тарьсан нь зөрчлөө л хураахыг санаарай.

Абсаломын түүх ба өнөөгийн үйлчлэлд тохиолддог явдал нь цаг хугацаа авдаг үйл явц. Гомдол зүрхэнд маань нэвтэрснийг бид өөрсдөө ч мэдэхгүй байх нь олонтаа. Хорслын үндэс ургаж байхдаа бараг үзэгдэхгүй. Арчилж тордоод байвал, ургаж бүдүүрсээр байна. Еврей номын бичээчийн хэлснээр: “Хэн ч Бурханы нигүүлслээс салахгүйн тулд болон ямар ч гашуун үндэс урган хор учруулан, түүгээр олон хүн бузарлагдахгүйн тулд сэрэмжил” (Еврей 12:15).

Эзэний үг л бидний зүрхний бодол, сэдлийг мэддэг учраас, зүрхээ шалгаж, Эзэний засалд нээлттэй байх ёстой. Ариун Сүнс хүний ухаанд ярьж, ойлгуулдаг. Бид Түүнийг үргээж, ойлголтыг нь үл ойшоож болохгүй. Ингэсэн хүн Бурханы өмнө гэмшиж, Бурханы засалд зүрхээ нээж өг.

Нэгэн үйлчлэгч хийсэн зүйлдээ Абсалом шиг үйлдэж үү, Давид шиг үйлдэж үү гэдгээ надаас асууж билээ. Тэрбээр нэгэн хотын пасторын туслахаар үйлчилж байтал, пастор нь түүнийг халчихжээ. Тэр залуугийн дээрх Бурханы мутрыг үзсэн пастор нь атаархсандаа л халсан болтой.

Жилийн дараа нөгөө халагдсан үйлчлэгч залууд Эзэн хотын нөгөө хэсэгт чуулган эхлүүл гэж хэлээд байх шиг санагджээ. Тиймээс чуулганаа эхлүүлсэнд, хуучин чуулганых нь зарим хүмүүс ирж нэгджээ. Тэрбээр Абсалом шиг байхыг хүсээгүйдээ сэтгэл зовсон боловч, хуучин удирдагчаа гомдоох юм хийгээгүйгээ мэдэж байж. Залуу шинэ чуулганаа Эзэний удирдамжаар эхлүүлснээс биш, хуучин чуулгандaa шаралхсандаа эхлүүлээгүй.

Би түүнд Абсалом, Давид хоёрын ялгааг хэлж өгөв. Абсалом удирдагчдаа гомдсондоо хүмүүсийн зүрхийг татсан. Харин Саул Давид руу дайрч байсан ч, Давид бусдыгаа Саулд үнэнч байхыг хүссэн. Абсалом хүмүүсийг авч явсан бол, Давид ганцаараа л явсан.

- “Чи тэр чуулганаас ганцаараа явсан уу? Чи хүмүүсийг өөртөө татах янз бүрийн зүйл хийсэн үү?”

- “Би хүмүүсийг татах юу ч хийгээгүй, ганцаараа л явсан.”

- “Сайн байна. Чи Давид шиг үйлджээ. Чамтай нэгдэж байгаа хүмүүс ч хуучин пастортаа гомдоогүй байх ёстой. Гомдсон байвал чөлөөлт, эдгэрэл рүү хөтлөөрэй.”

Эдүгээ тэр хүний чуулган хөгжин цэцэглэж байгаа. Тэрбээр зүрхээ шалгах зоригтой байсан нь үнэхээр хайр хүрмээр. Үүгээр барахгүй тэр бурханлаг зөвлөгөөг сонсож, хүлээж авсан. Түүнд “зөв” гэдгээ батлахаасаа илүү Бурханы замыг дагах л чухал байв.

Ариун Сүнс таны гомдол, хорслыг илчлэхээс бүү ай. Нуух тусам, гомдол зузаарч, зүрх чинь хатуурна. Өр зөөлөн зүрхтэй бай. Яаж?

Аливаа хорсол, уур, хилэн, шуугиан, гүтгэлэг нь бүх бузар муугийн хамт та нараас зайлаг. Бурхан та нарыг Христ дотор уучилсаны адил бие биеэ уучлан, нэг нэгнээ энэрэн өр зөөлөн сэтгэлээр ханд. Ефес 4:31-32

ГЭНЭТИЙН АЙМШИГТ ГОМДОЛ ТАНЫГ УЛАМ ӨСГӨНӨ.

Сатаны урхийг уншлаа! Олон ч хүнд санал болгоно.
Бурхан ч энэ номыг миний амьдралд их ашиглалаа.
Баярлалаа!

- S. T., GEORGIA

УРХИНААС ЗАЙЛ

*Иймээс би Бурханы ба хүмүүсийн өмнө хүний мөсөөр
гэм зэмгүй байхыг үргэлж хичээдэг билээ.*

Үйлс 24:16

Гомдлоос хол байхад зүтгэл чармайлт хэрэгтэй. Паул үүнийг дасгалтай жишсэн. Дасгал хийдэг хүний бие өвчин гэмтэлд өртөх нь бага. Би Хавайд зураг авахаар хананд авираад, өвдөгнийхөө бүл булчинг татаад, дараа нь дөрвөн өдөр явж чадаагүй билээ.

Физик эмчилгээний эмч надад: “Та тогтмол дасгал хийдэг бол, ийм юм болохгүй байсан. Булчин чинь хэлбэрээ алдсан учраас, та амархан бэртжээ” гэж хэлсэн юм.

Явж чаддаг болсон хойно маань өөр нэгэн эмч: “Та өвдөгнийхөө булчинг эрүүл хэлбэр, байдалд нь эргүүлж оруулахын тулд дасгал хийх хэрэгтэй болсон байна” гэж хэлж билээ. Би өвдгөө хэвийн болгох гэж нилээд хэдэн сар болов.

Дасгалыг Үйлс 24:16 дээр *аскео* гэдэг Грек үгээр хэлдэг. *Вайны илчлэл толь бичиг* дээр дасгалыг “Бэлтгэл юмуу сахилга батаар зовиур, бэрхшээл, дасгалыг даах”¹ гэж тайлбарладаг.

Эрүүл булчин шөрмөстэй хүн тэр хананд тоохгүй авирах байв. Үүнтэй адил зарим хүн Бурханыг дагаснаараа, үгээр нь

зүрхээ дасгалжуулдаг. Төлөвшлийн төвшин маань л биднийг гэмтэлгүй, гомдлыг даагаад гарах эсэхийг тодорхойлно.

Зарим гомдол бидний бэлтгэлийн хэмжээнээс хэтэрсэн жинтэй байдаг. Энэ илүүдэл сунгалт нь шарх юмуу гэмтэл учруулж чадах бөгөөд үүний дараа бид дахин чөлөөлөгдөж, эдгэрэхийн тулд сүнсээр дасгалжих ёстой болдог. Гэхдээ хүчин зүтгэлийн маань үр дүн талаар болохгүй.

Энэ бүлгээрээ би биднээс илүү хүчин зүтгэл бүхий шийдэл шаардсан тэдгээр эрс тэс, хүчтэй гомдлын талаар ярина.

Манай хамтран зүтгэгч, бид хоёрын хооронд нэг явдал болсон юм. Намайг хүндээр шархдуулсан тэр ланжгар гомдол ганц удаагийн явдал бус, харин жил хагасын явцад сайх хүний зүгээс намайг чиглэсэн олон удаагийн довтолгооны нэг байв.

Эргэн тойрныхон маань бүгдийг мэдэж байлаа. Тиймээс: “Чи гомдохгүй байна уу? Одоо яая гэж бодож байна? Чи юу ч хийлгүй, зүгээр өнгөрөөх гэж үү?” гэж асууна.

Би ч: “Би зүгээр ээ. Яагаа ч үгүй. Дуудлагаа үргэлжлүүлнэ” гэж хариулсаар.

Гэхдээ энэ бардам зангийн дуу хоолой байсан юм. Би хүнд шархадсан атлаа өөрөө ч няцааж байжээ. Тэгээд: “Яахаараа надад ийм зүйл тохиолддог байна аа” хэмээн олон цагаар гайхшран эргэцүүлнэ. Би гүнээ цочирдож, хөшиж, гайхсан байв. Би гүн шархдаж, тамирдсан атлаа бодлуудаа дараад, хүчтэй эрийн баг зүүсэн байлаа.

Сарууд өнгөрсөөр. Бүх зүйл хуурайшиж, үйлчлэл маань хагдарч, залбирал маань хоосорч, би ч тарчилж байлаа. Өдөр бүр чөтгөрүүдтэй тэмцэлдэнэ. Би энэ тэмцлийг миний тэнгэрийн дуудлагатай минь холбоотой гэж үзэж байсан ч, үнэндээ үл уучлалаасаа болж тарчилж байжээ.

Тэр хүнийг харах тоолондоо би сүнсээр няцарчихсан юм шиг л болдог байв.

Тэгтэл хэзээ ч мартагдашгүй тэр нэгэн өглөө болох нь тэр. Би гэрийнхээ арын цэцэрлэгт залбирч байгаад: “Эзэн минь, би гомдсон юм уу?” гэж асуусан юм.

Энэ үгийг гаргаж хэлэв үү үгүй юу сүнсний минь хэвэлд “Тийм!” гэж хашхирах шиг болов.

Бурхан надад гомдсоныг минь мэдүүлэхийг хүсчээ.

- “Бурхан минь, намайг энэ гомдол, шархаас авраач. Надад үнэхээр хэцүү байна” хэмээн би гуйлаа.

Эзэн ч надаас эцсийн дүнд үүнийг л хүсчээ. Бид дандаа л аливааг сэтгэлийнхаа хат, хүчээр хийх гэж оролддог. Үүнээсээ болж сүнсээр өсч чадалгүй, унадаг.

Эрх чөлөө, эдгэрэлд хүрэх эхний алхам нь шархаа хүлээн зөвшөөрөх. Бардам зан биднийг гомдож, шархалсанаа хүлээн зөвшөөрөхөд саад хийдэг. Би үнэн байдлаа хүлээн зөвшөөрснийхээ дараа Эзэнийг хайж, Түүний засалд бүрэн нээгдсэн юм.

Эзэн намайг хэдэн өдөр мацаг барихыг хүсч байх шиг санагдав. Мацаг намайг Ариун Сүнсний дуу хоолойд мэдрэг болгохоос гадна өөр олон талын тустай байлаа.

Нүгэл хилэнцийн хүлгийг мултлан, буулганы оосрыг тайлан, дарлагдагсдыг чөлөөлж, аливаа буулгыг эвдэхийн тулд мацаг барилтыг Би сонгосон бус уу? Исаиа 58:6

Би тэр ёрын хүлээсийг тас татаж, дарамтаас чөлөөлөгдөхөд бэлэн болов.

Хэдэн өдрийн дараа би оршуулгын ёслолд оролцсон юм. Намайг гомдоосон хүн ч тэнд байлаа. Би түүний чуулганы араас хараад уйлж эхлэв.

“Эзэн минь, би түүнийг уучилж байна. Түүний хийсэн бүхнээс нь чөлөөлж байна.” Гэтэл тэр даруй дарамт арилав. Би түүнийг уучилжээ. Тайтгарал ч урсан орж ирэв!

Гэхдээ энэ бүхэн эдгэрлийн маань гараа л байжээ. Би зүрхэндээ уучилсан боловч, шарх маань хичнээн гүн болохыг мэдээгүй юм. Би эмзэг бөгөөд дахин шархдахад бэлэн байв. Яг л биеийн гэмтлээс эдгэрэхтэй л адил. Би цаашдаа гэмтэхээс сэргийлэхийн тулд зүрх, оюун, сэтгэлээ бэхжүүлэх дасгал хийх ёстой байв.

ШАРХ СЭДРЭХ ҮЕД?

Дахиад хэдэн сар өнгөрөв. Үе үе би уучлахаас өмнө тээж байсан бодолтойгоо ахин дахин тэмцэлдэх ёстой болдог байлаа. Голдуу надтай адил шарх олсон хүн над дээр гомдол урсгасаар ирэх үед юм уу эсвэл нөгөө хүнийг харах эсвэл нэрийг нь сонсох үед тэр. Би энэ бодлыг таньмагцаа шууд эсэргүүцнэ (2Коринт 10:5-ыг

үзнэ үү). Энэ миний эрх чөлөөгөө хадгалах дасгал буюу тэмцэл байлаа.

Эцэст нь би үл уучлал руу эргүүлж байгаа эдгээр бодлоос өөрийгөө хэрхэн хамгаалахыг Эзэнээс асуулаа. Эзэн надад илүү өндөр төвшний эрх чөлөө хүсч байгааг би мэдэж байсан бөгөөд үлдсэн амьдралаа гомдол атгаж өнгөрөөхийг хүссэнгүй. Эзэн надад намайг гомдоосон хүний төлөө залбирахыг зааварчлаад, дараах үгийг сануулав:

Харин Би та нарт хэлье. Дайснуудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир. Матай 5:44

Тэгээд би залбирлаа. Эхлээд ямар ч сэтгэлгүй, хуурай, цулгай өнгө гарав. Тэгээд ёсыг бодож: “Эзэн минь, түүнийг ерөөгөөрэй. Ажил үйлсийг нь таалаарай. Түүнд туслаарай. Есүсийн нэрээр, амень” л гэлээ.

Ийм маягаар хэдэн долоо хоног залбирав. Энэ залбирал намайг юунд ч хүргэсэнгүй. Тэгтэл нэгэн өглөө Эзэн надад Дуулал 35-ыг сануулав. Би Дуулал 35-ыг мэдэхгүй учраас, гаргаад, уншлаа. Тэгээд талд нь ороод, өөрийнхөө байдлыг үзэв.

Хэрцгий гэрч нар босдог.
Тэд миний мэдэхгүй зүйлсийг надаас байцаадаг.
Тэд сэтгэлийг минь өнчрүүлэн
Тусыг минь усаар хариулдаг. Дуулал 35:11-12

Би яг л Давид шиг болжээ. Миний бодлоор, тэр хүн ч, түүний түншүүд ч миний сайныг муугаар хариулсан. Сэтгэл минь аргагүй өвджээ. Сүүлийн хэдэн жилийн тэмцлийг минь Эзэн энэ Дууллаар харуулав. Тэгтэл нэг үг намайг тааз тултал огло харайлгалаа.

Харин *миний хувьд* тэднийг өвчтэй байхад
Би тааран хувцас өмссөн.
Би сэтгэлээ мацгаар зовоосон бөгөөд
Миний залбирал цээжинд минь буцан ирсээр байв.
Би өөрийн найз, эсвэл ах дүүдээ юм шиг тэдэнд үйлдсэн.
Би эхийн хойноос гашууддаг нэгэн шиг гашуудан бөхийсөн.
Дуулал 35:13-14

Хүмүүс өөрийг нь устгахаар оролдож байгааг Давид хэлжээ. Тэд Давидыг гэмгүй байхад нь довтолсон.

Дараа нь би хариултаа олов: “*Харин миний хувьд...*”

Давидын хариу үйлдэл бусдын үйлдлээс хамаараагүй байна.

Давид зөв гэсэн зүйлээ үйлдэхээр хатуу шийдэж, тэдний төлөө дотно нөхдийнхөө төлөө мэт эсвэл эхийнхээ араас гашуудах мэт залбирчээ. Үүгээр Бурхан надад нөгөө хүний төлөө хэрхэн залбирахыг харуулж байв: “Чи Надаас өөртөө хүсдэг бүхнээ Түүний төлөө залбир!”

Ийнхүү залбирал маань эрс өөрчлөгдөв. Цаашид “Бурхан минь, Түүнийг ерөөж, сайн сайхан байлгаарай” гэхээ болив. Залбирал маань амиар сүлэгдэв. “Эзэн минь, Түүнд Өөрийгөө улам бүр зааж өгөөрэй. Оршихуйгаар ерөөгөөрэй. Таныг улам бүр дотно таньж мэдэх болтугай. Таны тааллыг олж, Таныг алдаршуулах болтугай.” Би өөрийнхөө амьдралд Бурханаас хүссэн зүйлээ түүний төлөө залбирав.

Түүний төлөө нэг сар үнэн голоосоо залбирсны дараа “Би таныг ерөөж байна! Есүсийн нэрээр би танд хайртай!” хэмээн сүнснийхээ цөмөөс дуу тавин орилдог болов. Би өөрийгөө бодсондоо түүний төлөө залбирдаг байгаад, сүүлдээ түүнийг бодсондоо түүний төлөө залбирдаг болсон юм. Би өөрийгөө гүйцэт эдгэрсэн гэдэгтээ итгэлтэй байлаа.

НҮҮРЭЛДСЭНЭЭР ЭДГЭРЭХ

Хэдэн долоо хоногийн дараа би түүнийг дахин харав. Бас л нэг эвгүй мэдрэмж зүрх рүү хатгаад явчихлаа. Дахиад л шүүмжлэл өрвөлзөж эхлэв.

- “Жон, чи түүнтэй уулзах хэрэгтэй” хэмээн гэргий минь намайг ятгалаа.

- “Зүгээр ээ, хэрэггүй. Би одоо эдгэрсэн” хэмээн би баталлаа.

Гэхдээ хэлсэн үгийг маань Ариун Сүнс батлахгүй байгааг мэдрэв. Тиймээс би түүнтэй уулзах эсэхээ Эзэнээс асуусан чинь Эзэн “Уулз” гэв.

Би түүнтэй уулзах цаг товлоод, бэлэг өгч, өөрийгөө даруусган, буруу хандлагаа хүлээн, уучлал эрэв. Бид эвлэрч, зүрх маань уучлал, эдгэрлээр халгилаа.

Би түүний албан өрөөнөөс гарахдаа эдгэрч, цэгцэрсэн байв.

Цаашид зовиуртай тэмцэлдэж, түүнийг шүүмжлэх хүсэл ч байсангүй. Түүнээс хойш бид нэг ч муудаагүй бөгөөд бидний харилцаа ган бат болсноор барахгүй, бие биеэ байнга дэмждэг болсон юм.

“Анх тэр хүн миний нүдэнд ямар ч алдаагүй, өөгүй, төгс харагдсан учраас, би түүнийг хайрласан. Дараа нь гомдсон үед түүнийг хайрлах хэцүү байсан. Үүний тулд би алхам бүрээ итгэлээр хийх ёстой байсан. Харин одоо би сэргээгдэх үйл явцыг туулж, эдгэрсэн учраас, түүний алдааг үл хэрэгсэн, анхных шигээ л хайрладаг. Энэ жинхэнэ төлөвшсөн хайр юм байна” гэж би Лизад хэлж билээ.

Миний санаанд дараах ишлэл буув:

Юуны өмнө, бие биеэ халуунаар хайрла. Учир нь хайр бол тоо томшгүй нүглийг далдалдаг юм. 1 Петр 4:8

Өө сэвгүй хүнийг хайрлах амархан. Энэ бол бал сарын дурлал. Нөгөөтэйгүүр, алдаа мэдгийг нь харсан, тэр тусмаа биднийг хохироосон хүнийг хайрлах тэс өөр. Бурханы хайр намайг төлөвшүүлж, зүрхийг минь бэхжүүлж байв.

Түүнээс хойш би яг адилхан нөхцөлд орохдоо, гомдлоо газар дээр нь тайлж сурсан юм. Шалтгаан нь: Би зүрхээ гомдлоос чөлөөтэй байлгахад дасгалжуулжээ.

Гэрийнхээ арын цэцэрлэгээс Эзэнтэй ярьсан өдрөөс нөгөө хүний албан өрөөнөөс эдгэрээд гарсан өдрийг хүртэл хэдэн сар болсон юм. Энэ бол зүрхний маань дасгалжуулалтын хугацаа байж. Тэр хугацаанд ямар ч ахиц дэвшил гарахгүй байгаа мэт санагдах үе зөндөө байлаа. Үнэндээ улам л уруудаад байна уу гэлтэй.

Тийм боловч, би бат эдгэрэлд хүрэх зам дээр явж байв. Эзэний сүнс намайг дааж чадах аясаар минь хөтөлжээ. Энэ нь миний төлөвшлийн үйл явцсын нэгээхэн хэсэг байв. Би энэ үйл явдлыг юугаар ч наймаалцахгүй бөгөөд амьдралд минь авчирсан өсөлтөд талархдаг.

ХҮНД БЭРХЭЭР ДАМЖИЖ ӨСӨХ

Бид зовлон дунд өсдгөөс биш, жаргал дунд өсдөггүй. Эзэнийг дагаж явахад бэрх үе заавал ирнэ. Үүнээс зугтах биш, нүүр

тулах ёстой. Учир нь зовлон нь бидний хувьд Түүний дотор төгс болох үйл явцсын нэгээхэн хэсэг юм. Зовлонгоос зугтаад байвал, өсөлтөндөө ноцтой саад учруулна.

Янз бүрийн саадыг даван туулахдаа, та илүү хүчтэй бас хайрлаж чаддаг хүн болно. Та Есүст улам л дурлана. Харин зовлонг давсан хойно ийм мэдрэмж төөрөхгүй байвал, та гомдлоосоо эдгээгүй ажээ. Эдгэрэл бол таны сонголт. Зарим хүн шархдаад, хэзээ ч эдгэрдэггүй. Хатуу үг хэдий ч, өөрсдийнх нь л сонголт тэр.

Есүс туулсан зовлонгоороо дуулгавартай байдалд суралцсан. Петр, Паул ч ялгаагүй. Тэгвэл та? Сурсан уу? Эсвэл хатуу, мэдрэмжгүй, цэвдэг, хорсолтой, эсэргүүцэгч хэвээрээ л байна уу? Тийм бол, та дуулгавартай байдалд суралцаагүй байна.

Тийм ээ, зарим гомдол ус сэгсрэхийн дайтай арилахгүй. Чөлөөлөгдөх гэж нилээд хүч хөдөлмөр зарцуулна. Гэхдээ энэ үйл явц дунд та өсч төлөвшинө.

Төлөвшил амархан ирэхгүй. Амархан байсан бол, бүгд л төлөвшчихсэн байх байв. Нүүрлэдэг эсэргүүцлийнх нь улмаас, хуруу дарам хүн л амьдралын энэ төвшинд хүрч чаддаг. Бид өнөөдөр амь амиа хичээдэг, бурханлаг бус нийгэмд амьдарч байгаа учраас, эсэргүүцэл ирдэг. Энэ дэлхийг “агаарын хүчний ханхүү” ноёлдог (Ефес 2:2). Иймээс Христийн төлөвшилд хүрэхийн төлөө амиа хичээсэн байдлын урсгалыг сөрөхөд чамгүй зовно.

Паул дагалдагч нарынхаа сэтгэлийг зоригжуулахын төлөө гурван хотод тарьсан чуулганаа эргэж очжээ. Гэхдээ хэрхэн зоригжуулсан нь маш сонирхолтой. Паул ингэж захижээ:

дагалдагчдын сэтгэлийг бэхжүүлж, үргэлж итгэлтэй байгаарай гэж урамшуулан, “Бид олон зовлон туулж байж Бурханы хаанчлалд орох ёстой” гэлээ. Үйлс 14:22

Паул тэдэнд амар хялбар амьдрал, дэлхийн жишиг болсон амжилт амлаагүй. Харин аян замаа баяртайгаар дуусгах гэж байгаа л бол, зовлон гэдэг эсэргүүцэлтэй тулна гэжээ.

Урсгал сөрж сэлүүрдэж байгаа хүн тасралтгүй сэлүүрдэж байж л урагш ахина. Сэлүүрдэхээ болиод амарчихбал, урсгалд туугдана. Бурханы замыг дагахаар шулуудсан хүн заавал ч үгүй гай зовлон үзнэ. Бүх зовлон нэг л чухал асуултад хариулах

болно: Та дэлхий шиг өөрийгөө л бодох уу эсвэл өөрийгөө үгүйсгэж амьдрах уу?

Есүсийн төлөө амиа орхисон хүн Есүсийн амийг олно. Фокусаа зөрчил дээр бус, эцсийн үр дүн төвлөрүүлж сур.

Петр үүнийг сайхан хэлжээ:

Хайртай хүмүүс минь, та нарыг сорихын тулд дунд чинь ирдэг галт сорилтод ямар нэгэн хачирхалтай юм та нарт тохиолдсон мэт бүү гайх. Харин та нар Христийн зовлонг хуваалцдагтаа баярла. Ингэснээр мөн Христийн алдар илчлэгдэхэд та нар баяр хөөртэйгээр баярлах юм.

1Петр 4:12-13

Петр зовлонгийн зэргийг баяр хөөрийн зэрэгтэй харьцуулжээ. Яаж ийм зэрэгтэй баярлах вэ? Есүсийн алдар илчлэгдэхэд, та Есүстэй хамт алдаршина. Та Есүст таны дотор алдраа төгөлдөршүүлэхийг зөвшөөрсөн тэр чинээгээрээ л алдаршина. Тиймээс гомдлыг бус, айсуй алдрыг хар. Халлелүяа!

**ӨӨРИЙНХӨӨ ЗӨВИЙГ БАТЛАСНААС
БҮДЭРСЭН АХ ДҮҮДЭЭ
ТУСЛАХ НЬ ЧУХАЛ.**

Би гайхамшигтай өнөр өтгөн гэр бүлтэй, 18 настай ирхийн өрөөсөн. Ээж маань ганцаараа биднийг хүн болгосон юм. Би төрсөн эцгээ хэзээ ч хараагүй, насан туршдаа үзэн яддаг байлаа. Харин миний өвөө бол Бурханы аугаа хүн. Тэр надад Сатаны урхи гэдэг номыг уншаарай гэж өгсөн юм. Үүнийг уншаад би аавыгаа бүрэн уучилсан билээ.

- N. M., NEW MEXICO

ЗОРИЛГО: ЭВЛЭРЭЛ

“Хүн алж болохгүй, хүний амийг хөнөөсөн хэн боловч шийтгүүлбэл зохино” гэж эртний хүмүүст айлдсаныг та нар сонссон. Харин Би та нарт хэлье, ах дүүдээ хилэгнэгч алив хүн шүүхийн өмнө буруутай. Ах дүүгээ “Хоосон толгой” гэж хэлсэн хэн боловч зөвлөлийн өмнө буруутай. “Мунхаг” гэж хэлсэн хэн боловч галтай тамд орохоор хангалттай буруутгагдах болно. Иймээс, хэрэв чи тахилын ширээнд өргөл өргөх гэж байхдаа чиний эсрэг ямар нэг юм ах дүүд чинь байгааг санавал, өргөлөө тахилын ширээний өмнө орхиод замаараа буц. Эхлээд ах дүүтэйгээ эвлэр, дараа нь ирж өргөлөө өргө.

Матай 5:21-24

Энэ бол Есүсийн Уулан дээрх сургаалын нэг хэсэг. Есүс яриагаа “...гэж эртний хүмүүст айлдсаныг та нар сонссон” хэмээн эхэлжээ. Гэвч дараа нь “Харин Би та нарт хэлье” гэсэн.

Есүс уг яриагаа дуусан дуустал энэ харьцуулалтыг ашиглажээ. Эхлээд бидний гадаад үйлдлийг зохицуулдаг хуулийг эшлээд, дараа нь үүний биеллийг зүрхэн дээр буулган

харуулжээ. Тэгэхээр, Бурханы мэлмийд гагцхүү хүн алсан хүн л алуурчин бус, харин ахан дүүгээ үзэн яддаг хүн ч алуурчин ажээ. Та зүрхэндээ хэн байна - тэр чинь л жинхэнэ та мөн!

Есүс энэ номлол дээрээ гомдлын үр дагаврыг маш тодорхой зааж, уур, гашуун гомдол тээхийн аюулыг дүрсэлжээ. Хүн ахан дүүдээ ямар ч урхаг шалтгаангүй уурлабал, өөрөө шүүгдэх аюулд орно. Уур нь үр жимс ургуулж, тэрбээр ахан дүүгээ “Рака!”¹ гэж дуудбал, өөрөө зөвлөлийн өмнө шүүгдэх аюулд орох нь байна.

Рака нь “усан толгой” буюу тэнэг гэсэн үг. Христийн цаг үед Еврейчүүд ингэж ярьцгаадаг байж. Хүн уурандаа ахан дүүгээ тэнэг гэж дуудахад л тамд орох болзлыг хангах байж. *Тэнэг* гэдэг нь бурхангүй гэсэн үг.² Тэнэг хүн зүрхэндээ Бурхан байхгүй гэдэг (Дуулал 14:1-ийг үзнэ үү). Тэр үед ахан дүүгээ тэнэг гэж дуудах нь тун ноцтой ял байжээ. Уур нь үзэн ядалт болж хувираагүй хүн ийм үг хэлэхгүй. Одоогийнхоор бол ахан дүүдээ “Там руугаа тонил” гэж үнэн голоосоо хэлэхтэй л ижил юм.

Есүс тэдэнд уур хилэнгээ шийдэхгүй бол, үзэн ядалт болж хувирахыг харуулжээ. Шийдээгүй үзэн ядалт нь тэднийг тамын аюулд унагана. Дараа нь Есүс ахан дүү чинь та нарт гомдолтой байгаа бол, олж очоод, эвлэрэхийг урьтал болго хэлжээ.

Бид яагаад эвлэрэхийг хичээнгүйлэх ёстой вэ? Өөрийнхөө төлөө юу, ахан дүүгийнхээ төлөө юу? Бид ахан дүүгийнхээ гомдлыг тайлахын тулд, түүний төлөө хөдлөх ёстой юм. Бид ахан дүүдээ гомдоогүй байлаа ч, Бурхан ахан дүүд маань хүрч, сэргээлгүй, ууртай чигээр нь үлдээхийг зөвшөөрөхгүй. Бид буруу юм хийгээгүй байж болно. Зөв, буруу нь хамаагүй. Гол нь өөрийнхөө зөвийг батлахаасаа илүү бүдэрсэн ах дүүдээ тусласан нь чухал.

Гомдлын тохиолдол хязгааргүй.

Магадгүй, бид хэнийг ч хохироогоогүй байхад, нөгөө хүн өөрт нь шударга бус хандлаа гэж хий үзэж болох. Магадгүй, ташаа мэдээллээс ташаа дүгнэлт гаргасан байж болох.

Нөгөөтэйгүүр, *батмай* мэдээнээс ташаа дүгнэлт ч гаргасан байж болох. Бидний хэлсэн зүйл харилцааны янз бүрийн сувгаар дамжихдаа, элдвээр эрэмдэглэгдсэн байж болох. Хэдийгээр хорлоё гэж бодоогүй ч, үг, үйлдэл маань өөрөөр илэрч ч болох.

Хүн өөрийгөө сэдлээрээ шүүдэг атлаа бусдыг үйлдлээр нь шүүх нь олонтаа. Нэг зүйлийг саначихаад, тэс өөр зүйлийг

ойлгуулж болдог. Заримдаа жинхэнэ сэдэл маань биднээс өөрсдөөс маань ч зальхай нь аргагүй нуугдсан байдаг. Бид сэдлээ цэвэр гэж боддог ч, Бурханы Үгээр шүүгээд үзбэл, тэс өөрөөр харагдана.

Эцэст нь бас бид хүнийг үнэхээр гомдоосон байж болох. Бидний уур, дарамт хүнийг жинхэнээсээ түлчихсэн байж болох. Эсвэл байнгын төвөг дарамт учруулсан хүнд таарсан хариуг нь барьчихсан ч байж болох.

Урхаг шалтгаан нь юу ч байлаа гэсэн, нөгөө гомдсон хүний ойлголт харанхуйлж, бидний жинхэнэ санаа, сэдлийг олоод мэдчихлээ хэмээн өөрийгөө мэхлэн, сонссон, харсан, гадарласан зүйл дээрээ тулгуурлан шүүж эхэлдэг. Бид баттай мэдээлэлгүй байж, яаж баттай шүүх билээ? Гэхдээ тэр хүн өөрийгөө жинхэнээсээ хохирсон гэдэгт үнэн голоосоо итгэж байгаа гэдэг баримтанд бид мэдрэг хандах ёстой. Тэрбээр ямар шалтгаанаар гомдолд хүрснээс нь үл хамааран, бидний зүгээс өөрийгөө даруусган, уучлал гуйх хүсэлтэй байх ёстой.

Бидний буруу биш байсан ч, Есүс биднийг эвлэрэхийг ятгасан. Эвлэрэл авчрахын төлөө өөрийгөө даруусгахад төлөвшил хэрэгтэй. Гэвч шархтай хүний хувьд эхний алхам хийх хэцүү. Тиймээс л Есүс гомдол тарьсан “эзнийг” нь өөрөө “...оч...” гэсэн байна.

ГОМДСОН ХҮНЭЭС УУЧЛАЛ ГҮЙХ

Элч Паул ингэж хэлжээ:

Тиймд амар тайвныг тогтоодог болон бие биеэ босгон байгуулдаг зүйлсийн хойноос мөшгөцгөөе. Ром 14:19

Энэ үг бидэнд гомдоосон хүн дээрээ яаж очихыг зааж байна. Дургай дургүй явж очбол, амар тайвныг тогтоохгүй. Гомдсон хүнийг улам л шархлуулна. Бид бардам зангаа таягдаж, дарууслыг мөшгих замаар л эвлэрлийн хандлагаа хадгална. Энэ бол жинхэнэ эвлэрлийг үзэх цорын ганц зам.

Заримдаа би гомдоосон эсвэл уурлуулсан хүмүүс дээрээ явж очих үед тэд намайг амиа бодсон, бодлогогүй, бардам, бүдүүлэг харгисаар минь дуудаж, давшилдаг.

Мэдээж хүн юм болохоороо: “Үгүй шүү, та намайг ойлгохгүй байна!” л гэж хариулна. Гэхдээ биеэ өмөөрөх нь гомдлын түймрийг улам л дэгдээнэ. Энэ бол амар тайван тогтоох үйлдэл биш. Өөрийгөө өмөөрч, “эрхээ” эдэлснээрээ, энх амрыг тогтоохгүй.

Тиймээс би хүмүүсийг онгойтлоо ярьж дуустал нь амаа үдэж байгаад, сонсож сурсан. Санал нийлэхгүй байвал, зүгээр л тэдний бодлыг хүндэтгэж байгаагаа мэдүүлээд, хандлага, сэдлээ шалгана. Тэгээд гомдоосонд минь уучлаарай гэж хэлнэ.

Харин миний талаарх үг нь үнэн байвал: “Таны зөв. Намайг уучлаарай” гэдэг.

Товчхондоо, мөн л эвлэрлийн төлөө өөрийгөө даруусгах ёстой л гэсэн үг. Магадгүй иймээс л Есүс дараах үгийг хэлээ байх:

Замд яваа дээрээ арцалдагчтайгаа аль болох түргэн сайдах хэрэгтэй. Эс тэгвэл арцалдагч чинь чамайг шүүгчид өгч, шүүгч түшмэдэд хүргэж, чи шоронд хаягдах вий. Үнэнээр би чамд хэлье. Чи эцсийн кодрантыг төлтлөө тэндээс гарахгүй
Матай 5:25-26

Бардамнал өмөөрдөг. Даруу зан: “Таны зөв. Би тийм юм хийж. Намайг уучлаарай” гэдэг.

Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгт ариун тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай (*буулт хийх хүсэлтэй*), өршөөлөөр ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж. Иаков 3:17

Бурханлаг цэц ухаан буулт хийх хүсэлтэй байдаг. Хүмүүсийн зөрчил дунд цэц ухаан хөшүүн хүзүүлж, зөрүүдэлдэггүй. Бурханлаг цэц ухаанд захирагддаг хүн - үнэнийг хөсөрдүүлээгүй тохиолдолд - бусдын үзэл бодолд буулт хийх юмуу байраа тавьж өгөхөөс айдаггүй.

ТАНЫГ ГОМДООСОН ХҮНТЭЙ ОЧИЖ УУЛЗАХ

Бид ахан дүүгээ гомдоосон нөхцөлд яах ёстойг үзсэн бол, харин одоо ахан дүү маань биднийг гомдоосон тохиолдолд яах ёстойг үзье.

Хэрэв ах дүү чинь нүгэл үйлдбэл, явж түүнтэй ганцаарчлан уулзан зэмлэ. Хэрэв тэр чамайг сонсбол, чи ах дүүгээ олж авсан хэрэг. Матай 18:15

Олон хүн бичээсийн ишлэлийг Есүсийн санаснаас тэс өөр хандлагаар ашигладаг. Тэд шарх авсан бол, гомдоосон хүн дээрээ уур хилэн, өс хонзонгийн сүнсээр явж очно.

Гэхдээ тэд нөгөө хүнтэй нүүрэлдүүлэхийг хүссэн Есүсийн хамаг зорилгыг гээдэг. Энэ үг нь яллахын төлөө бус, эвлэрлийн төлөө юм. Есүс биднийг ахан дүү дээрээ муу муухайг нь тоочоосой гэж хэрхэв ч хүсэхгүй.

Энэ нь Бурхан биднийг хэрхэн Өөртэйгээ эвлэрүүлдгийн үлгэр загвар юм. Бид Бурханы эсрэг нүгэл үйлдсэн боловч, "... биднийг нүгэлтнүүд байхад Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулжээ" (Ром 5:8). Биднийг гомдоосон хүнтэй эвлэрэхийн тулд бид биеэ өмөөрөхөө больж, бардам зангаа таягдаж чадах уу? Биднийг Бурханаас уучлал гуйхаас өмнө Бурхан бидэнд гараа сунгасан. Биднийг зөрчлөө хүлээн зөвшөөрөхөөс өмнө Есүс биднийг уучлахаар шийдсэн.

Хэдийгээр Бурхан бидэнд гараа сунгасан ч, бид Бурханы эвлэрлийн үгийг хүлээж авахаас нааш Аавтай эвлэрч чадахгүй.

Бүх юмс Бурханаас байгаа юм. Тэр Христээр биднийг Өөртэйгөө эвлэрүүлж, бидэнд эвлэрлийн үйлчлэлийг өгсөн байна. Яагаад гэвэл Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, хүмүүсийн гэм бурууг үл харгалзсан бөгөөд *эвлэрлийн* үгийг бидэнд даалгасан билээ. Иймээс бид Христийн төлөөх элчин сайд нар юм. Бурхан биднээр дамжуулж ятгаж байгаачлан бид *Христийн төлөө та нараас гуйя. Бурхантай эвлэрцгээ.*

2Коринт 5:18-20

Эвлэрлийн үг нь бид бүгдээрээ Бурханы эсрэг нүгэл үйлдсэн гэдэг нийтлэг хөрсөн дээрээс эхэлнэ. Салалт байдгийг мэдэхээс нааш хүн эвлэрэл, авралыг хүсдэггүй.

Хүмүүс Бурханы эсрэг нүгэл үйлдсэн гэдгийг Шинэ гэрээнд дагалдагч нар номложээ. Гэхдээ юуны тулд хүмүүст нүгэл үйлдсэнийг нь мэдүүлэх гэж? Яллахын тулд уу? Бурхан тэднийг ялладаггүй. “Бурхан Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан ертөнцийг авралын тулд илгээсэн юм” (Иохан 3:17). Хүмүүсийг нөхцөл байдлаа ухаарч, нүглээ гэмшихэд хүргэж, уучлах гэж.

Хүнийг юу гэмшилд хүргэдэг вэ? Хариулт нь Ром 2:4 дээр байна.

Эсвэл та Бурханы энэрэл өөрийг чинь гэмшүүлдэг гэдгийг мэдэлгүй, Түүний энэрэл, хүлцэл ба тэвчээрийн баяныг басамжлах уу?

Бурханы сайн нь биднийг гэмшүүлд хүргэдэг. Бурхан биднийг яллаад, там руу тонилгочихдоггүй. Бурхан цорын ганц Хүү Есүсээ илгээж, бидний төлөө загалмайд хадуулахдаа, биднийг гэх хайраа баталсан юм. Өөрийнх нь эсрэг нүгэл үйлдээд байхад л Бурхан биднийг яллах бус, сэргээж аврахын төлөө түрүүлж мутраа сунгажээ.

Тиймд Бурханыг даган дууриах ёстой бид ч (Ефес 5:1-ийг үзнэ үү) энэ эвлэрлийг өөрсдийн маань эсрэг нүгэл үйлдсэн ахан дүү дээрээ тэлэх ёстой юм. Есүс бидэнд: Явж очоод, яллахын тулд бус, харин та хоёрын дунд байгаа тээгийг зайлуулж, эвлэрч сэргээгдэхийн тулд түүнд нүглийг нь мэдүүл гэдэг үлгэр загварыг тогтоож өгсөн байна.

Иймд та нар дуудагдсан тэрхүү дуудлагадаа зүй зохистой явахыг Эзэний хоригдол би хичээнгүйлэн ятгая. Ингэхдээ аливаа төлөв даруу байдлаар бөгөөд дөлгөөн сэтгэлээр хайр дотор бие биеэ хүлцэн тэвчиж, амар тайвны хүлээс дотор Сүнсний нэгдлийг хадгалахыг хичээгтүн.
Ефес 4:1-3

Бид хайр дотор бие биеийнхээ сул талыг хүлээн зөвшөөрч, даруу, зөөлөн, гэвчээртэй хандлагаа сахиснаараа, энх тайвны холбоогоо хадгална. Тийнхүү хайрын холбоо бэхжинэ.

Намайг яллаж байгаа хүмүүст би буруу хандаж байсан. Үүнээсээ болж эвлэрэх ямар ч хүсэлгүй болно. Үнэндээ би тэднийг эвлэрэх хүсэлгүй, зүгээр л надад ямар их хилэгнэж байгаагаа л мэдүүлэх гэж байна гэж боддог байлаа.

Нөгөөтэйгүүр, надад гомдсон зарим хүн номхон зөөлнөөр ирж уулздаг. Тэр үед нь би хандлагаа бушуу өөрчилж, заримдаа тэднийг ярьж дуусахаас ч өмнө уучлал гуйна.

Тан дээр хүрч ирээд: “Чамайг олигтой найз байж чадаагүйд бас миний төлөө үүнийг, түүнийг хийгээгүйд чинь уучилъя” гэх маягтай үг хэлж байсан хүн бий юу?

Тэгж хяргачихаад, дараа нь “За алив, уучлал гуй” гэсэн янзтай зогсоно.

Та хэлэх үггүй болж, самгардана биз дээ. Тэд тантай эвлэрэхээр бус, харин сүрдүүлж, дарангуйлахаар иржээ.

Биднийг гомдоосон ахан дүүгээ чин зүрхнээсээ уучлахаар шийдсэн хойноо л тэдэн дээр очиж уулзаарай. Ахан дүү чинь ямар ч хариу үзүүлж болно. Уулзахаасаа өмнө бүх төрлийн дайсагнах мэдрэмжээсээ салах хэрэгтэй. Эс бөгөөс уулзах үед сөрөг мэдрэмжээрээ үйлдэж, нөгөөхөө эдгээх бус, шархлуулж орхино.

Гэхдээ би өөрийг маань гомдоосон хүний зүг зөв хандлага тээж, эвлэрэх гээд байхад, тэрбээр сонсохгүй бол яах уу?

Харин тэр үл сонсбол нэг юмуу хоёр ах дүүгээ дагуулж оч. Тэгвэл хоёр буюу гурван гэрчийн амаар хэрэг нь бүрэн нотлогдоно. Хэрэв тэднийг ч сонсохоос татгалзбал, чуулганд хэл. Хэрэв чуулганыг хүртэл сонсохоос татгалзбал, тэр чиний хувьд харь үндэстэн, татвар хураагч мэт байг.

Матай 18:16-17

Энэ бүх дэвшил нь нэг л ижил зорилготой: эвлэрэх. Есүс үнэндээ “оролдсоор бай” гэжээ. Гомдол тарьсан хүн бидний амьдралын алхам тутамд оролцож байгааг тэмдэглээрэй. Бид Есүсийн хэлснээр, гомдоосон хүнтэйгээ шууд очиж уулзах ёстой байтал оронд нь гомдлоо бариад л таньдаг мэддэг хүн болгон руугаа гүйчихдэг! Бид зүрхнийхээ асуудлыг шийдвэрлээгүй учраас ийм юм хийдэг. Өөрийнхөө талын түүхийг ярьснаараа,

өөрийгөө зөвтгөж байгаа гэх үү. Ингэж өөрийнхөө шалтгааныг бөхөлж, хүмүүсийн хөөрхийллээр тайтгарна. Энэ бол амиа хичээсэн л авир.

ДУГНЭЛТ

Бурханы хайрыг сэдлээ болгосон хүн бүтэлгүйтэхгүй. Учир нь хайр хэзээ ч хөсөрдүүлдэггүй. Бид Есүсээр хайрлуулдаг хайраараа бусдыг хайрлах үед нөгөө хүн бидэнтэй эвлэрэхийг хүсэхгүй байсан ч, бид чөлөөтэй байна. Дараах Бичээсийн ишлэлийг анхааралтай харна уу. Бурханы цэц ухаан бүх нөхцөлд хүрэлцээтэй.

Хэрэв боломжтой бол, та нараас шалтгаалж байгаа бол бүх хүнтэй эвтэй байгтун. Ром 12:18

Заримдаа хүмүүс бидэнтэй найрамдахаас татгалзах үе байдаг учраас л, Паул “хэрэв боломжтой бол” гэжээ. Эсвэл тухайн хүнтэй эвлэрэхийн тулд Эзэнтэй тогтоох харилцаагаа хөсөрдүүлэх шаардлагатай болох үе байна. Энэ хоёр тохиолдлын аль аль дээр нь тухайн харилцааг сэргээх боломжгүй.

Бурхан “...та нараас шалтгаалж байгаа бол” гэснийг тэмдэглэнэ үү. Үнэнээс гажаагүй тохиолдолд, бид тухайн хүнтэй эвлэрэхийн төлөө чадах бүхнээ хийх ёстой. Бид ер нь харилцаагаа амархан хаядаг.

Нэг нөхөр маань намайг таагүй нөхцөл байдлаас зугтахгүй байхыг зөвлөхдөө: “Жон, чамд энэ бүхнийг хаяж явах бичээсийн бүрэн үндэслэл бий. Гэхдээ ингэхээсээ өмнө би энэ нөхцөл байдалд Бурханы амар тайвныг авчрахын төлөө эцсээ хүртэл залбирч, эцсээ хүртэл тулалдсан гэдэг үгийг хэлж байж л яваарай” гэж хэлснийг би хэзээ ч мартажгүй.

Тэрбээр мөн: “Хожим эргэж хараад, энэ харилцааг аврахын төлөө би чадах бүхнээ хийсэнгүй хэмээн халаглахгүй л байх хэрэгтэй. Чи үнэнийг хөсөрдүүлэлгүйгээр, хийж чадах бүхнээ хийсэн бөгөөд чамд өөр ямар ч сонголт үлдээгүй гэдгээ баттай болгож байж л яваарай” хэмээн нэмж хэлж билээ. Би энэ зөвлөгөөнд хязаргүй талархсан бөгөөд Бурханы цэц ухаан гэдгийг нь ойлгосон юм.

Есүсийн үгийг санаж байна уу?

Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй еэ!

Есүс “Амар тайвныг сахидаг хүмүүс ерөөлтэй” гэж хэлээгүй. Амар тайвныг сахидаг хүн эв найрамдлаа бодсондоо, үнэнийг хөсөрдүүлээд ч хамаагүй, асуудалтай нүүр тулахаас зайлсхийдэг. Гэхдээ түүний сахиад буй амар тайван нь жинхэнэ амар тайван бус, зуурдын, хуурамч, өнгөн амар тайван юм.

Харин амар тайвныг тогтоогч нь хайраар нүүрэлдэхдээ, урт настай эвлэрэл авчирдаг. Тэрбээр өнгөн, хиймэл харилцаа тогтоолгүй, нээлттэй байдал, үнэн, хайрыг хүсдэг. Тэрбээр төвийг сахисан инээмсэглэлээр гомдлоо далдлалгүй, бат бэх хайраар амар тайвныг тогтоодог.

Бурхан хүн төрөлхтөнд ингэж л ханддаг. Тэр хэнийг ч алдахыг хүсдэггүй боловч, харилцааны төлөө үнэнийг хөсөрдүүлэхгүй. Бурхан өнгөц нөхцөл дээр бус, бүрэн зориулалт дээр тулгуурлаж эвлэрэхийг хүснэ. Энэ нь ямар ч муу ёрын зүйл нь эвдэж гэмтээж чадахааргүй, хайрын холбоог хөгжүүлдэг. Тэрбээр бидний төлөө амиа өгсөн. Бид үүнийг дууриах ёстой.

Эцсийн дүгнэлт нь Бурханы хайр гэдгийг тогтоож ав. Энэ хайр хэзээ ч хөсөрдүүлэхгүй, хагдрахгүй, төгсөхгүй, өөрийгөө бодохгүй, амархан гомдохгүй (1Коринт 13:5).

Элч Паул хайр бүх нүглийг ялан дийлдэг гэж бичжээ.

Та нарын *хайр* жинхэнэ мэдлэг ба бүх ойлгоцоор *улам бүр бялхсаар байх болтугай* гэж би залбирдаг. Ингэснээр та нар Христийн өдрийг хүртэл цэвэр, гэм зэмгүй (*гомдолгүй*) байхын тулд аль нь сайн болохыг ялгах чадвартай болох юм. Ингэхдээ Бурханы магтаал болоод алдрын төлөө Есүс Христээр ирэх зөвт байдлын үр жимсээр дүүрэн байгтун. Филиппой 1:9-11

Гомдлын занганаас эрх чөлөөтэй явах түлхүүр нь Бурханы хайр болой. Энэ нь бидний зүрхэнд тасралтгүй өсч, хүчирхэгждэг, элбэг баян хайр байх ёстой.

Өнөөдөр манай нийгэмд үй олон хүн үйл хэрэггүй, зөвхөн ярьдаг, өнгөц хайранд хууртагдах. Тэгвэл биднийг бүдрэхээс хамгаалдаг хайр нь дайсныхаа сайн сайхны төлөө ч амиа хайрлалгүй зориулж чадна. Ийм хайр дотор явбал, Сатаны урхинд явж орох өдөөлтөнд өртөхгүй.

ЭПИЛОГИ

ҮЙЛДЭЛ БОЛГОХ

Энэ номыг уншиж байхад, Эзэний Сүнс танд өнгөрсөнд болоод өнөөдөр хэн нэгэнтэй эвдрэлцсэн харилцааг чинь сануулсан байх. Тиймээс таныг энгийн чөлөөлөлтийн залбиралд хөтлөн дагуулахыг Эзэн надад зааварлалаа.

Гэхдээ залбирахаасаа өмнө таныг өнгөрсөн амьдрал руу чинь хөтөлж, таны гомдсон хүмүүсийг сануулахыг Ариун Сүнснээс гуй. Ариун Сүнс тэднийг сануулж байхад, Түүний өмнө чимээгүй бай. Байхгүй хүнийг өөрөө хайх хэрэггүй. Ариун Сүнс танд эргэлзэхээргүй, тодорхой харуулна. Ингэх зуур та зовиураа эргэж санаж магадгүй. Гэхдээ битгий ай. Ариун Сүнс дэргэд чинь байж, тайтгаруулна.

Та тэднийг хийсэн хэргийнх нь ялаас чөлөөлөхдөө, нэг нэгээр нь бодож, нэг нэгээр нь уучлаарай. Тэдний өрийг хүчингүй болго. Тэгээд дараах залбирлыг хэлээрэй. Гэхдээ заавал доорх үгээр хязгаарлагдах хэрэггүй. Доорх залбирлыг чиглүүлэг болгоод, Бурханы Сүнсээр хөтлүүл.

Аав аа, намайг гомдоосон хүмүүсийг үл уучлахдаа, би Таны өмнө нүгэл үйлдэжээ. Би нүглээ гэмшиж, Танаас өршөөл гуйж байна.

Түүнчлэн Тангүйгээр тэднийг уучилж чадахгүй гэдгээ ч хүлээн зөвшөөрч байна. Тиймээс тэр хүмүүсийг чин зүрхнээсээ уучилмаар байна. [Хүмүүсийг нэг бүрчлэн тодорхойлж, нэг нэгээр нь чөлөөлж явуулаарай.]

Тэдний хийсэн бүх бурууг Есүсийн цусан дор тавьж байна. Тэд надад ямар ч өргүй. Миний өмнө үйлдсэн тэдний бүх нүглийг би өршөөж байна.

Тэнгэрийн Аав минь, Эзэн Есүс Өөрийнх нь эсрэг нүгэл үйлдсэн хүмүүсийг уучлахыг гуйсан шиг, миний эсрэг нүгэл үйлдсэн хүмүүсийг ч бас Та өршөөх болтугай.

Тэднийг ерөөж, тантай бүр ч илүү дотно харилцаатай болохын төлөө залбирч байна. Амень.

Одоо чөлөөлсөн хүмүүсийнхээ нэрийг дэвтэрт бичээд, тэднийг уучилсан огноогоо бич.

Та гомдлоос чөлөөтэй байхын тулд дасгалжих хэрэгтэй (Үүнийг ойлгохгүй байвал, 13-аар бүлгийг дахиж уншаарай). Тэдний төлөө яг өөрийнхөө төлөө залбирч байгаа юм шиг залбир. Дэвтэр чинь танд сануулна. Тархийг чинь элдэв бодол бөмбөгдсөөр байвал, Бурханы Үгээр тууж, уучлах шийдвэрээ мэдэгдсээр бай. Та Бурханы уучлах нигүүлслийг хүссэн бөгөөд үл уучлал нь Бурханы нигүүлсэл шиг хүчтэй биш. Зоригтой байж, итгэлийн сайн тэмцлээр тэмц.

Зүрх чинь хүчтэй бөгөөд тогтвортой гэдгийг мэдбэл, нөгөө хүмүүстэйгээ уулз. Та өөрийнхөө төлөө биш, тэдний төлөө эвлэрч байгаагаа бүү март. Үүгээрээ та ялалтыг тамгалж, ах дүүгийнхээ зүрх сэтгэлийг байлдан дагуулна (Матай 18:15). Энэ нь Бурханы мэлмийд тааламжтай болой.

Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, гэм зэмгүйгээр зогсоож чадах Түүнд, бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, ноёрхол, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амень.

Иуда 24-25

ЖОН БИВЭР

САТАНЫ ҮРХИ

ЧИМЭЭГҮЙ ЦАГИЙН МАТЕРИАЛ

АГУУЛГА

Оршил	182
Өдөр 1: Би ямар гомдчихоо юу?	183
Өдөр 2: Зүрхний жинхэнэ дүр төрх	185
Өдөр 3: Бөөн гомдол	187
Өдөр 4: Хамгаалалтын хана	190
Өдөр 5: Яахаараа надад ийм зүйл тохиолддог байна аа?	193
Өдөр 6: Бурхан үнэхээр бүхнийг хянадагуу?	195
Өдөр 7: Аавдаа гологдох үед	198
Өдөр 8: Миний өшөөг хэнавах юм бэ?	201
Өдөр 9: Сүнсний тэнүүлчид хэрхэн төрдөг вэ?	203
Өдөр 10: Суулгагдсан нь л цэцэглэнэ	206
Өдөр 11: Бодит байдлаас нуугдахуй	209
Өдөр 12: Өөрийгөө өмөөрөхүй	211
Өдөр 13: Бат суурь	214
Өдөр 14: Өөр сонголт байхгүй	217
Өдөр 15: Шигшигдэх ёстой бүхэн шигшигдэнэ	220

Өдөр 16: Даруу хүнд нигүүлсэл өгөгддөг	223
Өдөр 17: Гомдоогч хад	225
Өдөр 18: Тэднийг гомдоохгүйнтөлөө	228
Өдөр 19: Эрхээ хойш тавих	231
Өдөр 20: Уучлал: Өгөхгүй болавахгүй	233
Өдөр 21: Өстзарц	235
Өдөр 22: Өшөө авах: Энэ бол урхи	237
Өдөр 23: Хайран ханхүү	239
Өдөр 24: Урхинаас зайл	242
Өдөр 25: Нүүр тулсанаар л эдгэрнэ	245
Өдөр 26: Зорилго: Эвлэрэл	248
Өдөр 27: Гомдсон хүнээс уучлал гуйх	250
Өдөр 28: Таныг гомдоосон хүнтэй очиж уулзах	252
Өдөр 29: Дүгнэлт	254
Өдөр 30: Үйлдэл болгохуй	257

ОРШИЛ

Жон Бивэрийн “Сатаны Урхи” номын арав дахь хэвлэлд чимээгүй цагийн материал орж байгаа юм. Номыг унших явцад ойлгосон чухал үнэнийг чимээгүй цаг хийх явцад өөрийн болгож, өмнө нь тун амархан гомдож байсан урхинаас чөлөөтэй амьдрах болно гэж итгэж байна. Гомдлын асуудлыг шийдэх Бурханы арга замыг өөрийн болгоход тань бид туслах гэсэн юм шүү.

Чимээгүй цагийн материал нь дараах үүрэгтэй:

- Бурханы үгийг ойлгоход тань тусална.
- “Сатаны Урхи” номоос унших хэсэгт чиглүүлнэ.
- Эрүүл амьдралд хөтлөх амьдралын зарчим танилцуулна.
- Өмнөх гомдлын хүлээснээс чөлөөтэй амьдрахад тань тусална.

Чимээгүй цагийн энэ материал Сатаны урхи болох гомдлын асуудлыг Бурханы арга замаар шийдэхэд тань туслаасай хэмээн залбирч байна. Бурхантай, өөртэйгээ, гэр бүлтэйгээ, сүм чуулгантайгаа, найз нөхөдтэйгээ, ажлынхантайгаа, ангийнхантайгаа- дайсагнасан харилцаа бүрт тань Бурханы амар тайван ирэх болтугай!

ӨДӨР 1

БИ ЯМАР ГОМДЧИХОО ЮУ?

“Эзэний боол тэмцэл мөргөлдөөнд оролцох ёсгүй. Харин бүх хүнд эелдэг зөөлөн ханд. Заах чадвартай, буруудахад тэвчээртэй байж, зөрөлдөгсдийг төлөв байдал дотор засаж бай. Хэрэв магадгүй Бурхан тэдэнд үнэний мэдлэгт хүргэх гэмшлийг соёрхвол тэд ухаан орж, диаволын торноос чөлөөлөгдөх буй. Учир нь диавол өөрийн хүслээр тэднийг хөдөлгөхийн тулд тэднийг олзлон авсан байжээ.”

2Тимот 2:24-26

Урхи тавьж ан хийдэг хүн бүр, урхи нь далд бөгөөд тухайн амьтны анхаарал татах өгөөштэй байвал амжилттай болно гэдгийг мэддэг.

Гомдол, шарх, сэтгэлийн хөндүүрээсээ болоод олон хүн Бурханы дуудлагын дагуу зүй зохистой үйлчилж чаддаггүй.

Дайсан болох Сатан, гомдлын зальтай бөгөөд үхлийн урхиндаа биднийг оруулсаар л байдаг. Түүний урхи далд бөгөөд өгөөштэй. Тэр өөрийн цэргүүдийн хамт хор найруулах ажиллагаагаа олон хүний боддог шиг ил биш харин далд, зальжин бөгөөд овжин хийдэг.

Түүний хамгийн түгээмэл аргатай итгэгч бүр нүүр тулдаг. Энэ бол гомдол юм. Хэрэв бид гомдохыг сонгож, дотроо тээж, тэжээж, өсгөх юм бол гомдлын үр жимс бий болдог.

Гомдлын үр жимсийг дор жагсаан бичив. Бусдад гомдох үед төрдөг мэдрэмжээ дугуйлна уу:

Шархлах	Атаархах	Зөрчилдөх
Уурлах	Хардах	Хорсох
Доромжлох	Өс санах	Үзэн ядах

Сэтгэлдээ шарх, гомдолтой хүний хувьд Бурханы хүслийн дагуу эрүүл зөв явахад тун хэцүү байдаг. Учир нь бүрэн нөөц бололцоогоороо ажиллахад сэтгэлийн ийм байдал саад болдог аж. Нэг Эзэнтэй итгэлийн ахан дүүсээсээ гомдол авах үед Давидын адил “Учир нь энэ бол намайг доромжилдог миний дайсан биш билээ. Тийм байсан бол би тэсэхсэн. Мөн энэ нь миний эсрэг өөрийгөө өргөмжилдөг намайг үзэн ядагч ч биш. Тийм байсан бол би түүнээс нуугдахсан. Гэвч энэ бол надтай нэг зиндаатай хүн болох чи, миний анд нөхөр бөгөөд миний дотнын найз билээ. Бид хамтдаа амттай яриа дэлгэж, Бурханы өргөөнд олон хүмүүсийн дундуур алхаж байсан” гэж хэлдэг.

Таныг гомдоосон таван хүний нэр бичнэ үү (Нэг нь хамгийн ойр байсан, бусад нь холын харилцаатай байсан хүн байвал сайн).

1. _____
2. _____
3. _____

Гомдсон хүний сэтгэл өвдөж, бодол нь балартдаг. Бусдыг хардалт, таамаг, үзэмж, сонссон үгээрээ шүүдэг. Гомдлоос болж нүд сохолсон Сатаны урхинаас хэрхэн чөлөөлөгдөхийг та энэ номоос сурна.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Сатаны урхинаас чөлөөтэй амьдрах мэрхэн ухаан хүсч залбираарай.

ӨДӨР 2

ЗҮРХНИЙ ЖИНХЭНЭ ДҮР ТӨРХ

Хэдийгээр та нар эдүгээ түр зуур шаардлагатай бол элдвийн зовлонг эдэлж байгаа ч гэсэн үүндээ үлэмж баярладаг.

Ингэснээр та нарын итгэлийн шалгуур нь галаар шалгах боловч мөхөх алтнаас ч илүү үнэтэй байн, Есүс Христийн илчлэлт дээр магтаал, алдар, хүндэтгэлд хүрэх юм.

1Петр 1:6-7

Гомдсон хэвээр байлгахын тулд зүрхийг нь бардам байлгах нь дайсны гол арга юм. Бардам зан бодит байдлыг үгүйсгэж, өөрийгөө хохирогч болгон харагдуулахад хүргэдэг. Учир нь гомдсон хүн, өөрт нь шударга бусаар хандсан гэж итгэсэн учраас, уучлахаас цааргалдаг. Та сэтгэлийнхээ үнэн төрхийг харахгүй байгаа ч Бурхан харж л байгаа. Шударга бусын золиос болсон ч энэ нь бусдыг уучилж болохгүй гэсэн үг биш юм. Учир нь хоёр буруу зүйл нэг зөвийг бий болгохгүй.

Алтыг галаар цэвэршүүлдэг (Илчлэлт 3:18). Алт бусад металтай холилдоход хатуу, уян хатан бус, мөн амархан өнгөө алддаг. Харин галаар төөнөхөд бусад метал хайлж, алт илүү уян хатан цэвэр болдог.

Шударга бусын золиос болсон ч энэ нь бусдыг уучилж болохгүй гэсэн үг биш юм.

Учир нь хоёр буруу зүйл нэг зөвийг бий болгохгүй.

Бидний зүрх сэтгэлийн байдал ч мөн үүнтэй адил. Гомдол тээсэн зүрх бардамнан хатуурхаж Бурханы хүслийг эсэргүүцэн байдаг. Бидний зүрх цэвэр байгаасай гэж Бурхан хүсдэг.

1Петр 1:6-7-г уншиж, Бурхан биднийг хэрхэн цэвэршүүлдэгийг өөрийн үгээр бичнэ үү:

Бурхан зовлон, сорилт, хүнд хэцүү байдлаар бидний зүрхэнд буй үл уучлал, уур, атаархал, хардалтыг салгаж өөрийн мөн чанарыг бидний дотор бий болгож цэвэр ба ариун байдалд биднийг төлөвшүүлдэг.

Та амьдралаа бод доо. Бурханы хүсэлд нийцтэл төлөвшихөд тань саад болж буй ямар цэвэр бус зан чанар таны амьдралд байна вэ?

Аливаа юмыг үнэн зөв харах нь эрх чөлөөтэй болохын эхлэл гэж Есүс хэлжээ. Бусдад гомдсон бид өөрийгөө зөвтгөж, бусдыг буруутгадаг. Өөрт төрсөн бүхий л буруу бодлоо бусдын буруугаас болсон гэж бид боддог. Харин Есүс, “харахын тулд нүдээ тослох нүдний тосыг Надаас худалдан ав” гэж зөвлөснийг санаарай (Илчлэлт 3:18).

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бусдыг буруутгаж байсан нүглээ гэмшиж, нүдийг тань нээж зүрх сэтгэлийнхээ бодит төрхийг харахын төлөө залбираарай.

БӨӨН ГОМДОЛ

Яагаад гэвэл өөрийнхөө махан биед таригч нь махан биеэсээ ялзралыг хурааж авна. Харин Сүнсэнд таригч нь Сүнснээс мөнх амийг хурааж авна. Сайныг үйлдэхдээ зүрхшээхгүй байцгаая. Учир нь хэрэв бид шантрахгүй байвал цаг нь болохоор хурааж авна.

Галат 6:8-9

Есүс удахгүй ирнэ гэдэгтэй олон хүн санал нийлдэг. Гэхдээ яг хэдэн оны хэдэн сарын хэдэнд ирэхийг тодорхойлох гэж оролдох нь утгагүй юм. Учир нь хэзээ ирэхийг нь зөвхөн Бурхан Аав л мэднэ. Гэхдээ Есүс ирэх үеийнхээ шинжүүдийг хэлсэн болохоор тэр цаг нь ойрхон гэдгийг бид мэднэ. Чуулганд ч, Израильд ч, байгаль дэлхийн талаар эш үзүүлсэн үгс биелсэн ийм цаг үед л бид амьдарч байна. Есүсийг ирэхээс өмнө “олон хүн бүдрэх” буюу гомдоно гэж хэлсэн. Амархан гомддог тийм хүнийг та мэдэх үү? Эсвэл та өөрөө тийм үү?

Бусдыг хайрлах бүрт би Сүнсэнд үр тарьж байгаа болохоор, цаг нь болохоор хайрын ургац хүлээн авахаа би ойлгосон юм.

Дараах асуултад өөрийн байр сууриа илэрхийлж тохирох хэсэгт “х”-ээр тэмдэглээрэй:

Итгэгчид их гомдомхой юм шиг санагддаг

Ер нь тийм

Хааяа

Би амархан гомддог

Ер нь тийм

Хааяа

Найзууд минь амархан гомддог юм шиг санагддаг

Ер нь тийм Хааяа

Ажлынхан амархан гомддог юм шиг санагддаг

Ер нь тийм Хааяа

Хамаатнууд амархан гомддог юм шиг санагддаг

Ер нь тийм Хааяа

Хэрэв “Ер нь тийм” гэдэг дээр “х” тэмдэг илүүтэй байвал энэ цаг үед хүмүүс ямар амархан гомддог болсныг та харах болно. Харин итгэгчдийн хувьд, Бурханы хайраар дүүрч, Түүний хайрын үрийг тарьж, гомдлын урхинаас өөрийгөө чөлөөтэй байлгах хэрэгтэй юм.

Бусдыг хайрлах бүр Сүнсний үр жимс болох хайрын үрийг бусдын амьдралд тарьж байгаа юм гэдгийг би ухаарсан юм. Хэзээ яаж энэ хайр ил болохыг мэдэхгүй ч хэзээ нэгэн цагт хайрын ургац ил гарах л болно. Хайрын хариу буцаж ирэхгүй болохоор урам минь хугардаг байснаа больж харин улам л ихээр бусдыг ямар нэг хариу нэхэлгүйгээр хайрлах болсон юм.

Харин бид хайрласны хариугаа авах гэж бэртэгчин зан гаргах үед дандаа гомддог. Хайрын хариуд хүссэн ямар нэг үйлдэл, хандлага нь үнэндээ биднийг гомдолд хөтлөх хавх болж байдаг. Хэдий их горьдлого тавина, төдий хэмжээгээр гүн гомдоно.

1-ээс (хамгийн бага) 5-ын (хамгийн их) хооронд дүн тавих байдлаар өөрийн хандлагыг тодорхойлно уу (хариултаа дугуйл).

Бусдад горьдлого их тавьдаг	1	2	3	4	5
Амархан урам алддаг	1	2	3	4	5
Нөхцөлтэйгээр хайрладаг	1	2	3	4	5
Ерөөгдөхийн тулд ерөөдөг	1	2	3	4	5

Дугуйлсан тоогоо хооронд нь нэмээд хэрэв 10-аас илүү гарч байвал

гомдол таны амьдралд томоохон байр суурь эзэлж байна гэсэн үг.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бусдаас горьдож ихийг хүсэх биш харин нөхцөл тавилгүй хайрлах хайрыг зүрхэнд тань Бурхан өгөхийн төлөө залбираарай.

ӨДӨР 4

ХАМГААЛАЛТЫН ХАНА

Учир нь бидний байлдааны зэвсэг бол махан биеийнх биш, харин цайзуудыг эвдэж нураах Бурханы хүчит зэвсгүүд юм. Бид цэцэрхэл болон Бурханы мэдлэгийн эсрэг босогч аливаа өндөрлөг зүйлийг устгаж, ямар ч бодол санааг Христийн дуулгавартай байдалд олзлуулдаг.
2Коринт 10:4-5

Гомдсон ах дүүгийнхээ сэтгэлийг олж авах нь бэхлэгдсэн хотыг эзлэхээс ч хэцүү. Хотын эргэн тойронд буй хана хотын аюулгүй байдлын баталгаа болж байдаг. Урилгагүй зочид, дайснаас энэ хана хамгаалдаг.

Махан бие минь бус харин зөвхөн Бурхан л гомдлоос хамгаалах тийм байр сууринд бид хүрэх ёстой.

Хэн нэгэнд гомдсон хүн, ирээдүйд ирж болох дараагийн гомдлоос шархалсан зүрхээ хамгаалахын тулд хана хэрэм босгодог.

Өөрөө өөртөө хана хэрэм босгосон эсэхийг мэдэхийг хүсч байвал ✓ тэмдгээр тэмдэглэнэ үү:

- Шилж сонгож хүнтэй харилцах
- Тийм ч нээлттэй бус, бусдад хаалттай байх
- Дотносохоос шархлахаас айх
- Бодол санаагаа нуух
- Зөвхөн өөрийн тал гэж бодсон хүмүүстээ л нээлттэй байх

Бусдаас өөрийгөө хамгаалж босгосон хана хэрэм маань биднийг хамгаалах бус харин бусадтай эрүүл саруул харилцаа байгуулах боломжгүй шорон болон хувирсан байдаг. Бид өөрсдийгөө л боддог, дотогшоогоо болдог. Байдаг л хүчээ ямар нэг шарх авчих вий гэдэгт зарцуулдаг. Хэрэв бид ямар ч шарх авахгүй атлаа бусдыг нөхцөл тавилгүй хайрлана гэвэл энэ боломжгүй. Нөхцөл тавилгүй хайрлах нь бусдад өөрийг тань гомдоох боломж олгож буй хэрэг.

Таныг гомдоох эрхтэй хүмүүсийн нэрсийг бичнэ үү. Мөн таны бий болгосон хананы цаана байгаа хүмүүсийн нэрсийг бичнэ үү.

Намайг гомдоох эрхтэй хүмүүс:

Хананы цаана байгаа хүмүүс:

Гомдсон хүн өөрийгөө зөвтгөх Библийн ишлэлийг тун амархан олдог ч, тэдгээр үгс нь үнэндээ сайтар шүүн тунгаагаагүй үгс байдаг. Хайр үгүй Бурханы үгийн мэдлэг нь аюултай зэвсэг болдог. Мэдлэг нь ихэрхэг болгодог (1Коринт 8:1-3). Нүглээ хүлээн зөвшөөрч гэмшихээс илүүтэй, энэ мэдлэг биднийг өөрийгөө л өмгөөлөх зэвсэг болдог.

Хайр үгүй Бурханы мэдлэг нь мэхлэгч чанартай болдог. Хуурамч эш үзүүлэгчдээс үүнийг тодорхой харж болно. Есүс “Олон хуурамч эш үзүүлэгчид гарч ирж олныг төөрөлдүүлнэ” (Матай 24:11) гэж хэлсэн. Өндөр, аюулгүй хана хэрэм дотроо хайр нь хөрсөн тэдгээр хүмүүсийг л тэд мэхлэнэ (Матай 24:12).

Бусдыг хохироон байж өөрийгөө өмгөөлөн хамгаалахын нэг хэлбэр нь урвалт юм. Урвалт бол гэрээгээ хөсөр хаяж буйн хэлбэр. Урвасан хүн үнэн голоосоо гэмшиж харилцаагаа сэргээхээс нааш тэр харилцаа дахин сэргэхгүй.

Өөрийгөө гомдлоос хамгаалахын тулд махан биедээ биш харин Бурханд итгэх тийм л төвшинд бид хүрэх ёстой. Гомдох

нь ноцтой нүгэл. Хэрэв гомдлын асуудлаа шийдэхгүй бол энэ нь үхэлд ч хүргэж мэдэх юм. Гомдлын хана байгуулах өдөөлтийг эсэргүүцвэл Бурхан таны амьдралд аугаа ялалтыг авчирна.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Гомдлоос болж босгосон алив ханыг нурааж, алив гомдлоо Эзэний өмнө гэмшээрэй.

ЯАХААРАА НАДАД ИЙМ ЗҮЙЛ ТОХИОЛДДОГ БАЙНА АА?

Иосеф тэдэнд хандаж

*Та нар намайг хорлох гэсэн боловч Бурхан
өнөөдрийнх шиг үй олон хүний амийг аврахын төлөө
түүнийг сайнаар эргүүлсэн юм
Эхлэл 50:19-20*

Гомдогсдыг хоёр бүлэгт хувааж болно: үнэхээр бусдын буруугаас болж гомдсон хүн, эсвэл бусад хүн намайг гомдоосон гэж бодож явдаг хүн. Бусдын буруугаас болж гомдлоо гэхэд, танд гомдох эрх байгаа гэж үү? Таныг санаатайгаар гомдоосон үйл явдлыг эргүүлээд нэг бод доо. Та тэр үйл явдалд хэрхэн хандав? Сэтгэлийг тань шархлуулсан учраас та гомдсон уу? Эсвэл та ер нь гомдомхой хүн үү?

Дараах жагсаалтыг хараад гомдолд хандах өөрийн хариу үйлдэлдээ 1-ээс 5-ын хооронд дүн тавина уу. 1 нь гомдомхой тал руугаа харин 5 нь тийм ч амархан гомдохгүй гэх байдлаар ойлгоорой.

- Би уурладаг
- Би шууд уучилдаг
- Би гөждөг
- Би уучлахын тулд бүхий л чадлаараа оролддог
- Тэр хүнээс зайгаа авдаг
- Эвлэрэхийн тулд хичээдэг

Хэрэв гомдомхой гэсэн тал руугаа илүү их хэлбийж байвал бусад хүн танд муухай хандах үед гомдох нь миний эрх гэж та өөрийгөө өмгөөлдөг хүн юм байна. Харин та заавал гомдож хандах албагүйг анхаарна уу.

Иосефийн түүхийг (Эхлэл 37-48) уншаарай. Иосефийн үг, үйлсийг та хэрхэн үнэлж байна вэ?

Гомдож болох нөхцөл бүрт Иосефийн үзүүлж буй харцу үйлдлийг та “х” гэж тэмдэглээрэй.

Тэр гомдсон

Тэр уучилсан

Тэр бусдыг буруутгасан

Тэр Бурханд найдсан

Тэр өс хонзон санасан

Тэр эвлэрэлийг хүссэн

Хэрэв та Иосефийн оронд байсан бол гомдолд хэрхэн хандах байсан бэ? Та өөрийгөө гомдох бүрэн эрхтэй гэж бодсоор байх уу?

Өгөөшийг нь үмхэж урхинд нь орчихвол насан туршдаа бид түүнийх болчихно гэж Сатан найддаг.

Хэрэв дуртай цагтаа бидний амьдралыг сүйрүүлэх хүч сатанд байдаг бол тэр аль хэдийнээ сүйрүүлчих л байсан. Өгөөшийг нь үмхэж урхинд нь орчихвол насан туршдаа бид түүнийх болчихно гэж Сатан найддаг. Тэр бидний бүхий л харилцааг устгаж Бурханаас салгахыг хүсдэг. Өгөөшийг нь үмхэхгүй л бол Сатан танд хүрч ч чадахгүй! Тийм учраас өгөөшийг нь бүү тоо!

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Өөрийгөө бусдын хохирогч болголгүй, Бурханд найдаж, гомдлын урхинаас өөрийгөө хол байлгасан Иосеф ишг мэргэн байхын төлөө залбиръя.

БУРХАН ҮНЭХЭЭР БҮХНИЙГ ХЯНАДАГ УУ?

Та нар намайг энэ газар худалдсандаа бүү санаа зов, бүү харамс. Бурхан амийг аврахаар та нараас өмнө намайг илгээжээ ... Бурхан их авралаараа та нарыг амьд үлдээж, үр удмыг чинь газар дэлхий дээр уламжлуулан үлдээхээр та нараас өмнө намайг илгээжээ. Тийм учраас намайг нааш нь та нар явуулаагүй, харин Бурхан явуулсан. Бурхан намайг Фараоны эцэг, түүний бүх гэрийн эзэн, Египетийн бүх нутгийн захирагч болгосон билээ.

Эхлэл 45:5, 7-8

Шоронд байхдаа, хожим нь Египетийг захирна чинээ бодоогүй л явсан байх, Иосеф. Гэхдээ амьдралынхаа бүхий л өдрүүдэд тэр л өндөрлөгийн төлөө Бурханаар бэлтгэгдэж байсан юм. Итгэгч бүрийн амьдралд хандсан төлөвлөгөө Бурханд бий. Тэр үнэндээ бүхнийг хянаж байдаг. Эцсийн эцэст тэр өндөрлөгт хүрэхийн өмнө ах нартаа, Потифарт, болон амьдарч байсан нөхцөлдөө хандах Иосефийн хандлага л их чухал байлаа. Тэр бүгдийг буруутгаж болох байв. Асуудлын бурууг бусдад чихэх амархан. Заримдаа хүнгүй газар байсан ч бол амар байхсан гэж бодогдох.

Гэвч Бурханаас өөр хэн ч таны ирээдүйг мэдэхгүй. Эрэгтэй, эмэгтэй хүн, ил далдын ямар ч хүч танд хандсан Бурханы хүслээс таныг холдуулж чадахгүй.

Эрэгтэй, эмэгтэй хүн, ил далдын ямар ч хүч танд хандсан Бурханы хүслээс таныг холдуулж чадахгүй.

Бурханаас Иосефийн авсан мөрөөдлийг нь устгачихлаа даа гэж ах нар нь бодсон байж магадгүй л дээ. Гэхдээ тэд чадаагүй юм. Ах нартайгаа эргэж эвлэрэх үед, тэд биш харин Бурхан энэ бүхний ард байсан юм гэдгийг Иосеф хэлдэг.

Эхлэл 45:5-8 болон Дуулал 105:16-17-г уншина уу. Иосефийг ямар учраас хүнд замаар дагуулж явсаныг тэмдэглээрэй.

Бурхан Иосефийг _____ руу илгээсэн
(Эхлэл 45:5).

Бурхан Иосефийг _____ руу илгээсэн
(Эхлэл 45:7).

Бурхан Иосефийг _____ руу илгээсэн
(Эхлэл 45:8).

Бурхан Иосефийг _____ руу илгээсэн
(Дуулал 105:16-17).

Өнгөрсөн жил таны амьдралд тохиолдсон хүнд хэцүү үеэ нэг өгүүлбэрээр бичнэ үү:

Одоо бүрэн өгүүлбэрээр бичнэ үү:

Асуудалдаа би _____ хандаж байв.

Харин Бурханы төлөвлөгөө _____ байв.

Эндээс би өөрийнхөө талаар _____ сурав.

Хэрэв та гомдлоос чөлөөтэй байвал Бурханы төлөвлөгөөн дотор байсаар л байгаа гэдгээ ойлгоорой. Харин гомдвол дайсныхаа олз болж түүний хүслээр амьдарна гэсэн үг. Тиймд

сонголтоо мэргэн хийгээрэй. Та алийг нь сонгов?

Бурханд өөрийгөө даатга. Гомдол тээлгүй амьдарч, чөтгөрийг эсэргүүц. Бодсоноос чинь өөрөөр Бурханы төлөвлөгөө хэрэгжиж болох ч Бурхан хэзээ ч амлалтаасаа буцахгүй. Бурханы хүслийг таслах гол зам нь дуулгаваргүй байх юм.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Амьдралд тань хандсан Бурханы төлөвлөгөө байгаад талархаж, таны нөхцөл байдлыг эерэгээр эргүүлж байгаад талархан залбираарай!

ААВДАА ГОЛОГДОХ ҮЕД

Тэрээр эцгүүдийн зүрхийг хүүхдүүд уруу нь, хүүхдүүдийн зүрхийг эцгүүд уруу нь эргүүлнэ. Эс бөгөөс Би ирж, энэ нутгийг хараалаар цохино.

Малахи 4:6

Ах дүүдээ гологдож хаягдах нэг хэрэг, аавдаа гологдож хаягдах тэс өөр мэдрэмж. Аав гэхээр төрсөн ааваас гадна Бурханы хаанчлалд биднийг удирдахаар дээр байх сүнслэг эцгүүдийг гэж бас ойлгоорой. Биднийг хайрлаж, сургаж, халамжилж, дэмжихээр тэд байдаг.

Аавдаа гологдож эсэргүүцэлтэй тулж байсан үе танд байсан уу?

Таныг гомдоож байсан хүмүүсийг дугуйлна уу:

Төрсөн аав

Хойд аав

Пастор

Чуулганы ажилтан

Чуулганы ахлагч

Захирал

Чуулганы туслагч

Багш

Удирдагч

Эцэг мэт анд

Бусад _____

Аавдаа гологдож эсэргүүцэлтэй тулж байсан Библийн нэгэн жишээ бол Саул хаан ба Давидын жишээ юм. “Сатаны урхи” номын 48-52-р хуудсыг анхааралтай уншина уу.

Унших явцад, Давид өөрт төрсөн мэдрэмжийн дагуу Саулаас өс хонзонгоо авах ямар боломж байсныг тэмдэглээрэй.

Одоо өгүүлбэрээ бүрэн бич:

Давид Саулд _____ хандсан.

Өс хонзонгийн оронд Давид _____ хандсан.

Эцэг нь, зөвлөгч нь, хаан нь байсан Саул өөрт нь муухай хандахад Давид өс хонзон санасангүй. Харин Саул хаан өөрөө Давидыг хардаж, түүнд хар буруу санаж байв. Дор нь ажиллаж буй хүнд Саул шиг хардангуй ханддаг удирдагч өнөөдөр бишгүй их бий. Тэд Саулын нэгэн адил өөрийн дуудлага байр сууринд итгэлгүй, дотроо сул дорой, хардаж сэрдсэн нүдээр хүмүүсийг хардаг. Тэд бусдын доторх бурханлаг чанаруудыг тун гярхай ажигладаг ч өөртөө ашигтай л байвал тэднийг үйлчлэлдээ ашиглаад л явдаг. Давидын амжилтад Саул хөөрч байсан ч, энэ амжилт өөрт нь аюултайг мэдэх үед баярлахаа зогсоосон юм. Тэр цагаас хойш Саул Давидыг хөөж туун, амь насанд нь заналхийсэн.

Хэрэв эцэг мэт хүн, удирдагч тань ямар нэг нүгэлт муу зүйл хийж байвал гомдол тээхээсээ илүү түүний төлөө залбирч яваарай.

Танд Саул шиг хандаж байгаа эцэг мэт байр сууринд байгаа хүн бий юу? Байвал хэрхэн хандах ёстой талаар Бурхан юу хэлэв?

1 Самуел 24:11-ийг уншиж өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү:

Хэн нэгэн над руу дайрвал, Бурхан намайг тэр хүнд _____

_____ гэж хандаасай гэж хүсдэг.

Хэн нэгэн намайг голж эсэргүүцэхэд, Бурхан намайг тэр хүнд

гэж хандаасай гэж хүсдэг.

Хэрэв эцэг мэт хүн, удирдагч тань ямар нэг нүгэлт муу зүйл хийж байвал гомдол тээхээсээ илүү түүний төлөө залбирч яваарай. Бурхан өөрөө тэр хүнийг засч хүмүүжүүлнэ. Удирдагчаа засах нь таны биш, Түүний хийх ажил. Гомдол тээхээс үргэлж зайлсхий.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Таны хувьд сүнслэг эцэг мэт хүнд гомдсон гомдол байх аваас уучилж, түүний төлөө залбирлаа Бурханд өргөөрэй.

МИНИЙ ӨШӨӨГ ХЭН АВАХ ЮМ?

*Хайртууд минь, хэзээ ч өөрийн өшөө хонзонг бүү ав.
Харин Бурханы уур хилэнд зай гарга.
Учир нь «Өшөө авалт нь Минийх,
Би буцааж төлнө» гэж Эзэн айлдав» гэж бичигджээ.
Ром 12:19*

Өөрийг нь алж болох байсан ч алаагүй үйлдлийг нь хараад Саул, Давид өөрт нь муу санаагүйг ойлгосон юм. Харин Давидын хамтрагч Абишай Давид шиг нигүүлсэнгүй биш байв. Давид Абишай хоёр Саулын хуаранд нэвтэрч ороход Саул унтаж байв. Үүнийг харсан Абишай “Бурхан таны гарт дайсныг чинь өгчээ. Түүнийг газартай нь сүлбэж алчихъя. Би ганц л зоолтоор гүйцэтгэнэ!” гэж Давидад хэлдэг. Абишай Давидад татгалзахын аргагүй санал тавьжээ.

Дараах жагсаалтыг хараад Саулын ямар үйлдэл түүнд цаазын ял авчрах нь ойлгомжтой гэж бодож байгаагаа ✓ тэмдэглээрэй.

1. Саул гэм зэмгүй 85 тахилчийг гэр бүлийнх нь хамтаар хүйс тэмтэрсэн (олон төрлийн аллага үйлдсэн үйлдэлтэй)
 Үхэх ёстой Амьдрах ёстой
2. Саул 3000 эрчүүдийн хамтаар Давид болон түүний эрчүүдийг устгахын тулд боломжтой бүхнийг хийж байсан (аллага үйлдэхийг завдсан олон удаагийн үйлдэл)
 Үхэх ёстой Амьдрах ёстой

3. Хаанчлах эрх нь Саулаас авагдаж, Давидад очсон байсан ч Саул хаан ширээнд суусаар л байсан.

Шийтгүүлэх ёстой Амьдрах ёстой

4. Саул Давидын талаар хүмүүст худал ярьж, Давидын эсрэг хүмүүсийг чиглүүлж Давидад амласан энхийн гэрээг зөрчиж байв.

Шийтгүүлэх ёстой Амьдрах ёстой

Саул нүглийнхээ төлөө алуулдаггүй юмаа гэхэд шийтгүүлэх ёстой. Харин 1Самуел 26:9-11-д тэмдэглэгдсэн, Абишайд хариулсан Давидын үгийг анхааралдаа авна уу. Түүнд өс хонзонгоо авах бүрэн эрх байсан ч Саулыг алах нь бүү хэл, шийтгэх хүсэл Давидад огтхон ч байхгүйг та харлаа. Өнөөдөр хичнээн хүн Давид шиг зүрх сэтгэлтэй бол?

***Ахан дүүсийн дунд хагарал, бутралын үрийг таригч нь
Эзэний хувьд жигшүүртэй юм.***

Хайр нь хөрч, ичгүүргүй жигшүүрт үгээр бие биеэ гомдоон чичлэх үгээр чуулганд хагарал, гэр бүлд салалт, гэрлэлтэд хуваагдал бий болсоор байна. Хорсол уур хилэнтэй үгээрээ зарим хүн найз нөхдөө, гэр бүлээ гомдоодог. Хэдийгээр зарим хүний ярьж байгаа үг баримт нь үнэн, зөв байсан ч сэтгэлийн хандлага нь цэвэр бус байснаас болоод сэтгэлд шарх авчрах нь бий. Ахан дүүсийн дунд хагарал, бутралын үрийг таригч нь Эзэний хувьд жигшүүртэй юм (Сургаалт үгс 6:16-19).

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Таныг гомдоосон алив хүний өмнө даруу байхыг Эзэн заан сургаж, уучлах сэтгэл өгөхийн төлөө залбираарай.

СҮНСНИЙ ТЭНҮҮЛЧИД ХЭРХЭН ТӨРДӨГ ВЭ?

Тэрээр хүмүүстээ

—ЭЗЭН байгаа тул, ЭЗЭНий тосолсон өөрийн эзэнд би ийнхүү хандан, тэр ЭЗЭНий тосолсон хүн тул түүний эсрэг гараа сунгасан ийм хэрэг надаас хол байг хэмээн өгүүлэв. Давид ингэж өгүүлээд хүмүүсээ ятган, Саул уруу дайрахыг тэдэнд зөвшөөрсөнгүй. Саул ч босож, агуйгаас гарч, замдаа гарав.

1Самуел 24:6-7

Саул Давид хоёрын харилцаанд Бурхан Давидын зүрхийг шалгаж байв (1Самуел 24:6-7). Саулыг хөнөөж өөрийн хаанчлалаа байгуулах нь уу эсвэл Бурханаар мөнхийн хаан ширээгээ байгуулах нь уу гэдгийг Бурхан харж байв.

Зөвхөн Бурхан л үнэн зөвийг шүүж, өс хонзон авах бүрэн эрхтэй. Ром 12:19-д “Хайртууд минь, хэзээ ч өөрийн өшөө хонзонг бүү ав. Харин Бурханы уур хилэнд зай гарга. Учир нь «Өшөө авалт нь Минийх, Би буцааж төлнө» гэж Эзэн айлдав» гэж бичигджээ. Бурханы бүрэн эрхэд халдаж Түүний өмнүүр орж болохгүй. Зөв зүйлийг буруу арга замаар хийх нь буруу юм.

Саул хийсэн үйлийнхээ хариуд шийтгүүлэх ёстой. Гэхдээ энэ ажлыг Давид биш Бурхан хийх ёстой.

Танд Бурханыг хүлээлгүй, өс хонзонгоо авах гэж өөрөө шийдэж байсан үе байсан уу? Яг юу болсон, ямар үр дүн гарсан?

Ноцтой буруу юм хийдэг, тэр ч бүү хэл ёрын удирдагчдын дор Бурхан яагаад хүмүүсийг байлгаад байдаг юм бол гэж заримдаа танд бодогдож байсан байх (1Самуел 1-5-д жишээ нь бий). Гэм зэмгүй бяцхан Самуел хүүг, Израилийн хамгийн завхарсан тахилчийн удирдлага дор Бурхан тавьж байв. Самуел тэнд л хүнд биш, Бурханд бүрэн найдаж, Түүнийг шууд сонсохыг сурсан юм. Бурхан өөрөө ялзарсан удирдагчтай тооцоо боддог болохыг тэр тэнд л сурсан.

Тухгүй, дарамттай газар Бурхан биднийг байлгахдаа тэнд л Түүний хайрыг зааж өгдөг. Хэрэв бид гомдол өвөртөлж тэр газраас явбал бидэнд хандсан Бурханы ажил зогсдог. Ийм байдлаар гомдол дээр гомдол нэмэгддэг. Гомдсон хүн гомдмоор нөхцөлд Бурханаас биш атлаа зөв юм шиг харагдмаар үйлдэл гаргадаг. Бид аливаа хүн, нөхцөл байдалд цочмог хандахаас илүү Бурханы хүсэлд дуулгавартай хандах учиртай.

***Тухгүй, дарамттай газар Бурхан биднийг байлгахдаа
тэнд л Түүний хайрыг зааж өгдөг.***

***Хэрэв бид гомдол өвөртөлж тэр газраас явбал
бидэнд хандсан Бурханы ажил зогсдог.***

Хүнд нөхцөлд орохдоо энэ байдлын талаар Бурханы хэлж буй үгэнд анхаарлаа хандуулахад шийдэл тайвшрал ирдэг билээ. Харин тэдгээр хүнд байдлаар Бурхан биднийг устгах гэж биш, харин биднийг төлөвшүүлж, хүчтэй болгож, улам чанаржуулдаг.

Дараах асуулгыг өөрөөсөө асууна уу:

1. Намайг чанаржуулах гэж буй Бурханы дарамтаас би зугтаадаг уу?

Тийм

Үгүй

2. Дарамтанд орохдоо би гомдоллодог уу?

Тийм

Үгүй

3. Би нүглээ өмгөөлж, бусдын нүглийг чичилдэг үү?

Тийм Үгүй

4. Миний сул талыг сүнслэг удирдагч нар маань хүчтэй болгохыг би зөвшөөрдөг үү?

Тийм Үгүй

5. Бурханы дуу хоолойг сонсохын тулд Түүнийг би хүлээдэг үү?

Тийм Үгүй

6. Исаиа 55:12-ыг уншина уу. Би амар тайвнаар явахыг хүсч байна уу?

Тийм Үгүй

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Есүс таны төгс Хоньчин юм. Таны амьдралд хоньчин мэт үүргийг гүйцэтгэж буй сүнслэг удирдагчдаар дамжуулаад төгс Хоньчин Есүс хайраа таны амьдралд дүүргэхийн төлөө залбираарай.

СУУЛГАГДСАН НЬ А ЦЭЦЭГЛЭНЭ

ЭЗЭНий өргөөнд суулгагдсан

Тэд бидний Бурханы хашаануудад цэцэглэнэ.

Тэд хөгширсөн ч жимс гаргана.

Тэд шүүслэг ба ногоон байна.

Энэ нь ЭЗЭН шулуун шударга гэдгийг тунхаглахын тулд юм.

Тэр бол миний хад бөгөөд Түүн дотор

шударга бус юм гэж үгүй.

Дуулал 92:13-15

Зарим хүн чуулганаас чуулганд, үйлчлэлийн нэг багаас нөгөөд шилжин өөрийн үйлчлэлээ хөгжүүлэх гэж явдаг. Тэдний чадварыг үнэлэхгүй, урамшуулахгүй газар Бурхан тавихад тэд амархан гомддог. Санал нийлэхгүй ямар нэг зүйл гарвал тэд амархан гомдож өөрийнхөө замаар явдаг. Гомдсон хүн өөрийгөө өмөөрч, гомдоллож, удирдлагаа буруутгаж явдаг атлаа өөрийнхөө алдааг олж хардаггүй гэмтэй юм.

Өсч төлөвшиж ёстой хэсэгт Бурхан таагүй дарамт өгөхдөө биднийг илүү үг даадаг, төлөвшсөн, ухаалаг болгохыг хүсдэг. Хэрэв Бурхан тавьсан газрыг орхиж нутаг сэлгэн яваад байвал Бурханы хүссэн хүн болж өсч төлөвшиж чадахгүйд хүрдэг.

*Хэрэв Бурхан тавьсан газрыг орхиж нутаг сэлгэн яваад
байвал Бурханы хүссэн хүн болж өсч төлөвшиж
чадахгүйд хүрдэг.*

Өнгөрсөн 10 жил сольсон чуулганаа дор бичнэ үү.

Хэрэв та чуулганаа сольсон бол шалтгаан нь юу байв? ✓ тэмдгээр тэмдэглэнэ үү:

- Өөр хот руу нүүсэн учраас
- Урсгал чиглэлээ сольсон учраас
- Пасторгаа гомдсон учраас
- Чуулганы ажилтанд гомдсон учраас
- Чуулганы сайн дурын удирдагчид гомдсон учраас
- Сургаалд нь гомдсон учраас
- Магтаалын стильд нь гомдсон учраас
- Гомдсон өөр шалтгаан: _____
- Бусад шалтгаан: _____

Хэрэв та гомдлоос болж чуулган сэлгэж явсан бол Сатаны урхийг тээн явж очсон газар бүртээ сөрөг байдлын үрийг тарьж, сүнслэг үр жимсгүй байдлыг бий болгож байгаа юм.

Дараах ишлэлийг уншиж, Бурханы хууль, гомдсон, сүнслэг өсөлт, ба үр жимстэй байхын холбоосыг олж тэмдэглэнэ үү:

Дуулал 1:1-3

Дуулал 119:165

Матай 4:16-17

Аль нэг чуулганд тогтвортой байж, чуулганы нөхөрлөл дунд байх таван ач холбогдлыг бичнэ үү:

1. _____
2. _____
3. _____
4. _____
5. _____

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бурхан таныг одоо байгаа чуулганд тань суулгасанд талархаж, тэндээ та өсч төлөвшиж, хөгжин цэцэглэхийн төлөө залбираарай.

БОДИТ БАЙДЛААС НУУГДАХУЙ

*Тийм эмэгтэйчүүд үргэлж суралцавч,
үнэний мэдлэгт хэзээ ч хүрч чадахгүй.*

2Тимот 3:7

Чуулганаас болон үйлчлэлийн багаас гарах ёстой цаг хугацаагаа яаж мэдэх вэ? гэж хүмүүс надаас их асуудаг. Харин би хариуд нь “Хэн таныг одоо байгаа чуулганд явуулсан бэ?” гэж асуудаг.

Олонхи хүн “Бурхан явуулсан” гэдэг. Харин би “Хэрэв Бурхан явуулсан юм бол, Бурхан тэр үйлчлэлээс нь чөлөөлөх хүртэл байж бай” гэж хэлдэг. Хэрэв Бурхан таныг явуулах бол, үйлчлэлийн нөхцөл байдал ямар ч байсан амар тайвнаар явуулна (Исаиа 55:12).

Өмнөх чуулганаас тань Бурхан явуулахдаа харилцааны хувьд амар тайвнаар чөлөөлсөн үйл явдлыг бичнэ үү.

Энэ номд би *teknon* (“нялхас буюу төлөвшөөгүй хөвгүүн”) болон *huois* (“төлөвшсөн хөвгүүн”) хоёрын ялгааг бичсэн. Ром 8:14-д төлөвшсөн хүүгийн тухай өгүүлдэг: “Учир нь Бурханы Сүнсээр удирдуулж байгаа бүхэн нь Бурханы хөвгүүд [*huois*] юм.” Бурхан өөрийн хөвгүүдээ хэрхэн төлөвшүүлдэг вэ? Хэрхэн төлөвшүүлдэг жишээг Бурханы төгс төлөвшсөн хөвгүүн Есүсээс бид харах хэрэгтэй юм.

***Гомдол сүнслэг төлөвшлийг хааж боогдуулдаг бол,
зовлон дунд ч дуулгавартай байх нь
бусадтай болон Эзэнтэй илүү
гүн харилцаанд оруулдаг.***

Есүс зовлон дунд дуулгавартай байдал дотор төлөвшсөн.

Одоо хамрагдаж байгаа чуулгандаа зовлон ба дуулгавартай байдлын талаар та юуг сурч байна вэ? Бусдад гомдох нөхцөлтэй учрах үед таны хандлага, бодол санаа, сэтгэл эмоци ямар байна вэ? Эсвэл учирч буй зовлон дунд ч Бурханд дуулгавартай байх тал дээр та юу сурч байна вэ?

Гомдол сүнслэг төлөвшлийг хааж боогдуулдаг бол зовлон дунд ч дуулгавартай байх нь бусадтай болон Эзэнтэй илүү гүн харилцаанд оруулдаг.

Дараагийн өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү:

Зовох үедээ би _____ ингэж ханддаг.

Дуулгавартай байх ёстой үед миний хандлага _____ ийм байдаг.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бурханд дуулгавартай байж бүхнийг Түүнд олзлуулж, өөрийгөө Христийн зовлонгийн хуваалцагч болгохыг зөвшөөрч залбираарай.

ӨӨРИЙГӨӨ ӨМӨӨРӨХҮЙ

*Энэ цугласан олон ч ЭЗЭН илд, жад хэрэглэлгүй аварна
гэдгийг мэдэх буй заа. Энэ тулалдаан бол ЭЗЭНийх бөгөөд
ЭЗЭН та нарыг бидний гарт өгнө хэмээв.
1Самуел 17:47*

Дуулгавартай байхгүйн шалтгаанаа гомдсон гэдэг үгээр тагладаг хүмүүс бий. Гомдол тээх нь өөрийгөө өмгөөлөх буруу хандлагатай болгодог. Учир нь өөрийн өөг харахгүй болгодог юм. Бусдыг буруутгах үед өөрийн балчир бодол, нүгэлтэйгээ нүүр тулах эр зориг танд төрдөггүй юм. Тийм учраас хүнд хэцүү амьдарлын нөхцлөөр Бурхан таныг хүчтэй хүн болгодгийг үл ойшоож болохгүй. Гомдсон хүн гомдолтойгоо нүүр тулах дургүй учраас зугтаадаг. Ийм байдлаар сүнслэг тэнүүлчид бий болдог аж.

Бусдыг буруутгах, шүүх талаар Библид их өгүүлдэг.

Бусдыг буруутгах, шүүх тал дээр Библид өгүүлсэнийг бичнэ үү:

Матай 7:1-5

Матай 5:21-26

Лук 6:36-37

Ром 12:17-21

Ром 14:10-13

Иаков 4:11-12

Иохан 20:23-д “Та нар хэний нүглийг уучилна, тэд уучлагдана. Та нар хэний нүглийг үл уучилна, тэд үл уучлагдах болно” гэж Есүс хэлж байсан.

***Хайр гэм бурууг хардаггүй учраас
ирээдүй итгэл найдвар гэж хүнд бий болдог.***

Бусдад гомдож, уурсах нь гэм бурууг нь дотроо тээж санаж явдгаас л үүдэлтэй. Гол асуудал нь гомдолтой нүүр тулж, эвлэрч засалгүй зугтаагаад байгаад л буй. Асуудал үүсгэгч гол цөм нь хөндөгдөөгүй учраас тодорхой цаг хугацааны дараа байнга сэдэрдэг.

Хайр гэм бурууг хардаггүй учраас ирээдүй итгэл найдвар гэж хүнд бий болдог. Хэрэв бид гомдлын асуудлыг давж чадвал жинхэнээсээ амар тайвныг эрэлхийлнэ. Заримдаа цагаа олоогүй байсан ч, зүрх сэтгэлдээ бид эвлэрч сэргэхийг л зорьдог.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Гомдолтойгоо нүүр тулж зугтахгүй байхын төлөө залбираарай.

БАТ СУУРЬ

*Тийм учраас Эзэн БУРХАН
“Үзэгтүн. Би Сионд нэг чулууг тавина.
Тэр нь шалгагдсан бөгөөд бат тавигдсан
суурийн булангийн үнэт чулуу юм.
Түүнд итгэгчийг яаруулахгүй.
Исаиа 28:16*

Эзэнд итгэгч нь яаран үйлдэхгүй. Яаран үйлдэж буй хүн нь тогтворгүй юм. Учир нь түүний үйлдэлд бат суурь үгүй. Тийм хүн зовлон бэрхшээлийн нөлөөгөөр амархан найгаж, өөрчлөгдөх боломжтой байдаг.

Зовлон бэрхшээлийн дунд хөдлөшгүй бат суурь нь Бурханы Үг юм. Эзэний Үгийг номлож байхдаа тэнд цугласан хүмүүсийг болон цуглааныханыг Эзэний үгийг тодорхой сонсоосой гэж уриалдаг. Эзэнээр тослогдсон номлогчийн үгс, тэдний бичсэн номыг уншиж байхад тодорхой нэг үг, өгүүлбэр сүнс дотор минь шинэ ухаарал өгдөг. Энэ бол Эзэний илчлэлт юм. Эзэний илчлэлт бидний зүрхэнд шинэ ухаарал, сүнслэг ойлголт өгдөг.

Дууллыг өргөгч, “Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг. Тэдгээр нь энгийн хүмүүст ухаарлыг хайрладаг” (Дуулал 119:130) гэж бичжээ. Бодолд бус харин зүрхэнд буюу сүнсэнд Бурханы Үг нэвтрэн орохдоо ухаарал өгч аливааг тодорхой ойлгуулдаг.

Долоо хоног бүр Бурханы Үг таны зүрхэнд хэрхэн ухаарал авчирдаг вэ? Бурханы дуу хоолойг хэрхэн сонсдог талаарх сонголтоос ✓ та сонгож тэмдэглээрэй.

- Библи судлал
- Сургаалын үгтэй дуу дуулахад
- Сургаал сонсоход
- Библи уншиж байхад
- Номлол сонсож байхад
- Христитгэлт ном уншиж байхад
- Бусад _____

Бурханы Сүнс илчилсэн зүйлийг зүрхнээсээ авч хаяна гэдэг боломжгүй. Аливаа шийдвэрээ Бурханы Үгэнд гүн үндэслэн гаргах хэрэгтэй юм. Хэрэв Бурханы Үгд суурилагагүй бол амьдралын ямар нэг зовлон бэрхшээлд амархан сөгдөж гомдох болно. Бурханы Үг бидний дотор бат суурилагагүй үед анх сонсохдоо үгийг баяртайгаар хүлээн ававч удалгүй тэр бүхнээ гээх болно (Марк 4:16-17).

Хэрэв Бурханы Үгэнд суурилагагүй бол амьдралын ямар нэг зовлон бэрхшээлд амархан сөгдөж гомдох болно.

Таны бодол, мэдрэмж, эсвэл амьдралын хэв загвартай тань зөрчилдөх үгийг Бурхан хэлэхэд таны анхны хариу үйлдэл юу байдаг вэ? Эхний үйлдлийг 1 гээд харин хамгийн сүүлд нь ингэж ханддаг гэдэгт 7 гэсэн тоог тавиарай.

- ___ Уурладаг
- ___ Эргэлздэг
- ___ Гомддог
- ___ Гэмшдэг
- ___ Бурханы үгд баярладаг
- ___ Шархладаг
- ___ Бусдыг болон Бурханыг буруутгадаг
- ___ Бусад

Бурханы Үгд гүн үндэслэж, Түүний Ариун Сүнсээр ухаарсан хүн Бурханаас болон бусдаас үг сонсохдоо гомдохгүйгээр харин тодорхой сонсож чаддаг байна.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бурханы Үг амьдралын тань олон талбарт ухаарал өгч байгаад талархан залбираарай.

ӨӨР СОНГОЛТ БАЙХГҮЙ

Эзэн уруу ир. Тэр бол хүмүүст гологдсон боловч, харин Бурханы өмнө сонгогдсон, үнэт, амьд чулуу билээ. Иймд амьд чулуу мэт болсон та нар ч Есүс Христээр дамжуулан Бурханд тааламжит, сүнслэг тахилуудыг өргөх ариун тахилч болохын тулд сүнслэг байшин болон баригдагтун.
Петр 2:4-5

Бурханы илчлэлт дээр амьдралаа босгон байгуулах нь ямагт баг суурьтай болдог. Түүний тушаал, хууль нь сонголт зөвлөгөө биш харин заавал дагаж мөрдөх ёстой үг байдаг. Түүний үг тушаалыг дагахгүй байж гомдоллох бус, харин цорын ганц сонголт болох дуулгавартай байдлыг бид сонгох ёстой.

Бурханы үгийг сонсоод гомдоллож, дагаагүй явсан тохиолдол танд байсан уу? Үр дагавар нь юу байв?

Дарамт зовлон дунд бид өөрсдийгөө сүнслэг байшингийн чулуу болж баригдах ёстойг Петр шиг ойлгодог. Петр (Petra) бол хад гэсэн утгатай. Энэ хад бол Есүс Христ бол амьд Бурханы Хүү гэж тунхагласан хүн билээ.

Зовлон бэрхшээл хүний сүнслэг байр суурийг нь тогтоодог. Зовлон бэрхшээл дунд хүний зүрхний жинхэнэ дүр төрх ил болдог.

Элсэн дээр баригдсан байшингийн (Матай 7:26-27) талаар

Библид өгүүлдэг. Энэ байшин таван давхар өндөр, үнэхээр сайхан засалтай байж болох. Нарны гэрэлд энэ байшин улам л сайхан, хүчтэй харагдана. Харин дэргэд нь үл тоогдох, хүний нүд булаамгүй нэг давхар намхан байшин байна гэнэ. Гэхдээ энэ байшин ил үл харагдах хадан дээр баригджээ.

***Зовлон бэрхиээл хүний
сүнслэг байр суурийг тогтоодог.***

Шуурга дэгдэж, их үер болоход нөгөөх сайхан харагдаж байсан таван давхар байшин юу ч үгүй нурдаг юм байна. Бат бэх суурь хад болох Есүс Христэд итгэлээ тавьсан хүний амьдрал, амьдралын ямар ч шуурга, зовлонгийн үерт нурдаггүй юм. Шуурга дэгдэхэд тэд зугтдаггүй, гомддоггүй, эсвэл бусдыг буруутгадаггүй. Харин амьдралын шуурга дунд тэд цэх зогсдог.

Дэлхийн үнэлэмж бол элс юм. Та элсэн дээр амьдралаа байгуулах гэж оролдож байв уу? Дараах элс мэт суурийн аль нь таныг ихээр өдөөж байв? Үр дагаварыг нь товчхон бичээрэй:

- Мөнгө: _____
- Амжилт: _____
- Эрх мэдэл: _____
- Эд хөрөнгө: _____
- Аюулгүй байдал: _____
- Хүн: _____
- Бусад: _____

Бусад хүн юу хийж, юу хэлэх нь хамаагүй. Бурханы илчлэлт дээр амьдарлаа барьж байгуулахыг эрмэлзээрэй. Зүрхэнд чинь хэлж байгаа Бурханы үгийг анхааралтай сонсож түүн дээр амьдралаа босгон байгуулаарай. Бүгдэд таалагдахын тулд амьдралаа бүү үрэн таран хийгээрэй. Түүнийг эрэн хайж, зүрхэнд тань ухааруулсан Түүний Үгийн илчлэлт дээр амьдралаа босгон байгуулаарай.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Танд хандсан Бурханы Үгийг Ариун Сүнс илчилж өгөхийн төлөө залбираарай. Тэр л үгэн дээр, Христ дээр, амьдралаа босгон байгуулаарай.

ШИГШИГДЭХ ЁСТОЙ БҮХЭН ШИГШИГДЭНЭ

Тэгэхэд Түүний дуу дэлхийг доргиож ганхуулсан. Харин эдүгээ Тэр “Би дахиж нэг удаа зөвхөн дэлхийг бус, тэнгэрийг ч мөн сэгсэрнэ” гэж амласан. “Дахиж нэг удаа” гэдэг нь үл ганхуулагдах юмс нь үлдэхийн тулд бүтээгдсэн ганхуулагдах юмс нь зайлуулагдахыг хэлж байгаа юм.

Еврей 12:26-27

Симон Петр хэдийгээр хад гэж хэлэгдсэн авч Есүсийн үйлчлэлийн төгсгөлд түүнд Эзэний үгийн дагуу алхах зан чанар дутуу байсан юм. Тэр өөрийн амьдралыг үйлчлэлийнхээ өнгөрсөн амжилт, бахархал дээр байгуулсан байв. Бат суурь болсон Христ дээр амьдралаа хэрхэн байгуулах тал дээр анхаарах ёстойг Паул захиж ийнхүү бичжээ:

Надад өгөгдсөн Бурханы нигүүлслийн дагуу би ухаалаг тэргүүн барилгачин мэт суурийг тавьсан бөгөөд харин өөр хүн түүн дээр барьж байна. Гэхдээ түүн дээр яаж барихаа хүн бүр анхаарагтун. Учир нь тавигдсан ганц суурь болох Есүс Христээс өөр суурийг хэн ч тавьж чадахгүй.

1Коринт 3:10-11

Дэлхийн үнэлэмж дээр түшиглэн байгуулсан амьдралын алив талыг Христ сэгсэрдэг.

Иохан 2:15-17-г уншина уу. Дэлхийн үнэлэмж дээр суурилсан

алив зүйлийг Христ амьдралаас авч хаядаг. Таны хувьд одоо ямар байдалтай байна тэр хэсэгт “х” гэж тэмдэглэнэ үү.

Махан биеийн хүсэл тачаал

Аль хэдийнээ ганхан унасан

Ганхаж унах хэрэгтэй байгаа

Нүдний хүсэл тачаал

Аль хэдийнээ ганхан унасан

Ганхаж унах хэрэгтэй байгаа

Амьдралын бардам бахдал

Аль хэдийнээ ганхан унасан

Ганхаж унах хэрэгтэй байгаа

Есүсийн үйлчлэлийн төгсгөлд Симон Петр бардам зангаасаа болж зэмлүүлдэг: “Симон оо, Симон оо, үзтүгэй, чамайг улаан буудай мэт шигшихийн тул Сатан зөвшөөрөл гуйсан” (Лук 22:31).

Шигшиж шалгах шалгуураас зугтаалгахын тулд бус харин шигшиж шалгуулж байхдаа Петр итгэлээр унахгүй байхын төлөө Есүс залбирсан юм.

Бардам зан Петрийн амьдралд орж ирэх үүд хаалга нээж түүний итгэлийг сэгсэрсэн юм. Хэрэв Есүс өнөөгийн чуулган шиг сэтгэлгээтэй байсан бол, “Залуус аа, найз Симонд минь ийм муу зүйл хийхгүй байхын төлөө Сатаны эсрэг залбирья” гэх байсан байх. Харин Есүс энд юу гэж залбирсаныг харвал: “Гэсэн ч итгэл чинь сульдахгүйн тулд Би чиний төлөө залбирсан. Чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул” (Лук 22:32).

Шигшиж шалгах шалгуураас зугтаалгахын тулд бус харин шигшиж шалгуулж байхдаа Петр итгэлээр унахгүй байхын төлөө Есүс залбирсан юм. Энэ шалгуурыг давсаны дараа Петрт, амьдралынхаа дуудлагыг биелүүлэх шинэ хүчирхэг зан чанар бий болж, ах дүүсээ хүчирхэгжүүлэх ёстой байв.

Петрийг сорих зөвшөөрлийг авсан Сатан, Петр шалгуурыг давалгүй итгэлээр унана гэж горьдож байв. Эзэнээс хүчирхэг

илчлэлт авсан их хүчтэй хүн гарч ирэх вий гэж айхдаа Петрийг устгахыг дайсан зорьж байсан юм. Харин Бурхан сэгсэрч сорихдоо, бидний амьдралд хөдөлж болох бүх юмыг хөдөлгөж биднийг илүү хүчтэй хүн болгох өөр зорилго агуулдаг. Бурханы арга ухаан Сатанаас үргэлж дээгүүр байдаг.

Бурхан дараах зорилгын алинаар нь ч сэгсэрч болох. Хэрэв одоо Бурхан таны итгэлийг сэгсэрч байвал ямар зорилгоор гэж та бодож байна вэ? (Танд хамаатай хэсгийг ✓ хийнэ үү.)

- Амьдралыг минь илүү бат суурьтай болгохын тулд
- Бардан занг авахын тулд
- Дотоод нөөц бололцоог дайчлуулахын тулд
- Сүнсээр сэргээхийн тулд
- Сүнслэг амьдралыг хүчтэй болгохын тулд

Бардамнал, хувиа хичээсэн алив зүйлд суурилсан зан чанар хандлага сэгсрэлтээр амьдралаас тань явах л болно.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Амьдралаас тань бардамнал, бэртэгчин зан, шунал тачаалыг амьдралаас тань авч хаяхыг Түүнд зөвшөөрөөрэй.

ДАРУУ ХҮНД НИГҮҮЛСЭЛ ӨГӨГДДӨГ

Залуус аа, та нар мөн түүнчлэн ахлагчиддаа захирагд. Та бүгд бие биедээ даруу хандах байдлаар өөрсдийгөө хувцасла.

*Учир нь Бурхан бардам хүнийг эсэргүүцдэг,
харин даруу хүнд нигүүлслээ өгдөг.*

1Петр 5:5

Сорилт бидний зүрхэнд буй далд гомдлыг ил болгодог. Сорилт ирэхэд Бурханд гомдох уу эсвэл найдах уу гэдэг сонголт тодорхой болдог. Хэрэв та сорилтыг даруухнаар давбал Түүнд хандсан итгэл тань илүү гүн үндэслэж ирээдүй тань илүү тогтвортой болно. Хэрэв та алдвал, та илүү их гомдож, хорсол сэтгэлийг тань дүүргэх болно.

Симон Петр өөрийгөө аугаа гэж хэлж чадахгүй болтлоо соригдон бардам зан нь сэгсрэгдсэн юм. Тэр өмнөх шигээ өөртөө итгэхээ больжээ. Өөртөө тэгэж их найдаж бардамнах нь ямар ч ашиг тусгүй юм гэдгийг тэр тодорхой ойлгосон юм. Харин одоо тэр Бурханы нигүүлсэлээр л бүх юм урагш явдгийг ойлгожээ. Бурхан даруу хүнд л нигүүлсэлээ өгдөг. Даруу зан бол нигүүлсэлийн болзол юм.

Та хэзээ нэгэн цагт “Бурхан минь ээ, би Танд үйлчилж, Таныг дагахдаа олон зүйлийг хойш тавьсан. Харин одоо яагаад надад ийм хэцүү зүйл болж байна вэ?” гэж хэлж байсан уу?

*Сорилт ирэхэд Бурханд гомдох уу эсвэл найдах уу гэдэг
сонголт тодорхой болдог.*

Бурханы төлөө амьдралаа зориулсан учраас Бурхан онцгой

хандах ёстой байсан юм гэж эндүү бодсоноос болоод олон итгэгчид Бурханд гомддог.

Хэрэв ийм сэдлээр л үйлчилж байсан бол буруу юм. Эзэнд үйлчлэхдээ, Тэр бидний төлөө юу хийж чадах вэ гэдгийг тооцоолж бус харин Тэр бидний төлөө юу хийсэн бэ гэдэгт талархаж Түүнд үйлчлэх нь зөв юм. Бурханд гомдогсод нэг л зүйлийг дутуу боддог. Бурхан хязгааргүй их нүглийг нь уучилж эрх чөлөө өгсөнийг тэд бүрэн ойлгодоггүй. Христ тэднийг ямар байдлаас гаргаж авсаныг тэд ухаардаггүй. Тэд мөнхийн ач холбогдлыг нь умартаж өнөө маргаашийн өнцгөөс ханддаг нь харамсалтай.

Та ямар сэдлээр Бурханд үйлчилж байна вэ? Өөрийн чадалдаа эрдэж, бусдад гайхуулах гэж үү эсвэл Түүнд үйлчилсэний хариуд амар хялбар амьдрал, эсвэл материаллаг ямар нэг ерөөл авна гэж бодсоны улмаас уу?

Дараах өгүүлбэрийг нөхөж бичнэ үү:

Христэд үйлчилдэг миний сэдэл бол: _____

Миний амьдралын баталгаа _____ зүйл дээр оршдог.

Түүнээс хүсч буй миний шагнал бол _____ юм.

Үнэндээ бид өөрийн хүч чадлаар мөнхийн үнэ цэнэтэй ямар ч зүйл бүтээж чадахгүй билээ.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Зүрхийг тань цэвэр байлгаж, алив махан биеийн хүслээс чөлөөтэй байлгахын төлөө залбираарай.

ГОМДООГЧ ХАД

Энэ нь Сударт

“Харагтун. Би Сионд сонгогдсон,

Булангийн үнэт чулууг тавина.

Түүнд итгэгч хүн ичгүүрт орохгүй” хэмээн бичигдсэн байдаг. Тиймээс итгэгч та нарт энэ нь үнэт. Харин үл итгэгчдэд “Барилгачдын голсон чулуу нь булангийн чулуу болов” гээд “Бүдрүүлэх Чулуу, тээглэх Хад болсон юм” гэжээ. Тэд үгэнд дуулгаваргүй байдгаас болж бүдэрдэг бөгөөд энэ нь тэдэнд тогтоогдсон аж.

1Петр 2:6-8

Өнөөдөр итгэх гэдэг үгийн хүч суларчээ. Энэ үгийг ердөө л бодит зүйлийг хүлээн зөвшөөрөх төдий л хэрэглэдэг болж. Ямар нэг байдлаар дуулгавартай дагахтай холбоогүй болжээ. Харин дээрх ишлэлд итгэх ба дуулгаваргүй байдлын талаар өгүүлжээ.

Библид “Түүнд [Есүст] итгэгч хүн шийтгэгдэхгүй харин мөнх амийг авна” (Иохан 3:16) гэж хэлжээ.

Хэрэв итгэх гэдэг үгийг олонхи хүний боддог шиг Есүс байдаг, тэр загалмайд биднийг Бурхантай эвлэрүүлэхийн тулд амиа өгсөн гэдгийг хүлээн зөвшөөрөх төдийд ойлгож байвал Сатаны талаар Библид хэлсэн шиг итгэлийн хувьд ижил байр сууринд очно гэсэн үг. Библид “Бурхан бол ганц гэдэгт чи итгэдэг. Энэ чинь сайн хэрэг. Чөтгөрүүд ч мөн үүнд итгэдэг бөгөөд чичирдэг юм” (Иаков 2:19) гэсэн байдаг. Чөтгөр Бурхан оршин байдгийг хүлээн зөвшөөрсөн итгэлээрээ аврагдахгүй нь тодорхой.

Дараах өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү:

Миний хувьд, итгэл бол _____

Миний хувьд, дуулгавартай байдал бол _____

Хэрэв би итгэж байна гэсэн атлаа дуулгавартай үйлдэхгүй бол _____.

Итгэх гэдэг нь бодит байдлыг хүлээн зөвшөөрөх гэдгээс өөр олон утгатайгаар Библид хэрэглэдэг үг юм. Дээрх ишлэлийн агуулгын хүрээнд итгэх нь дуулгавартай дагах гэсэн утгатай агаар нэг. Тиймд ийм байдлаар унших хэрэгтэй гэсэн үг: “Харагтун. Би Сионд сонгогдсон, Булангийн үнэт чулууг тавина. Түүнд итгэгч хүн [дуулгавартай хүн] ичгүүрт орохгүй” хэмээн бичигдсэн байдаг. Тиймээс итгэгч [дуулгавартай] та нарт энэ нь үнэт. Харин үл итгэгчдэд [үл дагагчдад] ‘Барилгачдын голсон чулуу нь булангийн чулуу болов’ гээд ‘Бүдрүүлэх Чулуу, тээглэх Хад болсон юм’ гэжээ. Тэд үгэнд дуулгаваргүй байдгаас болж бүдэрдэг бөгөөд энэ нь тэдэнд тогтоогдсон аж.”

***Эцсийн эцэст Христтэй харилцаатай энэ хайр л чухал юм.
Түүний сургаал зарчим нь биш, харин Түүнтэй Өөртэй нь
харилцаатай байж хайрлах л чухал юм.***

Таныг хайрлаж байгаа Түүний зан чанарыг мэдэж байвал дуулгавартай байх нь тийм ч хэцүү зүйл биш ээ. Эцсийн эцэст Христтэй харилцаатай энэ хайр л чухал юм. Түүний сургаал зарчим нь биш, харин Түүнтэй Өөртэй нь харилцаатай байж хайрлах л чухал юм. Энэ хайрыг ойлгохгүй бол, бид Түүнд гомдож, бүдрэх болно.

Бурханы хүсэлд дуулгавартай байхад та хүний хүслийг гүйцэлдүүлэхгүй ээ. Хэрэв хүний хүслийг гүйцээе гэвэл та эцэстээ зовно. Есүсийг хамгийн их зовоосон хүмүүс бол шашны удирдагчид байлаа. Шашинлаг хүмүүсийн ойлголтоор Бурхан

тэдний ойлголтын хүрээн дотор л ажиллах ёстой гэж боддог. Ариун Сүнсээр хөтлөгдсөн Есүс 2,000 жилийн өмнө шашны хүмүүсийг гомдоож байсан бол Түүнийг дагаж байгаа өнөөгийн хүмүүс ч гэсэн гомдоож мэдэх юм.

Таны хариу үйлдэл таны ирээдүйг тодорхойлно гэдгийг санаж байна уу. Дараах өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү:

Христийн үгээр амьдарсаны минь төлөө бусад хүн надад гомдож байвал би _____ хандана.

Паул “Гэвч ах дүү нар аа, хэрэв би хөвч хөндөх ёслолыг тунхагласаар байвал юунд би мөшгөгдөн хавчигдсаар байх билээ? Тэгвэл загалмайн бүдрүүлэх саад нь алга болсон хэрэг” (Галат 5:11).

Хэрэв сайн мэдээний үнэнийг хэн нэгэн сөрж байвал, уучлал гуйхгүйгээр гомдоосон ч болно. Ямар ч үнээр хамаагүй, Бурханы Ариун Сүнсийг ямар ч үед дуулгавартай дагана гэсэн бат шийдвэр зүрхэнд маань байх ёстой бус уу?

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Христэд итгэж, дагаж, хайрлана гэдгээ Түүнд хэлээрэй!

ТЭДНИЙГ ГОМДООХГҮЙН ТӨЛӨӨ

*Иймд цаашид бид бие биеэ шүүхээ больё.
Харин ч та нар ах дүүдээ бүдрүүлэх чулуу,
эсвэл саад тотгор тавихгүй байя гэж шийдэгтун.
Ром 14:13*

Олон хүн Есүст гомдоллодог ч, Тэр өөрийн эрх болон давуу талаа өмнөө барьдаггүй билээ. Есүс “Иймээс хэн өөрийгөө энэ хүүхэд адил даруу болгоно, тэр нь тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь болно” гэсэн (Матай 18:4). Гол үг нь “хэн өөрийгөө ... даруу болгоно” юм. Есүс энэ үгээ илүү дэлгэрүүлж ийнхүү хэлжээ.

Та нар тэгж болохгүй. Харин та нарын дунд хэн чинь агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог. Үүнчлэн Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд ирсэн бөгөөд амиа олны төлөө золиос болгон өгөхөөр ирсэн билээ гэв. Матай 20:26-28

Ямар хүчирхэг үг вэ! Есүс бусдаар үйлчлүүлэхийн тулд бус харин бусдад үйлчлэхийн тулд ирсэн билээ. Тэр чинь Бурханы Хүү шүү дээ! Тэр эрх чөлөөт Нэгэн! Тэр хэнд ч ийн үйлчлэх өртэй байгаагүй. Тэр ямар ч хүний өмнө өөрийгөө бөхийлгөх албагүй байсан. Есүс эрх чөлөөт байсан авч бусдад үйлчлэхийг сонгосон билээ.

*Есүс эрх чөлөөт байсан авч
бусдад үйлчлэхийг сонгосон билээ.*

Дараах ишлэлүүдийг уншиж, бусдад үйлчлэх талаар Библид юу гэж хэлсэнийг бичиж тэмдэглэнэ үү:

Лук 16:13

Лук 22:26

Иохан 12:26

Ром 7:6

Галат 5:13

Филиппой 2:5-11

Галат 5:13-т Паул бусдадаа үйлчлэх боломж, давуу талын тухай онцолжээ. Бидэнд өгөгдсөн эрх чөлөөг бид өөртөө биш харин бусдад үйлчлэхэд зориулах учиртай юм. Үйлчилнэ гэдэгт эрх чөлөө харин боолчлогдоно гэдэгт хүлээс бий. Боол албатай учраас зарцлагдана, харин үйлчлэгч чөлөөт сонголтоороо бусдад сайн дураар үйлчилдэг.

Олон итгэгч хүн хорссон хандлагаар үйлчлэхийг би харсан. Алба гувчуураа төлж байгаа юм шиг гомдоллож үйлчилнэ. Тэд чөлөөлөгдсөн хуулийнхаа дор өөрсдийгөө эргүүлэн боолчлуулжээ. Тэд зүрхэндээ боол хэвээрээ л байдаг.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Боолчлолоос чөлөөлөгдсөнөө тунхаглаж, өөрийгөө сайн дураар Христийн зарц болгож үйлчлэхийг сонгон залбираарай.

ЭРХЭЭ ХОЙШ ТАВИХ

Харин та нарын энэ эрх мөхөс хүмүүст бүдрүүлэх чулуу болох вий гэдэгт санаа тавь.
1Коринт 8:9

Бид бусдад үйлчлэх, бусдын төлөө амиа зориулах эрх чөлөөтэй. Бид устгахын тулд бус босгохын тулд, унагахын тулд бус ухааруулахын тулд байдаг. Өөрсдөдөө ашиг хонжоо олох гэж бид эрх чөлөөгөө ашиглах учиргүй. Бид хуучин зуршлаараа амьдарсаар байгаа учраас л итгэгчдээс болж олон хүн бүдэрдэг. Хэдийгээр бидэнд юуг ч хийх эрх чөлөө байгаа боловч энэ эрх чөлөөт байдлаараа бусдыг бүдрүүлж байвал бид эрхээсээ татгалзаж сурах хэрэгтэй юм. Ингэх нь зөвийн дууриал, сайн гэрчлэл болдог.

Би бусдын төлөө хийж байна уу эсвэл өөрийнхөө төлөө хийж байна уу?

Бусдыг гомдоохгүйн тулд, бүдрээхгүйн тулд өөрийн эрхээс татгалзах үйлдлээ жагсаан бичнэ үү:

Ийм зүйлд гомдохгүйн тулд

Татгалзаж буй эрх

Бусдыг Христийнх болгохын тулд би өөрийн ямар эрх, давуу талаасаа татгалздаг вэ? “Бусдын тусын төлөөх сорил” гэдэг зүйлийг та өөртөө хэрэглэж үзнэ үү.

Элч Паул, Ромчуудад бичсэн захидалдаа Бурханы зүрх сэтгэлийн талаар: “Тиймд амар тайванг тогтоодог болон бие биеэ босгон байгуулдаг зүйлсийн хойноос мөшгөцгөө” (Ром 14:19) гэж бичжээ.

Бидний үйлдлийг Библи зөвшөөрсөн байж болно. Гэхдээ өөрөөсөө: “Би өөрийн тусын тулд хийж байна уу эсвэл бусдын тусын тулд хийж байна уу?” гэж нэг асуу даа.

Бүх юмс зөвшөөрөгддөг, харин бүгд тустай биш. Бүх юмс зөвшөөрөгддөг, харин бүгд босгон байгуулдаггүй. Хэн ч өөрийн ашгийг бүү эр, харин бусдынхыг эрэг ... Иймээс та нар идэж, уухдаа, эсвэл юу ч хийсэн Бурханы алдрын төлөө бүхнийг хий. Иудейчүүдэд ч, грекчүүдэд ч, Бурханы чуулганд ч хэрэг төвөг бүү учруул. Яг надтай адил байгтун. Хүмүүсийг аврагдаасай гэсэндээ би өөрийн ашгийг бус, харин олны ашгийг хайн, бүхний дотор бүх хүний таалалд нийцүүлдэг.

1Коринт 10:23-24, 31-33

Амьдралын тань эс ширхэг бүрт Бурханы Үг нэвчин шингэг. Бусдын тусын тулд биш зөвхөн өөрийн тусын тулд далд нуугдсан урхаг санаа бүрийг илчлэн гаргаг. Таны ямар бодлыг Библи илчлэх гэнэ, түүнийг хүлээн авч Эзэний дуулгавартай зарц адил хандахыг хүсье.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бусдыг бүдрүүлж буй ямар зүйл амьдралд тань байна, түүнийг гаргаж хаяхын төлөө залбираарай.

УУЧЛАЛ: ӨГӨХГҮЙ БОЛ АВАХГҮЙ

Тийм учир Би та нарт хэлье. Та нар юуны төлөө залбирч, гуйж байна, түүнийгээ авсан гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр чинь ёсоор болно. Та нар залбиран зогсохдоо, хэрэв хэн нэгний эсрэг ямар нэгэн юм чамд байгаа бол уучил. Тэгвэл тэнгэр дэх Эцэг чинь мөн та нарын хилэнцийг уучлах болно. [Харин хэрвээ та нар уучлахгүй бол, тэнгэр дэх Эцэг чинь мөн та нарын хилэнцийг уучлахгүй гэв].

Марк 11:24-26

Гомдол өвөртөлж амьдрахын хор хөнөөл болон гомдлоос хэрхэн чөлөөтэй амьдрах талаар одоо ярилцъя. Есүс энэ үгийг хэлэх гэж хэлсэн: “Харин хэрвээ та нар уучлахгүй бол, тэнгэр дэх Эцэг чинь мөн та нарын хилэнцийг уучлахгүй.”

Хэлж байгаа үгэндээ нэг их ач холбогдол өгдөггүй тийм л нийгэмд бид амьдарч байна. Тэр ч бүү хэл зарим хүний хэлсэн үгэнд ач холбогдол өгөхөө ч больж бид. Хүний үгийг чухалчлан сонсдоггүй тийм л үед бид амьдарч байна.

Хүүхэд ахуйгаас энэ эхэлсэн юм. Эцэг эхчүүд хүүхдэдээ, “Хэрвээ чи дахиад дүрсгүйтвэл, алганы амт үзнэ шүү” гэнэ. Харин хүүхэд нь дүрсгүйтсээр л. Эцэг эх нь нөгөөх үгээ улиг болтол нь хэлсээр л. Сахилгын саваа сураггүй л. Хэрэв сахилгын саваа хэлсэн шигээ буудагсан бол хүүхэд эцэг эхийнхээ үгийн жинг ухаарах л байсан. Харамсалтай нь олон хүн хэлсэн шигээ байдаггүй учраас үг жингүй болжээ.

Уучлагдахын тулд та бусдыг уучилдаг уу?

Есүс хэлсэн үгийг нь анхаараасай гэж хүсдэг. Бид түүний үгд хаа хамаагүй хандаж болохгүй. Есүс хэлсэн л бол хэлсэн. Тэр хэлсэн шигээ үйлддэг, хэлсэндээ хүрдэг. Тиймээс Түүний үгд бүрэн найдаж болно. Тэр итгэмжтэй. Амьдрал ахуй, соёлын ялгаа сэтгэлгээг үл хамааран Есүс үнэнч шударга, итгэл даах чанараа үргэлж хадгалж явдаг. Тэрбээр “Харин хэрвээ та нар уучлахгүй бол, тэнгэр дэхь Эцэг чинь мөн та нарын хилэнцийг уучлахгүй” гэж хэлсэн энэ үгийг яг энэ утгаар нь хүлээж аваарай.

Сайн мэдээний номуудад уучлалын талаар юу гэж хэлснийг тэмдэглэж аваарай.

Матай 6:14-15

Лук 6:37

Матай 6:12

Та Есүсийн үгд ач холбогдол өгч, анхааран сонсож байна уу? Өөрөө уучлагдахын тулд бусдыг уучилж байна уу? Та бусдыг уучлахгүй бол, Бурхан Аавын уучлалыг хүлээн авах зүрх сэтгэлийн орон зайгүй болно.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бурхан Аавын уучлалыг хүлээн авахын тулд өөрийг тань гомдоосон тэдгээр хүмүүсийг үнэн голоосоо уучлах зүрх сэтгэл өгөхийг Бурханаас гуйгаарай.

ӨСТ ЗАРЦ

Дараа нь Петр ирж Түүнд

—Эзэн, ах дүү маань миний эсрэг нүгэл үйлдэхэд би хэдэн удаа түүнийг уучлах вэ? Долоон удаа юу? гэхэд нь

Есүс айлдсан нь

—Би чамд долоон удаа гэж хэлэхгүй. Харин дал дахин долоон удаа гэж хэлье.

Матай 18:21-22

Есүс, Петр болон бусад дагалдагч нартаа бусдыг уучлахдаа Бурханы хязгааргүй нигүүлсэлд суурилан уучилж байхыг ойлгуулсан юм. Үүнийгээ бататгахын тулд өст зарцын талаарх сургаалт зүйрлэлээ Есүс хэлжээ.

Матай 18:23-35 уншина уу. Тэгээд дараах өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү:

Миний ойлгосноор энэ сургаалт зүйрлэлийн гол санаа нь:

Энэ сургаалт зүйрлэлээр Бурхан надад үүнийг хэлээд байх шиг байна: _____

Бусдыг уучилж чадахгүй нүгэл, Бурхан биднийг уучилсан нүгэл хоёрыг харьцуулбал 10 төгрөгийг 10 сая доллартай харьцуулсантай адил их зөрөөтэй юм. Бусад хүн танд муухай хандсан байж болох ч, Бурханы эсрэг тэрсэлсэн таны нүгэлтэй харьцуулахад тэр нь юу ч биш байдаг. Есүс биднийг мөнхийн үхэл, тамлалаас чөлөөлсөн гэдгийг ойлгобол, бид бусдад ямар нэг болзол тавилгүй нүглээс нь чөлөөлдөг.

Уучлахад хэцүүгээ 1 гэсэн оноогоор, харин уучлахад арай л амар даа гэж бодсоноо 7 гэсэн оноо тавьж дугаарлана уу.

- _____ Намайг хов живд хутгасан хүн
- _____ Бие сэтгэлийг минь хүчирхийлсэн хүн
- _____ Миний хайртай хүнийг бие сэтгэлээр нь гутаан доромжилсон хүн
- _____ Надад худал ярьсан хүн
- _____ Надаас хулгай хийсэн хүн
- _____ Намайг залилсан хүн
- _____ Бусад _____

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бусдыг уучлахад саад болж байсан алив бодлыг өөрөөсөө зайлуул. Тэдгээр бодлуудыг суулгасан тодорхой хүний төлөө залбирч уучлахыг сонгоорой.

ӨШӨӨ АВАХ: ЭНЭ БОЛ УРХИ

Хэнд ч хэзээ ч бузар мууг бузар муугаар бүү хариул. Бүх хүний өмнө юу нь зөв болохыг л харгалзан үзэж бай.

Ром 12:17

Хэн нэгнийг уучлахгүй гомдол тээнэ гэдэг хэн нэгнээс авлагатай юм шиг амьдрахад хүргэдэг. Бусдад буруу юм хийхэд нөгөөх нь чи надад өртэй боллоо доо гэсэншүү юм бодоод үлддэг. Хохирлоо барагдуулах ямар л хэлбэр байна гомдолгүй болох хүртлээ өс хонзон өвөртөлж явна гэдэг Бурханы хүүхдүүдийн хувьд зөв биш юм.

Дараах ишлэлийг уншиж өс хонзонгийн талаар ойлгосноо бичиж тэмдэглэнэ үү:

Ром 12:19

Иаков 4:12; 5:9

Матай 5:38-42

Өс хонзон санах нь зөв гэсэн буруу бодлыг Есүс хумиж байгааг харж байна уу? Өөрийгөө ашиглуулчих вий гэж эмээх бус, харин ч дахин ашиглуулсан ч яадаг юм гэсэн өгөөмөр уучлал өршөөлөөр дүүрэн хандлагатай байхыг Есүс өөгшүүлж байгаа бус уу.

***Биднийг Бурханы хайранд гүн үндэслэж,
суурилахыг л Есүс хүсдэг.***

Есүс бидний зүрх сэтгэлийг хөрстэй зүйрлэж өгүүлжээ. Биднийг Бурханы хайранд гүн үндэслэж, суурилахыг л Есүс хүсдэг. Бурханы Үг зүрхэнд үр мэт унаж үндэслэж соёолоод зөвт амьдралын үр жимс ургуулдаг. Тэдгээр үр жимс нь, хайр, баяр баясгалан, амар тайван, тэвчээр, энэрэл, сайхан сэтгэл, итгэлтэй байдал, дөлгөөн зан, өөрийгөө захирах байдал нь юм (Галат 5:22-23).

Хөрсөнд юу тарина тийм л юм ургана. Хэрэв бид үл уучлал, гомдлын үр таривал Бурханы хайрын оронд тэдгээр гашуун үндэс (Еврей 12:14-15) ургадаг байна. Гашуун үндэс! Хэрэв энэ гашуун үндсийг арчилж, тордож, услаад, анхаарал тавиад байвал улам л хүчтэй гүн үндэслэх болно. Энэ үндсийг бага байгаа дээр нь сугалж хаяхгүй бол удах бүр гомдол томордог юм шүү. Ингэвээс зөвт байдлын үр жимс бус, харин уур хилэн, өс хонзон, атаархал, хардалт, эрээ цээргүй амьдралын үр жимс ургана. Эдгээр үр жимсийг Есүс ямар ч ашиггүй гэж хэлжээ (Матай 7:19-20).

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бурханы амар тайван зүрхэнд тань ирсэнд талархаж, бугласан гомдлыг авч хаяхын төлөө залбираарай.

ХАЙРАН ХАНХҮҮ

Харин Абсалом Амнонд энэ хэргийн талаар сайн муу юу ч ярьсангүй. Охин дүү Тамарыг нь доромжилсон учир Амноныг Абсалом үзэн ядаж байв.

2Самуел 13:22

Абсалом дүү Тамарыг нь хүчиндсэн Амноныг алж өшөөгөө авдаг. Дүү Тамарыг нь хүчиндсэн байхад Амноныг яагаад шийтгэлгүй яваад байгааг хараад Давидад тэр бас хорсдог байв. Абсалом сөрөг бодолдоо хордсон байв. Үүний улмаас Давидын өө сэвийг түвэггүй олж шүүмжилдэг нэгэн болж хувирав. Гэсэн ч дотроо аав нь түүнийг дуудаж уулзах буй хэмээн харсан боловч, Давид дуудаж уулзаагүй тул улам л хорсов.

Шүүмжлэмтгий, гомдсон хандлагаасаа болоод Абсалом сэтгэл дундуур яваа хүмүүсийг өөртөө татах болсон юм. Тэр бусдын гомдлыг хүлээн авч сонсдог хүн болж, тэдэнд анхаарал тавих болов. Би хаан байсан бол тэгэх байсан юм гэх мэтээр гомдоллогч хүнд итгэл найдвар төрүүлдэг байв. Тэр хааны өмнөөс хүмүүсийн асуудлыг шийдэж байгаа мэт дүр исгэв. Абсалом бусдын асуудлыг шударгаар шүүж байгаа мэт байсан авч өөрийнхөө асуудлыг шийдэж чадаагүй л байлаа.

Тэр хүмүүст санаа тавьж байгаа мэт дүр исгэж байв. Абсалом, Израилийн зүрхийг Давид хааны оронд өөртөө татав гэж Библид бичсэн байдаг. Абсалом жинхэнээсээ хүмүүст санаа тавьж байв уу эсвэл эцэг Давидыг хаан ширээнээс нь буулгах арга сүвэгчлэн хүмүүсийг өөртөө урвуулж байв уу?

*Хүний мөс чанарт хандан
Ариун Сүнс үгээ хэлдэг.*

Чуулганы удирдагч нарт тусалж байгаа хүмүүс удирдагч нартаа гомдох тохиолдол их байдаг. Удалгүй тэдний үг үйлдэл бүрээс нь өө сэв харж шүүмжилдэг нэгэн болчихсон байдаг. Тэд гомдсоноосоо болоод бодит үнэнийг тодорхой харж чадахаа больдог. Тэд аливааг тэс өөр өнцгөөс харж замаасаа гаждаг.

Дараах өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү:

Хэн нэгэн хүн чуулганы удирдагч нарыг шүүмжилсээр ирбэл би _____

Би өөрөө чуулганы удирдагч нарыг шүүмжилмээр болбол ____

Христийн Биед байгаа гомдлыг шийдэх хамгийн зөв арга нь _____

Чуулган дотор, ялангуяа удирдагчдын дотроос таныг гомдоосон хүмүүсийн нэрийг жагсаан бичнэ үү. Тэдний нэрийн ард, хэзээ тэдэн дээр очиж уучлал гуйх огноогоо бичиж тэмдэглээрэй.

Нэрс

Уучлал гуйх огноо

Чуулганы удирдагч нарын сул талыг ажиглах нь заримдаа зөв байж болох юм. Давид Амноны талаар шийдэмгий алхам хийх хэрэгтэй байсан. Үүнийг хийгээгүй нь удирдагч хүний хувьд алдаа байсан юм. Гэхдээ хэн шүүгч вэ? Эзэн Бурхан уу эсвэл чи юу? Хэрэв зөрчлийн үр тарьвал зөрчил л хурааж авна гэдгийг санахад илүүдэхгүй.

Хүний мөс чанарт хандан Ариун Сүнс үгээ хэлдэг. Түүний

үгийг үл тоож Түүнийг гомдоож үл болно. Хэрэв ингэсэн байх
аваас, нүглээ гэмшиж Түүний залруулгад зүрхээ нээж өгөөрэй.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бусдыг шүүмжлэгч сүнсийг танаас авч хаяхын төлөө залбираарай.

УРХИНААС ЗАЙЛ

*Иймээс би Бурхан ба хүмүүсийн өмнө хүний мөсөөр
гэм зэмгүй байхыг үргэлж хичээдэг билээ.*

Үйлс 24:16

Гомдлоос чөлөөтэй байхад хүчин чармайлт хэрэгтэй. Паул үүнийг дасгал хөдөлгөөнтэй зүйрлэжээ. Хэрэв бид дасгал хөдөлгөөн хийвэл гэмтэж бэртэх магадлал бага болдог. Бид уучлах дасгал хийж хэвшвэл гомдол хурах нь багасч мөс чанар нь цэвэршдэг.

*Гомдлоос чөлөөтэй байхад
хүчин чармайлт хэрэгтэй.*

Заримдаа хүмүүс биднийг гомдоох үед бид амархан уучилдаг. Бид уучлах дасгал хийсээр байвал ямар ч гомдлыг зүрхэндээ тулгахгүй гаргаж чадна. Үр дүнд нь ямар нэг гомдлоос үүдэлтэй бэртэл хохирол учрахгүй. Зарим гомдлыг уучлах хэцүү байдаг тул биднээс илүү их уучлах дасгал шаарддаг. Илүү их хүч гаргаж уучлалыг сонгоход заримдаа бид бэртдэг ч сүнслэг дасгалын ачаар амархан эдгэрдэг. Үр дүнд нь уучлах дасгал бидэнд олон талын ашиг тустай байдаг. Ноцтой, гомдмоор, хүндхэн гомдолтой та тулж байна уу? Дараах дасгалыг хийж хүчээ сэлбэж аваарай.

Дараах алхмыг уншаад, хийх алхмаа тодорхой бичээрэй.

1. Гомдсон гэдгээ хүлээн зөвшөөр.

Би _____ хүнд гомдсон.

2. Эзэнд гомдол шархаа илчил.

Эзэн минь, би _____ үед
_____ гомдсон шүү.

3. Түүний чиглүүлэг, залруулгад нээлттэй бай.

Эзэн минь, та намайг _____
ингээсэй гэж хүсч байгааг ойлгож байна.

4. Эцэст нь биднийг гомдоосон хүнийг уучлах хэрэгтэй.

Есүс ээ, би _____
хүний ийм _____
үйлдэл, үгийг уучилж байна.

Дараагийн алхам нь уучилсан хүнээ дахин дахин бодохгүй байх дасгал юм. Уучлахаас өмнө тухайн хүний талаарх бодолтойгоо бид зөрчилддөг. Тэр зөрчилдөөн уучлалын дараа сэдрэх гэдэг. Сэдрэх гээд байвал тэр хүнийг ерөөж залбираарай. Дараах ишлэл залбирахад тань туслах болно.

Биднийг гомдоосон хүмүүсийн талаар ямар бодолтой байх талаар Библид хэлсэн Бурханы үгс танд тус болно. Тэмдэглэж аваарай.

Матай 5:44

Дуулал 35:11-44

2Коринт 10:5

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Таныг гомдоосон хүнд байгаа амин хэрэгцээг нь олж залбираарай.

НҮҮР ТУЛСАНААР Л ЭДГЭРНЭ

Юуны өмнө, бие биеэ халуунаар хайрла.

Учир нь хайр бол тоо томшгүй нүглийг далдалдаг юм.

1Петр 4:8

Зөвхөн нүүр тулж байж л эдгэрэлд хүрэх цаг гэж бий. Бидний нүдэнд муу нь харагдахгүй хүнийг хайрлах амархан. Үүнийг бал сарын хайртай ч зүйрлэдэг. Харин нүдэнд муу муухай нь харагдаад байгаа, тэр тусмаа биднийг хохироосон хүнийг хайрлах хэцүү.

Эзэнтэй алхах үед хүнд хэцүү, хөндүүртэй өдрүүдийг бид туулдаг. Бид тийм өдрүүдээс зугтаж ч чадахгүй. Харин бид нүүр тулж Түүний дотор зан чанараар төлөвшдөг. Хэрэв та зугтахыг сонговол төлөвшилд тань сөргөөр нөлөөлнө.

Саадыг давах бүр, та өмнөхөөсөө ч илүү хүчтэй, сэтгэл зүрх тань уужим болно. Та Есүсийг өмнөхөөсөө ч илүү хайрлах болно. Хэрэв та хүнд бэрхийг туулсан хирнээ ийм зүйлийг мэдрэхгүй бол өмнөх шарх тань аниагүй байж ч магад. Та эдгэх сонголт хийх ёстой. Зарим хүн шархалсан хирнээ эдгэх сонголт хийгээгүйгээсээ болж хэзээ ч дахин сэргэдэггүй.

- Хэрвээ таны өнгөрсөн шарх одоо ч хөндүүртэй байвал та шархтай байхыг сонгосон гэсэн үг.
- Эдгэх цорын ганц зам бол уучлал. Таныг шархлуулсан хүн болон сэтгэлийнхээ шархаа Эзэнд өгөөрэй.
- Бусдыг энэрэх сэтгэлгүйн асуудал бол бусдын сул талыг уучлах хүсэлгүйтэй холбоотой юм.
- Өнгөрсөн шархтайгаа нүүр тулж, уучилж, өнгөрүүлж

орхих чадвараас тань таны сүнслэг төлөвшил ихээхэн хамаатай байдаг юм шүү.

Есүс зовлон дунд дуулгавартай байхыг сурсан. Петр ч мөн адил зовлон дунд дуулгавартай байхыг сурсан. Паул ч мөн адил зовлон дунд дуулгавартай байхыг сурсан билээ.

Өнгөрсөн шархтайгаа нүүр түлж, уучилж, өнгөрүүлж орхих чадвараас тань таны сүнслэг төлөвшил ихээхэн хамаатай байдаг юм шүү.

Харин таны хувьд? Та юу сурав? Өнгөрсөн шархаа бодоход та юу мэдэрч байна вэ?

Яг одоо мэдэрч байгаа мэдрэмжээ ✓ тэмдэглээрэй.

Эдгэрсэн мэдрэмж:

- Чөлөөтэй болсон
- Уучлагдсан
- Хайртай болсон
- Дөлгөөн болсон
- Сэтгэлийн галтай
- Хүлээн зөвшөөрөгдсөн
- Даруу болсон
- Дулаахан сэтгэлтэй
- Амар тайван
- Баяр хөөртэй
- Эдгэрсэн
- Сэргэсэн

Шархалсан мэдрэмж:

- Дарамттай
- Уучлагдаагүй
- Хонзогносон
- Хатуурхсан
- Шүүмжилсэн
- Эсэргүүцсэн
- Бардам
- Сэтгэл хөрсөн
- Ууртай
- Гүн дарамтад орсон
- Шархалсан
- Хорссон

Хэрэв та эдгэрсэн гэхээсээ шархалсан мэдрэмжийг илүү тэмдэглэсэн байвал, та таныг төлөвшүүлэх Бурханы удирдамжийг дагахаа, эдгэх үйл явц чинь зогсчээ гэсэн үг.

Хүн тийм амар хялбар төлөвшдөггүй. Тэгдэгсэн бол бүгд л төлөвшчихсэн байхсан. Цөөхөн нь амьдралын энэ шатанд

хүрдэг нь амьдралын эсэргүүцлээс болдог аж. Ертөнц “агаарын хүчний ноёрхогч”-оор удирдуулдаг (Ефес 2:2). Нийгмийн гол урсгал нь бурханлаг бус бэртэгчин байдаг. Тиймд Христтэй адил болж төлөвшихийн тулд нийгмийн энэ хүчит урсгалыг сөрөх хэрэгтэй болдог юм.

Христийн төлөө амиа алдахад, амиа олдог тухай Есүс ярьж байсныг санаж байна уу? Харцаа одоогийн зөрчил дээрээ бус, харин эцсийн үр дүн дээр тусгаарай (1Петр 4:12-13).

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Амьдралын янз бүрийн зовлон бэрхиээл амсаж байхдаа ч Бурханд таларх. Өнөө маргаашийн зөрчилд бус, ирэх өдрүүдийн сайхан үр дүнд анхаарлаа хандуулж залбираарай.

ЗОРИЛГО: ЭВЛЭРЭЛ

“Хүн алж болохгүй, хүний амийг хөнөөсөн хэн боловч шийтгүүлбэл зохино” гэж эртний хүмүүст айлдсаныг та нар сонссон. Харин Би та нарт хэлье, ах дүүдээ хилэгнэгч алив хүн шүүхийн өмнө буруутай. Ах дүүгээ “Хоосон толгой” гэж хэлсэн хэн боловч зөвлөлийн өмнө буруутай. “Мунхаг” гэж хэлсэн хэн боловч галтай тамд орохоор хангалттай буруутгагдах болно ... өргөлөө тахилын ширээний өмнө орхиод замаараа буц. Эхлээд ах дүүтэйгээ эвлэр, дараа нь ирж өргөлөө өргө.
Матай 5:21-22, 24

Уулан дээрх сургаалдаа Есүс эхлээд гадаад үйлдэлтэй холбоотой зүйлийн талаар сургадаг. Харин дараа нь энэ бүхэн зүрхний хандлагаас үүдэлтэй гэдгийг хэлдэг (Матай 5:21-22, 24). Бурханы хувьд хүн алсан нь л алуурчин болдог бус мөн ах дүүгээ үзэн яддаг нь ч алуурчин болдог аж. Зүрхэндээ та хэн байна та тийм л хүн гэсэн үг.

Гомдлын талаар ч Есүс сургаалдаа дурьдсан байдаг. Хэн нэгэнд гомдож хорсоно гэдэг ямар аюултайг Тэр онцлон хэлдэг. Хэрэв ямар нэг шалтгаангүйгээр ах дүүгийнхээ эсрэг уурлаж байвал тэр шүүгдэхэд хангалттай шалтгаантай гэжээ. Ууртай хүн үзэн ядалтаар дүүрнэ. Үзэн яддаг хүн тамд унах аюултай гэжээ. Есүс дагалдагч нартаа гомдлыг шийдмээр байвал эвлэрэлийг сонго гэжээ.

Бид зөвхөн өөрийн тусын тулд бус мөн ахан дүүсийнхээ тусын тулд эвлэрэхэд яарах ёстой. Гомдлоос ангижрахад нь та идэвхижүүлж болох шүү дээ. Эвлэрэхийн тулд очиж уулзахгүй уурласаар байхыг Бурханы хайр тэвчдэггүй юм. Бид буруу юм

хийгээгүй ч байж болох. Үнэндээ хэний зөв буруу нь тийм ч чухал биш. Өөрсдийгөө зөв гэж зөвтгөхөөс илүүтэй бүдэрсэн ах дүүгээ буцаан авах нь илүү чухал юм.

Бид өөрсдийгөө болохоор уг нь би ингэх гэж байсан юм гэсэн бодлоор шүүдэг хирнээ бусдыг болохоор үйлсээр нь шүүдэг.

Бусдад гомдсон гомдлоо дор бичнэ үү. Нэрийг нь бичээд ард нь хэзээ түүнтэй эвлэрэхийг хүсч байгаагаа бичээрэй.

Нэрс	Огноо	Цаг
_____	_____	_____
_____	_____	_____
_____	_____	_____
_____	_____	_____
_____	_____	_____

Бид өөрсдийгөө болохоор уг нь би ингэх гэж байсан юм гэсэн бодлоор шүүдэг хирнээ бусдыг болохоор үйлсээр нь шүүдэг. Санаа нь зөв байсан ч бусдад буруугаар ойлгогдохоор үйлдэж болох шүү дээ. Заримдаа бидний жинхэнэ санаа биднээс өөрсдөөс минь хүртэл ухаалгаар нуугдсан байдаг. Бид цэвэр хандлагаар хийсэн дээ гэж итгэдэг. Харин Бурханы Үгээр шүүгээд үзэхээр тэс өөр дүн гардаг тал бий. Хэрэв бид эвлэрлийг хүсч байвал, сайн хандлага хангалттай биш юм. Харин бид даруй очиж эвлэрэх ёстой. Та очих уу үгүй юу?

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Гомдсон ч гэлээ тэр хүнтэй уулзаж, эвлэрэх хайр ба эр зоригийг Бурханаас гуйгаарай.

ГОМДСОН ХҮНЭЭС УУЧЛАЛ ГҮЙХ

*Тиймд амар тайванг тогтоодог болон бие биеэ босгон
байгуулдаг зүйлсийн хойноос мөшгөцгөөе.*

Ром 14:19

Гомдоосон хүнд ямар сэтгэлээр хандах ёстойг Ром 14:19-д хэлжээ. Хэрэв уурлаж цухалдсан сэтгэлээр очвол амар тайвныг авчрахгүй. Харин гомдсон дээр нь улам л дарь нэмэхээс цаашгүй. Харин бид бардам зангаа залгиж даруу сэтгэлээр уулзах ёстой.

Надад гомдсон, надад уурласан хүмүүстэй би уулзаж байлаа. Намайг бэртэгчин, бодлогогүй, бардам, бүдүүлэг, харгис гэх мэтээр хэлэхгүй үгээр хэлж байхыг нь сонсож л явлаа.

Хүн юм болохоор би “Би тийм биш ш дээ. Намайг та буруу ойлгоод байна” гэж хэлэх нь гарцаагүй. Харин өөрийгөө өмгөөлөөд л эхэлбэл галд тос нэмнэ. Ийм байдлаар энх тайван тогтоохгүй л дээ. Өөрийнхөө эрхийн төлөө тууштай зогсвол хэзээ ч жинхэнэ амар тайван тогтохгүй.

Харин үүний оронд дуугүй байж, тэдний хэлж байгаа үг бүрийг даруухнаар сонсох нь зөв юм. Хэрэв санал нийлэхгүй зүйл гарвал би тэдний бодлыг хүндэлж байгаагаа илэрхийлээд дотроо өөрийн хандлагаа дахин шүүж боддог болсон. Тэгээд гомдоосондоо уучлал хүсч эвлэрэхийг зорьдог.

*Сайныг өдөөн тэтгэх нь
бурханлаг мэргэн ухаан.*

Заримдаа тэд зөв байдаг. Би хүлээн зөвшөөрч “Таны зөв өө. Намайг уучлаарай” гэдэг.

Ойрын үед та хэн нэгнээс уучлал хүсч байв уу? Тэдэнд хандсан өөрийн хандлагаа нэг тодорхойлоод үз дээ. Бардамнан хэлсэн үгээ нэг дугуйлж зураад бод доо.

Өөрийгөө даруу болгох нь эвлэрлийг авчирдаг. Бардамнал өөрийгөө өмөөрдөг, харин даруу зан “Таны зөв өө. Би тэгэж хандсан. Намайг уучлаарай” гэж хэлэх зоригтой байдаг.

Иаков 3:17-г уншаад өөрийн үгээр бичээрэй.

Сайныг өдөөн тэтгэх нь бурханлаг мэргэн ухаан. Хувийн асуудалд хандахдаа бурханлаг мэргэн ухаан зөрүүдэлж гөждөггүй. Бурханлаг мэргэн ухаанд өөрийгөө даатгасан хүн үнэнээс гажихгүй л бол өөрөө буруудахаас ч айдаггүй юм.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Зүрхэнд байгаа шархыг тань илчилж, гомдоосон хүнээсээ уучлал гүйх мэргэн ухаан өгөхийг Бурханаас асуугаарай.

ТАНЫГ ГОМДООСОН ХҮНТЭЙ ОЧИЖ УУЛЗАХ

*Хэрэв ах дүү чинь нүгэл үйлдвэл, явж түүнтэй ганцаарчлан
уулзан зэмлэ. Хэрэв тэр чамайг сонсвол,
чи ах дүүгээ олж авсан хэрэг.
Матай 18:15*

Олон хүн Матай 18:15-ыг Есүсийн хэлснээс өөрөөр хэрэглээд байх шиг. Гомдоосон хүнтэйгээ уулзахдаа өөрийгөө зөвтгөх Библийн аль л ишлэл байна түүнийгээ урдаа барьж, хорсол уур хилэнгээр уулзах гэнэ. Харин Есүс бие биетэйгээ яаж уулзахыг заасан ухааныг нь ойлгосонгүй ээ тэд. Буруутгахын тулд бус харин эвлэрэхийн тулд уулздаг. Өөдгүйг нь сануулах гэж уулз гэж Есүс хэлээгүй ээ. Харин бид харилцаанд үүсгэн ан цавыг битүүлэхээр эвлэрэхээр уулздаг билээ.

Бурхан ийм л замаар өөртэйгээ эвлэрүүлдэг. Хэдийгээр бид Бурханы эсрэг тэрсэлсэн ч, "... Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм" (Ром 5:8). Биднийг гомдоосон хүнтэй эвлэрэхийн тулд өөрийн бүрэн эрхээсээ татгалзаж, бардам зангаа залгиж чадах уу бид? Уучлал гуйхаас минь өмнө Бурхан бидний төлөө ирсэн. Бид гомдоосноо ч мэдээгүй байхад Есүс биднийг уучлахыг сонгосон.

Ром 5:6-11-ийг анхааралтай уншиж, өөрийн байдлаа бичнэ үү.

Анх Христийн тухай сонсох үед миний амьдралын байдал ийм байсан _____

Христэд би Түүний дараах үйлдлээс илүү тодорхой ойлгож
итгэсэн _____

Есүс намайг өөрийнхөө _____
_____ улмаас л хүлээн авсан.

Намайг өөрийн болгохдоо Бурхан өөрийн аугаа зорилго болох
_____ гүйцээсэн юм.

Есүс бидний төлөө ирсэн ч, Бурхан Аавын эвлэрэлийн үгийг
хүлээн авахаас нааш бид Бурхан Аавтай эвлэрээгүй юм.

***Бид харилцаанд үүссэн ан цавыг
битүүлж, эвлэрэхээр уулздаг билээ.***

Шинэ Гэрээнд Есүсийн дагалдагч нар хүн бүр Бурханы
эсрэг тэрсэлсэн гэж номлосоор ирсэн. Яагаад хүмүүст үүнийг
нь сануулаад байгаа юм бэ? Буруутгах гэж үү? “Бурхан Өөрийн
Хүүгээ ертөнцийг яллахын тулд биш, харин Түүгээр дамжуулан
ертөнцийг аврахын тулд ертөнц уруу илгээсэн билээ” (Иохан
3:17). Тэдний бодит байдлыг харуулж, ухааруулж, гэмшүүлж,
уучлал гуйн эвлэрүүлэх гэж л тэр шүү дээ.

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

*Таныг гомдоосон эсвэл өөрийн гомдоосон хүнтэй уулзаж уучлал гуйн
эвлэрэхийн төлөө залбираарай.*

ДҮГНЭЛТ

*Хэрэв боломжтой бол, та нараас шалтгаалж байгаа бол
бүх хүнтэй эвтэй байгтун.*

Ром 12:18

Бурханы хайрыг сэтгэлийнхээ алив сэдэл болгож явбал та хэзээ ч алзахгүй ээ. Хайр хэзээ ч бурууддаггүй. Хэрэв бид Бурханы хайраар бусдыг хайрлаж амьдарвал, тэр хүн бидэнтэй эвлэрэхгүй байсан ч бид сэтгэл тэнүүн амьдарч чаднаа.

Есүс хэлэхдээ “хэрэв боломжтой бол” гэжээ. Учир нь зарим хүн бидэнтэй эвлэрэхээс татгалздаг юм. Эсвэл Эзэнтэй цааш алхахад тань саад болох тийм болзол тавьж эвлэрэх гэдэг. Дээрх хоёрын аль ч тохиолдолд эвлэрэх тун хэцүү.

Бурхан “... та нараас шалтгаалж байгаа бол” гэжээ. Үнэнээс гажихгүй тохиолдолд бүхий л чадлаараа эвлэрэхийн төлөө бид явах ёстой. Заримдаа бид дэндүү амархан харилцааны асуудалд бууж өгдөг.

Есүс “Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй еэ! Учир нь тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно” (Матай 5:9) гэж хэлсэн. Есүс “Амар тайвныг сахигчид” гэж хэлээгүйг анхаарна уу. Амар тайвныг сахигчид нь амар тайван харилцаагаа алдахгүйн тулд ямар ч үнээр хамаагүй үнэнээс зайлсхийж явдаг. Тийм харилцаанд байгаа амар тайван бол жинхэнэ амар тайван биш ээ. Сэтгэл хөдлөм, хуурамч амар тайван удаан оршин тогтнохгүй.

*Хайр хэзээ ч буруудахгүй, хэзээ ч буурахгүй,
хэзээ ч төгсөхгүй.*

Амар тайвныг тогтоогч нь үүрд орших амар тайван харилцааг бий болгохын тулд үнэнийг илчилж хайраар нүүр тулдаг. Тийм хүн зохиомол, хуурамч харилцааг хадгалдаггүй. Тэр нээлттэй, үнэн, ба хайрыг хүсэмжилдэг. Зөв мэт харагдуулахын тулд хуурамч инээмсэглэлийнхээ цаана үнэнийг тэр нуухгүй. Тэр эр зоригтой хайраар нүүр тулж амар тайвныг тогтоодог.

Та хэр сайн “амар тайвныг тогтоогч” вэ? Амар тайвныг тогтоогч хүний зарим нэг чанарыг энд бичив. Танд буй чанарыг “х” гэж тэмдэглээрэй.

Амар тайвныг тогтоогч нь ...

Хайрладаг

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Анхааран сонсдог

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Тэвчээртэй

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Уурлахдаа удаан

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Уучламтгай

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Яаран ам нээдэггүй

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Нээлттэй

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Дуулгавартай

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Эмзэг

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Бурханыг сонсдог

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Бурханыг сонсдог

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Үнэнч шударга

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Даруу

Тийм Сурах хэрэгтэй байгаа

Есүст эдгээр чанар бүгд байсан. Амар тайвны Жонон Есүсийн Сүнс бидний дотор оршиж байхад эдгээр бүх зүйлийг хийх хүч чадал бидэнд байгаа л гэсэн үг. Тэр хэнийг ч мөхүүлэхийг хүсээгүй юм. Харин тэр харилцаагаа хадгалахын тулд үнэнээс нүүрээ булзааруулахгүй. Хуурамч өнгөц биш харин жинхэнэ үнэнч харилцааг Есүс хүсдэг. Ийм харилцаанд л хар хор орох ч боломжгүй хайр байдаг билээ л. Тийм учраас Тэр энэ хайрандаа үнэнч гэдгээ батлах гэж амиа бидний төлөө зориулсан юм. Бид ч мөн Түүний адил энэ хайранд үнэнч байх ёстой.

Хайр хэзээ ч буруудахгүй, хэзээ ч буурахгүй, хэзээ ч төгсөхгүй. Хайр өөрийнхөө ашиг сонирхолыг ч эрэхгүй. Хайр тийм ч амархан гомдохгүй (1Коринт 13-г уншаарай).

ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Бусдыг гэх Бурхан хайраар сэтгэл чинь дүүрэн байхын төлөө залбираарай. Ялангуяа таныг гомдоосон, дайсанд тооцогдох тэдгээр хүмүүст хайраар хандахад туслахын төлөө.

ҮЙЛДЭЛ БОЛГОХУЙ

*Тийм учир зөв юмыг үйлдэхийг мэддэг хэрнээ
үл үйлддэг хүнд энэ нь нүгэл юм.
Иаков 4:17*

Одоо юу сурсанаа үйлдэх цаг! Далдалсан, мартсан, үгүйсгэсэн гомдол бүрийг чинь Эзэн сануулсан байх. Өнгөрсөн цаг үедээ алхаж гомдлын хүлээсийг тайлахад тань Ариун Сүнс туслах болтугай!

*Өнгөрсөн гомдлын хир бүртгээс сэтгэл тань цэвэр болоход
ирээдүйд өмнө тань тавих Сатаны алив урхинд орохгүй
байх эр зориг, ухаан танд ирдэгийг та мэдэх болно.*

Уучлахын төлөө залбиран үйлдэхэд бэлэн бай. Эвлэрэхийн төлөө даруухнаар очиж уучлал гуйхад сэтгэлээ бэлтгэ. 182-р хуудсанд буй залбирлыг чиг болгоорой.

Залбирч байхдаа дараах хэсэгт анхаарлаа хандуулаарай.

30 өдрийн чимээгүй цагаар би хамгийн гол нь үүнийг сурлаа:

Сатаны урхи өдөөхөд би _____ болно.

Хүнд гомдол өвөрлөхгүйн тулд би дараах алхмыг хийнэ: _____

Би дараах хүнээс даруй уучлал гуйх ёстой юм байна:

Сүнслэг үйл явдлаа тэмдэглэн хөтлөх нэг шалтгаан нь:

Гомдлын хувьд өдөр бүр залбирах нэг зүйл нь:

Өнгөрсөн гомдлын хир бургтаас сэтгэл тань цэвэр болох үед танд Сатаны алив урхинд орохгүй байх эр зориг, ухаан ирнэ. Ефес 6:10-18 дээр өгүүлсэн Бурханы бүрэн хуяг дуулгын талаар сайтар унш. Та дайсан бүрээ дарахын төлөө төрсөн хүн шүү!


ЗАЛБИРЛАА БИЧНЭ ҮҮ ...

Танд зориулсан бэлтгэсэн сүнслэг хуяг дуулга болгоноор Бурхан таны амьдралд хамгаалалт өгөхийн төлөө залбираарай.




MessengerX.com

Газар газрын хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 110 гаруй хэл дээр үнэ төлбөргүй үзэх боломжтой.
- Апп хэлбэрээр ч, онлайн хэлбэрээр ч хэрэглэх боломжтой.
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан материал.
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой.



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

MessengerX.com



Download on the
App Store



GET IT ON
Google Play

Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой.

Өстөн дайсныхаа үхлийн занганаас чөлөөтэй амьдар!

САТАНЫ УРХИ ном Бураны хүслээс итгэгчдийг тун амархан урхиддаг арга болох "гомдол"-ын тукай өгүүлнэ. Олон хүн урхидуулсанаа ч мэдэлгүй энэ урхинд унадаг..

Бүү хуурт! Таныг гомдоох зүйлээс зугтаж чадахгүй ч гомдох гомдохгүйгээ сонгох боломж танд бий. Гомдлыг зөв шийдвэл хорсож үлдэлгүй харин улам хүчирхэг болно. Зөвхөн зөв шийдсэн нь Бурхантай ямар ч саадгүй харилцана.

Арав дахь жилдээ хэвлэгдэж буй номоороо Жон Бивэр танд хэрхэн хардалт, үл итгэх байдлаас чөлөөтэй байж Бурханы дуудлага дотор хүчтэй хэвээрээ байхыг заах болно. Дэлхий даяар энэ номыг 1,000,000 гаруй хувиар борлуулжээ. Номын анхны уншигчид хэрхэн амьдрал нь өөрчлөгдсөн талаарх гэрчлэлийг энэхүү шинэчилсэн найруулсан номд багтаав. Мөн чимээгүй цаг хийх нэмэлт материал, бүлгээр хийх судлал асуулт, Библийн ишлэл болон залбирал багтаасан байна.

Та энэ номоос дараах хүнд асуултдаа хариулт авна:

- Яагаад би "өөрийгөө зөвтгөх талыг" ярих хэрэгтэй болов?
- Хардалт болох үл итгэх бодолтойгоо хэрхэн тэмцэх вэ?
- Зүрх зүссэн дурсамжаа хэрхэн бодохоо зогсоох вэ?
- Гүн шархлуулсан нэгэнд хэрхэн эргээд итгэх вэ?

Дайсны үргэлж хэрэглэдэг "Гомдох үрхи"-наас чөлөөтэй байж Бурхантай саадгүй харилцаатай байхад тань энэ ном тусална.



ЖОН БИВЭР - шилдэг номын зохиогч, конференцүүдэд ихээхэн эрэлтэй номлогчдын нэг. Гэргий Лиза нь мөн шилдэг номын зохиогч бөгөөд тэд хамтдаа 1990 онд John Bevere ministries нэртэй үйлчлэлээ байгуулжээ. Даруухан эхэлсэн үйлчлэл нь олон улсад хүчээ авч, долоо хоног тутмын The Messenger ТВ-ийн нэвтрүүлэг нь дэлхийн 214 оронд цацагдах болсон юм. Жон Бивэрийн бичсэн номуудаас дурьдвал Ариун Сүнс: Түүнтэй танилцахуй номыг Монгол уншигчид хэдийнээ мэдэх болсон билээ.



X Үнэ төлбөргүй материал, видео дамжуулалтыг **MessengerX.com** хаягаас хүлээн авна уу.
MessengerX



MESSENGER
INTERNATIONAL
MessengerInternational.org

Зохиогчоос Монгол чуулгана
бэлэглэж буй бэлэг бөгөөд
худалдахыг хориглоно.